

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР  
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

# “ПАРЛАМЕНТ”

(Судалгааны эмхэтгэл)



## ТОЙМ АГУУЛГА

- **КОВИД-19: СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ**
  - ✓ **ТАРХАЛТ**
  - ✓ **ЭМНЭЛЗҮЙ**
  - ✓ **НӨЛӨӨЛӨЛ**
  - ✓ **ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ**

ННА 66  
ДАА 351  
П-183

“Парламент” судалгааны эмхэтгэл (XXXIII боть)-ийг  
Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгааны хүрээлэнгээс эрхлэн  
гаргав.

Хянасан: Т.Баярмаа  
Ц.Норовдондог (PhD)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Г.Баатар



УИХ-ын Тамгын газар ©  
“ПАРЛАМЕНТ” СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ - XXXIII БОТЬ

**978-9919-9618-8-6**

## ГАРЧИГ

### КОВИД-19: ТАРХАЛТ, ЭМНЭЛЗҮЙ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУРШЛАГА

1.1	КОВИД-19-ийн тойм: Сонгуульд үзүүлэх нөлөө (2020.10.01-ний байдлаар)	5
	<i>Г.Билгээ</i>	
1.2	Дэлхийн улс орнуудад коронавирусийн эсрэг авч буй арга хэмжээ, парламентын үйл ажиллагаа болон вакцины тойм мэдээ (2020.11.15-ны байдлаар)	10
	<i>Д.Амаржаргал (Ph.D), О.Билгүүтэй, Г.Билгээ, С.Золжаргал, Ч.Жаргал, Д.Жигваагүнсэл</i>	
1.3	Хөл хорио тогтоосон үед улс орнуудын парламентууд хэрхэн ажиллаж байгаа талаарх тойм мэдээ (2020.11.15-ны байдлаар)	21
	<i>Д.Халиун, Г.Билгээ</i>	
1.4	КОВИД-19 цар тахлын үед дэлхийн улс орнуудын парламентууд халдвар-хамгааллын дэглэмийг баримтлан үйл ажиллагаа явуулж байгаа туршлага (2020 .11.17-ны байдлаар)	25
	<i>Д.Халиун, Г.Билгээ, Р.Нургүл, О.Билгүүтэй, Д.Уянга, Г.Уянга, С.Золжаргал, Р.Оргилмаа, Б.Батцэцэг, Ж.Үүрцайх, Б.Долгормаа, Д.Жигваагүнсэл, Ц.Ариунаа, Э.Анужин, Ч.Жаргал, О.Нарантуяа</i>	
1.5	КОВИД-19 цар тахлаас Монгол Улсын нийгэм, эдийн засагт үүссэн нөхцөл байдлын шинжилгээ, тоон үзүүлэлтүүд (2020.01. 20-ны байдлаар)	55
	<i>Г.Уянга</i>	
1.6	КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм-эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр эрх бүхий байгууллагуудаас гаргасан шийдвэрийн талаарх мэдээлэл, лавлагаа (2020.01.01-11.23-ны байдлаар)	69
	<i>Д.Халиун, Д.Аюуш, П.Уранчимэг, Б.Туул, С.Золжаргал</i>	
1.7	КОВИД-19 цар тахлын тархалт, эмнэлзүйн практик: гадаад, дотоод нөхцөл байдлын тойм (2020.11. 23-ны байдлаар)	139
	<i>Д.Амаржаргал (Ph.D), Ц.Ариунаа, Б.Туул</i>	
1.8	КОВИД-19 цар тахлын хорио цээрийн дэглэмийг сулруулснаас үүдэн гарсан сургамж: Ази Номхон Далайн болон Европын бүсийн орнуудын туршлагад хийсэн дүн шинжилгээ (2020 оны 11-р сарын 23-ны байдлаар)	152
	<i>О.Билгүүтэй, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Г.Уянга, О.Нарантуяа, С.Золжаргал, Б.Батцэцэг</i>	

- 1.9 **КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр дэлхийн бусад орнуудад авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний туршлага (2020.11.30-ны байдлаар)** 174  
*О.Билгүүтэй, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, О.Нарантуяа, Г.Уянга, С.Золжаргал, Б.Батцэцэг, Б.Долгормаа*
- 1.10 **Монгол Улсын Засгийн газраас цар тахлын нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулах, иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр авсан арга хэмжээний тойм (2020.11.30-ны байдлаар)** 213  
*Б.Төмөр-Очир*
- 1.11 **КОВИД-19 цар тахлын дэлхийн улс орнуудын эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл ба хариу арга хэмжээний үр дүн (2020.11.30-ны байдлаар)** 223  
*Д.Халиун, Р.Оргилмаа*
- 1.12 **КОВИД-19-ийн вакцины талаарх товч мэдээлэл (2020.12.01-ний байдлаар)** 233  
*Д.Амаржаргал (Ph.D)*
- 1.13 **Олон улсад мөрдөгдөж буй КОВИД-19-ийн вакциныг ашиглах бэлэн байдлын үнэлгээний системийн талаарх лавлагаа мэдээлэл (2021.02.24-ний байдлаар)** 236  
*Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа*
- 1.14 **КОВИД-19-ийн эсрэг вакцин үйлдвэрлэл ба хэрэглээний талаарх олон улсын мэдээллийн тойм (2021.02.24-ний байдлаар)** 242  
*Д.Амаржаргал (Ph.D), О.Билгүүтэй, С.Золжаргал*
- 1.15 **КОВИД-19 цар тахлын эсрэг вакцины талаарх нийгмийн сүлжээний мэдээлэлд хийсэн контент анализ (Мэдээллийн сайт, фэйсбүүк, твиттерийн хүрээнд) (2021.02.24-ний байдлаар)** 257  
*Д.Аюуш, Б.Батцэцэг, Б.Ариунаа*

**КОВИД-19-ийн тойм: СОНГУУЛЬД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ**(2020 оны 10-р сарын 01-ний байдлаар)<sup>1</sup>

Г.Билгээ

КОВИД-19 цар тахлын улмаас дэлхийн олон оронд үндэсний болон орон нутгийн хэмжээнд явуулахаар товллоод байсан сонгууль, ард нийтийн санал асуулгыг хойшлуулсан бол нэлээдгүй оронд эдгээр арга хэмжээг амжилттай зохион явуулсан байна.

Энэхүү мэдээлэл, лавлагаанд дэлхийн улсууд үндэсний хэмжээнд ерөнхийлөгчийн, парламентын сонгууль, ард нийтийн санал асуулгыг, орон нутгийн хэмжээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын, парламентын нөхөн сонгуулийг КОВИД-19 цар тахлын үед зохион явуулсан, эсхүл энэхүү аюулаас сэргийлэхийн тулд хойшлуулсан, эсхүл эрсдэлийг тооцоолон 2020 онд багтаан явуулахаар төлөвлөсөн байдлыг гаргасан болно.

Мэдээлэл, лавлагааг тоймлож үзвэл:

**1.Цар тахлын үед сонгууль явуулсан орнууд (02.21-09.30)**

- 63 улс (нутаг дэвсгэр) үндэсний болон орон нутгийн хэмжээнд сонгууль, ард нийтийн санал асуулга явуулсан байна. Үүнээс:
  - 49 улс (нутаг дэвсгэр) үндэсний хэмжээнд сонгууль, ард нийтийн санал асуулгыг явуулжээ;
  - цар тахлын үед 29 улс хойшлуулсан байсан сонгууль, ард нийтийн санал асуулгаа 2020 оны 4-9 дүгээр сард багтаан явуулжээ.

Сонгууль	Цар тахлын үед сонгууль явуулсан орнууд	
	тоо	нэр
Бүх нийтийн сонгууль (general election)	7	Вануату, Гайана, Их Британи, Мали, Ниуэ, Суринам, Тринидад ба Тобаго
Ерөнхийлөгчийн сонгууль	9	АНУ, Беларусь, Бурунди, Доминиканы БНУ, Исланд, Кирибати, Малави, Польш, Того
Парламентын сонгууль	24	АНУ, Доминиканы БНУ, Египет, Израиль, Иран, Ирланд, Камерун, Кирибати, Мали, Монгол, Монтенегро, Өмнөд Солонгос, Папуа Шинэ Гвиней, Сент Кит ба Невис, Серб, Сингапур, Сири, Словак, Тажикистан, Хойд Македони, Хорват, Шри Ланка, Энэтхэг, Ямайка
Парламентын нөхөн сонгууль	5	Бангладеш, Гвиней, Украин, Чех, Япон
Ард нийтийн санал асуулга	6	Гвиней, Итали, Их Британи, Лихтенштейн, ОХУ, Швейцар
Орон нутгийн сонгууль	25	Австрали, Австри, Бенин, Герман, Доминиканы БНУ, Испани, Итали, Канад, Латви, Ливи, Малайз, Молдова, Монтенегро, Нигери, ОХУ, Польш, Румын, Серб, Тайвань, Тунис, Уругвай, Франц, Швейцар, Энэтхэг, Япон

<sup>1</sup> Парламентын судалгааны хүрээлэнгээс “КОВИД-19-ийн тойм: Сонгуульд үзүүлэх нөлөө” судалгааг өмнө нь 2020 оны 04 дүгээр сарын 01-ний байдлаар бэлтгэснийг “Бодлогын товчоон” сэтгүүлийн 2020 оны 1 дэх дугаараас үзнэ үү.

Бусад	2	<ul style="list-style-type: none"> <li>- Уганда (Тусгай сонирхлын бүлэг (Special Interest Group)-ийн сонгууль)</li> <li>- Тайвань (Гоминьдан (Kuomintang)-ны даргын сонгууль)</li> </ul>
-------	---	--

## 2.Цар тахлын улмаас сонгуулиа хойшлуулсан орнууд

- 58 улс (нутаг дэвсгэр) үндэсний болон орон нутгийн хэмжээнд явуулах байсан 73 сонгууль, ард нийтийн санал асуулгын товыг хойшлуулсан байна. Үүнээс:
  - 16 улс (нутаг дэвсгэр) үндэсний хэмжээний сонгууль, ард нийтийн санал асуулгыг хойшлуулжээ;
  - 29 улс (нутаг дэвсгэр) нь хойшлуулаад байсан сонгууль, ард нийтийн санал асуулгаа 2020 оны 4-9 дүгээр сард багтаан явуулжээ;
  - 12 улс (нутаг дэвсгэр) нь хойшлуулсан арга хэмжээгээ 2020 оны сүүлийн 3 сард багтаан явуулахаар төлөвлөсөн байна;
  - 8 улс (нутаг дэвсгэр) хойшлуулаад байсан арга хэмжээгээ 2021 онд явуулахаар төлөвлөөд байна;
  - харин 19 улс (нутаг дэвсгэр) хойшлуулаад байсан сонгууль, ард нийтийн санал асуулга явуулах тодорхой товоо гаргаагүй байна.

## 3.2020 онд багтаан сонгууль явуулахаар төлөвлөсөн орнууд (10.01-12.31)

- 39 улс (нутаг дэвсгэр) 2020 оны сүүлийн 3 сард багтаан үндэсний болон орон нутгийн хэмжээнд сонгууль, ард нийтийн санал асуулга явуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:
  - энэ оны сүүлээр явуулахаар товлосноос гадна цар тахлын улмаас хойшлуулаад байсан сонгууль, ард нийтийн санал асуулга орсон;
  - 29 улс (нутаг дэвсгэр) үндэсний хэмжээнд сонгууль, ард нийтийн санал асуулга явуулна.

Сонгууль	2020 онд багтаан сонгууль явуулах орнууд	
	тоо	нэр
Бүх нийтийн сонгууль (general election)	11	Австрали, Белиз, Болив, Бразил, Гана, Египет, Мьянмар, Палау, Танзани, Төв Африкийн БНУ, Шинэ Зеланд
Ерөнхийлөгчийн сонгууль	8	АНУ, Буркина Фасо, Гвиней, Котд'Ивуар, Молдова, Сейшелийн Арлууд, Тажикистан, Хойд Кипр
Парламентын сонгууль	8	Бразил, Буркина Фасо, Венесуэл, Иордан, Кыргыз, Либер, Литва, Нигери
Ард нийтийн санал асуулга	2	Либер, Чили
Орон нутгийн сонгууль	16	Австрали, Австри, Аргентин, Босни-Герцеговин, Бразил, Индонез, Канад, Ливи, Малайз, Монгол, Намиби, Нигер, Нигери, Словак, Украин, Энэтхэг

Үүнийг дараах хүснэгтүүдээс дэлгэрүүлж үзнэ үү:

1. Цар тахлын үед сонгууль явуулсан орнууд (02.21-09.30);
2. Цар тахлын улмаас сонгуулиа хойшлуулсан орнууд;
3. Сонгуулиа 2020 онд багтаан явуулахаар төлөвлөсөн орнууд (10.01-12.31).

### 1.Цар тахлын үед сонгууль явуулсан орнууд (02.21-09.30)

ДЭМБ-ын мэдээлснээр, сонгууль, ард нийтийн санал асуулга явуулсан дараах улсууд<sup>2</sup> эрүүл ахуй, аюулгүй байдлын тусгай арга хэмжээнүүдийг сайтар авсны үр дүнд эдгээр улсуудад сонгуулийн үеэр КОВИД-19-ийн тохиолдол бүртгэгдээгүй байна.

Австрали	Израиль	Молдова	Тажикстан
АНУ	Иран	Монгол	Тайвань
Бангладеш	Ирланд	Монтенегро	Того
Беларусь	Итали	Нигери	Тринидад ба Тобаго
Бенин	Их Британи	Ниуэ	Украин
Бурунди	Камерун	Өмнөд Солонгос	Франц
Вануату	Канад	Польш	Хорват
Гайана	Кирибати	Сент Кит ба Невис	Швейцар
Гвиней	Ливи	Серби	Энэтхэг
Герман	Малави	Сингапур	Ямайка
Доминиканы БНУ	Малайз	Словак	Япон
Египет	Мали	Суринам	

### 2.Цар тахлын улмаас сонгуулиа хойшлуулсан орнууд

Австрали	Зимбабве	Молдова	Сомали
Австри	Индонез	Монтенегро	Тунис
АНУ	Иран	Нигери	Уганда
Аргентин	Испани	ОХУ	Уругвай
Армен	Итали	Өмнөд Африк	Франц
Бангладеш	Их Британи	Пакистан	Хонконг
Болив	Канад	Папуа Шинэ Гвиней	Чад
Босни-Герцоговин	Кипр	Перу	Чех
Ботсвана	Колумби	Польш	Чили
Бразил	Косово	Румын	Швейцар
Габон	Кыргыз	Серби	Шинэ Зеланд
Гамби	Латви	Сири	Шри Ланка
Герман	Либер	Словак	Энэтхэг
Доминиканы БНУ	Македони	Соломоны арлууд	Этиоп

### 3.Сонгуулиа 2020 онд багтаан явуулахаар төлөвлөсөн орнууд (10.01-12.31)

Д/д	Улсын нэр	Сонгууль	Сонгууль болох газар	Товлогдсон огноо	Анх товлогдсон огноо
1	Австрали	Бүх нийтийн сонгууль		2020.10.17	
2	Австрали	Орон нутгийн сонгууль	Нийслэлийн нутаг дэвсгэрийн хууль тогтоох байгууллага	2020.10.17	
3	Австрали	Орон нутгийн сонгууль	Victoria мужийн зөвлөл	2020.10.23	

<sup>2</sup> Үүнд: Гайана, Кирибати, Ниуэ, Словак, Тажикистан, Того, Вануату зэрэг улсууд хамаарахгүй аж.

4	Австрали	Орон нутгийн сонгууль	Queensland муж	2020.10.31	
5	Австри	Орон нутгийн сонгууль	Vienne хот	2020.10.11	
6	АНУ	Ерөнхийлөгчийн сонгууль		2020.11.03	
7	Аргентин	Орон нутгийн сонгууль	Cordovan City, Rно Cuarto	2020.11.29	2020.03.29
8	Белиз	Бүх нийтийн сонгууль		2020.11-р сард	
9	Болив	Бүх нийтийн сонгууль		2020.10.18	2020.05.03
10	Босни-Герцоговин	Орон нутгийн сонгууль		2020.11.15	2020.10.04
11	Бразил	Бүх нийтийн сонгууль		2020.10.02	
12	Бразил	Сенатын нэмэлт сонгууль	Mato Grosso муж	2020.11.15	2020.04.26
13	Бразил	Орон нутгийн сонгууль		2020.11.15, 29	2020.10.04, 25
14	Буркина Фасо	Ерөнхийлөгчийн болон Парламентын сонгууль		2020.11.22	
15	Венесуэл	Парламентын сонгууль		2020.12.06	
16	Гана	Бүх нийтийн сонгууль		2020.12.07	
17	Гвиней	Ерөнхийлөгчийн сонгууль		2020.10.18	
18	Египет	Бүх нийтийн сонгууль		2020.11.29	
19	Индонез	Орон нутгийн сонгууль		2020.12.09	2020.09.23
20	Иордан	Парламентын сонгууль		2020.11.10	
21	Канад	Орон нутгийн сонгууль	Saskatchewan	2020.10.26	
22	Кот д'Ивуар	Ерөнхийлөгчийн сонгууль		2020.10.31	
23	Кыргыз	Парламентын сонгууль		2020.10.04	
24	Либер	Сенатын завсрын сонгууль		2020.12.08	2020.10.13
25	Либер	Ард нийтийн санал асуулга		2020.12.08	2020.10.13
26	Ливи	Орон нутгийн сонгууль (хэсэгчилсэн)	Misllata, Zliten, El Khoms, El Haraba, Jadu, Kabaw, El Sayeh, Zawiya Janub	2020.10.15	



27	Литва	Парламентын сонгууль		2020.10.11	
28	Малайз	Мужийн Ассамблейн сонгууль	Sabah	2020.09.29	
29	Молдова	Ерөнхийлөгчийн сонгууль		2020.11.01	
30	Мьянмар	Бүх нийтийн сонгууль		2020.11.08	
31	Намиби	Орон нутгийн сонгууль		2020.11.26-27	
32	Нигер	Орон нутгийн сонгууль		2020.11.01	
33	Нигери	Сенатын нөхөн сонгууль	Bayelsa, Imo, Plateau мужид	2020.10.31	2020 оны 03-р сард
34	Нигери	Орон нутгийн сонгууль	Ondo	2020.10.10	
35	Палау	Бүх нийтийн сонгууль		2020.11.03	
36	Сейшелийн Арлууд	Ерөнхийлөгчийн сонгууль		2020.10.22-24	
37	Словак	Орон нутгийн сонгууль		2020.10.03	2020.04.04
38	Тажикистан	Ерөнхийлөгчийн сонгууль		2020.10.11	
39	Танзани	Бүх нийтийн сонгууль		2020.10.28	
40	Төв Африкийн БНУ	Бүх нийтийн сонгууль		2020.12.27	
41	Украин	Орон нутгийн сонгууль		2020.10.25	
42	Хойд Кипр	Ерөнхийлөгчийн сонгууль		2020.10.11	Хойшлогдсон 2020.04.26
43	Чили	Ард нийтийн санал асуулга		2020.10.25	2020.04.26
44	Шинэ Зеланд	Бүх нийтийн сонгууль		2020.10.17	2020.09.19
45	Энэтхэг	Орон нутгийн сонгууль	Kamataka, Maharashtra, Rajasthan	2020.10.20	2020 оны 7, 8, 12-р сард

## ДЭЛХИЙН УЛС ОРНУУДАД КОРОНАВИРУСИЙН ЭСРЭГ АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ, ПАРЛАМЕНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ВАКЦИНЫ ТОЙМ МЭДЭЭ

(2020 оны 11 сарын 3-ны байдлаар)

*Д. Амаржаргал (Ph.D), О.Билгүүтэй, Г.Билгээ,  
С.Золжаргал, Ч.Жаргал, Д.Жигваагүнсэл*

### 1. Коронавирусийн эсрэг вакцин гаргах явц

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас 2020 оны 11 сарын 03-ны байдлаар нэгтгэсэн коронавирусийн вакцины талаарх мэдээлэлд<sup>3</sup> нийт 47 боловсруулж буй бүтээгдэхүүний эмнэлзүйн дүгнэлтийг оруулсан байна. Үүнээс 10 нь эмнэлзүйн туршилтын төгсгөлийн шат буюу 3-р шатанд явж байна.

	Вакцин үйлдвэрлэгч	Улс	Вакцины төрөл
1.	Sinovac <sup>4</sup>	Индонез	Идэвхгүйжүүлсэн
2.	Wuhan Institute of Biological Products/Sinopharm <sup>5</sup>	Хятад	Идэвхгүйжүүлсэн
3.	Beijing Institute of Biological Products/Sinopharm <sup>6</sup>	Хятад	Идэвхгүйжүүлсэн
4.	University of Oxford/AstraZeneca <sup>7</sup>	Англи	Сулруулсан вирусийн вектор
5.	CanSino Biological Inc./Beijing Institute of Biotechnology <sup>8</sup>	Хятад	Сулруулсан вирусийн вектор
6.	Gamaleya Research Institute <sup>9</sup>	ОХУ	Сулруулсан вирусийн вектор
7.	Janssen Pharmaceutical Companies <sup>10</sup>	Голланд	Сулруулсан вирусийн вектор
8.	Novavax <sup>11</sup>	АНУ	Цэвэршүүлсэн уураг
9.	Moderna/NIAID <sup>12</sup>	АНУ	РНХ
10.	BioNTech/Fosun Pharma/Pfizer <sup>13</sup>	Герман	РНХ

Аюулгүй, үр дүнтэй КОВИД-19-ийн вакцин хэзээ бэлэн болохыг ДЭМБ тодорхойлж чадахгүй байгаа ч 2021 оны эхний хагас жилд байх магадлалтай хэмээн тооцролж байна. КОВИД-19-ийн вакциныг түгээхэд дараах үе шатыг даван туулах шаардлагатай.<sup>14</sup>

<sup>3</sup> <https://www.who.int/publications/m/item/draft-landscape-of-covid-19-candidate-vaccines>

<sup>4</sup> <https://www.clinicaltrials.gov/ct2/show/NCT04560881?term=vaccine&cond=covid-19&draw=2>

<sup>5</sup> <http://www.chictr.org.cn/showprojen.aspx?proj=62581>

<sup>6</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04560881?term=vaccine&cond=covid-19&draw=2>

<sup>7</sup> <http://www.isrctn.com/ISRCTN89951424>

<sup>8</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04526990?term=vaccine&cond=covid-19&draw=6>

<sup>9</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04564716?term=vaccine&cond=covid-19&draw=3>

<sup>10</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04505722?term=NCT04505722&draw=2&rank=1>

<sup>11</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04611802>

<sup>12</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04470427?term=vaccine&cond=covid-19&draw=5>

<sup>13</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04368728?term=vaccine&cond=covid-19&draw=3>


<sup>14</sup> [https://www.who.int/news-room/q-a-detail/coronavirus-disease-\(covid-19\)-vaccines?gclid=C-jwKCAiAtK79BRAIEiwA4OskBrUhYei3xeq8y7pBxsEeMyU8fyy3RINnB499dGTWjJvTw0Ty-wsMpsRoCJ20QAvD\\_BwE](https://www.who.int/news-room/q-a-detail/coronavirus-disease-(covid-19)-vaccines?gclid=C-jwKCAiAtK79BRAIEiwA4OskBrUhYei3xeq8y7pBxsEeMyU8fyy3RINnB499dGTWjJvTw0Ty-wsMpsRoCJ20QAvD_BwE)

- Бүх үе шатны эмнэлзүйн туршилтаар вакцин нь аюулгүй, үр дүнтэй болох нь батлагдсан байх
- ДЭМБ-аас вакциныг урьдчилсан шалгаруулалтад (prequalification<sup>15</sup>) хамруулахаас өмнө вакцин үйлдвэрлэсэн орны зохицуулалтын хяналт, аюулгүй байдлын нотолгоо шаардлагатай. Энэ үйл явцад вакцины аюулгүй байдлын дэлхийн зөвлөх хороо (Global Advisory Committee on Vaccine Safety) мөн оролцдог.
- ДЭМБ-аас зохион байгуулах SAGE хэмээх олон улсын шинжээчдийн баг эмнэлзүйн туршилтын үр дүн ба бусад нотолгоонд дүн шинжилгээ хийж, вакциныг улс орнуудад зөвлөх эсэх, хэрэглэх аргачлалын талаар зөвлөмж гаргадаг. Харин улс орнууд ДЭМБ-ын энэ зөвлөмжийг үндэслэн өөрийн оронд уг вакциныг хэрхэн ашиглах талаар бодлого боловсруулна.
- Вакциныг их хэмжээгээр үйлдвэрлэсэн байх ёстой бөгөөд энэ нь урьд өмнө гарч байгаагүй томоохон сорилт байх болно. Үүний зэрэгцээ ашиглагдаж байгаа бусад зайлшгүй хийх вакцины үйлдвэрлэлийг зогсоож үл болно.
- Эцсийн шатанд вакциныг хадгалах менежмент, температурыг чанд мөрдөн ложистикийн нарийн төвөгтэй үе шатаар дамжуулан тараах шаардлагатай.

## 2. КОВИД-19 цар тахлын эсрэг дэлхийн улс орнуудын авч буй арга хэмжээ

Коронавирусийн халдварын хоёр дахь давалгаа Европын орнуудад зонхилон тохиолдож байна. Франц ба Англид халдварын тоо 11 сар гарснаас хойш огцом ихэссэн байгаа бөгөөд Солонгос ба Японд харьцангуй тогтмол байна. Өнөөдөр (2020.11.12) Европт шинэ коронавирусийн халдварын тохиолдол 1.6 сая болсон нь Америк, Карибын бүс нутгуудынхаас давж гараад байна.

2020 оны 11 сарын 11-ний байдлаар 1000 хүнд ногдох коронавирусийн улмаас нас барагсдын тоо уг мэдээлэлд сонгосон улсуудад хэрхэн өөрчлөгдөж байгааг доор харуулж байна.



<sup>15</sup> <https://www.who.int/medicines/regulation/prequalification/prequal-vaccines/en/>

## 2.1 КОВИД-19 цар тахлын эсрэг Франц улсын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ<sup>16</sup>

Франц улс нь хэдийгээр эрүүл мэндийн маш сайн тогтолцоотой боловч өнгөрсөн хавар дэлхийн КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн нэгэн том голомт болсон. Гэтэл цар тахлын халдвар авагсдын тоо 11-р сараас дахин өсч эхэлжээ. Франц улс нийгмийн тогтолцооны дээрээсээ доошоо чиглэсэн хяналтын арга хэмжээ авч хэрэгжүүлснээр хямралыг асар хурдацтай саармагжуулж, үхлийн тохиолдлыг бууруулахад зохих үр дүнд хүрсэн байна.

2020 оны 1 дүгээр сард шинэ коронавирус (SARS-CoV-2) дэлхийн нийтийн эрүүл мэндийн онцгой нөхцөл байдал болж тархах үеэс Франц Улс вирусээс урьдчилан сэргийлэх үндсэн арга зам бол хөл хорио тогтоох явдал юм гэдэг байр суурийг тууштай баримталж ирсэн.

Франц дахь КОВИД-19 өвчний тархалтын нөхцөл байдлын талаар “Франц 24 мэдээ” -гээр “Цар тахлын 2 дугаар давалгаа хэдийгээр ард иргэд албан ёсоор амны хаалт зүүж, шинжилгээ өгсөөр байгаа боловч илүү хүнд тусч, хариу арга хэмжээ авахын аргагүй байна”<sup>17</sup> гэжээ. Цар тахлын дэгдэлт, тархалт эрчимтэй байсан өнгөрсөн 3, 4 дүгээр сарын үед Франц улс амны хаалт болон оношлуурын гачигдалтай байлаа. Гэтэл өнөөдөр эдгээрийн аль аль нь хангалттай бөгөөд өвдсөн хүнд үйлчлэх, эмчлэх арга аргачлал илүү сайн болсон байтал одоогийн байдлаар энэ тахлын халдварыг авч, өвчлөгсдийн тоо улам бүр өсч, өнгөрсөн хаврын үзүүлэлттэй адил шахам болоод байна.

Франц улсын ерөнхийлөгч Эммануэль Макрон КОВИД-19-ийн дэгдэлт, тархалтыг бууруулах үүднээс 2020 оны 10 дугаар сарын 30-наас эхлэн Парис болон бусад найман хотод шөнийн цагаар хөл хорио тогтоох зарлиг гаргасан байна. Энэ нь үдшийн 21 цагаас үүрийн 06 цаг хүртэл үйлчлэх ба хөл хориог наанадаж 4 долоо хоног үргэлжлүүлнэ.<sup>18</sup>

Франц улсын КОВИД-19-ийн тархалтын талаарх мэдээ мэдээлэл, зааварчилгааны цахим хуудсанд 2020 оны 11 дүгээр сарын 2-нд тавьсан мэдээллээр:<sup>19</sup> Францын 9 томоохон хотуудад дараах шинэ хорио цээрийн дэглэм тогтоохоор болсон байна. Үүнд дараах нөхцөлүүдэд албан ёсны гэрчилгээтэй тохиолдолд гэрээсээ гарч явж болно:

- Ажил, сургууль, сургалтын төв рүүгээ зорчих, эсхүл хойшлуулшгүй чухал бизнесийн аялал, шалгалт өгөх;
- Ажил мэргэжлийн шаардлагатай хэрэгсэл, ахуйн хэрэгсэл ба захиалга хүлээж авахаар явах;
- Зайнаас хийх боломжгүй бөгөөд яаралтай эмчид үзүүлэх шаардлагатай бол;
- Гэр бүлийн хүндэтгэн үзэх шалтгаантай, өвчтэй, эрсдэлтэй нөхцөлд буй хүнийг асрах, туслах эсхүл хүүхдээ асрах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тэдгээрийг харгалзан авч яваа хүн;

<sup>16</sup> <https://www.iiss.org/publications/strategic-comments/2020/frances-response-to-covid-19>

<sup>17</sup> <https://www.france24.com/en/video/20201111-covid-19-are-protective-measures-having-an-impact-in-france>

<sup>18</sup> <https://www.france24.com/en/video/20201015-coronavirus-in-france-parisians-react-to-macron-s-announcements>

<sup>19</sup> <https://www.gouvernement.fr/en/coronavirus-covid-19>

- Зөвхөн өөрийн гэр бүлийн гишүүдийн хамтаар, эсхүл тэжээвэр амьтантайгаа гэрээсээ 1 км-ээс холгүй, 1 цагаас илүүгүй хугацаагаар явган явах, зайлшгүй гадаа дасгал хийх шаардлагатай;
- Шүүх, захиргаанаас дуудагдсан, төрийн албаны уулзалтанд оролцох;
- Захиргааны байгууллагын хүсэлтээр нийтийн эрх ашгийн үйл хэрэгт оролцох;
- Хүүхдээ сургуульд болон хичээлийн дараах үйл ажиллагаанд нь хүргэх, авах.

*(Гэрчилгээний цахим хувилбарыг ухаалаг утсанд аа хадгалан холбогдох албан тушаалтнуудад үзүүлж, хэрэглэж болно гэж заасан. Зөвхөн франц хэлээр гэж онцолсон байна.)*

Хэрвээ энэ журмыг зөрчвөл €135 еврогоор торгох арга хэмжээ авна.

### **Ажил эрхлэлт**

Хэрвээ боломжтой бол гэрээсээ ажиллахыг зөвлөж байна. Гэрээсээ ажиллах боломжгүй бол ажлын байр болон тээврийн хэрэгсэлд зорчих хүмүүсийн тоог багасгах гэх зэрэг хувилбарын зохицуулалт хийж болно.

### **Сургууль**

Бүх шатны боловсролын байгууллагууд хөл хорионы үеэр хэвийн ажиллана. Гэхдээ 6 -аас дээш насны хүүхэд заавал амны хаалт зүүнэ. Их, дээд сургуулиудын лекцийг видео хурлын хэлбэрээр явуулж, номын санг зөвхөн цаг авч хэрэглэнэ.

### **Үйлчилгээний байгууллага**

Өргөн хэрэглээний биш бүх дэлгүүр хоршоо, бар цэнгээний газар, ресторануудыг хаана. Хүнсний дэлгүүр, супермаркетууд, эмийн сан, тамхины мухлаг, шатахуун түгээгүүр зэрэг өргөн хэрэглээний гол нэрийн барааны дэлгүүрүүд, нийтийн ахуйн үйлчилгээний газрууд нээлттэй байна. Мөргөл залбиралын газрууд зөвхөн хурим (ихдээ 6 хүнтэй), оршуулга (ихдээ 30 хүнтэй) ёслолд нээлттэй ажиллана. Эдгээр нээлттэй ажиллах бүх газруудад амны хаалттай үйлчлүүлнэ. Гадаад улсад зорчихын тулд та 72 цагийн дотор хийлгэсэн PCR тест шинжилгээний сөрөг хариутай гэрчилгээтэй байх ёстой.

### **Аялал жуулчлал**

Европын дотоод хилүүд нээлттэй байх ч гадаад хил онц чухал шаардлагатай л биш бол хаалттай байна. Франц руу ирж буй бүх зорчигчдоос нисэх буудал, боомт дээр шинжилгээ авна. Францын хотуудын хооронд аялахгүй. Нийтийн тээврээр үйлчлүүлэхдээ амны хаалттай зорчино.

### **Парламентын үйл ажиллагаа**

Францын парламентын үйл ажиллагаа цар тахлын үед хуулийн дагуу хэвийн үргэлжилж байгаа бөгөөд сүүлийн үеийн мэдээгээр Онцгой байдлын үеийн эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжих хугацааг сунгах талаар авч хэлэлцсэн байна. Энэ хуулиар КОВИД-19 цар тахалтай холбоотой аливаа хорио цээрийн дэглэмийг 2021 оны 3 сарын 31 хүртэл сунгах боломжийг Засгийн газарт олгожээ.

## **2.2 КОВИД-19 цар тахлын эсрэг ИБУИНХУ-ын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ**

### **КОВИД-19-ийн эсрэг онцлог арга хэмжээ**

ИБУИНХУ-д тахлын дараах давалгаа эхэлсэн тул 2020 оны 11-р сарын 5-ны өдрөөс эхлэн хорио цээрийн шинэ горимд шилжсэн байна.<sup>20</sup> Үүнд:

- Аялал жуулчлалаар явахыг хориглох ба уг журмыг эхэлж зөрчсөн хүнд £200 давтан зөрчсөн хүнд £6,400 хүртэлх торгууль ногдуулна.
- Хязгаарлагдмал шалтгаанаар буюу ажил, сургуульдаа явах, хүнс цуглуулах, эм авах, хуульд заасан үүргээ биелүүлэх, өөрийн хүрээний хүмүүст туслах, эрүүл мэндийн байгууллагад хандахаас өөр зорилгоор гадагш гарахыг хориглоно. Энэ хязгаарлалт 12 сарын 02 хүртэл үргэлжилнэ.

Ерөнхий боловсролын сургуулиуд бүгд ажиллах ба ангиудын эхлэх ба дуусах цагийг зөрүүлэх, цуглаан хийхгүй байх, бие биедээ хүрэлцэх спортоор хичээллэхгүй байх, 11-ээс дээш насны хүүхэд маск зүүх, бүх сурагчдыг гар ариутгагчаар хангах, эцэг эхчүүд хүүхдээ хүргэж өгч, авахдаа хоорондоо бөөгнөрөхгүй, амны хаалт байнга зүүх журмыг гаргасан байна.<sup>21</sup>

### **Парламентын үйл ажиллагаа**

Цар тахлын үеэр парламентын гишүүдийг чуулганд алсаас оролцох боломжийг олгох ба энэ түр зохицуулалтыг 2021 оны 3-р сарын 30 хүртэл хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.<sup>22</sup> Чуулганы танхимд 50 парламентын гишүүдийг орохыг зөвшөөрсөн ба зайлшгүй шаардлагатай ирэх албан тушаалтнуудаас бусад нь гэрээр ажил үүргээ гүйцэтгэж байна.<sup>23</sup>

## **2.3 КОВИД-19 цар тахлын эсрэг Япон улсын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ**

### **Коронагийн эсрэг онцлог арга хэмжээ**

Өнөөдөр буюу 2020/11/12-ны өглөөний 11 цагт Японы Засгийн газрын дэд хороо хуралдаж тодорхой шийдэлд хүрлээ. Энэ 11 сарын эхний хагаст 8 сараас хойш хамгийн их халдвар авсан хүний тоо бүртгэгдсэнийг дурдан ирэх оны 2 сарыг дуустал олныг хамарсан арга хэмжээнүүдийг хязгаарлах болсноо зарлалаа. Эдийн засгийн асуудал эрхэлсэн сайд Нишимура «Энэ халдварын байдал газар авч байгаа нь хямралаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг илүү хүчтэй авах хэрэгтэйг сануулж байна. Засгийн газраас бөөгнөрлийн арга хэмжээнд анхаарлаа хандуулна» хэмээн мэдэгдэж ард түмнээсээ олон нийтийн газар маскаа тайлалгүй, агааржуулалт, ариутгалаа сайн хийхийг хүслээ. Мөн гадаадын иргэдэд ялгаварлан гадуурхалгүй дэмжлэг үзүүлж, олон хэлээр мэдээлэл өгөх талаар холбогдох байгууллагуудад үүрэг өгсөн байна.

### **Вакцин**

Япон улс КОВИД-19-ийн вакцины туршилтыг явуулсаар байна. Осакагийн Их сургууль, Япон улсын тэргүүлэх эм үйлдвэрлэгч Анжес групптэй хамтран бүтээсэн

<sup>20</sup> <https://www.gov.uk/government/news/germany-and-sweden-removed-from-travel-corridor-list-of-exempt-countries>

<sup>21</sup> <https://www.bbc.com/news/education-51643556>

<sup>22</sup> <https://www.parliament.uk/about/how/covid-19-hybrid-proceedings-in-the-house-of-commons/>

<sup>23</sup> <https://www.ipu.org/country-compilation-parliamentary-responses-pandemic>



«AG0301-COVID19» вакцин 6 сарын 30-ны өдрөөс P1/2 туршилтыг явуулж байна. Мөн Shionogi Pharmaceutical нь UMN Pharma групптэй хамтран нийлэгжүүлсэн уургийн вакцин боловсруулж байгаа ба энэ оны сүүлээр клиник туршилтыг эхлүүлж ирэх оны 3 сард 3-р шатанд орно. KM biologics идэвхгүйжүүлсэн вакцины туршилтыг энэ сард эхлэхээр төлөвлөж Дайчи Санкёогийн mPHX вакцин, ID pharma-ын Сэндай нэртэй сулруулсан вирусийн вакциныг ирэх оны 3 сараас тус тус туршихаар төлөвлөж байна.<sup>24</sup>

### **Парламентын үйл ажиллагаа**

10 сарын 26-нд эхэлсэн ээлжит бус чуулган нь 41 хоног үргэлжлэх ба өнөөдрийн байдлаар бүх гишүүд танхимаар хуралдаж байна. Энэ удаагийн ээлжит бус чуулганаар “Шинэ коронавирусийн эсрэг авах арга хэмжээний тусгай хууль»-д нэмэлт өөрчлөлт оруулах талаар хэлэлцэнэ. Энэ нь Японы парламентаас одоогийн үүсээд байгаа нөхцөл байдалд авч буй томоохон арга хэмжээний нэг юм.

### **2.4.КОВИД-19 цар тахлын эсрэг БНСУ-ын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ**

#### **Коронавирусийн халдварын тархалтын эсрэг онцлог арга хэмжээ**

БНСУ нь КОВИД-19 цар тахлын тархалтын үед хамгийн оновчтой түргэн шуурхай шийдвэр гаргасан орнуудын нэг бөгөөд өнөөдрийн байдлаар (2020.11.12) Өмнөд Солонгос улсад нийт 2.749.772 удаа шинжилгээ хийснээс (Tests Performed) КОВИД-19-н батлагдсан тохиолдол 27.942, тусгаарлалтаас гарсан иргэдийн тоо 25.404, тусгаарлалтад байгаа иргэдийн тоо 2051, нас барсан иргэдийн тоо 487 хүрээд байна.<sup>25</sup> БНСУ-ын Засгийн газар КОВИД-19 цар тахлын тархалтын эсрэг тогтвортой урт хугацааны нийгэм, эдийн засагт сөрөг нөлөөгүй, иргэдийн өдөр тутмын амьдрал саад учруулахгүй байх шийдвэрүүд гаргахыг зорилго болгосон байна. Уг зорилгын хүрээнд дараах 3 үндсэн арга хэмжээг авсан:

- Нээлттэй
- Ил тод
- Технологит суурилсан бүтээлч арга хэмжээг хэрэгжүүлсэн.

#### **1. Нээлттэй байдал**

Солонгос улс нь өргөн хүрээний харилцан холбоо бүхий бие биенээсээ хамааралтай эдийн засгаас бүтдэг учир ямар нэг хязгаарлалт, хөл хорио тогтоох нь эдийн засгийн хувьд том эрсдэлтэй шийдвэр хэмээн үзсэн. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар хөл хорио тогтоох нь өвчний тархалтыг түр хугацаанд багасгах шийдвэр мөн боловч нийгэм, эдийн засгийн тогтвортой шийдвэр биш хэмээжээ. Өвчний тархалтыг эрт үед илрүүлэх, халдвар авсан хүмүүсийг хяналтад авч эрт арга хэмжээ авах нь КОВИД-19 цар тахлын тархалтыг багасгах үндсэн арга юм. Мөн Солонгосын Засгийн газраас гадаадаас ирж буй иргэдэд зориулсан нэвтрэх тусгай журмыг гаргасан. Гадаадаас ирсэн иргэдийг урьдчилсан шинжилгээнд хамруулж, биеийн халуун, шинж тэмдгийн шалгалт хийж холбогдох мэдээллийн баазыг бүрдүүлдэг байна. (Эх сурвалж: Пак ХЭ Кюун Халдварт өвчний ерөнхий газар)

<sup>24</sup> answers.ten-navi.com

<sup>25</sup> http://ncov.mohw.go.kr/en

## **2. Ил тод байдал**

Солонгос улсад Тэгү, Тэжон-оос эхлэлтэй КОВИД-19-ийн халдвар огцом өссөн ч хөл хориог урьтал болгоогүй ба түүний оронд Засгийн газар мэдээллийг олон нийтэд ил тод нарийн мэдээлж байсан байна. Гамшгийн болон аюулгүй байдлын эсрэг төвөөс тулгамдаж буй асуудлуудын талаар өдөр бүр онлайн хурлыг олон нийтэд нээлттэй явуулдаг байсан ба Ерөнхий сайд болон 18 яамд, 17 агентлагууд оролдог байна. Засгийн газраас гаргасан шийдвэрүүдийг өдөр бүр тодорхой мэдээлж бусад мэдээллийн хэрэгслүүд болох сонин, сэтгүүл, радиогоор цаг алдалгүй хүргэж байсан байна.

## **3. Технологид суурилсан бүтээлч арга хэмжээ**

КОВИД-19 маш хурдацтай тархаж буйтай холбоотойгоор шийдвэр гаргагчид, яамдууд хоорондоо технологи ашиглан хурдан мэдээлэл солилцож, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлсэн. 2020 оны 2-р сараас Идэвхтэй засаглалын холбоог байгуулж (Proactive governance committee) эрүүл мэндийн салбарынханд түргэн шуурхай чиглэл өгч арга хэмжээ авч байсан ба үүний нэг жишээ нь Солонгос улсад Нэвтрэх тусгай журмыг баталж гар утасны апп бүтээсэн байна. Засгийн газраас хэрэгжүүлж буй стратеги, арга хэмжээг яамдууд болон орон нутгийн удирдлагууд түргэн шуурхай авсан. Үүнд: авто машинтай болон явган зорчигчдын биеийн байдлыг шалгах, анхан шатны тусламжийн газрууд болон утсаар зөвлөгөө өгөх арга хэмжээг түргэн шуурхай өгч байсан. Дээрх 3 арга хэмжээнээс үүдэлтэй шуурхай шинжилгээ, хяналт, эрүүл мэндийн тусламжийг хурдан зөв өгсөнөөр Солонгос улс тархалтыг богино хугацаанд тогтоосон байна.

### **Шуурхай шинжилгээ**

Засгийн газар, Эрүүл мэнд, халамжийн яамд хангалттай хүрэлцэхүйц шинжилгээний багцыг нийлүүлэхээр дотоодын эмийн үйлдвэрүүдэд үүрэг өгч хамтран ажилласны үр дүнд их хэмжээний шинжилгээг түргэн шуурхай гүйцэтгэсэн.

### **Хяналт**

Тархалтыг бууруулахад зориулсан ITC based tracing system буюу мэдээллийн технологид суурилсан мөшгөлтийн систем (The international traveler information)-ийг зохиосон ба тухайн хүнээс эмийн хэрэглээний тойм (Drug utilization review) мэдээллийг авч Халдварт өвчний төвд мэдээлснээр эмнэлэг болон эмийн сангуудад тухайн мэдээлэл очдог байна.

Эрүүл мэндийн тусламж: Нийтийн эрүүл мэндийн төвүүд болон цэргийн эмнэлгүүд КОВИД-19 цар тахлын тархалтын үед бэлэн байдал зарлаж нэмэлт төхөөрөмж, ор хэрэгслүүдийг бэлтгэж ачааллыг тэгш хуваарилсан байна.

### **Парламентын үйл ажиллагаа**

Цар тахлын үед буюу 2020.08.27-нд эрх баригч Ардчилсан намын хурлыг сурвалжилж буй гэрэл зурагчнаас коронавирүс илэрснээс үүдэн парламентын үйл ажиллагааг хааж байсан. Мөн тус улсын нэг танхимтай хууль тогтоох байгууллага болох 300 гишүүнтэй Үндэсний Ассамблейн барилгыг тухайн үед тодорхойгүй хугацаагаар хөл хорио тогтоож байсан. Ерөнхийлөгч, парламентын удирдагч тэргүүтэй Ардчилсан намын арван албан тушаалтан скрининг шинжилгээнд хамрагдаж, өөрсдийгөө тусгаарлахаар болжээ. Энэ нь коронавирусийн улмаас парламентыг хоёр дахь удаагаа хаасан тохиолдол бөгөөд эхнийх нь хоёрдугаар



сард гарсан юм. БНСУ-ын Үндэсний Ассамблей хөл хорионы үеэр цахимаар хуралдааныг зохион байгуулж байсан ба Ерөнхийлөгч, Ассамблейн дарга Ардчилсан намын арван албан тушаалтан скрининг шинжилгээнд хамрагдаж, өөрсдийгөө тусгаарлаж байжээ.

Үндэсний Ассамблей КОВИД-19-ийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан ба (action plan) 8 сард Ассамблейн үйл ажиллагааг албан ёсоор хөл хорионд шилжүүлсэн. Өнөөдрийн байдлаар (2020.11.12) энэ долоо хоногт Үндэсний Ассамблей 2021 оны төсвийг хэлэлцэж танхимаар хэвийн хуралдааныг явуулж байна.<sup>26</sup>

### **КОВИД-19-ийн эсрэг Вакцины нөхцөл байдал**

КОВИД-19-ийн эсрэг вакцин бүтээх өрсөлдөөн дэлхий дахинд өрнөж байгаа ба Солонгос улсын хувьд Genexine, SK Bioscience, Jinwon Life Science зэрэг газрууд вакцин хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж байна. SK Bioscience 10 сарын 7-ны өдөр Эмийн аюулгүй байдлын яамнаас (Ministry of Food and Drug Safety) боловсруулсан КОВИД-19-ийн вакцины 1-р шатны клиник туршилтад хамрагдах өргөдөл гаргажээ.<sup>27</sup> Холбогдох яамнаас зөвшөөрөл авсны дараа энэхүү вакцины хөгжүүлэлтийн ажил цааш үргэлжлэх төлөвтэй байна. SK Bioscience нь дархлааны хариу урвал үүсгэдэг вирусийг сонгон генийн рекомбинацийн технологийг ашиглан нийлэгжүүлсэн уургийн вакцин боловсруулж байна.

## **2.5 КОВИД-19 цар тахлын эсрэг АНУ-ын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ**

### **Коронавирусийн халдварын тархалтын эсрэг онцлог арга хэмжээ**

2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр АНУ-ын Конгрессын баталсан Коронавирусийн тусламж, нөхөн олговор, эдийн засгийн аюулгүй байдлын тухай хууль (Coronavirus Aid, Relief, and Economic Security – CARES Act)-ийн дагуу коронавирсийн цар тахлын улмаас хүнд байдалд орсон жижиг бизнесүүдийг дэмжих зорилгоор 350 тэрбум ам.долларыг баталсан.

Үүний үндсэн дээр тус улсын Жижиг бизнесийн хэрэг эрхлэх газар (Small Business Administration)-аас дараах 4 төрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Цалингийн цэсийг хамгаалах хөтөлбөр (Paycheck Protection Program);
2. Эдийн засгийн хүндрэлтэй, онцгой нөхцөлд олгох урьдчилгаа зээл (Economic Injury Disaster Loan Emergency Advance);
3. Жижиг бизнесийн хэрэг эрхлэх газрын шуурхай гүүрэн зээл (SBA Express Bridge Loans);
4. Жижиг бизнесийн хэрэг эрхлэх газрын зээлийн хөнгөлөлт, чөлөөлөлт (SBA Debt Relief) зэрэг болно.

Нью-Йорк мужийн засаг захиргаанаас 2020 оны 10 дугаар сарын 6-ны өдрөөс нутаг дэвсгэрээ халдварын тархалтаар нь “Бичил кластерийн бүс” (Micro-Cluster Focus Zone)-д хувааж, тухайн бүс бүрт тохирох шинэ кластер арга хэмжээ (cluster action)-г хэрэгжүүлж байна.<sup>28</sup> Нью-Йоркийн Засаг даргын 202/68 дугаар тушаалын дагуу нийгмийн эрүүл мэндийн тэргүүлэх мэргэжилтнүүдтэй хамтран Засгийн газар тус мужийн коронавирсийн тархалтын түвшинг тогтоох, тархалтыг зогсоох талаар нотолгоонд суурилсан арга хэмжээг боловсруулсан хэмээн үзэж байна.

<sup>26</sup> <https://www.assembly.go.kr/assm/userMain/main.do>

<sup>27</sup> <https://www.donga.com/news/Economy/article/all/20201016/10344933>

<sup>28</sup> [https://z5h64q92x9.net/proxy\\_u/en-ru/en/https/forward.ny.gov/cluster-action-initiative](https://z5h64q92x9.net/proxy_u/en-ru/en/https/forward.ny.gov/cluster-action-initiative)

Үүнд коронавирусийн халдвар хамгийн их тархсан нутаг дэвсгэрийг хамарсан шинэ журам, хязгаарлалтыг багтаасан байна. Энэхүү шинэ журмыг 14-өөс доошгүй хоног хэрэгжүүлнэ.

Тодорхой үйл ажиллагааг хязгаарлаж, доор дурдсан 3 бүсэд зөвшөөрөгдсөн аливаа үйл ажиллагааг Эрүүл мэндийн газрын удирдамжийн дагуу явуулж байна. Үүнд:

- улаан бүс – коронавирусийн тархалт өндөртэй бүс;
- улбар шар өнгийн бүс – анхааруулах бүс;
- шар бүс – урьдчилан сэргийлэх бүс юм.

Энэхүү санаачилга нь дараах гурван үе шатаас бүрдэнэ. Үүнд:

- 1) бүс доторх аливаа харилцааны үйл ажиллагааг багасгах;
- 2) тархалтыг зогсоохын тулд бүсийн ойролцоо арга хэмжээ авах;
- 3) алслагдсан орон нутагт урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

Нийтийг хамарсан зарим үйл ажиллагааг кластер буюу бүс тус бүрээр дараах байдлаар хязгаарласан байна:

Үйл ажиллагааны төрөл	Улаан	Улбар шар	Шар
<b>Шаардлагагүй уулзалт</b>	Хориотой	Барилгын дотор болон гадаа 10-аас илүүгүй хүн	Барилгын дотор болон гадаа 25-аас илүүгүй хүн
<b>Сүм, хийд</b>	Багтаамжийн 25%, эсвэл 10 хүн	Багтаамжийн 33%, эсвэл 25 хүн	Багтаамжийн 50%
<b>Үйлчилгээ</b>	Шаардлагагүй аж ахуйн нэгжүүд ажиллахгүй.	Зарим эрсдэлтэй, зайлшгүй шаардлагатай бус үйлчилгээ (жишээлбэл, биеийн тамирын заал, фитнес төв, үсчин, хувийн асрамжийн үйлчилгээ)-г ажиллахгүй.	Ажиллана
<b>Хоолны үйлчилгээ</b>	Зөвхөн хүргэлтээр	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаа үйлчлүүлэх;</li> <li>- Хүргэлтээр;</li> <li>- Нэг ширээнд хамгийн ихдээ 4 хүн үйлчлүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Барилгын дотор болон гадаа үйлчлүүлэх;</li> <li>- Нэг ширээнд хамгийн ихдээ 4 хүн үйлчлүүлэх;</li> <li>- Бар, ресторанууд шөнийн 00 цаг хүртэл ажиллах.</li> </ul>
<b>Сургууль</b>	Хаалттай* Зөвхөн зайны сургалт	Хаалттай* Зөвхөн зайны сургалт	Нээлттэй Өдрийн ангийн оюутан, багш нарын танхимын сургалт нь 7 хоногийн хөтөлбөрийн 20%

### Конгрессын үйл ажиллагаа

Төлөөлөгчдийн танхимын Санхүүгийн үйлчилгээний хороо (Committee on Financial Services)-ноос 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр “Зөвлөх зохицуулагч нарт

хяналт тавих: Цар тахлын үед асран хамгаалах байгууллагуудын аюулгүй, найдвартай байдал, бусад асуудал, тэдгээрийн хариуцлагыг тогтворжуулах” сэдвээр цахим сонсголыг хийсэн байна.<sup>29</sup>

КОВИД-19 цар тахалтай холбоотой дараах хууль тогтоомжуудыг хэлэлцэж байна.<sup>30</sup> Үүнд:

- Коронавирусийн эмчилгээг дэмжих тухай хуулийн төсөл (US S4800 - A bill to provide Coronavirus relief);
- Нийгмийн хамгааллын тухай хуулийн XVIII хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл:
  - Коронавирусийн цар тахлын улмаас нийгмийн эрүүл мэндийн салбарын онцгой байдал үүссэнтэй холбогдуулан “Medicare” хөтөлбөрийн хүрээнд теле-эмчилгээний уян хатан байдлыг тогтмолжуулах тухай нэмэлт, өөрчлөлт (US HR8727 - To amend title XVIII of the Social Security Act);
  - Коронавирусийн цар тахлын улмаас “Medicare” хөтөлбөрийн зарим үйлчилгээний тэтгэмжийг нэмэгдүүлэх тухай нэмэлт, өөрчлөлт (US HR8702 - To amend title XVIII of the Social Security Act);
- Коронавирусийг устгах, цаашид цар тахлын эсрэг авах хариу арга хэмжээний бэлтгэлийг хангахтай холбоотой Холбооны үүргийг нэмэгдүүлэх болон бусад арга хэмжээний тухай (US HR14 - To increase the Federal commitment to defeating the virus that causes COVID-19 and prepare for future pandemics, and for other purposes);
- КОВИД-19 цар тахалд хамгийн их өртсөн орон нутгийн боловсролын салбар дахь ажлын байрыг хадгалах, шинээр бий болгох зорилгоор Боловсролын ажлын байрны сан байгуулах (US HR8691 - To authorize the establishment of an Education Jobs Fund to retain and create education jobs in communities most impacted by COVID-19);
- Асрамжийн газруудыг цар тахлаас хамгаалах тухай хуулийн төсөл (US S4846 - Nursing Home Pandemic Protection Act):
  - КОВИД-19-ийн дэгдэлттэй тэмцэх зорилгоор эрүүл мэндийн мэргэшсэн байгууллагууд, сувилахуй болон туслах байгууллагуудад тавигдах шаардлагыг тогтоох;
- Гэр бүлийн хүчирхийллийг таниулах үндэсний сарын зорилго, зорилтыг дэмжих тухай тогтоол (US SRes753 - A resolution supporting the goals and ideals of National Domestic Violence Awareness Month);
- Ахмад настнуудад КОВИД-19-ийн эсрэг вакцины хүртээмжийг хангах тухай хуулийн төсөл (US S4825 - Ensuring Access to COVID-19 Vaccines for Seniors Act):
  - “Medicare” хөтөлбөрийн хүрээнд КОВИД-19-ийн вакцины хамрах хүрээг тодорхой болгох;
- КОВИД-19 цар тахалд өртсөн болон бусад зорилгоор жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих тухай хуулийн төсөл (US S4818 - A bill to provide assistance to small businesses affected by COVID-19, and for other purposes).

<sup>29</sup> <https://www.house.gov/>

<sup>30</sup> [https://ballotpedia.org/State\\_laws\\_in\\_response\\_to\\_the\\_coronavirus\\_\(COVID-19\)\\_pandemic,\\_2020](https://ballotpedia.org/State_laws_in_response_to_the_coronavirus_(COVID-19)_pandemic,_2020)

## 2.6. КОВИД-19 цар тахлын эсрэг ОХУ-ын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

ОХУ-д 11 сарын 12-ны байдлаар 21608 хүн нэмж халдварлан нийт халдварласан хүний тоо 1.836 сая гарсан байна. Харин коронавирусийн халдвараас болж нас барагсдын тоо энэ өдөрт 439-р нэмэгдэн 31593 болсон байна. Тахал эхэлснээс хойш нийт 1.36 сая гаруй хүн эдгэрчээ.

### КОВИД-19 цар тахлын тархалтын эсрэг онцлог арга хэмжээ

Орос улс коронавирусийн цар тахлын улмаас гарч буй бэрхшээлийг даван туулахад технологийн хүчин чадлын хувьд бэлэн байдалтай байсан гэж Ерөнхийлөгч Владимир Путин онцолсон байна. Ялангуяа ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудад зайны сургалтыг амжилттай зохион байгуулж чадсан гэж үзэж байна.

“ОХУ-ын эрх баригчид хатуу чанга хориг тавихын оронд хувь хүний хариуцлагад илүү итгэл тавьж байна. Халдварын тоо нэмэгдэж байгаа ч тогтолцооны хувьд бүрэн дүүрэн ажиллаж байна» гэж Кремлийн хэвлэлийн төлөөлөгч Дмитрий Песков энэ долоо хоногт тэмдэглэсэн байна.<sup>31</sup>

ОХУ нь КОВИД-19-ийн тархалттай тэмцэх олон арга хэмжээг орон даяар авч байна. Үүнд:

- 10-р сарын 28-ны Лхагва гарагаас эхлэн хүн ам ихтэй газар, түүнчлэн нийтийн тээврийн хэрэгсэл, такси, зогсоол, цахилгаан шатанд явахдаа заавал амны хаалт зүүх;
- Эрсдэл өндөртэй бүлгийнхэн болох 65-аас дээш насны болон архаг өвчтэй хүмүүсийг тусгайлан хамгаалах арга хэмжээ авах;
- Нийтийн хоолны үйлчилгээ эрхлэхгүй байх, 23.00-6.00 цаг хүртэл зугаа цэнгэлийн үйл ажиллагаа явуулахгүй байх;
- Нийтийн тээвэр, худалдааны байгууламж, кафе, ресторан гэх мэт олон нийтийн газарт ариутгалын дэглэмийг чангатгах.

Мөн Засгийн газар коронавирусийн цар тахлын гамшигт хамгийн их нэрвэгдсэн аж үйлдвэр эрхлэгчдийн татварын хөнгөлөлтийг гурван сараар сунгасан байна.<sup>32</sup>

### Вакцин

Москва хотын Эпидемиологи, микробиологийн үндэсний төвд бүтээсэн Sputnik V вакцин одоогоор клиник туршилтын 3-р үе шатанд явж байна. Одоогийн байдлаар аюулгүй байдлын талаар ямар нэгэн асуудал гараагүй байгаа бөгөөд сайн дурын клиникийн туршилтад оролцогчдод хоёр тарилгын эхний тарилга хийснээс хойш 21 хоногийн дараа гаж нөлөө илрээгүй байна.

<sup>31</sup> <https://www.dw.com/en/coronavirus-russia-restrictions-pandemic-lockdown/a-55301714>

<sup>32</sup> [https://www.gazeta.ru/social/news/2020/10/27/n\\_15137581.shtml](https://www.gazeta.ru/social/news/2020/10/27/n_15137581.shtml)

## ХӨЛ ХОРИО ТОГТООСОН ҮЕД УЛС ОРНУУДЫН ПАРЛАМЕНТУУД ХЭРХЭН АЖИЛЛАЖ БАЙГАА ТАЛААРХ ТОЙМ<sup>33</sup>

(2020 оны 11-р сарын 15-ны байдлаар)

*Д.Халиун, Г.Билгээ*

### Финланд

**Нөхцөл байдал:**<sup>34</sup> Нийт халдвар авсан хүний тоо 19,102, эдгэрсэн 14,000, нас барсан 369 байна.

Сүүлийн саруудад халдварын тоо эрс нэмэгдсэнтэй холбоотойгоор Финландын Засгийн газраас холбогдох арга хэмжээ авч эхлээд байна. Ингэхдээ улс даяар бүх нийтийн хөл хорио тогтоох бус, халдвар ихээр тархаж бүс нутгуудад хязгаарлалтын арга хэмжээг чангатгах стратегийг баримтлан ажиллаж байна.

Финландын Засгийн газраас 2020.10.15-нд<sup>35</sup> коронавирусийн халдвар тархахаас сэргийлж холбогдох зөвлөмжүүдийг гаргасан байна. /Зөвлөмжүүдийг 2020.12.31-нд шинэчилнэ./

Үүнд, улсын хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтнуудыг зайнаас ажиллахыг зөвлөсөн.

Бүс нутгийн хувьд халдварын хэмжээ, өсөлт, тархаж буй хурд зэргээс хамаарах үе шат бүрд зориулсан зөвлөмжийг боловсруулсан байна.

- Халдварын хэмжээ хэвийн байгаа бүс нутгууд: 50 дээш хүн оролцож буй арга хэмжээг зохион байгуулахдаа холбогдох байгууллагуудаас боловсруулсан эрүүл ахуйн заавар зөвлөмжийг дагаж мөрдөх, олон нийтийн газар хүмүүс хоорондоо зай барих дэглэмийг баримтлах;
- Халдварын хэмжээ хурдацтай тархаж буй бүс нутагт 20-иос дээш хүн цугларсан хувийн арга хэмжээ зохион байгуулахгүй байх. Их дээд сургуулиудыг зайн сургалтын горимд шилжүүлэх;
- Халдвар ихээр тарсан бүс нутагт 10-аас дээш хүн цугларсан хувийн арга хэмжээ зохион байгуулахгүй байх. Шаардлагатай бол олон нийтийг арга хэмжээг цуцлах. ЕБ-ын сургуулиудын ахлах ангийг зайн сургалтын горимд шилжүүлэх зэрэг орж байна.

<sup>33</sup> Хамтын нөхөрлөлийн парламентын холбооноос Парламентуудад коронавирусийн цар тахлын үед хэрхэн ажиллах талаар гаргасан зөвлөмжөөс <http://www.cpahq.org/cpahq/cpadocs/CPA%20toolkit%20Covid-19%20Coronavirus%20e-version.pdf>

...Хөл хорио тогтоосон үед Парламентын гишүүдийн төлөөллийн чиг үүргээ биелүүлэх нь ихээхэн хүндрэлтэй байх боловч сонгогч нартайгаа холбоотой байх нь иргэдэд сэтгэл санааны дэмжлэг болоход ихээхэн ач холбогдолтой талаар дурдсан байна. Гишүүд шуудан, эсхүл и-мэйлээр дамжуулан иргэдтэйгээ харьцаж, тэдэнд хүрч амжаагүй байгаа мэдээ, мэдээлэл, нийтийн эрүүл мэндийн зөвлөгөө зэргийг дамжуулах нь чухал гэжээ.

<sup>34</sup> <https://www.worldometers.info/coronavirus/country/finland/>

<sup>35</sup> <https://valtioneuvosto.fi/en/-/10616/government-agrees-on-national-and-regional-recommendations-to-prevent-spread-of-covid-19-epidemic>

**Финландын Парламентын хувьд**<sup>36</sup> парламентын хуралдаанд оролцох үед хоорондын зай барих дэглэмийг нэвтрүүлсэн. Гишүүд парламентын үйл ажиллагаанд зайнаас оролцох боломжтой ч санал өгөх боломжгүй байна. Байнгын хороодын хуралдаанаар гагцхүү зайлшгүй шаардлагатай асуудлыг хэлэлцэх бөгөөд хуралдааны тоог цөөлсөн байна.

Парламентын гишүүд ажлын байрандаа ажиллах боломжтой ч нийтийн тээврээр зорчихгүй байхыг зөвлөсөн байна. Уусима /нийслэл Хельсинки бүхий/ бүс нутагт хөл хорио тогтоосон нь гишүүд тойрогтоо очиж ажиллахыг хязгаарлаагүй байна.

### **ХБНГУ**

**Нөхцөл байдал:**<sup>37</sup> Нийт халдвар авсан хүний тоо 788,899, эдгэрсэн 493,200, нас барсан 12,619 байна.

Герман Улсын хувьд коронавирусийн халдварын тоо сүүлийн саруудад эрс нэмэгдэж 24 цагийн дотор халдварын 16700 тохиолдол бүртгэгдэж, 75%-д нь хавьтагч нарыг тодорхойлох боломжгүй байдалд хүрсэн байна.

Энэ нөхцөл байдалд Герман Улсын Засгийн газраас хэсэгчилсэн хөл хориог 2020 оны 11 дүгээр сарын 2- 30-ныг дуустал тогтоохоор шийдвэрлээд байна.<sup>38</sup>

Ингэхдээ сургууль, өдөр өнжүүлэх төвүүд, сүм хийд, хүнсний дэлгүүр, үсчин зэрэг хэвийн ажиллах бол кино театр, бялдаржуулах төв, усан сан, бар, ресторан /хүргэлтийн хоолноос бусад/ зэргийн үйл ажиллагааг хориглосон байна.

**Германы Бундестагийн хувьд**<sup>39</sup> 2020.11.09-өөс эхлэн 2021.01.17-ныг дуустал амны хаалт зүүх дэглэмийг нэвтрүүлсэн байна. Амны хаалтыг Парламентын барилгын хонгил, цахилгаан шат зэрэг бүхий л хэсэгт зүүх ёстой ба зөвхөн бусдаас 1,5м зайд суусан тохиолдолд, эсхүл хуралдааны танхим суухдаа, хуралдааныг даргалахдаа амны хаалтаа авч болох юм. Дэглэмийг зөрчигчид 5000 хүртэлх еврогийн торгууль ногдуулах бол удаа дараа зөрчсөн этгээдийн байгууламжид нэвтрэх эрхийг хасах юм.

Парламентын хуралдааны дэгийн хувьд 2020.03.25-аас 2020.09.30-ны хороонд түр хугацаатай үйлчлэх өөрчлөлт оруулж, нэгдсэн болон байнгын хорооны хуралдааныг хүчинтэйд тооцох ирцийг гишүүдийн 25% болгож бууруулсан. Байнгын хороодын хувьд зайнаас оролцох боломжийг бүрдүүлсэн. Нийтийн сонсгол, хороодын үйл ажиллагаанд иргэдийн оролцох оролцоог цахимаар хангах зэрэг горимуудыг нэвтрүүлсэн.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>36</sup> Олон улсын парламентын холбоо, Улс орнуудын парламентуудын коронавирусийн цар тахлын эсрэг хариу арга хэмжээний талаарх тойм  
<https://www.ipu.org/country-compilation-parliamentary-responses-pandemic>

<sup>37</sup> <https://www.worldometers.info/coronavirus/country/germany/>

<sup>38</sup> <https://www.dw.com/en/coronavirus-angela-merkel-defends-lockdown-warns-of-difficult-winter-in-germany/a-55430787>

<sup>39</sup> <https://www.thelocal.de/20201006/masks-made-compulsory-in-german-bundestag-amid-rise-in-berlin-covid-19-cases>



## **ИХ БРИТАНИ**

**Нөхцөл байдал:** Нийт халдвар авсан хүний тоо 1,344,356, эдгэрсэн -, нас барсан 51,766. /2020.11.15/<sup>40</sup>

**Их Британийн Парламентын хувьд**<sup>41</sup> коронавирусийн халдвар тархсан үеэс эхлэн Парламентын үйл ажиллагаатай холбоотой тодорхой арга хэмжээ хэрэгжүүлж ирсэн. 2020.10.22-нд гаргасан шийдвэрийн дагуу 2021 оны 3 дугаар сарын 30-ныг дуустал гишүүд танхимдаа биечлэн хүрэлцэн ирж эрүүл ахуйн шаардлага, зөвлөмж, горимыг дагаж мөрдөн Парламентын үйл ажиллагаанд оролцох юм. Ингэхдээ зөвхөн эрүүл мэндийн шалтгаанаар оролцох боломжгүй, эсхүл коронавирусийн цар тахалтай холбоотойгоор нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гишүүд парламентын үйл ажиллагаанд зайнаас оролцох боломжтой юм.

## **ЕВРОПАРЛАМЕНТ**<sup>42</sup>

**Нөхцөл байдал:**<sup>43</sup> Европод нийт халдвар авсан хүний тоо 13,794,640 (+67,252), эдгэрсэн 5,123,229, нас барсан 320,482 (+1,055) <sup>44</sup> байна.

Европарламентад 10 дугаар сарын сүүлээр Европын Холбооны Парламент (Европарламент)-ын гишүүд болон ажилтнуудын дунд шинэ КОВИД-19-ийн 171 тохиолдол бүртгэгдсэн байна. Тэдний ихэнх нь шинж тэмдэггүй тохиолдлууд байв.

Европарламент нь 705 гишүүнтэй бөгөөд тэнд 4000 орчим туслах, 7500 орчим ажилтнууд ажилладаг байна.

**Европарламент:** Цар тахлын улмаас Европарламентын хуралдаан, уулзалтуудыг хязгаарласан бөгөөд Европарламентын гишүүд, түүний Ажлын албаны ажилтнууд хатуу тусгаарлалтад гэрээсээ ажиллаж байна.

Ийнхүү Европарламент зайнаас ажиллахдаа үндсэн чиг үүргийнхээ дагуу хүрээнд хууль батлах, Европын Холбоо (ЕХ)-ны төсвийг батлах, Европын Комисст хяналт тавих ажлаа үргэлжлүүлэн хийж байна. Европарламентын хорооны болон нэгдсэн хуралдаанаар КОВИД-19-ийн эсрэг хариу арга хэмжээ авах болон Ногоон хэлэлцээр (Green Deal), дижитал үйлчилгээ, ЕХ-ны орнуудын хөдөө аж ахуйн бодлого, урт хугацааны төсөв, Брексит (Brexit) зэрэг урт хугацааны тэргүүлэх чиглэлийн талаар хэлэлцэж байна.

Европарламентын Ерөнхийлөгч Дэвид Сассоли 2020 оны 3 дугаар сард түүхэндээ анх удаа зайнаас санал хураалт явуулах Европарламентын чуулганыг нээхдээ “Ийм огцом хямралын үед ардчиллыг түр зогсоох ёсгүй. Хууль тогтоогчдын хувьд бидэнд туслах арга хэрэгсэл, чадвар, үүрэг хариуцлага байна” хэмээн хэлжээ.

<sup>40</sup> <https://www.worldometers.info/coronavirus/country/uk/>

<sup>41</sup> <https://www.parliament.uk/about/how/covid-19-hybrid-proceedings-in-the-house-of-commons/>

<sup>42</sup> <https://www.europarl.europa.eu/news/en/headlines/priorities/eu-response-to-coronavirus/20200408STO76807/how-parliament-works-during-a-pandemic>. EU affairs, Updated: 27-10-2020 - 22:17.

<sup>43</sup> <https://www.bbc.com/news/topics/cygp15jgmd5t/european-parliament> . Posted at 19:27 12 Nov.

<sup>44</sup> [https://www.worldometers.info/coronavirus/?utm\\_campaign=homeAdvegas1?%22%20%5C%20%22countries](https://www.worldometers.info/coronavirus/?utm_campaign=homeAdvegas1?%22%20%5C%20%22countries)

Европарламент нь аюулгүй бөгөөд үр ашигтай алсын системийг боловсруулан 3 дугаар сарын сүүлээр явуулсан **нэгдсэн хуралдаандаа** ашигласан байна. Энэ үеэр нэг хэлэлцүүлэг (debate), санал хураалттай 3 хуралдаан (voting sessions), 11 санал хураалт (votes) явуулсан байна. Харин 10 дугаар сарын 19-23-ны өдрийн нэгдсэн хуралдааны үеэр 18 хэлэлцүүлэг, санал хураалттай 13 хуралдаан, 1500 гаруй санал хураалт явуулжээ. Одоо Европарламентын гишүүд нийт Европын Холбооны нутаг дэвсгэрт холбоо барих газруудаасаа нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт оролцох боломжтой болсон.

Европарламентын **Хороодын хуралдаан** нөхцөл байдалд зохицуулан видео-хуралдаан, эсхүл хосолсон (hybrid) хэлбэрээр зохион байгуулж байгаа бөгөөд Хороодын санал хураалт үргэлжилж байна.

Парламентуудын улс төрийн 7 бүлэг болон Ерөнхийлөгч нарын Бага хурал (Conference of Presidents) зэрэг удирдах байгууллагууд мөн зайнаас ажлаа үргэлжлүүлж байна.





**КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ПАРЛАМЕНТУУД  
ХАЛДВАР-ХАМГААЛЛЫН ДЭГЛЭМИЙГ БАРИМТЛАН  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ТУРШЛАГА**

(2020 оны 11-р сарын 17-ны байдлаар)

*Д.Халиун, Г.Билгээ, Р.Нургүл, О.Билгүүтэй,  
Д.Уянга, Г.Уянга, С.Золжаргал, Р.Оргилмаа,  
Б.Батцэцэг, Ж.Үүрцайх, Б.Долгормаа,  
Д.Жигваагүнсэл, Ц.Ариунаа, Э.Анужин,  
Ч.Жаргал, О.Нарантуяа*

2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас коронавирусийн халдварын тархалтыг цар тахал гэж зарласан цагаас хойш дэлхийн улс орнуудын парламентууд халдварын тархалтад суурилсан тусгаарлалтын шаардлага болон хөрөнгө санхүү, техникийн хүчин чадал зэрэг бодит нөөц боломжиндоо тааруулан тасралтгүй хэвийн үйл ажиллагаа явуулж, цар тахалтай холбоотой улс оронд үүссэн тулгамдсан асуудлуудыг шуурхай шийдвэрлэхээс гадна парламентын ээлжит чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлуудаа ч мөн саадгүй хэлэлцэн шийдвэрлэхийн төлөө ажиллаж байна.

Цар тахлын үед дэлхийн бусад орнуудын парламентын ажиллаж байгаа туршлагуудыг нэгтгэн дүгнэж үзвэл:

- Халдвар хамгаалал-эрүүл ахуйн нийтээр дагаж мөрдөх журам, зааварчилгыг дагаж мөрдөхтэй холбоотой онцгой нөхцөл байдал үүссэн, цаашид хэр хугацаанд, хэрхэн үргэлжлэх нь тодорхойгүй байгаагаас шалтгаалан дэлхийн ихэнх орны парламентууд цахим хуралдааны системийг хөгжүүлж, инновацийн шинэлэг шийдлүүдийг эрэлхийлж байна. Тухайлбал, Бразилийн парламент System of Remote Deliberation (SRD) болон парламентын хуралдааны тусгайлсан аппликейшн хөгжүүлж байгаа бол БНСУ-ын Үндэсний Ассамблей мэдээллийн технологийн их, дээд сургуулийн профессорын багт захиалга өгөн хиймэл оюун ухаант технологи (AI) хөгжүүлж байх жишээтэй. Судалгаанаас үзэхэд, дэлхийн бусад орнуудын парламентууд урт хугацаандаа парламентын цахим хуралдааны программ хангамжийг хөгжүүлж, Парламентын дэгийн тухай хууль болон холбогдох бусад хуулиудад цахим хуралдааны дэгийн өөрчлөлтийг оруулах замаар эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа байдал ажиглагдаж байна. Хуралдааны цахим системд чуулган, Байнгын хороодын хуралдааны дэгийн дагуу хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах бүх процедур, мэдээлэл лавлагаа, зөвлөх үйлчилгээний системийг холбох шаардлагатай тул ажлын даалгаврыг гаргахтай сайтар анхаарах шаардлагатай.
- Бусад орны парламентууд одоо байгаа нөхцөл байдал, техникийн боломж, суурилагдсан хүчин чадалдаа тулгуурлан боломжтой бүх хэлбэрээр цахим хуралдааныг зохион байгуулсаар байна. Цахим хэлэлцүүлгийг илүү үр ашигтай болгох, хаалттай хэлэлцүүлэг, санал хураалтын горимууд зэрэг тусгайлсан горимыг сайжруулах шаардлага гарч, улс орон бүр өөр өөрийнхөөрөө асуудлаа шийдсэн байна. Цахим хуралдаанаас гадна бусад орны парламентууд шаардлагатай тохиолдолд танхимын хуралдааныг зохион байгуулж байна. Жишээ нь, ОХУ-ын Төрийн Думын өнөөдрийн 2020.11.17-ны хуваарийг харахад БХ-ны хуралдаан 1 удаа, Нэгдсэн чуулган

1 удаа, Мөрдөн шалгах тусгай комиссын хуралдаан 1 удаа тус тус танхимаар хуралдахаар товлогдсон байна. Энэ тохиолдолд хамгийн гол нь халдвар хамгааллын дэглэм сахих асуудал чухал. Судалгаанаас үзэхэд танхимын хуралдааны үед шаардагдах хамгаалалтын хэрэгслээр хангах, хүний тоо хязгаарлах, суудал хоорондын зай барих, танхим болон танхимын доторх техник эд хэрэгслийг ариутгах, агааржуулалт санитаци хийх зэрэг арга хэмжээнүүдийг зааврын дагуу авч байна.

- Цар тахлын үед парламентын үйл ажиллагааг хэвийн явуулах асуудал хэдий чухал боловч тархалтын байдлаас үүдэн хөл хорио тогтоосон, Тамгын газрын ажилтнууд зайнаас ажиллаж байгаа энэ цаг үед хамгийн гол нь цаг үеийн асуудлаар парламентаар үндэслэл бүхий шийдвэр гаргаж бодлого, эрх зүйн орчныг шуурхай бүрдүүлэх, Засгийн газар болон УОК-ын үйл ажиллагаанд хяналт тавьж засаглалын тэнцвэрт байдлыг хангах, төрийн эрх барих дээд эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах нөхцөлийг бүрдүүлэх, онлайн горимд бүрэн мэдээлэлтэй, шуурхай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах нь зүйтэй байна. Бусад орнуудын туршлагаас үзэхэд КОВИД-19 цар тахалтай холбоотой тусгайлсан мэдээллийн сан үүсгэн портал сайт ажиллуулж байгаа нь байгууллага хоорондын уялдаа холбоог хангах, иргэдийг мэдээллээр хангахад их чухал үүрэгтэй байна. Энэхүү портал сайт нь УИХ, Засгийн газар, УОК болон холбогдох байгууллагуудаас гаргасан бүх хууль, бодлогын шийдвэр, заавар зөвлөмж, дүрэм журам болон өвчний тархалтын мэдээ, эдийн засаг, иргэдийн нийгмийн асуудлыг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх бүх мэдээллийг төрөлжүүлэн байршуулсан эрх зүйн мэдээллийн сан хэлбэртэй байна. Ийм портал сайтыг ажиллуулах нь иргэдийг мэдээллээр хангах, хууль тогтоох байгууллага-гүйцэтгэх засаглалын байгууллагын мэдээллийн нэг урсгалыг бий болгоход ихээхэн ач холбогдолтой байна. Жишээ нь, <http://www.garant.ru/>
- Танхимаар хуралдаж байгаа зарим улсууд (Энэтхэг, Солонгос, Грек) хүн хооронд тусгаарлагч тунгалаг хаалтуудыг хэрэглэж, танхимд масктай байх, хүн хоорондын зайг барихыг шаардаж байна.

Зураг 1: Грекийн парламент



Зураг 2: Грекийн парламент



Зураг 3: Солонгосын Үндэсний Ассамблейн хуралдаан






Зураг 4: Энэтхэгийн Лок сабха хуралдаан



Зураг 5: Энэтхэгийн Лок сабха хуралдаан



Зураг 6: Германы Бундестаг



Зураг 7: Австралийн парламент





Зураг 8: Австралийн парламент



Зураг 9: Латвийн парламентын хуралдаан



*Цар тахлын үед бусад орнуудын парламент халдвар хамгаалал, ариун цэврийн дэглэмийг сахин хэрхэн хуралдаж байгаа талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх судалгаанаас үзнэ үү.*

## ПОЛЬШ УЛС

**Нөхцөл байдал:** Нийт халдвар авсан хүний тоо 733,788 (+20,816), эдгэрсэн 306,022, нас барсан 10,491 (+143). /2020.11.16/<sup>45</sup>

Польш Улсын хувьд коронавирусын цар тахлын нэгдүгээр давалгааг харьцангуй амжилттай давсан хэдий ч хоёрдугаар давалгаа буюу 2020 оны 10 дугаар сараас эхлэн халдвар авагсдын тоо огцом өсч, өвчлөгчдийн тоогоор Европод 4-т орж байна. Үүнээс гадна төрийн өндөрлөгүүд, Ерөнхийлөгч Анджей Дуда 2020.10.23-нд коронавирусын халдвар авсан нь тогтоогдсон. Ерөнхий сайд Матеуш Моравецки коронавирусын халдвар авсан иргэнтэй уулзсан нь тогтоогдож 2020.10.14-нд өөрийгөө тусгаарласан байна.

### Халдвар хамгааллын нийтлэг журам<sup>46</sup>

Хоорондын зай: Олон нийтийн газар доод тал нь 1,5м зай барих. (Үүнд: 13-аас доош насны хүүхэдтэй эцэг эх, хамт амьдарч буй иргэд, бие даан хөдлөх боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэд орохгүй.)

Амны хаалт: Олон нийтийн газар, нийтийн үйлчилгээний газар амны хаалт зүүх. (цэцэрлэгт хүрээлэн, ой, хувийн авто тээврийн хэрэгслээр зорчиход амны хаалт зүүхгүй байж болно.)

2020.11.29-ныг хүртэл бүх соёлын арга хэмжээг цуцалсан. Театр, музей, кино театр, уран зургийн галерей, соёлын төвүүдийн үйл ажиллагааг зогсоосон. Үзэсгэлэн, хурал, чуулган зэрэг зөвхөн видео буюу онлайн хэлбэрээр зохион байгуулахыг зөвшөөрсөн.

Нийтийн тээвэр: нийтийн тээврээр нэгэн зэрэг зорчих зорчигчийн тоо тухайн суудлын багтаамжийн 50%-иас хэтрэхгүй байх.

Сүм хийд: нэг хүнд ногдох талбай 15м<sup>2</sup>-аас доошгүй байх, 1,5м хоорондын зай барих, амны хаалт хэрэглэх.

Бүх шатны боловсролын байгууллага: Үүнд бага, дунд, ахлах сургууль, их дээд сургууль, мэргэжлийн сургалтын төвүүд зайнаас ажиллах горимд шилжсэн бол ясли, цэцэрлэгүүд хэвийн ажиллаж байна.

Олон улсын нислэг: 2020.11.24-ныг хүртэл Босни-Герцеговин, Монтенегро, Гүрж, Йордан, Аргентин, Армен, Коста Рика, Хойд Македон, АНУ /Иллиной, Нью Йорк мужаас бусад/ зэрэг 10 улсын нутаг дэвсгэрт байрлах нисэх онгоцны буудлаас нислэг үйлдэхийг хориглосон.

Худалдаа, үйлчилгээ: Худалдааны төв, дэлгүүр, үсчин, гоо сайхан, шивээс зэрэг үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд ажиллаж байна. Ингэхдээ холбогдох халдвар хамгааллын дэглэмийг сахих юм.

Хоолны газар: Хүргэлтээс бусад хоолны газрын үйл ажиллагааг зогсоосон.

Зочид буудал: Зочид буудлууд хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд, ажлын шугамаар аялж буй иргэд, спортын тэмцээнд оролцож буй тамирчид, тусгай хөтөлбөрт оролцож буй эмнэлгийн ажилтнууд, тусгай асаргаа шаардлагатай өвчтөн, тэдгээрийн асрагч нарт үйлчилгээ үзүүлж байна. Ажилтнуудын дотуур байрны үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

<sup>45</sup> <https://www.worldometers.info/coronavirus/country/poland/>

<sup>46</sup> <https://www.gov.pl/web/coronavirus/temporary-limitations>

**Польшийн Парламентын хувьд<sup>47</sup> (2020 оны 5-р сарын 14)**

Польшийн Сейм нь парламентын гишүүдэд зайнаас ажиллах боломжийг олгосон. Сеймийн хуралдааны дэгээр онлайн хэлбэрээр хуралдаан зохион байгуулахыг хориглодог тул Тэргүүлэгчид тогтоол гаргаж, КОВИД-19-тэй холбоотойгоор дэгд өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан. Анхны видео хуралдааныг 2020.03.27-нд явуулсан.

Сенат ба Сенатын хороодын хуралдаанаар гол төлөв КОВИД-19-тэй холбоотой асуудлыг хэлэлцэхээр хязгаарласан. Хуралдаан холимог системээр явагдаж байгаа бөгөөд зарим гишүүд уулзалтын танхим, зарим нь Сенатын байрны өөр хоёр өрөөнд, бусад нь гэрээсээ хуралдаанд оролцож байна.

Гишүүн бүр зайнаас хуралдаанд хэрхэн оролцох заавар бүхий видеог хүлээн авах бөгөөд тэдний хувийн мэдээллийг мессежээр баталгаажуулна. Гэртээ байгаа хүмүүс асуулт асууж, үг хэлэх боломжтой. Чуулганы танхим дахь хоёр хананы дэлгэцээс уг хуралдааныг дамжуулна.

Сенатын нэгдсэн хуралдаан, хорооны хуралдаан зохион байгуулах журамд өөрчлөлт ороогүй болно.

Нэгдсэн хуралдаан. 2020.10.20



<sup>47</sup> Олон улсын парламентын холбоо, Улс орнуудын парламентуудын коронавирусний цар тахлын эсрэг хариу арга хэмжээний талаарх тойм <https://www.ipu.org/country-compilation-parliamentary-responses-pandemic>



Хорооны хуралдаан. 2020.10.23



Эх сурвалж: [facebook.com/KancelariaSejmu/photos/](https://facebook.com/KancelariaSejmu/photos/)

### **ЕВРОПАРЛАМЕНТ**<sup>48</sup>

**Нөхцөл байдал:**<sup>49</sup> Европод нийт халдвар авсан хүний тоо 13,794,640 (+67,252), эдгэрсэн 5,123,229, нас барсан 320,482 (+1,055). /2020.11.15/<sup>50</sup>

Европарламентад 10 дугаар сарын сүүлээр Европын Холбооны Парламент (Европарламент)-ын гишүүд болон ажилтнуудын дунд шинэ коронавирусийн халдвар 171 тохиолдол бүртгэгдсэн байна. Тэдний ихэнх нь шинж тэмдэггүй тохиолдлууд байв.

Европарламент нь 705 гишүүнтэй бөгөөд тэнд 4000 орчим туслах, 7500 орчим ажилтнууд ажилладаг байна.

**Европарламент:** Цар тахлын улмаас Европарламентын хуралдаан, уулзалтуудыг хязгаарласан бөгөөд Европарламентын гишүүд, түүний Ажлын албаны ажилтнууд хатуу тусгаарлалтад гэрээсээ ажиллаж байна.

Ийнхүү Европарламент зайнаас ажиллахдаа үндсэн чиг үүргийнхээ дагуу хүрээнд хууль батлах, Европын Холбоо (ЕХ)-ны төсвийг батлах, Европын Комисст хяналт тавих ажлаа үргэлжлүүлэн хийж байна. Европарламентын хорооны болон нэгдсэн хуралдаанаар КОВИД-19-ийн эсрэг хариу арга хэмжээ авах болон Ногоон хэлэлцээр (Green Deal), дижитал үйлчилгээ, ЕХ-ны орнуудын хөдөө аж ахуйн бодлого, урт хугацааны төсөв, Брексит (Brexit) зэрэг урт хугацааны тэргүүлэх чиглэлийн талаар хэлэлцэж байна.

<sup>48</sup> <https://www.europarl.europa.eu/news/en/headlines/priorities/eu-response-to-coronavirus/20200408STO76807/how-parliament-works-during-a-pandemic> . EU affairs, Updated: 27-10-2020 - 22:17.

<sup>49</sup> <https://www.bbc.com/news/topics/cygp15jgmd5t/european-parliament> . Posted at 19:27 12 Nov.

<sup>50</sup> [https://www.worldometers.info/coronavirus/?utm\\_campaign=homeAdvegas1?%22%20%5C%20%22countries](https://www.worldometers.info/coronavirus/?utm_campaign=homeAdvegas1?%22%20%5C%20%22countries)

Европарламентын Ерөнхийлөгч Дэвид Сассоли 2020 оны 3 дугаар сард түүхэндээ анх удаа зайнаас санал хураалт явуулах Европарламентын чуулганыг нээхдээ “Ийм огцом хямралын үед ардчиллыг түр зогсоох ёсгүй. Хууль тогтоогчдын хувьд бидэнд туслах арга хэрэгсэл, чадвар, үүрэг хариуцлага байна” хэмээн хэлжээ.

Европарламент нь аюулгүй бөгөөд үр ашигтай алсын системийг боловсруулан 3 дугаар сарын сүүлээр явуулсан **нэгдсэн хуралдаандаа** ашигласан байна. Энэ үеэр нэг хэлэлцүүлэг (debate), санал хураалттай 3 хуралдаан (voting sessions), 11 санал хураалт (votes) явуулсан байна. Харин 10 дугаар сарын 19-23-ны өдрийн нэгдсэн хуралдааны үеэр 18 хэлэлцүүлэг, санал хураалттай 13 хуралдаан, 1500 гаруй санал хураалт явуулжээ. Одоо Европарламентын гишүүд нийт Европын Холбооны нутаг дэвсгэрт холбоо барих газруудаасаа нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт оролцох боломжтой болсон.

Европарламентын **Хороодын хуралдаан** мөн нөхцөл байдалд зохицуулан видео-хуралдаан, эсхүл хосолсон (hybrid) хэлбэрээр зохион байгуулж байгаа бөгөөд Хороодын санал хураалт үргэлжилж байна.

Парламентуудын улс төрийн 7 бүлэг болон Ерөнхийлөгч нарын Бага хурал (Conference of Presidents) зэрэг удирдах байгууллагууд мөн зайнаас ажлаа үргэлжлүүлж байна.

### **БРАЗИЛ УЛС**<sup>51</sup>

КОВИД-19 цар тахлын үед парламентын хууль тогтоох үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахын тулд Бразилын Депутатуудын танхим (Үндэсний Конгрессын доод танхим)-аас тус Танхимын **нэгдсэн хуралдааныг цахимаар явуулах тухай** 14/2020 дугаар тогтоол (Resolution 14/2020 on virtual plenary sessions)-ыг 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдөр баталжээ. Тус Танхим нь **Депутатуудын танхим дахь цахим хууль тогтоох үйл явцын тухай** 12/2019 тогтоол (Resolution 12/2019 on the digital legislative process)-ыг бүр 2019 онд баталсан байна.

Эдгээр тогтоолуудын дагуу тус Танхимын 513 депутат **бүрэн эрхээ зайнаас хэрэгжүүлэх боломжтой** болсон.

Депутатуудын танхимын 14/2020 дугаар тогтоол батлагдсанаас хойш 8 хоногийн дараа анхны цахим чуулганы хуралдаанаа хийсэн бол, түүнээс 2 хоногийн дараа тус Танхимын депутатууд гар утаснаасаа “Infoleg” аппликейшныг ашиглан цахим хуралдаанд оролцох боломжтой болов.

Депутатуудын танхимын Ажлын албаны техникийн ажилтнуудын боловсруулсан “Infoleg” аппликейшн нь нэгдсэн хуралдааны ерөнхий бүтэц, хууль тогтоох дотоод систем болон бусад видео-хуралдааны үйлчилгээг багтсан байна. Цахим хуралдааныг Танхимын дотор болон гадна байгаа депутатуудыг хамруулахын тулд холимог горим (hybrid mode)-д ашиглахаар зохиосон. Энэхүү аппликейшны уян хатан чанар нь цар тахлын төрөл бүрийн нөхцөлд хуралдаан явуулах, түүнд оролцох боломжийг олгох төдийгүй хямралын дараа гэнэтийн тохиолдолд стратеги болох боломжтой (as a contingency strategy after the crisis).

<sup>51</sup> Preserving parliament's functionality during the COVID-19 pandemic: Brazil's experience. IPU, 2020.07.20. Эх сурвалж: <https://www.ipu.org/innovation-tracker/story/preserving-parliaments-functionality-during-covid-19-pandemic-brazils-experience>

2016 онд нээгдсэн “Infoleg” аппликейшныг хууль тогтоох үйл явц, парламентын гишүүд, хороодын болон нэгдсэн хуралдаан, хууль, хуулийн төсөл (хууль, хуулийн нэмэлт, өөрчлөлт, холбогдох бүх шийдвэр)-ийн талаар иргэдэд мэдээлэх зорилгоор ашиглаж байсан.

Харин Депутатуудын танхимын 14/2020 дугаар тогтоолын дагуу цахим хуралдааныг зөвхөн Танхимын депутатуудад зориулсан шинэ үйлдэл нэмж оруулжээ. Үүнд:

- хуралдаанд оролцож байгаа депутатууд, бусад оролцогчдыг бүртгэх;
- удирдлагуудад санал хураалтын үед чиг баримжаа (leaders' voting orientation) авах;
- санал хураалтын дүнгийн самбарыг гаргах;
- хуралдаанд илтгэгчдийн жагсаалтыг гаргах гэх мэт.

Нэгдсэн хуралдааны үйл явц бүрийг нарийвчлан боловсруулжээ. Тухайлбал, цахим хуралдаан эхлэхээс 2 цагийн өмнө оролцогчдын бүртгэл, илтгэгчдийн нэрсийн жагсаалтыг, үг хэлэхээр бүртгүүлсэн депутатуудыг Танхимынхаа программ, эсвэл цахим хуудаснаас харах боломжтой.

Мөн энэхүү аппликейшн нь мэдээлэл авах боломжийг олгох бөгөөд санал хураалттай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Тухайлбал, удирдлагууд (leaders) санал хураалтаас өмнө бүх депутатуудтайгаа харилцах боломжийг олгоно, санал хураалт нээгдэх, хаагдах үед Танхимын депутатуудад анхааруулга өгнө.

Энэхүү аппликейшны хамгийн том асуудал болох аюулгүй байдлыг нь шийдэж чадсан байна. Уг апплейкешинд нэвтрэх нууц үгээс гадна бусад баталгаажуулалт, шифрлэгдсэн сувгийг (an encrypted channel) өөрчилж тус Танхимын депутатуудад аюулгүй цахим орчинг үүсгэсэн гэж үзэж байна. Эдгээр баталгаажуулалтаас гадна Танхимын депутатууд ухаалаг гар утасныхаа нүүр, нүдний солонгон бүрхэвч, хурууны хээ зэрэг биометрийн аргаар таних үйлдлийг ашиглаж болно.

Мөн цар тахлын үед Депутатуудын танхим **зайнаас хуулийн төсөл өргөн барих** боломжийг нэвтрүүлсэн байна. Бүхий л цахим хуралдаантай хамт хуулийн төслүүдийг цахимаар баталгаажуулах боломжтой.

Цахим хуралдааны платформ нь Танхимын **Ерөнхийлөгчид өөрийн бүх орлогч нартай уулзах** боломжийг мөн олгоно.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ нь энэхүү аппликейшн болон бусад хууль тогтоомжийн системүүдтэй хамааралгүй тул парламентын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахдаа хуралдааныг телевиз, YouTube, парламентын цахим хуудсаар дамжуулан мэдээллийг иргэдэд нээлттэй түгээж байна.

2020 оны 4-7 дугаар сард 44 цахим хуралдаан явуулсны дараа Депутатуудын танхимын үйл ажиллагааг дараах байдлаар дүгнэж байна:

- 2020 онд хийсэн цахим хуралдаан, уулзалтуудыг 2019 оны мөн үеийн статистик үзүүлэлттэй харьцуулахад илүү олон удаа зохион байгуулсан бөгөөд Депутатуудын танхим 2020 онд 2019 оны мөн үеийнхтэй харьцуулахад 20 хувиар илүү хуулийн төсөл баталсан.
- 2019, 2020 онд хуралдаан, уулзалтуудын үргэлжлэх хугацаа ойролцоо буюу 5 цаг орчим байна.

- Депутатуудын ирц 2019 онд 89.2 хувь байсан бол 2020 онд 98.1 хувь болж өссөн.
- Депутатуудын санал хураалтын идэвх 71.3 хувиас (2019 онд) 86 хувь (2020 онд) болж өссөн.

Тус Танхим цар тахлаас өмнө авсан стратеги шийдвэр, мэдээллийн технологийн салбарт урт хугацааны хөрөнгө оруулалт хийснээр энэхүү амжилтад хүрсэн хэмээн Депутатуудын танхимаас мэдээлж байна.

Парламентын үйл ажиллагааг цахимжуулах арга хэмжээ Төлөөлөгчдийн танхим (доод танхим)-аас гадна **Сенат (дээд танхим)-д хэрэгжүүлж** байгаа аж.<sup>52</sup>

## **БНСУ**

### **Цар тахлын үед авч буй БНСУ-ын Үндэсний Ассамблейн үйл ажиллагаа**

Цар тахалтай холбоотойгоор 9-р сарын 1-ээс ээлжит чуулганыг хуралдуулах талаар Үндэсний Ассамблейгаас цахим хурлын системийг хөгжүүлэх, мөн хурлын өрөөнүүдэд ширээ хооронд тунгалаг тусгаарлагчуудыг байрлуулах, орох хэсгүүдэд камер байрлуулах зэрэг хорио цээрийн дэглэмийн талаар хэлэлцжээ. Үндэсний Ассамблейн бүх ажилтнуудыг ажлын шинж чанар, яаралтай байдлаас шалтгаалан долоо хоногт хоёроос гурван өдөр гэртээ ажиллахыг уриалж байна. Зарим хэлтсүүд уян хатан ажлын цагийн хуваарийг нэвтрүүлсэн.<sup>53</sup>

Солонгосын Үндэсний Ассамблей ухаалаг, дэвшилтэд технологид суурилсан хэрэглэхэд хялбар цахим хуралдааны танхимыг ашиглаж байна. Өндөр нарийвчлалтай дэлгэц мэдээллийг шууд дамжуулах горим зэрэг нь гишүүдэд илүү нарийн, тодорхой хэлэлцүүлэг хийх боломжийг олгодог. Үүнд цахим санал хураалт, хаалттай санал хураалтын горимууд багтсан байна. Уг цахим хурлын танхимыг Ассамблейн хоорондын чуулганд төдийгүй НҮБ-ын олон улсын бага хурал болон бусад төрлийн конвенцуудад ашиглаж, хэрэглэдэг байна.<sup>54</sup>

БНСУ-ын Үндэсний Ассамблей 2-р сарын 26-аас КОВИД-19-ийн халдвар хурдацтай нэмэгдсэнтэй холбогдуулан хариу арга хэмжээ авах зорилгоор 3 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Үүнд халдварт өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх хууль (Infectious Disease Control and Prevention Act), хорио цээрийн тухай хууль (Quarantine Act), эмнэлгийн үйлчилгээний тухай хуулиудад (Medical Service Act) нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан байна.

Нэмэлт өөрчлөлт нь засгийн газар болон эрүүл мэндийн байгууллагуудад вирусийн тархалтаас урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн байна. Жишээлбэл, Халдварт өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр төрөөс шинжилгээнд хамрагдахаас татгалзсан сэжигтэй өвчтөнүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хорио цээрийн журам зөрчсөн тохиолдолд дээд тал нь нэг жилийн хорих ялаар шийтгэх эсвэл торгох (ойролцоогоор 1000 USD) шийтгэлийг оногдуулахаар болжээ.

Үндэсний Ассамблей КОВИД-19 цар тахлын үед эдийн засгийн нөлөөллийг зохицуулах зорилгоор ойролцоогоор нийт 3 удаа 35 их наяд вонын (ойролцоогоор 29 тэрбум ам доллар) нэмэлт төсвийг баталжээ. Энэ нь 1972 оноос хойш

<sup>52</sup> Parliaments and Crisis: Challenges and Innovations. Parliamentary Primer No. IDEA. 2020. 138 дахь тал.

<sup>53</sup> <https://www.ipu.org/country-compilation-parliamentary-responses-pandemic#R>

<sup>54</sup> [https://korea.assembly.go.kr:447/digital\\_plenary/menu02.jsp](https://korea.assembly.go.kr:447/digital_plenary/menu02.jsp)

Үндэсний Ассамблей нэг жилийн хугацаанд гурван нэмэлт төсвийг баталсан анхны тохиолдол болсон байна. (02.25.2020)

### **Цар тахлаас сэргийлэх БНСУ-ын Үндэсний Ассамблейн цахим хуралдаан**

БНСУ-д есдүгээр сараас арваннэгдүгээр сар хүртэл хууль тогтоогчдын хувьд хамгийн их ачаалалтай байдаг ба Энэ хугацаанд (9-р сард) Үндэсний Ассамблейн жилийн ээлжит чуулганыг нээж, 10-р сард Ассамблейгаас жил бүр төрийн байгууллагуудад аудит хийж, 11-р сард ирэх оны засгийн газрын төсөвт хяналт шалгалт хийдэг. Гэвч КОВИД-19 цар тахлаас үүдэлтэйгээр Үндэсний Ассамблей одоогоор 2 сарын сүүлээр нэг, 9 сард хоёр удаа нийт гурван удаа хөл хорионд шилжсэн. Энэ хугацаанд Ассамблейн зарим байгууллагууд мөн хэсэгчилсэн хөл хориог хэд хэдэн удаа хэрэгжүүлсэн. Нөхцөл байдлыг даван туулахын тулд тэд зайнаас ажиллах системийг нэвтрүүлж, намын зарим хурлыг онлайнгаар зохион байгуулсан. Ассамблейн байранд зохион байгуулахаар төлөвлөж байсан семинар, хурлыг цуцалж, онлайн семинар, бага хурлыг зохион байгуулж байна. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар эдгээр нь хангалтгүй бөгөөд цаашид цахим системээр дамжуулан хуулийн төсөл санал болгох, хуулийн төсөлд тоон хэлбэрээр санал өгөх зэрэг онлайн хууль тогтоох үйл ажиллагааг идэвхжүүлэх шаадлагатай хэмээжээ. БНСУ-ын Ардчилсан намын зарим хууль тогтоогчид (Democratic Party of Korea, Jo Seoung-lae), Үндэсний чуулганы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онлайн системийг нэвтрүүлэх санал гаргасан боловч энэ нь бусад гишүүдийн эсэргүүцэлтэй тулгарч уг системийг улс төрийн бусад зорилгоор ашиглах, мөн Үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй хэмээн үзэж дэмжээгүй байна.

*Зураг. 9-р сарын 3-ны өдөр Үндэсний Ассамблейгаас зохион байгуулсан онлайн семинар.*



Цар тахлаас үүдэлтэй цахим шилжилтийг хөгжүүлж байгаа ба Ассамблейд хиймэл оюун ухаант (AI) технологийг нэвтрүүлэх ажлыг KAIST-ийн тооцооллын сургуулийн (School of Computing at KAIST) дэд профессор Ким Жү Хо хариуцан ажиллаж байна. Энэ систем нь Ассамблейн ажилтнуудын цаг хугацаа хэмнэж,



баримт бичгүүдийг цэгцлэх, хууль тогтоогчдын хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийн санал авах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах зэрэг захиргааны үүргийг мөн гүйцэтгэхэд тус болно гэж үзэж байна.<sup>55</sup>

## **ИРЛАНД УЛС**

Ирланд улсын парламент нь “КОВИД-19 тусгай хороог” 2020 оны 5-р сарын 6-ны өдрөөс 2020 оны 10-р сарын 8-ны хооронд байгуулсан. Уг хороо нь цар тахалтай тэмцэх Ирланд улсын авч буй арга хэмжээнүүдийн талаарх нотолгоог авч үзэх үүрэгтэй байгуулагдсан.

IPU: “Хоёр танхим буюу Dáil Éireann, Seanad танхимууд 4-р сарын 16 хүртэл завсарлага авсан байна. Энэ хугацаанд Парламентад ажиллаж буй гишүүд, ажилтнууд болон бусад хүмүүсийн аюулгүй байдлыг хангах үүднээс хуралдааны тусгай арга хэмжээ авсан.<sup>56</sup> Үүнд:

- Депутатын гуравны нэг нь Даилийн (Dáil Éireann) хуралд оролцох ба нийгмийн эрүүл мэндийн зөвлөмжийн дагуу зохих зайг баримталж байна.
- Парламентын үйл ажиллагааг хязгаарласан бөгөөд КОВИД-19-тэй холбоотой асуудлаар яаралтай хуралдсан байна.
- Даил парламентын асуултуудыг энэ хугацаанд түдгэлзүүлсэн.
- Санал хураалт одоогоор “дуут санал хураалт” “Voice Votes” эсвэл “дуудлага өгөх санал” (role call vote) хэлбэрээр явагдсан байна. Дуут санал хураалт нь Даил дахь ердийн журам бөгөөд “бүрэн дуудлагын санал” нь буюу бүртгэгдсэн санал нь чуулганы гишүүн тус бүрийн саналыг (зөвшөөрсөн эсвэл эсэргүүцсэн) тэмдэглэсэн (мөн хожим нь нийтлэгддэг) санал юм.

Даил Эиран (*Dáil Éireann*), Шеанад Эиран (*Seanad Éireann*) танхимууд хуралдахдаа бүх гишүүд оролцох шаардлагатай хуралдаанаас бусад тохиолдолд Даил танхимд хуралддаг. Салбар хороодын хурлыг ердийн хорооны өрөөнд зохион байгуулдаг бөгөөд зайлшгүй оролцох шаардлагатай гишүүдийг зайнаас оролцуулдаг.

2020 оны 10-р сарын байдлаар Парламентын өдөр тутмын үйл ажиллагаанд зориулж Microsoft Teams нь бүх ажилтнууд, гишүүдэд алсын зайнаас ажиллах боломжийг олгож байна. Парламентын ихэнх ажилтнууд гэрээсээ ажиллаж байна.

2020 оны 7-р сарын 20-ны Даваа гарагаас байгаа бүх хүмүүсийг нүүрээ халхлах эсвэл маск зүүхийг зөвлөсөн байна.

<sup>55</sup> [https://www.koreatimes.co.kr/www/nation/2020/09/356\\_295892.html](https://www.koreatimes.co.kr/www/nation/2020/09/356_295892.html)

<sup>56</sup> <https://www.europarl.europa.eu/cmsdata/211286/Overview%20Covid%20Measures%20DRF%2014%20LIBE.pdf>

Ирланд улсын нэгдсэн чуулганы хуралдаан: 2020.11.12-ны өдөр<sup>57</sup>**ЭСТОНИ УЛС**

Эстони Улсын хувьд 2020.03.16-ны өдөр Парламентын (Рийгикогу) Үндсэн хуулийн хороо онцгой байдлын үед нэгдсэн хуралдаан болон хороодын хуралдаануудыг цахимаар буюу алсын зайнаас зохион байгуулах асуудлыг хэлэлцсэн байна. Хорооноос Парламентын дэг, дотоод журмын тухай хууль (Riigikogu Rules of Procedure and Internal Rules Act)<sup>58</sup>-ийн дагуу Парламентын нэгдсэн болон байнгын хороодын хуралдааныг цахим буюу алсын зайнаас явуулах боломжтой гэж дүгнэсэн байдаг. “Хуралдаанд оролцоход шаардлагатай нөхцөл болох үг хэлэх, асуулт асуух, санал өгөх зэргийг хангасан тохиолдолд хуралдааныг алсын зайнаас явуулж болно гэж одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг тайлбарлаж болохоор байна” гэж Үндсэн хуулийн хорооны дарга мэдэгдсэн. Мөн онцгой нөхцөл байдлыг харгалзан хуралдааны үйл ажиллагааг тасалдуулахгүй, алсын зайнаас үргэлжлүүлэн ажиллах нь чухал болохыг онцолсон бөгөөд Парламент дахь бүлгүүдэд захидал илгээж Парламентын дэг, дотоод журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг үнэлэхийг хүссэн байна. Үүний дагуу 2020.04.13-нд Үндсэн хуулийн хороо нь Рийгикогу алсын зайнаас ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан өргөн барьжээ.<sup>59</sup> Улмаар 2020.06.02-нд Парламентын дэг, дотоод журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн баталсан байна.

Нэмэлт өөрчлөлтөөр Рийгикогу нь хуралдаанд алсын зайнаас цахим хэлбэрээр оролцон, хууль боловсруулах үйл ажиллагаатай холбоотой аливаа үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх үүднээс ямар үед алсын зайнаас хуралдах, цахимаар хуралдаж буй үед хэрхэн санал өгөх, хурлыг хэрхэн зохион байгуулах асуудлыг тус тус зохицуулсан байна. Үүнд.<sup>60</sup>

Хуулийн 3-р бүлгийн §12-т зааснаар “Рийгикогугийн удирдах зөвлөл нь Рийгикогугийн дарга, дэд дарга нараас бүрддэг.

<sup>57</sup> <https://www.oireachtas.ie/>

<sup>58</sup> <https://www.riigiteataja.ee/en/eli/504062020005/consolide>

<sup>59</sup> <https://www.riigikogu.ee/pressiteated/pohiseaduskomisjon-et-et/pohiseaduskomisjon-algatas-seadusemuudatused-riigikogu-kaugtoo-voimaldamiseks/>

<sup>60</sup> <https://www.riigiteataja.ee/en/eli/504062020005/consolide>

§ 13. Рийгикогугийн удирдах зөвлөл нь:

6<sup>1</sup>) хэрэв зайлшгүй шаардлагатай бол Рийгикогугийн хуралдааныг алсын зайнаас хуралдуулах асуудлыг шийдвэрлэх;

6<sup>2</sup>) Рийгикогугийн хуралдааныг зайнаас хуралдуулах шаардлага, дүрмийг тогтоох;

*Бүлэг 10. Рийгикогугийн хуралдаан*

§ 57. Хуралдаан зохион байгуулах газар

(1) Рийгикогугийн дарга хэрэв хүндэтгэх шалтгааны улмаас өөр газар хуралдааныг зохион байгуулах шийдвэр гаргаагүй бол Таллин дахь Тумпеа цайзын хуралдааны танхимд хуралдааныг зохион байгуулна.

(2) Рийгикогугийн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр энэхүү хуулийн § 89 1-т заасан алсын зайн хуралдааныг энэ хэсгийн дэд хэсэг (1)-т заасан газар эсвэл тодорхой байршил заахгүйгээр алсын зайнаас цахим хэрэгслээр зохион байгуулж болно.

§ 58. Хуралдаанд оролцогчид

(1) Рийгикогугийн хурлын танхимд нэвтрэх ба оролцох эрх нь гишүүд, Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүд, Хууль зүйн канцлер, Ерөнхий аудитор, Төрийн нарийн бичгийн дарга, Рийгикогугийн чуулганы нэгдсэн хуралдаанд албан үүргийнхээ хувиар оролцох шаардлагатай ажилтнууд болон Рийгикогугийн даргын урилгаар ирсэн хүмүүст олгогдоно.

(2) Рийгикогугийн гишүүд, Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч болон Засгийн газрын гишүүд нь танхимд тусгайлсан суудалтай байдаг.

*Бүлэг 3. Рийгикогугийн хуралдаанд санал өгөх*

§ 81. Санал өгөх аргууд

(1) Санал өгөхдөө цахим санал өгөх системийг ашиглана.

(2) Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Рийгикогугийн дарга, дэд дарга нарыг сонгоход сонгуулийн саналын хуудас хэрэглэнэ.

(3) Санал хураалтын цахим системийг ашиглах боломжгүй бол саналаа гар өргөх эсвэл нууц санал хураах шаардлагатай бол саналын хуудсаар явуулна.

(4) Рийгикогугийн хуралдааныг алсын зайнаас (цахим) зохион байгуулж байгаа үед санал өгөх цахим систем эсвэл гараар санал өгөх боломжгүй тохиолдолд санал хураалтыг хуралдаан даргалагчийн зөвшөөрсөн өөр аливаа хэлбэрээр явуулж болно.

§ 82 Үндэсний цахим хороо болон санал хураалтын хорооны чадамж

энэ хуулийн 81-р зүйлийн (2)-р хэсэгт заасан тохиолдлуудад санал хураалтын дүнг баталгаажуулж үүнтэй холбоотой ямарваа эсэргүүцлийг Үндэсний цахим хороогоор шийдвэрлүүлнэ.

Энэ хуулийн 3, 4-р зүйлд заасан нөхцалүүдээр санал хураалтыг зохион байгуулах үед санал хураалтыг баталгаажуулах, маргааныг шийдвэрлэх асуудлыг Санал хураалтын хороогоор шийдвэрлүүлнэ.

Санал хураалтын хороонд Рийгикогугийн бүлэг тус бүрээс нэг гишүүн оролцоно.

*Бүлэг 4. Рийгикогугийн алсын зайны хуралдааныг зохион байгуулах* (энэ бүлгийг шинээр нэмж оруулсан байна)



## § 89<sup>1</sup> Алсын зайн хуралдаан

(1) Рийгикогугийн Удирдах зөвлөл нь онцгой нөхцөл байдлын улмаас хуралдааныг алсын зайнаас зохион байгуулахаар шийдвэрлэж болно.

(2) Алсын зайны хуралдаан гэдэг нь Рийгикогугийн хуралдаанд гишүүд биечлэн ирэлгүйгээр цахим хэлбэрээр оролцохыг хэлнэ.

(3) Рийгикогугийн гишүүд хуралдааныг алсын зайнаас тухайн цаг хугацаанд нь ажиглах, хуралдааны үйл ажиллагаанд оролцох (төсөл өргөн барих, танилцуулга, тайлбар, санал шүүмж хэлэх, асуулт асуух, үг хэлэх, санал хураалт болон бусад үйлдэл) болон эдгээрт аливаа саад учрах тохиолдолд мэдэгдэх боломжууд баталгаажсан, хангагдсан үед алсын зайн хуралдааныг зохион байгуулж болно.

(4) Алсын зайнаас хуралдаанд оролцож байх үед хуралдаан даргалагч энэ хуулийн хуралдааныг зохион байгуулах заалтыг хэрэглэх үедээ Рийгикогугийн гишүүдийн аливаа эрхээ эдлэх боломжийг алдагдуулж болохгүй.

(5) Хэрэв алсын зайн хуралдааны үйл ажиллагаанд ямар нэг саад учирвал тэрхүү саадыг арилгах хүртэл хуралдааныг түр хойшлуулна.

(6) Алсын зайнаас хуралдаанд оролцож буй Рийгикогугийн гишүүнд канцлерын албаны хяналтаас давсан учир шалтгаанаар саад учирсан тохиолдолд хуралдааныг даргалагч оролцох боломжтой гишүүдтэй хуралдааныг үргэлжлүүлэн явуулах эсэхийг шийдвэрлэнэ.

(7) Рийгикогугийн дарга нь хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө алсын зайнаас хуралдаан зохион байгуулах тухайгаа Рийгикогугийн гишүүдэд Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдэгдэнэ. Онцгой нөхцөл байдалд зарлан мэдэгдэх хугацаа үүнээс хугацаа богино байж болно.

Эстонийн Парламентын үйл ажиллагаа нь дээрх хуулийн хүрээнд цахимаар хэвийн зохион байгуулагдаж байгаа бөгөөд хэсэгчилсэн хуралдаан нь дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу хоорондын зайг барьж, танхимын ариутгал цэвэрлэгээг өдөрт хэд хэдэн удаа хийж, амны хаалт зүүх зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байгаа талаар парламентын веб сайтад мэдээлсэн байна.

Мөн тус улсад цар тахлын шинэ нөхцөл байдлын улмаас Засгийн газраас коронавирусийн тархалтыг хязгаарлах, Эстоничуудын амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор ажил, гэр, нийтийн тээврийн хэрэгсэл болон бусад олон нийтийн газарт авах шинэ арга хэмжээний зөвлөмжийг<sup>61</sup> 2020.11.10-нд баталсан тогтоол гаргасан байна.

Уг тогтоолд эдгээр арга хэмжээг 11-р сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг тушаажээ.

Ажлын байрны арга хэмжээ:

- Боломжтой бол ажилчдаа алсаас ажиллуулахыг зөвлөж байна.
- Ажил олгогчдод хэн нэгэн ажил дээрээ коронавирусийн халдвар авсан тохиолдолд алсын ажлын төлөвлөгөө боловсруулж, алсын ажил зохион байгуулахыг зөвлөж байна.
- Зул сарын баярыг оролцуулаад бүх хамтарсан арга хэмжээг цуцлахыг зөвлөж байна. Гэр бүлийн зул сарын баярыг зөвшөөрнө.

<sup>61</sup> <https://www.kriis.ee/et/uudised/valitsus-avalikustas-uued-koroonaviiruse-vastased-meetmed>

Гэрийн болон гэр бүлийн орчин тойронд:

- Эрсдэлтэй хүнтэй уулзах, халдвар авахаас урьдчилан сэргийлж, гэрээс гарахдаа аюулгүй байдлыг хангах: маск зүүж, зайгаа барьж, гар угаах, гэрээ цэвэрлэх шаардлагатай.
- Халамжийн байгууллагууд эрсдлийн бүлэгт хамрагдах хүмүүст холбоо барих аюулгүй боломжийг хангах ёстой.
- Коронавирусийн халдвар авсан хүнтэй хамт амьдрах аюулгүй байдлын дүрмийг чандлан сахиж, зайгаа барьж, эрүүл мэндийн зөвлөмжийг чанд сахиж ёстой.

Олон нийтийн газар, нийтийн тээврийн хэрэгслүүд:

- Нийтийн тээврийн хэрэгсэл, худалдааны үйлчилгээний газрууд болон тэдгээрийн нийтийн эзэмшлийн талбайд амны хаалт зүүх ёстой. Түүнчлэн тээвэрлэгчид, худалдаа эрхлэгчид, арга хэмжээ зохион байгуулагчдаас энэхүү шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, ажиллахыг үүрэг болгов. Амны хаалтыг сонсголын бэрхшээлтэй хүмүүс болон 12-оос доош насны хүүхдүүд зүүхгүй байж болно.
- Тээвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдээс маск зүүхийг шаардах, уриалах, санамжийг байршуулах арга хэмжээг байнга зохион байгуулахыг шаардана.
- Засгийн газраас энэхүү тогтоолоороо 2+2 гэсэн дүрмийг үйлчилгээний танхимууд болон арилжааны байгууллагуудын нийтийн эзэмшлийн талбайд тогтоож, гэрээнд зааснаас бусад тохиолдолд хоёроос илүүгүй хүн нэг дор байх ба хоорондоо хоёр метр зайтай байж болно.
- Зөвшөөрөгдсөн хоолны болон үйлчилгээний газруудад хүмүүс хоорондын зайг хоёр метрээс багагүй байх журмыг тогтоож, нэг дор хамгийн ихдээ 10 хүн ногдож байхаар зохицуулах.
- Олон хүн цуглахаас урьдчилан сэргийлэх үүднээс нийтийн хоол, үзвэр үйлчилгээний газруудын ажиллах цагийг шөнийн 00 цагаас өглөөний 6 цаг хүртэл хязгаарласан. Хязгаарлалт нь хүнсний худалдаа эрхлэхэд хамаарахгүй.

## **ХЯТАД УЛС**

### **Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал**

Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (БХАТИХ)-ын 13 дахь сонгуулийг 2017 оны 10 дугаар сараас 2018 оны 2 дугаар сар хүртэл хугацаанд зохион байгуулж нийт 2956 төлөөлөгч сонгогдсон бөгөөд бүрэн эрхийн хугацаа 2018-2023 онд үргэлжилнэ. БНХАУ-ын Үндсэн хуулийн 61-р зүйлд заасны дагуу БХАТИХ жилд нэг удаа, 3-р сард 11 хоног чуулдаг.<sup>62</sup> Чуулганыг БХАТИХ-ын Байнгын хороо зохион байгуулдаг.

13 дахь сонгуулийн БХАТИХ-ын 3 дугаар чуулган 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдөр эхлэх байсан боловч КОВИД-19 цар тахлаас шалтгаалан 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдөр эхлэхээр хойшлуулсан.<sup>63</sup> 13 дахь сонгуулийн БХАТИХ-ын 3 дугаар чуулган 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс 28-ны өдөр хүртэл

<sup>62</sup> БНХАУ-ын Засгийн газрын албан ёсны цахим хуудас. <http://www.gov.cn/guoqing/> 2018-03/22/content\_5276318.htm

<sup>63</sup> Хятадын Шинхуа агентлагийн албан ёсны цахим хуудас. [http://www.xinhuanet.com/politics/2020-02/24/c\\_1125620449.htm](http://www.xinhuanet.com/politics/2020-02/24/c_1125620449.htm)

хугацаанд хуралдсан. Тус чуулганыг цахим хэлбэрээр хийх асуудлыг дэвшүүлж байсан ч халдвар хамгааллын чанга дэглэм дор танхимаар хуралдахаар шийдвэрлэсэн. Ингээд чуулганд 2956 төлөөлөгч оролцох ёстойгоос 2902 төлөөлөгч оролцсон. Чуулган зохион байгуулагддаг Ардын их танхимд гаднаас сэтгүүлчдийг оруулаагүй бөгөөд төлөөлөгчөөс ярилцлага авах, нэвтрүүлэх үйл ажиллагааг Шинхуа агентлаг, Засгийн газрын сайтаар дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулсан.<sup>64</sup>

### **БХАТИХ-ын Байнгын хороо**

БНХАУ-ын Үндсэн хуулийн 58-р зүйлд заасны дагуу хууль тогтоох эрх мэдлийг БХАТИХ болон түүний байнгын хороо хэрэгжүүлнэ. 13 дахь сонгуулийн БХАТИХ-ын Байнгын хороо нь 159 төлөөлөгчөөс бүрдэнэ. БХАТИХ-ын Байнгын хорооны хуралдааны журмын 3 дугаар заалтад заасны дагуу тус хороо 2 сард нэг удаа хуралддаг. Хорооны нийт төлөөлөгчийн талаас илүү нь хуралдаанд ирсэн тохиолдолд хуралдааныг эхлүүлнэ. Хуулийн төслийг нийт төлөөлөгчийн дийлэнх олонхын саналаар батална.<sup>65</sup>



13 дахь сонгуулийн БХАТИХ-ын Байнгын хорооны 2020 оны анхны хуралд буюу 16 дугаар хуралд 2020 оны 2 дугаар сарын 24-ний өдөр эхэлж, 114 хүн танхимаар, 57 хүн цахимаар хуралд оролцсон<sup>66</sup> Танхимаар хуралд оролцсон төлөөлөгчдийг хооронд нь 1,5 зайтай суулгасан. Ан амьтны хууль бус худалдааг бүрэн зогсоох, зэрлэг амьтныг хоол хүнсэнд

хэрэглэх зуршлыг халах, ан амьтан болон экологийн аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн эрүүл мэндийн томоохон эрсдэлийг үр дүнтэйгээр урьдчилан сэргийлэх, ард олны амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдлыг баталгаажуулахын тулд 13-р сонгуулийн БХАТИХ-ын Байнгын хорооны 16 дахь хурлаар ан амьтны хууль бус худалдааг бүрэн зогсоож, зэрлэг амьтны махыг хоол хүнсэнд хэрэглэхийг хориглож, ард олны эрүүл мэнд, аюулгүй байдлыг баталгаажуулах тухай шийдвэрийг баталсан.

2020 онд БХАТИХ-ын Байнгын хороо нийт 7 удаа хуралдаж, эдгээр хуралдааныг танхимын болон цахим хэлбэрээр хослуулан зохион байгуулсан байна.

### **ШОТЛАНД УЛС**

Шотланд Улсын Парламент КОВИД-19 цар тахлын эсрэг бодитой, үр дүнтэй арга хэмжээ авах зорилгоор 9 гишүүний бүрэлдэхүүнтэй “КОВИД-19 тусгай хороо”

<sup>64</sup>Хятадын Шинхуа агентлагийн албан ёсны цахим хуудас. <http://www.xinhuanet.com/politics/2020lh/zbrdfbh/wzsl.htm>

<sup>65</sup>БХАТИХ-ын Байнгын хорооны хуралдааны журам [http://www.npc.gov.cn/wxzl/gongbao/200910/31/content\\_1543670.htm](http://www.npc.gov.cn/wxzl/gongbao/200910/31/content_1543670.htm)

<sup>66</sup>БХАТИХ-ын мэдээлэл 2020 (#48 /1) х.31 <http://www.npc.gov.cn/npc/c16175/202005/c71b686a60e643f58aede49469a2b0d3/files/68c6cdeefeb145b89efe9a2c653c43d3.pdf>

байгуулан ажиллаж байна.<sup>67</sup> Түүнчлэн 2020 оны 4 сарын 6-нд Коронавирусийн тухай хууль (Coronavirus (Scotland) Act 2020)<sup>68</sup>-ийг баталсан бөгөөд уг хуулийн хоёр дахь хувилбар (Coronavirus (Scotland) (No.2) Act 2020)<sup>69</sup>-ыг 2020 оны 5 сарын 26-ны өдөр баталсан.

Энэхүү хуулийн зорилго нь корона바이러스ийн цар тахлын улмаас үүссэн онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах явдал юм. Өөрөөр хэлбэл, онцгой байдлын үед төрийн үйлчилгээг үргэлжлүүлэн явуулахад чиглэгдсэн. Үүнд онцгой нөхцөл байдлын үед төрийн үйлчилгээг авдаг иргэд болон бизнес эрхлэгчдийг дэмжих, хүмүүсийн ажиллаж, амьдрах арга хэлбэрийг тодорхой болгох талаар зохицуулалтууд тусгагдсан байна.<sup>70</sup>

### **Виртуал асуулт болон Хорооны хурал**

Шотланд Улсын Парламент “КОВИД-19” цар тахалтай холбогдуулан зайнаас хуралдах, санал авах журмыг баримталж байгаа бөгөөд виртуал хэлбэрээр асуулт тавих аргыг нэвтрүүлсэн. Шотландын Парламент виртуал асуултын цагийг зөвшөөрөх зорилгоор Байнгын дүрэм (Standing Order)-дээ нэмэлт өөрчлөлт оруулсан. Ийнхүү Парламент нь виртуал асуултын цаг зохион байгуулж, бусад хяналт шалгалтын зохицуулалтын талаар хэлэлцдэг байна. Парламент бусад үйл ажиллагааныхаа талаар долоо хоногт нэг удаа танхимд хуралддаг.<sup>71</sup> Гишүүдийн анхны виртуал асуултын цаг нь 2020 оны 4-р сарын 17-нд болсон бөгөөд 19 гишүүн КОВИД-19 цар тахалтай холбогдуулан дөрвөн сайдаас асуулт асуусан байна.<sup>72</sup>

Хорооны виртуал хурал нь чуулганы виртуал хуралдаанаас илүү түгээмэл ба Шотландад КОВИД-19 тусгай хороо энэ хэлбэрээр хуралддаг.<sup>73</sup> Чуулганы виртуал хуралдаан нь зөвхөн асуулт асуух, мэдэгдэл хийхэд зориулагдсан байдаг тул бүх гишүүдийг багтаах боломжгүй юм. Одоогоор Шотландын Парламент виртуал хуралдаанд олон гишүүдийг оролцуулах боломжийн талаар хэлэлцэж байгаа аж.<sup>74</sup>

### **BlueJeans платформ**

Шотланд Улсын Парламент сүүлийн үеийн шинэ технологийг судалж, илүү олон гишүүнийг оролцуулах боломжтой, төрөл бүрийн форматыг багтаасан виртуал хяналтын зохицуулалтыг өргөжүүлэхээр зорьж байна. BlueJeans нь хуралдааныг шууд дамжуулах зориулалт бүхий платформ бөгөөд Шотландын Парламент үйл ажиллагаандаа ашиглаж байна.

<sup>67</sup> Scottish Parliament Covid-19 committee webpage <https://www.parliament.scot/parliamentarybusiness/CurrentCommittees/114991.aspx>

<sup>68</sup> Coronavirus (Scotland) Act 2020 <https://www.legislation.gov.uk/asp/2020/7/introduction>

<sup>69</sup> Coronavirus (Scotland) (No.2) Act 2020 <https://www.legislation.gov.uk/asp/2020/10/introduction>

<sup>70</sup> <https://beta.parliament.scot/bills/coronavirus-scotland-bill>

<sup>71</sup> How parliaments are working during the Covid- 19 pandemic. 2020. L&RS Note. Page 6. [https://data.oireachtas.ie/ie/oireachtas/libraryResearch/2020/2020-05-01\\_l-rs-note-how-parliaments-are-working-during-the-covid-19-pandemic\\_en.pdf](https://data.oireachtas.ie/ie/oireachtas/libraryResearch/2020/2020-05-01_l-rs-note-how-parliaments-are-working-during-the-covid-19-pandemic_en.pdf)

<sup>72</sup> Scottish Parliament News 21 April 2020 <https://www.parliament.scot/newsandmediacentre/114988.aspx>

<sup>73</sup> How parliaments are working during the Covid- 19 pandemic. 2020. L&RS Note. Page 6. [https://data.oireachtas.ie/ie/oireachtas/libraryResearch/2020/2020-05-01\\_l-rs-note-how-parliaments-are-working-during-the-covid-19-pandemic\\_en.pdf](https://data.oireachtas.ie/ie/oireachtas/libraryResearch/2020/2020-05-01_l-rs-note-how-parliaments-are-working-during-the-covid-19-pandemic_en.pdf)

<sup>74</sup> Мөн тэнд., Page 9-10.

Мөн Дэгийн тухай дүрэм (Standing Order)-ээрээ Шотландын Парламентыг парламентайн мэтгэлцээний танхимаас бусад газарт хуралдахыг зөвшөөрдөг.<sup>75</sup>

## **НОРВЕГИ УЛС**

### **1. Норвегийн парламентын тухай Үндсэн хуулийн зохицуулалт**

Норвегийн Парламент (Стортинг) нь Норвегийн ард түмнийг төлөөлдөг хууль тогтоох байгууллага юм. 169 гишүүнтэй нэг танхимтай. Хуулийн төсөлд хаан гарын үсэг зурж, түүний нэр дээр хууль тогтоомжийг баталдаг.

Парламент дараах асуудлыг хариуцна. Үүнд

- хууль батлах, хүчингүй болгох, татвар, төлбөр, хураамж болон бусад улсын өр төлбөрийг гаргах;
- улсын зээл авах;
- Норвегийн мөнгөний системийг хянах;
- улсын санхүүгийн үүргийг биелүүлэхэд шаардлагатай хөрөнгийг олгох;
- хааны хишгийг тодорхойлох;
- төрийн баримт бичгийг архивлах;
- Хаан бусад мужуудтай байгуулсан хориг арга хэмжээ, гэрээг зарлах;
- парламентын сонсголыг зарлах;

Норвегийн Үндсэн хуульд дайны үед эсвэл халдварт өвчний улмаас Парламент танхимаасаа өөр газарт хуралдаж болно гэж заасан ба үүнээс өөр зохицуулалт ороогүй.

Мөн Норвегийн Үндсэн хуульд санал хураахад парламентын нийт гишүүдийн тэн хагас нь заавал байх ёстой. Энэ нь ямар ч үед парламент санал хураалт явуулахад 169 гишүүний 85-аас доошгүй ирцтэй байх ёстой гэсэн үг юм.

Харин Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд гишүүдийн гуравны хоёр нь оролцох ёстой. Хуралдаанд оролцсон гишүүдийн тал нь хууль, арга хэмжээг батлахын тулд санал өгөх ёстой.

### **2. КОВИД-19-ийн тархалтыг хязгаарлах арга хэмжээ**

Норвегийн Парламент 2020 оны 3-р сард КОВИД-19-ийн тархалтыг хязгаарлахад чиглэсэн хэд хэдэн арга хэмжээ авсан. Жишээлбэл, 2020 оны 3-р сарын байдлаар Парламент хэлэлцэх асуудлынхаа тоог багасгасан.

2020 оны 3, 4-р сард зөвхөн зайлшгүй шаардлагатай асуудлуудаар танхимд хуралдсан байна. Парламентын спикер намын удирдлагатай урьдчилан зөвлөлдөж, ярилцсаны дараа ямар асуудлыг яаралтай шийдвэрлэхээ тодорхойлох болсон.

2020 оны 3-р сард Коронагийн тухай хуулийг хоёр дахь хэлэлцүүлгээр батлав.

Энэ хуулиар Норвегийн Засгийн газарт урьд өмнө байгаагүй их эрх мэдэл олгосон гэж шүүмжилж байв.

Коронагийн тухай хуулийн дагуу парламентын гишүүд нэгдэж, Засгийн газраас баталсан аливаа хуулийг хүчингүй болгож болох тухай зохицуулалт туссан.

Байнгын хорооны хуралдааны дэг, хуралдааны дижитал шийдлүүдийг дэмжиж, гишүүд хуралд оролцох боломжийг бүрдүүлсэн.

<sup>75</sup> Мөн тэнд., Page 14.

Хуралдааны санал хураалт, хэлэлцүүлэг нь цахим хэрэгслийг ашиглан явагдах боломжтой. Гэхдээ аль дижитал платформыг ашиглаж байгаа талаарх мэдээллийг ямар ч хуульд зааж өгөөгүй байна.

Парламент мөн КОВИД-19-ийн асуудлаар тусгай хороо байгуулан долоо хоног бүр хуралдах ба үүнд Парламентад суудалтай 9 намын гишүүд орно.<sup>76</sup>

Бүх уулзалтууд танхимыг парламентын вэбсайтаар онлайнаар шууд дамжуулж байна.<sup>77</sup>

## **ЛАТВИ УЛС**

Латви улсад 11-р сарын 16-ны өдөр КОВИД-19-ийн 89 шинэ тохиолдол бүртгэгдсэн.

2020 оны 11-р сарын 10-ны ээлжит бус хуралдаанаар Сейм нь КОВИД-19 хурдацтай тархаж, эрүүл мэндийн тогтолцоонд хэт ачаалал өгөх эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан Онц байдал зарлах тухай Засгийн газрын шийдвэрийг хянаж батлав. Шийдвэрийн дагуу 12-р сарын 6-ны өдрийг хүртэл улс даяар онц байдал зарласан. 5-р сарын 26-ны өдрийн хуралдаанаар Сеймийн боловсруулсан цахим Сеймийн шинэ платформыг ашиглаж эхэлсэн. Энэ нь чуулганы нэгдсэн хуралдааныг алсаас зохион байгуулж, Сеймийн гишүүд чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудлыг тухайн цаг хугацаанд нь хэлэлцэж, санал хураалт явуулах боломжийг олгосон. Цахим Сейм платформыг цахим гарын үсгийг ашиглан тусгай вэбсайтаар дамжуулан авах боломжтой. Санал хураалтын горим идэвхжсэний дараа Парламентын гишүүд “зөвшөөрөх”, “эсэргүүцэх”, “түдгэлзэх” гэсэн гурван товчлуурын аль нэгээр санал өгөхөд 30 секундын хугацаатай байна. Энэ хугацаанд Парламентын гишүүд саналаа өөрчилж болно. Санал хураалт дуусахад үр дүнг нэгдсэн хуралдааны танхимын суудал төлөвлөгөөний дагуу дэлгэцэн дээр гаргана. Цахим Сейм вэбсайт дээр хуралдаанд оролцож байгаа гишүүдийн талаарх мэдээлэл, хэлэлцэх асуудал, үйл явцын дараалал, илтгэгчдийн жагсаалт, санал хураалтын дүн зэргийг мэдээлдэг байна. Сеймийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байна. Сеймийн нэгдсэн хуралдааныг долоо хоногт нэг удаа Пүрэв гарагт хийдэг. Хорооны хурал ихэвчлэн Мягмар, Лхагва, Пүрэв гарагт болдог.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН


<sup>76</sup> <https://www.parliaments-and-crisis-challenges-and-innovations.pdf>

<sup>77</sup> <https://www.loc.gov/law/help/emergency-legislative-activities/emergency-legislative-activities.pdf>




## Чуулганы нэгдсэн хуралдаан (схем 1)

Latvijas Republikas Saeimas 2020.gada 21.maija sēde



## Чуулганы нэгдсэн хуралдааны санал хураалтын дүнг харуулсан байдал (схем 2)



## ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

ОХУ-ын Төрийн Дум КОВИД-19 цар тахлын үед Төрийн Думын хуралдааны дэгийг өөрчлөлгүй ердийн горимоор ажиллаж байна. Төрийн Думын дарга В.Володин 2020 оны 9 сарын 20-ны өдрийн чуулганд хэлсэн үгэндээ “Бид энэ хүнд хэцүү үед Думын үйл ажиллагааг хэвийн явуулж, улс орны өмнө тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай хууль, тогтоомжуудыг цаг алдалгүй батлан гаргаж байх нь чухал байна. Ингэхдээ халдвар, аюулгүй байдлын арга хэмжээг гишүүдийн бүрэн эрхийг хязгаарлахгүйгээр авч хэрэгжүүлнэ. Думын дэгийн хуульд өөрчлөлт оруулалгүйгээр шинэ нөхцөл байдалд ажиллах боломжтой” гэж хэлсэн.



Өнөөдрийн байдлаар Төрийн Дум нь халдвар хамгааллын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Чуулганы танхимд гишүүдийг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зайтай суулгах зорилгоор гишүүдийн суудлыг өөрчлөх;
- Чуулганы хуралдааны хугацааг 15:00 цагаас хэтрүүлэхгүй байх (өмнө нь 17:00 эсвэл, 19:00 цаг хүртэл хуралддаг байсан);
- Чуулганы үеэр гишүүдийн үг хэлэх хугацааг богиносгох (үүнийг гишүүдэд санал болгож байгаа бөгөөд албан бусаар сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлнэ);
- Чуулганы хуралдааны хугацаа богиноссонтой холбогдуулан байнгын хороо, ажлын хэсгийн хурлаар хууль тогтоомжийг илүү сайн судалж, боловсруулах;
- Гишүүд амны хаалт байнга зүүх;
- Халдвар авсан, тусгаарлалтад орсон эсвэл, халдварт өртөх эрсдэл бүхий гишүүдийг (өндөр настай, архаг хууч өвчтэй гэх мэт) аль болох зайнаас хуралд оролцуулах. Ингэхдээ тухайн хэлэлцэж буй асуудлаарх саналыг нь албан бичгээр авах;
- Чуулганы хуралдаан, байнгын хороо болон ажлын хэсгийн хуралдааны үеэр мэдээлэл авах, сонсгол хийх болон бусад Думаас явуулж буй арга хэмжээг “видео конференц” хэлбэрээр явуулах;
- Парламентын ордон дахь буфет, цайны газрыг хаах;
- Төрийн Думын ажлын албаны зайлшгүй ажлын байрандаа ажиллах шаардлагатайгаас бусад ажилтнуудыг зайнаас ажилуулах.

Төрийн дум нь цахим хэлбэрээр санал өгөх асуудлыг одоогоор хэргжүүлээгүй байна.

2020 оны 10-р сарын 26-ны байдлаар нийт 91 гишүүн коронавирусийн халдвар авч, 1 гишүүн нас барсан байна.<sup>78</sup>

### **КАЗАХСТАН УЛС**

Казахстан улсад 2020 оны 3-р сард коронавирусийн тархалтын улмаас хатуу хөл хорио тогтоосон бөгөөд энэ үед парламентын доод танхим буюу Мажилис нь онцгой нөхцөл байдлын дагуу дараах зарчмыг баримтлан ажилласан байна.

1. Мажилисын гишүүд нь доорх тохиолдолд ажлын байрандаа ирж ажиллах. Үүнд:

- Чуулганы хуралдаан хуралдах;
- Байнгын хороод хуралдах;
- Ажлын хэсэг хуралдах.

2. Дээрхээс бусад тохиолдолд зайнаас ажиллах.

3. Чуулганы хуралдааны хуралдаанд доорх хүмүүс оролцох:

- Мажилисын гишүүд;
- хууль санаачлан өргөн барьсан субъектээс хуулийн төслийг танилцуулах хүмүүс.

<sup>78</sup> <http://duma.gov.ru/news/49655/>,  
<http://duma.gov.ru/news/49461/>,  
<http://duma.gov.ru/news/49603/>,  
<http://duma.gov.ru/news/48136/>,

#### 4. Ажлын хэсгийн хуралдаанд доорх хүмүүс оролцох:

- Ажлын хэсэгт орсон Мажилисын гишүүд;
- хууль санаачлан өргөн барьсан субъектээс ажлын хэсгийн хуралдаанд оролцох хүмүүс.

#### 5. Хууль боловсруулах үйл ажиллагаатай холбоотой асуулт, хариулт явуулах, санал болон мэдээлэл авах зэргийг “видео конференц” хэлбэрээр явуулах.

#### 6. Бусад парламентын үйл ажиллагааг мэдээлэл, технологийн дэвшлийг ашиглан зайнаас явуулах.

Түүнчлэн Эрүүл мэндийн сайдын 2020 оны 7-р сарын 5-ны өдрийн тушаалаар батлагдсан “Цар тахлын эсрэг эрүүл ахуй, халдвар хамгааллын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” журамд заасны дагуу бүх албан байгууллагууд ажлын байрандаа дараах эрүүл ахуй, халдвар хамгааллын дүрмийг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Биеийн температурыг хэмжих;
- Ажлын байранд гар ариутгагч байршуулах;
- Ажлын байранд тогтмол цэвэрлэгээ, ариутгал хийх;
- Ажлын байранд хүн хоорондын зайг баримтлах;
- Амны хаалт хэрэглэх, бээлий өмсөх;
- Ажлын байранд орж гарсан хүмүүсийн талаар нарийн тэмдэглэл хөтлөх зэрэг болно.<sup>79</sup>

### **КАНАД УЛС**

Канад улс нь Үндсэн хуульт хаант засаглалтай бөгөөд хууль тогтоох салбар нь хатан хаан, Нийтийн танхим, Сенат гэх гурван хэсэгтэй. Канадын хоёр танхимтай парламентыг Нийтийн танхим (доод танхим) ба Сенат (дээд танхим) бүрдүүлдэг. Амбан захирагч нь ерөнхий сайдын зөвлөмжийн дагуу Канадын муж, нутаг дэвсгэрийг төлөөлөх 105 хүнийг Сенатад томилдог. Харин Нийтийн танхимд суух 335 парламентын гишүүд нь (УИХ-ын гишүүд) сонгуулийн журмаар сонгогддог.<sup>80</sup>

Онцгой байдлын үе дахь парламентын үйл ажиллагааны тусгай дүрэм гэж байдаггүй. 1867 оны Үндсэн хуулийн дагуу бүрэн эрхтэй Нийтийн танхимын хуралдааныг бүрдүүлэхэд 20 гишүүний (Нийтийн танхимын дарга үүнд багтана) кворум шаардлагатай.<sup>81</sup>

### **КОВИД-19 цар тахлын үеийн парламентын үйл ажиллагаа**

2020 оны 3-р сарын 13-нд Канад улсын Нийтийн танхимд суудалтай намууд КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор парламентыг дор хаяж 4-р сарын 20 хүртэл түдгэлзүүлэхийг санал нэгтэй зөвшөөрөв. Гэвч 2020 оны 3-р сарын 23-ны Засгийн газрын хуралдаанаар “КОВИД-19 цар тахлын эсрэг хэрэгжүүлэх яаралтай арга хэмжээ”-г батлахын тулд тус 7 хоногт парламентын хуралдааныг яаралтай хуралдуулахаар зарлажээ. Нийтийн танхимыг зохицуулах

<sup>79</sup> Санитариялық-эпидемияға қарсы және санитариялық-профилактикалық іс-шараларды ұйымдастыру мен жүргізудің кейбір мәселелері туралы <http://adilet.zan.kz/kaz/docs/V2000020935>

<sup>80</sup> [https://www.ourcommons.ca/About/ProcedureAndPractice3rdEdition/ch\\_01\\_1-e.html](https://www.ourcommons.ca/About/ProcedureAndPractice3rdEdition/ch_01_1-e.html)

<sup>81</sup> <https://laws-lois.justice.gc.ca/eng/Const/FullText.html>

журамд парламентын гишүүд онлайнаар санал өгөх, хуралдах талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй тул зарим гишүүд хуралд биечлэн оролцох шаардлагатай.<sup>82</sup> Дээр дурдсанчлан “санал хураалтыг хүчин төгөлдөр болгохын тулд Нийтийн танхимын даргыг оролцуулан дор хаяж 20 гишүүн оролцох ёстой.” 2020 оны 3-р сарын 24-ний өдрийн парламентын яаралтай хуралдаанд парламентын 32 гишүүн оролцон, 82 тэрбум Канад долларын (61.5 тэрбум орчим ам доллар) КОВИД-19 цар тахлын үеийн санхүүгийн тусламжийн багцыг баталжээ.

2020 оны 4-р сарын 11-нд Канадын парламент хуралдаж КОВИД-19 цар тахлын эсрэг зарим арга хэмжээний талаарх хууль тогтоомжийг батлав. Үүний дараагаар:

- Нийтийн танхим 2020 оны 4-р сарын 20 өдрөөс 8-р сарын 12 хүртэл 9 удаа хуралдаж, 9-р сарын 23 хүртэл завсарласан.

Нийтийн танхимын Ажлын албаны ажилтнууд:<sup>83</sup>

- 2020.03.16-ны өдрөөс эхлэн: Ажилтнуудыг онлайн хэлбэрээр (зайнаас) ажиллахыг зөвлөсөөр байна.
- 2020.03.16-ны өдрөөс эхлэн: Ажлын байран дээр биечлэн ирж ажиллах шаардлагатай ажилтнуудыг хариуцсан дарга нар нь мэдэгдэх ёстой.
- 2020.09.18-ны өдрөөс эхлэн: Ажлын байранд ажиллах ажилтнууд нийтийн эзэмшлийн зайд (хоолны заал, ариун цэврийн өрөө, цахилгаан лифт, корридор гэх мэт) маск зүүж байх ёстой. Мөн хүмүүсээс 2 метрийн зай барих боломжгүй үед маск зүүх шаардлагатай.

Парламентын (Нийтийн танхимын) гишүүд:<sup>84</sup>

- 2020.09.23-ны өдрөөс 2020.12.11-ныг хүртэл: Нийтийн танхим нь холимог (гибрид) хэлбэрээр хуралдуулах болон онлайн хэлбэрээр (зайнаас) санал хураах зохицуулалтыг батлав.

Гишүүд танхимын үйл ажиллагаанд биечлэн эсвэл видео хурлаар оролцож болно.

Биечлэн оролцсон гишүүдийн хувьд Хурлын дарга эхлээд тухайн саналыг дэмжсэн, дараа нь эсэргүүцсэн хүмүүсийг дуудна. Гишүүд дуудсан үед саналаа өгөх ёстой.

Танхимд байгаа гишүүдийн нэрсийг дуудаж дууссаны дараа зайнаас оролцогч гишүүдийн нэрийг намууд болон хүснэгтийн жагсаалтад үндэслэн цагаан толгойн дарааллаар дуудах болно. Гишүүд санал өгөх хугацаанд видео бичлэг болон микрофоноо асааж баталгаажуулах ёстой. Гишүүний нэрийг дуудмагц микрофоноо асааж, “Би энэхүү саналыг дэмжиж байна” эсвэл “Би эсрэг санал өгч байна” гэж тодорхой хэлэх ёстой.

## **ЯПОН УЛС**

Тус улс Халдвар хамгааллын журмыг хамгийн сүүлд 2020 оны 3 сард баталсан. Гэвч шинэ коронавирусийн 2 дахь давалгааны (2020.8.28) нөхцөл байдлаас шалтгаалан Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яамнаас коронавирусийн халдвараас сэргийлэх санамж бичиг гаргасан байна.

<sup>82</sup> [https://www.loc.gov/law/help/emergency-legislative-activities/canada.php#\\_ftnref12](https://www.loc.gov/law/help/emergency-legislative-activities/canada.php#_ftnref12)

<sup>83</sup> <https://www.ourcommons.ca/Content/Newsroom/Articles/Statusupdate1to25-EN-Nov-10.pdf>

<sup>84</sup> <https://www.ourcommons.ca/Content/Newsroom/Articles/Factsheet-Hybrid%20record-ed%20divisions-e.pdf>

*Уг санамж бичигт:*

- Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх Засгийн газрын тогтоолуудыг дахин хянаж, шинэчлэн найруулах, өөрчлөх;
- Хяналтын системийг өргөжүүлэх. Үүнд:
  - Урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг гаргах;
  - Сорилог хурдан шуурхай авах;
  - Орон нутагт эмнэлгийн тусламжийн системийг сайжруулах.
- Хяналт шалгалтыг хийх. Үүнд:
  - Халдвар авсныг эс тооцон суурь өвчтэй болон өндөр настан хүмүүст үзлэг шинжилгээг хийх;
  - Гэрийн эмчилгээний аргыг сайжруулах;
  - Эмнэлгийн нөөц бололцоог нэмэгдүүлэх;
  - Эрүүл мэндийн төвүүдийн боловсон хүчний тогтолцоог бэхжүүлэх, санхүүгийн арга хэмжээг авах.
- Халдварт өвчний үеийн менежментийн тогтолцоог хөгжүүлж мэдээлэл цуглуулах, халдварын эсрэг авах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд түргэн шуурхай явуулах.
- Халдвар судлалын үндэсний хүрээлэн, Олон улсын анагаах ухааны үндэсний төв хамтран нөхцөл байдлыг цаг алдалгүй үнэлэх, мэдээллээр ард олныг хангах системийг бий болгох талаар дурджээ.

*Тусгаарлалт зай барих журмын хувьд:*

- Олон хүн цугларсан газраас зайлсхийх;
- Өрөө тасалгаанд агааржуулалт сайн хийх;
- Гадуур явахгүй байх;
- Зайлшгүй гадагш гарах тохиолдолд маск зүүх зэрэг халдвар хамгааллын дэглэмийг баримтлахыг журамласан.

2020.10.23-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Дархлаажуулалтын тухай хууль, Хорио цээрийн тухай хуулийг хэсэгчлэн шинэчлэх тухай хуулийн төслийг баталсан.

**ИСПАНИ УЛС**

Испани Улсад КОВИД-19-ийн халдварын 1.521.899 тохиолдол бүртгэгдсэнээс 41.253 хүн нас барсан байна. 2020.10.25-нд тус улсын Ерөнхий сайд КОВИД-19-ийн 2 дахь давалгаатай холбоотойгоор улсын хэмжээнд Онц байдлыг тодорхойгүй хугацаагаар зарлан, шөнийн 23.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл хөл хорио тогтоосон байна. Конгрессын зарим гишүүд Онц байдлыг 5 дугаар сар хүртэл сунгах шаардлагатай байна гэсэн байр сууриа илэрхийлж байсан ба халдварын тохиолдол нэг хоногт 23580 бүртгэгдсэнээс шалтгаалан Онц байдлыг 6 сараар сунгасан байна. Мөн 6-аас дээш хүн цуглахыг хоригложээ.

Испани Улсын Үндсэн хуульд улс орныг хамарсан гэнэтийн аюул тохиолдсон үед тус улсын Гүйцэтгэх засаглалын тэргүүн 15 хоног хүртэлх хугацаанд Онц байдал зарлах эрхтэй бөгөөд үргэлжлүүлэх шаардлагатай тохиолдолд Конгрессын зөвшөөрлийг авдаг байна.

2020.03.12-нд Парламентын үйл ажиллагааг, Ерөнхий сайдын санал болгосноор Парламентын гол намуудын төлөөллүүдтэй зөвшилцөн, тус улсын эрүүл мэндийн салбарын удирдлагуудын зөвлөснөөр 2 долоо хоногийн хугацаанд зогсоосон байна. Конгресс нь улс орны яаралтай чухал асуудлуудаар хугацаа алдалгүй шийдвэр гаргаж байхаа мэдэгдсэн байна. Сүүлийн үеийн дэвшилтэт технологи ашиглан цахим хуралдаан, санал хураалт явуулж байгаа бөгөөд Испани Улсын парламентын хувьд алсын зайнаас санал өгөх тухай 2012.05.21-ний Конгрессын танхимын удирдлагуудын баталсан шийдвэрийг мөрддөг бөгөөд Сенатад мөн ижил шийдвэрийг батлан мөрдөж эхэлсэн байна. Энэ нь өвчтэй, төрөхийн амралтаа авсан гэх мэт шалтгааны улмаас хуралдаанд оролцон, санал өгөх боломжгүй байгаа гишүүдийг хамруулахыг зорьсон үйл ажиллагаа юм. Энэхүү цар тахалтай холбоотой тус арга хэмжээг өргөжүүлэн бүх гишүүдийг алсын зайнаас хуралд оролцох, санал өгөх боломжийг ханган ажиллаж байна.

Энэхүү цар тахалтай холбоотой парламентын 2 танхим ажлын байран дээр халдвар тархах аюулаас сэргийлэх үүднээс үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Цар тахлын аюулаас сэрэмжлүүлсэн мэдээлэл бүхий зурагт хуудас байрлуулах, парламентын ордны орох хаалга, цахилгаан шат, ресторан гэх мэт газруудад гар ариутгалын бодис байрлуулах, нийтийн байнгын хэрэглээний газруудад тогтмол ариутгал, цэвэрлэгээг хийх гэх мэт арга хэмжээг авч байна. Парламентын ордонд зочлох болон бусад төрлийн үйл ажиллагаа зохион байгуулахыг бүрэн хориглосон. Парламентын ордны ажилтнууд цахимаар ажил үүргээ гүйцэтгэж байна.<sup>85</sup>

## ИХ БРИТАНИ УЛС

### КОВИД-19 цар тахлын үед парламентын хуралдаанд хэрэгжүүлж буй түр зохицуулалтууд

КОВИД-19 цар тахалтай холбогдох хууль, хуулийн төслийг боловсруулан, хэлэлцэн, баталсан:

- 2020 оны Коронавирусийн тухай хууль (Coronavirus Act 2020)<sup>86</sup>
- Коронавирусийн тухай хуулийн төсөл: Орон нутгийн эрх баригчдын уулзалт<sup>87</sup>

#### Нийтийн танхим:

- *Олон нийтийн эрүүл мэндийн талаарх удирдамжийг* хангах үүднээс Танхимын хуралдаан, парламентын үйл ажиллагаанд зайнаас оролцох арга хэмжээ авч ажиллаж байна;
  - Нийтийн танхимын танхимд нэг дор 50-аас илүүгүй гишүүд оролцоно. Танхим дахь гишүүн хоорондын зайг 2 метр байхаар зохицуулсан.
  - Танхимын гишүүн танхимд аюулгүй нэвтрэх, гарах зохих нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Танхимын дарга хэлэлцэх асуудлын хооронд хуралдааныг түр хугацаагаар завсарлуулж болно.
- Урьдчилан нийтэлсэн ирцийн жагсаалтаар дамжуулан Танхим дахь ирц бүртгэнэ;

<sup>85</sup> <https://www.ipu.org/country-compilation-parliamentary-responses-pandemic#M>

<sup>86</sup> <https://www.legislation.gov.uk/ukpga/2020/7/contents/enacted>

<sup>87</sup> <https://commonslibrary.parliament.uk/research-briefings/cbp-8873/>

- Зарим Танхимын гишүүд зарим парламентын процесст алсаас оролцох боломжтой;
- Хуралдаанд эрүүл мэндийн шалтгааны улмаас оролцох боломжгүй гишүүд *итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр* дамжуулан санал өгөх боломжтой.
- Гишүүд хуралдааны танхимын гадна байрлах 4 электрон төхөөрөмжид хуваагдан өөрсдийн үнэмлэхээрээ дамжуулан санал хураалтад оролцож ба<sup>88</sup> одоогийн байдлаар Парламентын цахим үйлчилгээ дотоод сүлжээг ашиглан цахим хэлбэрээр оролцож байна.<sup>89</sup>
- Хороодууд цахим болон танхимын хэлбэрээр явагдаж байна. Ингэснээр хороод завсарлагын үеэр хуралдахад илүү хялбар болсон.

#### Лордуудын танхим

- Лордуудын танхимын хороодууд цахим хэлбэрээр хуралдаж байна.<sup>90</sup>
- Гишүүд цахим платформуор дамжуулан санал хураалт явуулж байна. Иргэд, олон нийт санал хураалтын дүн болон холбогдох мэдээллийг парламентын цахим хуудсаар дамжуулан үзэх боломжтой.<sup>91</sup>

Иргэд, олон нийт танхим, хороодын хуралдааныг парламентын телевизийн сувгаар дамжуулан үзэж болно.

#### Онцлох зохицуулалтууд цаг хугацааны эрэмбээр:

2020.04.21-2020.05.20 - Хуралдааны танхимд нийтийн танхимын гишүүд биечлэн оролцох, хуралдаанд алсаас цахим хуралдааны хэрэгсэл болох Зүүм платформ эсвэл утсаар дамжуулан ирц бүрдүүлж, холимог (гибрид) хэлбэрээр хуралдаанд оролцох асуудлыг зохицуулсан байна. Энэ үеэр Нийтийн танхим Даваа, Мягмар, Лхагва гарагт хуралдав. Алсаас оролцсон гишүүдэд техникийн зарим асуудлууд үүссэн байна.

2020.06.02-2021.03.30 - Нийтийн Танхим нийгэм, олон нийтийн эрүүл мэндийн удирдамжийн дагуу биечлэн болон алсаас оролцох холимог горимд эргэн шилжсэн. Харин, цар тахлын хоёрдугаар давлагаатай холбогдуулан зарим гишүүд бүтэн цахим горимд шилжих хүсэлт гаргаж байна.

2021.03.30-ний өдөр хүртэл КОВИД-19 цар тахлын шалтгаантай холбоотойгоор эрүүл мэндийн болон олон нийтийн эрүүл мэндийн шалтгаанаар хуралдаанд биечлэн оролцох боломжгүй зарим гишүүдийг алсаас оролцох боломжийг олгох түр зохицуулалтыг хэрэгжүүлж байна. Эдгээр гишүүдэд асуулт болон мэдэгдэл хүргүүлэх процесст алсаас оролцох зөвшөөрөл олгосон боловч хууль, тогтоомжийн хэлэлцүүлэг, мэтгэлцээнд алсаас оролцох боломжгүй байна. (2020.11.17-ны өдрийн байдлаар)

<sup>88</sup> <https://www.parliament.uk/about/how/covid-19-hybrid-proceedings-in-the-house-of-commons/>

<sup>89</sup> <https://apo.org.au/sites/default/files/resource-files/2020-05/apo-nid305235.pdf>

<sup>90</sup> <https://www.parliament.uk/about/how/changes-to-lords-proceedings/changes-to-work-in-the-lords-chamber-and-committee-/>

<sup>91</sup> <https://votes.parliament.uk/Votes/Lords>

## **ЭНЭТХЭГ УЛС**

Энэтхэгийн парламентын нийт гишүүдийн хуралдаанд оролцоходоо зай баримтлах протоколын нөхцлийг хангах үүднээс дээд (Ражяа Сабха) болон доод (Лок Сабха) танхимуудын хуралдааны танхимууд болон галерейд 2 танхим ээлжлэн хуралдхаар тов гарган зохион байгуулсан. Гишүүд хуралдаанд нэгэн зэрэг оролцох зохицуулалт хангах үүднээс танхимуудад хуралдаан цацах дэлгэц суурилуулсан.

Хуралдааны танхимуудад поликарбонат тунгалаг тусгаарлагчаар хангасан ба гишүүд маск, бээлий өмсөж оролцоно.<sup>92</sup> (Аадар борооны ээлжит хуралдаан).

Хуралдааны ирцийг биечлэн бүртгүүлэхийн боломжтой хэдий ч гар утасны програмаар дамжуулан хуралдааны ирц бүртгүүлэхийг 1546 тоот шийдвэрт зөвлөсөн. Тухайн програм нь зөвхөн парламентын ордны зөвшөөрөгдсөн хэсэгт ажиллана.<sup>93</sup>

Гишүүдийг чуулганы хуралдаанд оролцохын өмнө RT-PCR шинжилгээнд хамруулдаг.

Чуулганы үеэр парламентын ордонд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрэхийг хязгаарлаж цөөн тооны сурвалжлагч, сэтгүүлч нарыг нэвтрүүлж байна. Ням гарагт КОВИД-19 туршилтыг парламентын ордон доторх хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан.

Парламентын хоёр танхимын ариутгалыг хангах үүднээс тус бүр 20 хүний бүрэлдэхүүнтэй хоёр тусгай баг байгуулсан. Ариутгалын ажилтнууд хуралдаан эхлэхээс өмнө, завсарлага бүрийн үеэр, мөн өдрийн хуралдааны төгсгөлд хоёр танхимыг гүн цэвэрлэнэ.

Хууль санаачлагчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хоол ундны хэрэгцээг хангахын тулд урьдчилан захиалсан катеринг хайрцганд хийлгүүлж хүргүүлж байна.<sup>94</sup>



<sup>92</sup> <https://theprint.in/india/held-amid-covid-this-parliament-session-was-shortest-in-20-years-but-most-productive/509259/>

<sup>93</sup> [http://loksabhapn.nic.in/writereaddata/Updates/EventLSS\\_637355920742783684\\_Document%20\(24\).pdf](http://loksabhapn.nic.in/writereaddata/Updates/EventLSS_637355920742783684_Document%20(24).pdf)

<sup>94</sup> [http://www.xinhuanet.com/english/2020-09/13/c\\_139365487.htm](http://www.xinhuanet.com/english/2020-09/13/c_139365487.htm)



**КОВИД-19 ЦАР ТАХЛААС МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ  
ҮҮССЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ, ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

(2020 оны 11-р сарын 20-ны байдлаар)

*Г.Уянга*

**АГУУЛГА**

**1.МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ**

1.1 ДНБ-ний мэдээлэл

1.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

1.3 Ядуурал

**2. ХҮН АМ**

2.1 Зээлтэй иргэдийн тоо, зээлийн хэмжээ

2.2 Нийгмийн даатгалын сан, халамжийн сан

**3. АЖ ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА**

3.1 МҮХАҮТ-аас явуулсан судалгааны үр дүн

3.2 ААН-н зээлийн үлдэгдэл

**4. БАНК, САНХҮҮ**

**5. ЭРҮҮЛ МЭНД**

5.1 КОВИД-19-ийн эмчилгээ

5.2 Хөл хорионы үеийн гэмтлийн мэдээлэл

**6. БОЛОВСРОЛ**

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

## 1.МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ

2008 оны сүүл, 2009 онд АНУ-с эхэлсэн дэлхийн санхүүгийн хямралын үед Монгол Улсын эдийн засгийн өсөлт анх удаа хасах гарч байсан. Энэ үед ашигт малтмалын үнэ бууж, экспортын орлогын хэмжээ төдий чинээ бууж байсан юм. Харин 2020 оны 11 сарын байдлаар Монгол Улсын эдийн засаг 2008 оны хямралаас илүү муудаж -7.3 хувиар агшсан байна.

### 1.1. ДНБ-ний мэдээлэл

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2020 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 12.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.0 (7.3%) их наяд төгрөгөөр буурсан. Үүнд:




Эх сурвалж: nso.mn

**Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын 2020 оны эхний 10 сарын тайланд:** ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 7.3 хувиар буурахад уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 595.5 (20.7%) тэрбум төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 401.4 (7.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлөв.

### 1.2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

**Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ** 2020 оны 10 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.4 хувиар, өмнөх оны эцсээс 2.3 хувиар, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар өссөн байна. Үүнд:

УИХ МН  
СУДАЛГААНЫ САН



Эх сурвалж: nso.mn

**Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын 2020 оны эхний 20 сарын тайланд:** Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар өсөхөд:

- хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.7 хувиар өссөн
- согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.6 хувиар өссөн
- хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.8 хувиар өссөн
- орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 2.8 хувиар өссөн
- эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувиар өссөн
- тээврийн бүлгийн үнэ 4.5 хувиар буурсан байна.

### 1.3. Ядуурал

2018 онд Үндэсний Статистикийн хорооноос тооцсон Монгол Улсын ядуурлын түвшинд 71.6 хувийг ядуу бус иргэд эзэлж байсан бол үлдсэн 28.4 хувийг ядуу иргэд эзэлж байсан үзүүлэлттэй байна. Энэ нь нийт иргэдийн 900'0 гаруй нь ядууралд өртсөн гэсэн үг юм.



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол


Улсын хэмжээнд 2010 онд ядуурлын шугам 146,145 төгрөг байсан бол 2018 онд 166,580 төгрөгт хүрч 8 жилийн дотор нийтдээ 20,435 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Ядуурлын хамралтын хүрээний индекс буюу ядуурлын түвшин нь нийт хүн амд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувийг харуулна.<sup>95</sup>



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Ядуурлын түвшин улсын дундаж, хот болон хөдөө гэх ангиллаар харьцангуй ялгаатай байна. Ядуурлын хамралтын хүрээ 2016 оны байдлаар 907.5 мянган хүн буюу нийт хүн амын 29.6 хувийг эзэлсэн. Хоёр жилийн дараах 2018 оны байдлаар 904.9 мянган хүн буюу 28.4 хувийг эзэлж буй нь уг дүн 1.2 хувиар буурсныг харуулж байна.



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Монгол Улсын хэмжээнд ядуурлын хамралтын хүрээг бүс нутгаар нь буюу Баруун бүс, Хангайн бүс, Төвийн бүс, Зүүн бүс мөн Улаанбаатар хот гэх ангиллаар 2010-2018 оны хооронд тусгав. Дээрхээс харахад, 2016 оны байдлаар хамгийн өндөр үзүүлэлттэй байсан Зүүн бүсийн хувьд 43.9 хувиас 2018 онд 6.5 хувиар буурч 37 хувьд хүрсэн байна. Түүнчлэн Баруун бүс болон Хангайн бүс 3-5 хувь тус бүрчлэн буурсан. Төвийн бүсийн хувьд 0.7 хувиар түвшин буурсан бол Улаанбаатар хотын хувьд 1.1 хувийн өсөлттэй харагдаж байна.


<sup>95</sup> World Bank, 2019, УБ хот

Үүнээс харахад, хүмүүс илүү таатай нөхцөл, боломжийг эрэлхийлж Улаанбаатар хот болон бусад хот суурин газрыг зорьж буй хандлагатай байна. Сүүлийн арван жилд Улаанбаатар хотын гэр хороолол хурдацтайгаар хүрээгээ тэлсэн. Гэр хорооллын нийт хүн амын 38 хувь нь ядуу байгаа бөгөөд өрхийн тэргүүн нь ажилгүй, боловсролын түвшин багатай, нийгмийн халамж тэтгэмжээр амьдардаг, албан бус салбарт ажилладаг гэр хорооллын өрхүүд ядууралд өртөж байна.

## 2. ХҮН АМ

10 сарын 31-ны өдрийн байдлаар Монгол Улсад хөдөлмөрийн насны 2150.0 мянган хүн ам байгаа бол, ажиллах хүчний 1288.6 мянган хүн ам, харин ажиллах хүчнээс гадуурх 881.4 мянган хүн ам байна.

Монгол Улсын хэмжээнд хүн амын амьжиргааны доод түвшинг нэг хүнд сард ногдохоор 5 ангилалд бүсээр хуваан тооцсон үзүүлэлтээс харахад, 2001 онд Улаанбаатар хотод 23,600 төгрөг ногдож байсан бол 2019 оны байдлаар 217,900 төгрөгт хүрч өссөн байна. Монгол Улсын хэмжээнд баруун бүс, хангайн бүс, төвийн бүс, зүүн бүс болон Улаанбаатар хотод хүн амын амьжиргааны доод түвшин 2001 оноос 2019 он хүртэл тасралтгүй өссөн байна.



Эх сурвалж: Нэг хүнд сард ногдох хэрэглээ, хэрэглээний үндсэн бүлэг, улсын дундаж, нийт ядуу болон ядуу бус иргэдийн хэрэглээтэй харьцуулсан байдал (ҮСХ)


### 2.1 Зээлтэй иргэдийн тоо, зээлийн хэмжээ

Монголбанкны 10 сарын тайланд нийт МУ-д 1,397,138 хэвийн зээлтэй хүн ам байна.





Монголбанкны 10 сарын тайланд хэвийн зээлийн 17,042,921.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.



## 2.2 Нийгмийн даатгалын сан, халамжийн сан

2020 оны эхний 10 сард нийгмийн даатгалын сангийн орлого 2.1 их наяд төгрөг, зарлага нь 2.6 их наяд төгрөг байна. Харин ажилгүйдлийн даатгалын сангаас 17.9 мянган хүнд 41.5 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Нийгмийн халамжийн сангаас 2020 оны эхний 10 сард 2.4 сая хүнд 1.3 их наяд төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна. Үүнд нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж өмнөх оны мөн үеэс нэмэгдэхэд 18 хүртэлх насны хүүхдэд олгосон тэтгэмжийн хэмжээ 648.6 тэрбум (4.4 дахин) төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

## 3. АЖ ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА

Худалдааны салбарын нийт борлуулалт 2020 оны эхний 9 сард 15.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.7 (9.8%) их наяд төгрөгөөр буурсан байна. Үүнд:

- Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2020 оны эхний 9 сард 9.6 их наяд төгрөг

- Бөөний худалдааны борлуулалтын орлого 5.6 их наяд төгрөг байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2020 оны 3-р улиралд 114.6 тэрбум төгрөг, зочид буудлын салбарын орлого 2020 оны эхний 9 сард 101.7 тэрбум төгрөг байсан бол хөл хорионы үед уг салбаруудын үйл ажиллагааг зогсоосон энэхүү салбаруудын орлого 4-р улиралд өмнөх оны энэ үеэс 40 хувь буурах шинжтэй байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны эхний 10 сард урьдчилсан гүйцэтгэлээр 13.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (12.5%) их наяд төгрөгөөр буурсан байна. Үүнд:

- Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1.8 (16.3%) их наяд төгрөг
- Цахилгаан хий, уур, агааржуулалтын салбарын үйлдвэрлэл 67.8 (7.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2020 оны эхний 10 сард урьдчилсан гүйцэтгэлээр 15.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (11.2%) их наяд төгрөгөөр буурсан. Үүнд:

- Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 1.7 (14.4%) их наяд төгрөг
- Боловсруулах аж үйлдвэрийн салбарын борлуулалт 316.4 (7.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан

### 3.1 МҮХАҮТ явуулсан судалгааны үр дүн

МҮХАҮТ 03 сард КОВИД-19 вирусийн халдвар, тархалтаас сэргийлэх арга хэмжээний ажлын байранд үзүүлж байгаа үр нөлөө ба шаардагдаж буй дэмжлэгийг тодорхойлох зорилгоор 2020 оны 3 сарын 20-23 өдрүүдэд МҮХАҮТ-ын гишүүн болон гишүүн бус 1504 аж ахуйн нэгжийг хамруулан “КОВИД-19 вирусийн ажлын байрны нөлөөллийн судалгааг” явуулсан байна. Энэхүү судалгаанд оролцсон ААН-үүдийг салбараар харвал 19% нь худалдаа, 15% нь үйлчилгээ, 13% нь аялал жуулчлал, 9% нь хүнсний үйлдвэрлэл, 6% нь хөнгөн үйлдвэрлэл ба 40% нь бичил, 39% нь жижиг дунд, 21% нь орлоготой том аж ахуй нэгж бөгөөд 51% нь 10 жилээс дээш үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд:

- Бизнес дэх нөлөө



Эх сурвалж: МҮХАҮТ


• Ажлын байрны тооны өөрчлөлт




Эх сурвалж: МҮХАҮТ

Ажлын байрыг хадгалахад төрөөс үзүүлэх шаардлагатай бусад дэмжлэг гэсэн нээлттэй асуултад зээлийн төлбөрийн асуудлаар Засгийн газар Монголбанкны хамтарсан шийдвэр гаргах, түүнийг бодитой хэрэгжүүлэх; түрээсийн зардлыгтэ бууруулах талаар талууд нэгдсэн шийдэл гаргах, хэрэгжүүлэх; цахилгаан, дулааны төлбөрөөс хөнгөлөх; хорио цээрийн үед бизнесийн зохицуулалт, тусгай зөвшөөрөл, төрийн худалдан авалтын шаардлагыг бууруулах, бизнест үзүүлэх төрийн үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай болгох гэж олон ААН хариулсан байна. Түүчлэн хөрөнгө оруулалтыг оновчтой болгох; гадаад худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн олон улсын тээврийн хуваарийг тодорхой болгох; 2020 онд гадаадын жуулчдад визийн хөнгөлөлт үзүүлэх, хорио цээрийн дараа 8-10 саруудад жуулчдын визийг нисэх буудал дээр олгох; төрийн байгууллагын худалдан авалтыг импортыг орлох дотоодын бараа бүтээгдэхүүнээс хийх; ургац хураах үеэр аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх; хорио цээрийн дэглэмийг тодорхой түвшинд сулруулах шаардлага байна гэж цөөн тооны оролцогчид үзсэн байна.

3.2 ААН-н зээлийн үлдэгдэл



Эх сурвалж: Монголбанк



Эх сурвалж: Монголбанк

#### 4.БАНК, САНХҮҮ

Монгол Улсын хэмжээнд 11 сарын 14-ний байдлаар банкны төлбөр тооцоо хэвийн үргэлжилж байгаа бөгөөд нийт 76,721 ширхэг пос машин, 2732 ширхэг АТМ ажиллаж байна.

Эх сурвалж: Монголбанк



Монголбанкнаас КОВИД-19 цар тахалд өртсөн иргэд, аж ахуйн нэгжүүд хэрэглээний болон бизнесийн зээлийн эргэн төлөлтөө банктайгаа тохиролцон хойшлуулах боломжийг олгосон зохицуулалтыг энэ оныг дуустал үргэлжлүүлж байгаагаа мэдэгдсэн. Үүнд:

3.7 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийгдсэний 2.2 их наяд төгрөг нь бизнесийн зээл, 1.5 их наяд төгрөг нь иргэдийн зээл байна. Иймд КОВИД-19 цар тахлаас үүдэн орлого, үйл ажиллагаанд хүндрэл үүссэн иргэд, аж ахуйн нэгжүүд

харилцагч банкиндаа хандан зээлдээ бүтцийн өөрчлөлт оруулах асуудал нээлттэй байгааг мэдэгдсэн.

Өнөөдрийн байдлаар МБ-д нийт 125,206 зээлдэгчийн 5.3 их наяд төгрөгийн зээл КОВИД-19 цар тахалд өртсөн нь нийт зээлийн багцын 33 хувийг бүрдүүлж байна.

Төрөөс хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй нөхцөлтэй ипотекийн зээлийн төлбөрийг түр хугацаанд хойшлуулах арга хэмжээ энэ оны 5 дугаар сараас 10 дугаар сарын хооронд 6 сарын хугацаанд хэрэгжсэн. Энэ хугацаанд нийт 38,152 зээлдэгчийн 2.0 их наяд төгрөгийн зээлийн төлбөрийг 6 сарын хугацаатайгаар хойшлуулсан билээ. Монголбанкны зүгээс Засгийн газартай зөвшилцож, дэмжих тохиолдолд энэ арга хэмжээг үргэлжлүүлэх боломжтой гэж үзэж байгаагаа мэдэгдсэн.

Банкны салбарт нийт 9.2 сая харилцах, хугацаагүй болон хугацаатай хадгаламжийн дансанд нийт 21.7 их наяд төгрөгийн эх үүсвэр байршиж байна. Энэ оны 10 дугаар сарын дүнгээр банкны салбараас эх үүсвэрт төлж буй 1 сарын хүүний зардал 184.7 тэрбум төгрөг байгаа нь банкны хүүний орлогыг хязгаарлах тохиолдолд томоохон алдагдал үүсэхийг харуулж байгааг илэрхийлсэн.

## **5. ЭРҮҮЛ МЭНД**

### **5.1 КОВИД-19-ийн эмчилгээ**

SARS-COV2 вирусийн үржлийг зогсоох Авиган 100mg, Япон улсын ремдисивер 100mg дуслаар 10 хоног тус тус эхний шатны эмчилгээ хийгддэг Хатгаанд шаардлагатай бол антибиотик, хүчилтөрөгчийн дутагдалтай бол хүчилтөрөгчийн хамрын гуурс ба маска өгдөг байна. Хүнд хатгааны үед амьсгалын дутагдалтай бол амьсгалын аппаратад оруулна. Энэ нь өөрөөрөө амьсгалах боломжгүй ашиглана. Эдгээр нь шинж тэмдгийн эмчилгээ буюу одоогоор КОВИД-19 туссан өвчтөнүүдэд ашиглаж байгаа эмчилгээний аргууд юм.

### **5.2 Хөл хорионы үеийн гэмтлийн мэдээлэл**


Гэмтэл согог судлалын үндэсний төв:

2020 оны 11 сарын 01-нээс 11 сарын 16-ны байдлаар ГССҮТөвийн ХАЯТТасгаар 4450 хүн үйлчлүүлсэн ба 2019 оны мөн үеэс 687 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.


Нийт үйлчлүүлэгчдийн 60.5%-ийг эрэгтэй, 39.5%-ийг нь эмэгтэйчүүд эзэлж байна.

Осол гэмтлийн шалтгаанаар авч үзвэл:

- Уналт-2098
- Амьгүй механик хүчинд өртөх-785
- Хүчирхийлэл-453
- Амьтай механик хүчинд өртөх-404
- Зам тээврийн осол-321
- Түлэгдэлт-170
- Байгалийн хүчинд өртөх /хөлдөлт, осолт/-11
- Амиа хорлохыг завдах-9
- Тодорхойгүй осол-147
- Бусад осол-52 байна.







Эх сурвалж: ГССҮТөвийн Статистик мэдээлэл тандалт судалгааны алба

## 6. БОЛОВСРОЛ

2020 оны 11 сарын 18-ны өдрийн байдлаар ЕБС-ийн дотуур байранд 772 хүүхэд, улсын хэмжээнд 71 их дээд сургуулийн 12 мянга гаруй оюутан сургуулийн дотуур байранд байрлаж байна. (Үүнд: нийтийн байр, түрээсийн байр багтаагүй). Улсын болон хувийн их, дээд сургуулиуд өөрсдийн харьяа оюутны байранд амьдарч байгаа оюутнуудыг хоол хүнсээр хангах мөн ариутгал халдваргүйжүүлэлтийг тухайн байгууллагын төсвөөс хийж байна.

2020-2021 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ерөнхий боловсролын 839 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж, 680.837 хүүхэд суралцаж байна. Үүнд:

Үзүүлэлт		2020-2021
<b>Сургууль</b>		<b>839</b>
Өмчийн хэлбэр	Төрийн	672
	Хувийн	167
Байршил	Хот	277
	Хөдөө	562
<b>Бүлэг</b>		<b>22,979</b>
3 дугаар ээлжинд хичээллэдэг бүлэг		8
<b>Суралцагч /өдөр/</b>		<b>680,837</b>
Хүйсээр	эмэгтэй	339,681
	эрэгтэй	341,156
Нийт суралцагчид	Нэгдүгээр ангид суралцагч	78,219
	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч	5,628
	Малчдын хүүхэд	124,444
Төрийн өмчийн сургууль		632,499

Хүйсээр	эмэгтэй	316,021
	эрэгтэй	316,478
Хувийн сургууль		48,338
Хүйсээр	эмэгтэй	23,660
	эрэгтэй	24,678
Суралцагч /орой, эчнээ/		144
Үүнээс	орой	51
	эчнээ	93
Хүйсээр	эмэгтэй	65
	эрэгтэй	79
Дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч		5,340
Хүйсээр	эмэгтэй	1,378
	эрэгтэй	3,962
Дотуур байр		540
Дотуур байранд амьдарч буй хүүхэд		35,000
Хүйсээр	эмэгтэй	18,075
	эрэгтэй	16,925
Нийт багш, ажиллагчид		54,498
Хүйсээр	эмэгтэй	41,986
	эрэгтэй	12,512
Үндсэн багш		34,073
Хүйсээр	эмэгтэй	27,729
	эрэгтэй	6,344

Эх сурвалж: Боловсролын яам

## Гурав. Теле хичээлийн хүртээмж

СӨБ ба БДБ-ын дэд салбарын суралцагчдын теле хичээлд хамрагдалтын мэдээг сүүлийн 2020 оны 2-5 дугаар сард аймаг, сум, хот, хөдөөгөөр нь ангилсан байдлаар, мөн төрийн өмчийн их, дээд сургуулиудын онлайн хичээлд хамрагдалтын тоон мэдээллийг дараах хүснэгтээс үзнэ үү.

№	Аймаг, дүүрэг	Суралцагчдын теле хичээлд хамрагдалтын мэдээ					Дундаж
		2020 он					
		2 дугаар сар	3 дугаар сар	4 дүгээр сар	5 дугаар сар		
		Дундаж хувиар	Дундаж хувиар	Дундаж хувиар	Дундаж хувиар		
1	Архангай	Аймгийн төв	91	93	82	70	84.0
		Сум	72	54	48	48	55.5
2	Баян-Өлгий	Аймгийн төв	68	73	79	78	74.5
		Сум	52	59	64	68	60.8

3	Баянхонгор	Аймгийн төв	65	63	61	60	62.3
		Сум	58	56	53	52	54.5
4	Булган	Аймгийн төв	75	74	73	73	74.0
		Сум	77	75	73	72	74.0
5	Говь-Алтай	Аймгийн төв	61.8	67.3	60.7	62.4	63.1
		Сум	66.4	65.1	61.1	61.5	63.5
6	Говьсүмбэр	Аймгийн төв	77.8	71	65.7	70	71.1
		Сум	82	81.9	81.4	86	82.8
7	Дархан-Уул	Аймгийн төв	56.9	53.6	58.3	66.8	55.0
		Сум	43.7	52.5	55.6	50.8	49.6
8	Дорноговь	Аймгийн төв	75.6	74.2	72.5	73.7	74.0
		Сум	75.6	73.1	70.5	70.2	72.6
9	Дорнод	Аймгийн төв	72	86	85	88	83.0
		Сум	65	73	75	77	72.0
10	Дундговь	Аймгийн төв	68.5	61.4	62.3	64.5	64.2
		Сум	68.5	61.4	62.3	64.5	64.2
11	Завхан	Аймгийн төв	71.48	78.6	66.3	62.3	69.7
		Сум	69.2	65.2	61.2	58.2	63.5
12	Орхон	Аймгийн төв	94.6	95.4	93.6	90.4	93.5
		Сум	92.6	94.4	89.6	87	90.9
13	Өвөрхангай	Аймгийн төв	84	88.3	90.1	80.3	85.6
		Сум	83.7	86.5	88.2	76.2	83.6
14	Өмнөговь	Аймгийн төв	71.3	70.5	65.1	67.7	68.7
		Сум	69.3	63.6	60.6	61.8	63.8
15	Сүхбаатар	Аймгийн төв	80	80	75	73.6	77.2
		Сум	82	78	76.5	72.6	77.2
16	Сэлэнгэ	Аймгийн төв	97	95	92	97	95.3
		Сум	92	85	80	94	87.8
17	Төв	Аймгийн төв	94.06	87.06	77.94	75.16	82.5
		Сум	73	71.86	65.2	62.05	66.8
18	Увс	Аймгийн төв	86.2	67.1	71.8	64.6	72.4
		Сум	72.2	57.3	59.7	75.9	66.3
19	Ховд	Аймгийн төв	65.8	64.1	63.7	54.6	62.1
		Сум	55.6	56.5	57.9	41	52.8
20	Хөвсгөл	Аймгийн төв	76.77	69.32	61.98	65.54	68.4
		Сум	68.55	65.99	58.86	65.32	64.7
21	Хэнтий	Аймгийн төв	95	94.6	94.3	94.9	94.7
		Сум	94.3	93.7	92.7	93.1	93.5

22	Улаанбаатар	Баянгол	94	95	93	92	93.5
		Баянзүрх	87.8	85.3	80.2	79.8	83.2
		Багахангай	85.75	82.7	82	87.25	84.4
		Налайх	87	88	86	90	87.8
		Сонгинохайрхан	89.5	87.5	85	84	86.5
		Сүхбаатар	92	93	90.6	92.5	92.0
		Хан-Уул	92	93	92.6	92.7	92.7
		Чингэлтэй	80.2	75.1	88	86	82.3
		<b>Дүүргийн дундаж</b>	88.5	87.5	87.2	88	88.4
Улсын дундаж			<b>76.6</b>	<b>75.6</b>	<b>73.7</b>	<b>73.4</b>	<b>74.7</b>
Аймаг			<b>76.7</b>	<b>76.5</b>	<b>73.9</b>	<b>72.9</b>	<b>75.0</b>
Сум			<b>72.0</b>	<b>69.9</b>	<b>68.3</b>	<b>68.4</b>	<b>69.5</b>

Эх сурвалж: Боловсролын яам

(Теле хичээлийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Монголын телевизүүдийн холбооны гишүүн 17 телевизээр нэвтрүүлж эхэлсэн.)

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**КОВИД-19 ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ-  
ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР  
ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДААС ГАРГАСАН ШИЙДВЭРИЙН ТАЛААРХ  
МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА**

(2020.01.01-2020.11.23-ны байдлаар)

*Д.Халиун, Д.Аюуш, П.Уранчимэг  
Б.Туул, С.Золжаргал*

**АГУУЛГА**

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛААС ГАРГАСАН ШИЙДВЭРҮҮД

- 1.1.Хууль
- 1.2. Тогтоол

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ГАРГАСАН ШИЙДВЭРҮҮД

- 2.1.Засгийн газрын тогтоол
- 2.2.Засгийн газрын агентлаг, зөвлөл, хорооны тушаал, шийдвэр

ГУРАВ. УЛСЫН ОНЦГОЙ КОМИССООС ГАРГАСАН ШИЙДВЭРҮҮД

- 3.1. Тогтоол
- 3.2. Албан даалгавар
- 3.3. Бусад шийдвэр

ДӨРӨВ. АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭС ГАРГАСАН ШИЙДВЭРҮҮД

- 4.1. Нийслэл /Улаанбаатар хот/
- 4.2. Орон нутаг /Аймгууд/
  - Орхон аймаг
  - Дорноговь аймаг
  - Дундговь аймаг
  - Сэлэнгэ
  - Завхан
  - Өмнөговь
  - Сүхбаатар

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН



## НЭГ.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛААС ГАРГАСАН ШИЙДВЭРҮҮД

### 1.1. Хууль

№	Батлагдсан огноо	Хуулийн нэр	Үйлчлэх хугацаа	Холбоос
1	2020.04.29	КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай	2020.12.31-ний өдрийг хүртэл үйлчилнэ. Дээрх хугацааг УИХ зургаа хүртэл сараар нэг удаа сунгаж болно.	<a href="https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312">https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312</a>

### 1.2. Тогтоол

№	Огноо	Тогтоолын дугаар	Тогтоолын нэр	Тогтоолын үйлчлэх хугацаа	Холбоос
1	2020.04.09	№20	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	1/онц байдал, дайн бүхий болон дайны байдал, Гамшгийн тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлд чуулганы хуралдааны байршлыг өөрчилж хуралдах шаардлагатай болсон үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах;	<a href="https://www.legalinfo.mn/law/details/15246?lawid=15246">https://www.legalinfo.mn/law/details/15246?lawid=15246</a>
2	2020.04.09	№21	КОВИД-19 цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай	2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	<a href="https://www.legalinfo.mn/law/details/15236?lawid=15236">https://www.legalinfo.mn/law/details/15236?lawid=15236</a>

3	2020.04.29	№32	<p>КОВИД-19 цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай</p> <p>Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэх/</p>	<p>2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	<p><a href="https://www.legalinfo.mn/law/details/15310?lawid=15310">https://www.legalinfo.mn/law/details/15310?lawid=15310</a></p>
4	2020.10.29	№31	<p>Бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэх/</p>	<p>2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	<p><a href="https://www.legalinfo.mn/law/details/15702?lawid=15702&amp;sword=КОВИД">https://www.legalinfo.mn/law/details/15702?lawid=15702&amp;sword=КОВИД</a></p>

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ГАРГАСАН ШИЙДВЭРҮҮД

2.1. Засгийн газрын тогтоол

№	Огноо	Тогтоолын дугаар	Тогтоолын нэр	Агуулга	Хамаарах хугацаа
1	2020.01.26	№30	Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	<p>1. Шинэ коронавирусийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, оношлуур худалдан авах болон иргэдэд сургалт, сурталчилгаа явуулах, сэрэмжлүүлэг, зөвлөмж хэвлүүлэн тараахад шаардагдах зардал, Хилийн боомт дахь МХЕГ-ын харьяа алба, хэлтэст нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийг худалдан авахад шаардагдах нийт 5,509,989,000 төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргах.</p> <p>2. Нэн шаардлагатай эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах 4.2 тэрбум төгрөгийн зардлыг Азийн хөгжлийн банктэй хэлэлцэн тохиролцож, шийдвэрлүүлэх.</p> <p>3. Энэ тогтоолд заасан багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилах.</p> <p>4. БНХАУ-тай хиллэх хилийн авто замын боомтоор тээврийн хэрэгслээр болон явганаар нэвтрэх зорчигчийн хөдөлгөөнд түр хугацаагаар хязгаарлалт хийх асуудлыг Дипломат харилцаа, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд Хятадын талтай харилцан тохиролцож, шийдвэрлэх.</p> <p>5. Бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, их, дээд сургуулийн сургалтын үйл ажиллагааг энэ оны 3, 4, 5 дугаар сарын</p>	2020.01.28 2020.01.27- 2020.04.30

				<p>долоо хоног бүрийн Бямба гарагт сунгаж хичээллүүлэх арга хэмжээ авах.</p> <p>6. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын хөтөлбөрийн агуулгаар сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах арга хэмжээ авах.</p> <p>7. Бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан олон нийтийг хамарсан урлаг, спортын нэгдсэн арга хэмжээ зохион байгуулахгүй байх, хүүхдийн зуслан болон тоглоомын газруудыг ажиллуулахгүй байх, кино, үзвэрийн газарт 18 наснаас доош насны хүүхдийг оруулахгүй байх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах.</p> <p>8. Шинэ коронавирусын халдварын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар бүх нийтэд үнэн, зөв мэдээллийг шуурхай хүргэж байх, халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, сэрэмжлүүлэг, зөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>9. БНХАУ-ын Үхань хотод сурч байгаа монгол иргэдээ татаж авах асуудлыг судалж, шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах.</p> <p>10. Амьсгалын замын цочмог халдвар, томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарсан ажил хөдөлмөр эрхэлж байгаа эх, эцэг, асран хамгаалагчдад тав хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгох.</p> <p>11. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар өөрийн байгууллагадаа ухуулга, сурталчилгаа хийх, ажилтнуудын дархлааг дэмжих, амны хаалт хэрэглэх, гар угаах болон халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг уриалах.</p>	2020.02.01-2020.12.31
2	2020.01.31	№39	Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай	<p>1.1. МУ, БНХАУ-ын хилийн агаарын зам, төмөр зам, авто замын бүх боомтоор БНХАУ-ын иргэд болон тус улсаас ирж байгаа гуравдагч орны иргэн, харьяалалгүй хүнийг МУ руу нэвтрүүлэх хөдөлгөөнийг зогсоох.</p> <p>1.2. БНХАУ-аас ирэх МУ-ын иргэдийг авто замын Булган-Ташикэн, Баянхошуу-Өвдөг, төмөр замын Замын-Үүд-Эрээний боомт болонагаарын замын Буянт-Ухаа боомтоор, агаарын замын Буянт-Ухаа боомт болон төмөр замын Замын-Үүд-Эрээний боомтоор олон улсын галт тэргээр тус тус улсын хил нэвтрүүлэх.</p>	2020.02.06

				<p>1.3.Монгол, Хятадын хилийн Даян-Хунышанзүй, Байтаг-Улиастай, Бургастай-Лаомеяо, Сүмбэр-Рашаан, Хавирга-Архашаат авто замын боомтуудыг түр хаах.</p> <p>1.4.Агаарын замын Буянт-Ухаа боомт болон Замын-Үүд-Эрээний төмөр замын боомтоор хуваарийн дагуу хил нэвтэрч байгаа ачаа тээврийн галт тэрэг, зүтгүүрийн бие бүрэлдэхүүн, агаарын хөлгийн багийн гишүүдийг зохих журмын дагуу шалгаж улсын хил нэвтрүүлэх.</p> <p>1.5.Монгол, Хятадын хилийн Булган-Такашикэн, Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Замын-Үүд-Эрзэн, Бичигт-Зүүнхатавч, Баянхошуу-Өвдөг авто замын боомтоор хил нэвтэрч байгаа ачаа тээврийн авто машин болон тэдгээрийн жолооч нарыг зохих журмын дагуу шалгаж улсын хил нэвтрүүлэх.</p> <p>2. 1.4, 1.5-д заасан этгээдийн эрүүл мэндийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах.</p> <p>3. БНХАУ руу албан ажлын зайлшгүй шаардлагаар зорчих тохиолдолд Улсын онцгой комиссын даргын зөвшөөрлөөр улсын хил нэвтрүүлэх.</p>	Агаар: 2020.02.06- 2020.03.02
3	2020.02.04	№48	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	2020.01.26-ны өдрийн 30-р тогтоолын 2 дахь заалтыг өөрчлөн найруулах.	
4	2020.02.12	№62	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай	<p>1. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020.02.13-ны өдрөөс мөн 2020.12.31-ний өдрийг дуустал хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх. (Энэ заалтад өөрчлөлт орсон)</p> <p>2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байх.</p> <p>3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу хэрэгжүүлж ажиллах.</p>	2020.02.13 2020.03.02



5	2020.02.13	№63	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	<p>1. Улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэнтэй холбогдуулан Монгол Улс, БНХАУ хоорондын авто зам, төмөр зам болон агаарын замаар нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг зогсоох.</p> <p>2. Зорчигч тээврийн хөдөлгөөнийг зогсоосонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:</p> <p>2.1.БНХАУ-аас эх орондоо ирэх хүсэлт гаргасан монгол иргэдийг зохион байгуулалттайгаар татан авах;</p> <p>2.2.БНХАУ руу зорчих гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг улсын хилээр нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах.</p> <p>3. Шинэ коронавирусийн халдвартай холбоотой худал, ташаа мэдээ, мэдээлэл тараасан иргэн, хуулийн этгээдэд хуулийн дагуу хариуцлага тооцох, хуурамч цахим хуудсыг хаах арга хэмжээ авах.</p>	2020.02.15-2020.12.31
6	2020.02.19	№64	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	<p>1. БНХАУ-д гарсан КОВИД-19-ийн тархалт буурахгүй байгаатай холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах. (Энэ заалтад өөрчлөлт орсон)</p> <p>2.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан тогтоолд заасан хугацаанд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх:</p> <p>2.1. цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг түр зогсоох хугацаанд хүүхдийн хоол, үдийн цайны зардлаас хэмнэгдсэн хөрөнгийг бямба гарагт хичээллэх багш, ажилтны цалин хөлс болон тухайн байгууллагад ариутгал, халдваргүйтгэлийн материал худалдан авахад зарцуулах;</p> <p>2.2. ЕБС-ийн сурагчдад зориулсан теле хичээлийг үргэлжлүүлэх, багш нарын 1, 5, 10 дахь жилийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулахад шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө зохицуулалт хийж шийдвэрлэх.</p>	2020.07.15-ныг дуустал

7	2020.02.19	№68	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан санхүү, төсвийн чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай	<p>1. МУ-д импортолж байгаа бүх төрлийн будаа, элит үрийн улаан буудай, хүнсний улаан буудай, элсэн чихэр, ургамлын тосны гаалийн албан татвар, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг татвар ногдуулсан өдрөөс хойш 2 сар хүртэл хугацаагаар сунгах, хэсэгчлэн төлүүлэх арга хэмжээ авч ажиллах.</p> <p>2. МУ-д импортлох 15 мянган тонн элит үрийн улаан буудай, дотоодын гурилын үйлдвэрлэлд шаардагдах 160 мянган тонн хүнсний улаан буудай, бүх төрлийн хүнсний будаа, өндөг, элсэн чихэр, ургамлын тосыг гаалийн албан татвар, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.</p> <p>3. Шаардлагатай тохиолдолд төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан төсвийн зарлагын санхүүжилтийг зохицуулах арга хэмжээ авах</p>	2020.06.30-ны өдрийг хүртэл
8	2020.02.28	№78	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай	<p>1. Нүүрс, газрын тос болон ашигт малтмалын бусад бүтээгдэхүүний экспортыг эхлүүлэхтэй холбогдуулан хилийн боомтуудыг бүрэн хүчин чадлаар ажиллуулан дараалал үүсгэхгүйгээр тээвэрлэлтийг зохион байгуулах, тээвэрлэлт хийж байгаа жолооч нарын хоол хүнсний хангамж, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээ авах, жолооч нарт эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх, тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>2. Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг уртагдсан горимоор ажиллуулах асуудлыг БНХАУ-ын талд дипломат шугамаар тавьж шийдвэрлүүлэх.</p> <p>3. Ашигт малтмалын бүтээгдэхүүн болон газрын тосны экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах заавар, журмыг боловсруулж, ААН, байгууллагуудаар мөрдүүлэх, дотоодын болон экспортын тээвэрлэлт хийж байгаа иргэдэд халдварт өвчин дамжихаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах.</p> <p>4. Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд хамаарах НДШ-ийг хуулийн хугацаанд оногдуулж тайлагнасан боловч хуулийн хугацаанд төлөөгүй тохиолдолд тооцох алданги, торгуулийг нэг удаа чөлөөлөх</p>	

			<p>тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.</p> <p>5. Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд хамаарах татварыг хуулийн хугацаанд ногдуулж тайлагнасан боловч хуулийн хугацаанд төлөөгүй тохиолдолд тооцох алданги, торгуулийг нэг удаа чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.</p> <p>6. Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд гэрээнд заасан түрээсийн төлбөрийн хэмжээг бууруулсан төвлөрсөн зах, худалдааны төв, үйлчилгээний газарт худалдаа, үйлчилгээний чиглэлээр байр, талбай түрээслүүлсэн татвар төлөгчийн түрээсийн орлогод ногдуулсан татварыг нэг удаа чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.</p> <p>7. Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн авлагатай этгээд улсын болон орон нутгийн төсөвт татварын өртэй тохиолдолд татвар төлөгчийн хүсэлтээр Татварын ерөнхий хуулийн 55.2.7-д заасны дагуу татварын өрийг тухай бүр суутган тооцох.</p> <p>8. Энэ онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шуурхай зохион байгуулж, мэдээллийг ил тод нийтэлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгах.</p> <p>9. Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан төсвийн захирагч нарын төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлж, цалин, тэтгэврээс бусад зарлагыг эрэмбэ тогтоож санхүүжүүлэх арга хэмжээ авах.</p> <p>10. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, борлуулалтын байдал, нөөц, үлдэгдлийн хөдөлгөөнд өдөр тутамд хяналт тавьж, нийлүүлэлтийн болон үнийн түвшинг тогтвортой байлгах, үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэх, хэт нөөцлөх, дамлан худалдаалахаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллах.</p>



9	2020.03.18	№98	Эрүүл мэндийн сургалт, эрдэм шинжилгээний зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай	3. КОВИД-19 цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлж өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан боловсролын салбарын багш, албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хэвтүүлэн эмчлэх бэлтгэл ажлыг шуурхай хангах зорилгоор нийслэлийн ЕБС, цэцэрлэгт хуваарилсан тусгай зориулалттай зардлын хэмнэлтийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэгт шилжүүлэн зарцуулах зохицуулалтын арга хэмжээ авах.	2020.12.31  2020.03.23- 2020.03.28  2020.12.31
10	2020.03.22	№102	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	1. Дэлхий нийтэд өндөр хурдацтай тархаж байгаа КОВИД-19 цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020.12.31-ний өдрийг дуустал сунгах. (Энэ заалтад өөрчлөлт орсон) 3. ОХУ-аас зорчин ирэх МУ-ын иргэдийг 2020.03.23-ны 20:00 цагаас 3-р сарын 28-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд зөвхөн Алтанбулаг боомтоор улсын хилээр нэвтрүүлсний үндсэн дээр хилийн бүх боомтоор нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020.12.31-ний өдрийг дуустал түр зогсоох. 4. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ажлын байр, орон сууц болон өрөө, тасалгаанд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг улсын хэмжээнд 14 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулах. 5. Тусгаарлалтад хамрагдсан иргэдэд тавих хяналтыг чангатгах, тусгаарлалтын журам зөрчсөн иргэдэд хуулийн дагуу хариуцлага тооцох арга хэмжээ авах.	2020.02.19-ны өдрийн 68-р тогтоолын 2 дахь заалтыг өөрчлөн найруулах.
11	2020.03.25	№112	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай		

12	2020.03.27	№114	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай	<p>1. Татвар, нийгмийн даатгал төлөгч ААН-ийг татвар, торгууль, алдангиас чөлөөлөх, татварын зарим зохицуулалт хийх, даатгуулагчийн төлсөн шимтгэлийг хөнгөлөх, ажлын байраа хадгалж байгаа ажил олгогчийг дэмжихэд чиглэсэн дор дурдсан зохицуулалт бүхий хуулийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг даалгав:</p> <p>1.1. Дэлхий дахинд үүсээд байгаа КОВИД-19 цар тахал тархсан онцгой нөхцөл байдлын улмаас ААН, байгууллага, түүнтэй хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа даатгуулагч болон сайн дурын даатгуулагчийг төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх. Үүнд:</p> <p>1.1.1. хувийн хэвшлийн бүх ААН, түүнд ажиллаж байгаа даатгуулагч;</p> <p>1.1.2. төрийн бус байгууллага, түүнд ажиллаж байгаа даатгуулагч;</p> <p>1.1.3. төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, түүнд ажиллаж байгаа даатгуулагч;</p> <p>1.1.4. сайн дурын даатгуулагч.</p> <p>1.2 Сайн дураар даатгуулсан нийгмийн даатгалын байгууллагатай мөн сайн дураар даатгуулахаар гэрээ байгуулсан МУ-ын иргэний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцох;</p> <p>1.3. КОВИД-19 цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад ААН-ийн даатгуулагч МУ-ын иргэнд 2020.04.01-2020.07.01 хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200 000 (хоёр зуун мянган) төгрөгийн дэмжлэг олгох;</p> <p>1.4. ААН-ийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогын нийт дүн</p>	<p>2020.04.01-2020.10.01</p> <p>2020.04.01-2020.10.01</p> <p>2020.04.01-2020.07.01</p> <p>2020.04.01-2020.10.01</p>
----	------------	------	--	--	---

2020.02.01-2020.04.01	<p>нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад МУ-ын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн 2020.04.01-10.01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон орлогод мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2.7-д заасны дагуу ногдуулан тайлагнасан ААН-ийн орлогын албан татварыг чөлөөлөх;</p> <p>1.5. 2020.02.01-04.01-ний өдрийг хүртэлх хугацаанд ногдуулж тайлагнасан боловч хуульд заасан хугацаанд НДШ төлөөгүй төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад ААН, байгууллагыг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан торгох шийтгэл, мөн зүйлийн тайлбарын хоёр дахь өгүүлбэрт заасан алдангиас тус тус чөлөөлөх;</p> <p>1.6. 2020.02.01-09.01-ний өдрийг хүртэлх хугацаанд татвар төлөгчийн хуулийн дагуу ногдуулан тайлагнасан төлбөл зохих татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас тухайн татвар төлөгчийг нэг удаа чөлөөлөх;</p> <p>1.7. 2020.02.01-09.01-ний өдрийг хүртэлх хугацаанд зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлсэн татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан нь гэрээ болон Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан төлбөрийн баримтаар нотлогдсон тохиолдолд бууруулсан хэмжээгээр түрээсийн орлогод ногдуулах ААН-ийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэх;</p> <p>1.8. 2020.03.01-06.30-ны өдрийг хүртэлх хугацаанд элсэн чихэр, ургамлын тос, бүх төрлийн хүнсний будаа, 15 мянган тонн элит үрийн улаан буудай, 160 мянган тонн хүнсний улаан буудайг импортлоход гаалийн болон импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх;</p> <p>1.9. МУ-ын иргэний 2020.04.01-10.01-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх. Энэ чөлөөлөлтөд дараах орлогод ногдох хувь хүний орлогын албан татвар хамаарахгүй байх:</p> <p>1.9.1. төрийн албан хаагчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;</p>
2020.02.01-2020.09.01	
2020.02.01-2020.09.01	
2020.03.01-2020.06.30	
2020.04.01-2020.10.01	
2020.02.01-2020.10.01	



				<p>1.9.2. төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажилладаг хувь хүний цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого;</p> <p>1.9.3. гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэх тендерт шалгарч, тус ажлыг хийж гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд ажилладаг хувь хүний зөвхөн уг ажилтай холбоотой олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого.</p> <p>1.10. 2020.02.01-10.01-ний өдрийг хүртэлх хугацаанд КОВИД-19-ийн цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортоор оруулахад гаалийн болон импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх.</p> <p>2. Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотойгоор СӨБ, ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлгийн зардлын хэмнэлтээс 18 хүртэлх насны бүх хүүхдэд сар бүр 10.0 мянган төгрөгийг гурван сарын хугацаанд олгох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх.</p> <p>3. Эдийн засаг идэвхжиж, бэлэн байдлын зэргийг цуцлах хүртэлх хугацаанд төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан мөнгөн хөрөнгийн зохицуулалтын хүрээнд төсвийн урсгал зардал болон улсын төсвийнхөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг дор дурдсан байдлаар санхүүжүүлэх:</p> <p>3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг ач холбогдлоор нь эрэмбэлж он дамжин хэрэгжиж байгаа болон эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг тэргүүн ээлжид санхүүжүүлэх ажлыг эрчимжүүлж, боловсрол, эрүүл мэндийн салбарын их засварын санхүүжилтийг КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах;</p> <p>3.2. Төсвийн урсгал зардлаас дараах зардлыг тэргүүн ээлжид санхүүжүүлэх:</p>
--	--	--	--	---

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

			<p>3.2.1. бүх шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны зардал;</p> <p>3.2.2. бүх шатны төсвийн байгууллагын коронавируст халдвар КОВИД-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахтай холбоотой бүх төрлийн зардал;</p> <p>3.2.3. бүх шатны төсвийн байгууллагын цалин хөлс, ажил олгогчийн төлөх НДШ, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай зардал;</p> <p>3.2.4. нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ.3.3. Төсвийн урсгал зардлаас дараах зардлыг төсвийн орлогын бүрдэлт болон ач холбогдолтой нь уялдуулан санхүүжүүлэх:</p> <p>3.3.1. бүх төрлийн судалгаа, тооллого, соёл урлаг, спортын чиглэлээр хэрэгжүүлэх нэг удаагийн арга хэмжээ, бүх төрлийн дэмжлэг урамшуулал, зээлийн хүүгийн татаас;</p> <p>3.3.2. эрчим хүч, хөдөө аж ахуйн салбарын татаас, Ипотекийн зээлийн санхүүжилт;</p> <p>3.3.3. агаарын бохирдол, байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах арга хэмжээний санхүүжилт;</p> <p>3.3.4. хүн, малын халдварт, архаг болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис бэлтгэх, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авах санхүүжилт, мал эмнэлгийн үйлчилгээний төлбөр;</p> <p>3.3.5. Засгийн газрын нөөц хөрөнгө, сонгуулийн арга хэмжээний санхүүжилт, гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр, хүнс, шатахуун, өвс тэжээл, үрийн нөөц бүрдүүлэх зардал;</p> <p>3.3.6. онцгой байдал, цагдаа, шүүхийн шинжилгээ, хил хамгаалах, хилийн шалган нэвтрүүлэх, батлан хамгаалах салбарын анги, нэгтгэлүүд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, мэргэжлийн хяналтын байгууллагын дотоод албан томилолтын зардал, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авах зардал;</p> <p>3.3.7. мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчид олгох тэтгэлэг;</p>
--	--	--	--

13	2020.04.15	№132	Жагсаалт батлах тухай	<p>3.3.8. бусад нийтлэг зориулалт, арга хэмжээний зардал.</p> <p>3.4. Төсвийн урсгал зардлаас дараах зардлын санхүүжилтийг түр зогсоох:</p> <p>3.4.1. бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинар зохион байгуулах, тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх;</p> <p>3.4.2. хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал;</p> <p>3.4.3. цалин хөлснөөс бусад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр;</p> <p>3.4.4. бараа үйлчилгээний бусад зардал.</p> <p>4. Цахилгаан эрчим хүч хэрэглэгч айл өрхүүдийн хэрэглээний төлбөрт алданги оногдуулахгүй байх, төлбөрөө төлөөгүй өрхүүдийн цахилгааныг хязгаарлах арга хэмжээ авахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх.</p> <p>5. Олон улсын зах зээлд түүхий тосны үнэ буурч байгаатай холбогдуулан бүх төрлийн шатахуун, дизель түлшний жижиглэнгийн үнийг литр тутамд 300-400 төгрөгөөр бууруулах, цаашид жижиглэнгийн үнийг тогтворжуулах зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан өмнө нь байгуулсан гэрээ, хэлцлээр тохиролцсон нөхцөлийн хүрээнд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.</p>	2020.09.01
14	2020.04.15	№139	КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	<p>Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх КОВИД-19 цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалт</p> <p>1. КОВИД-19-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалтын үйл ажиллагааг 2020.09.01-ний өдрийг хүртэл зогсоох, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх:</p> <p>1.1. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, их, дээд сургууль, коллежийн суралцагчдад зориулан зохион байгуулж байгаа теле болон цахим хичээлийг 2020.06.01-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэх;</p> <p>1.2. энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийг төгсөгч, 2020-2021 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид элсэгчдээс монгол хэл бичгийн хичээлээр шалгалт авахгүй байх зохицуулалт хийх;</p>	2020.06.01

15	2020.04.17	№140	Журам батлах тухай	<p>1.3. ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг сургуулийн орчинд халдвар, хамгааллын дэглэм баримтлан 2020.05.11-ний өдрөөс эхлэн нэг сарын хугацаатай зохион байгуулах арга хэмжээ авах.</p> <p>2. Сургалтын үйл ажиллагааг зогсоосон хугацаанд боловсролын байгууллагын гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, түлш халаалт зэрэг байр ашиглалттай холбоотой зардлыг хэмнэх зорилгоор шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p> <p><b>Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам</b></p> <p>1.1. Энэ журмын зорилго нь дэлхий дахинд үүсээд байгаа цар тахал буюу коронавируст халдвар тархсан онцгой нөхцөл байдлын улмаас улс орны эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал хүндэрч, ААН, байгууллагын орлого буурч, үйл ажиллагаа нь доголдож байгаатай холбогдуулан нийт ААН, байгууллага, даатгуулагчийг дэмжихэд оршино.</p> <p>1.2. НДШ-ээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн дагуу ААН, байгууллага болон даатгуулагч-МУ-ын иргэний тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх болон нийгмийн даатгалын сан хооронд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмыг баримтална.</p> <p>1.3. Энэ журамд заасан хувийн хэвшлийн ААН, ТББ, их, дээд сургууль тэдгээртэй хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа даатгуулагч, сайн дураар даатгуулагч 2020.04.01-10.01-ний өдрийг хүртэл хугацаанд НДШ төлөхгүй.</p> <p>1.4. Хувийн хэвшлийн ААН-ийн борлуулалтын орлого 2020 оны 4-9 дүгээр саруудын аль нэг сард өмнөх оны мөн үеэс буурсан нь татварын тайлан, татварын төлбөрийн баримтаар баталгаажсан бол “үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурсан” гэж үзнэ.</p> <p>1.5. Хууль хэрэгжих хугацаанд ААН, байгууллагад хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа тухайн сарын ажилтны тоогоор “ажлын байрыг хадгалж байгаа” гэж үзнэ...</p>	2020.05.11-2020.06.11
----	------------	------	--------------------	--	-----------------------

16	2020.04.17	№147	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	<p>1. Дэлхий нийтэд коронавируст халдвар КОВИД-19-ийн тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020.12.31-ний өдрийг дуустал сунгах. (Энэ заалтад өөрчлөлт орсон)</p> <p>2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг сонгуульд оролцох нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэх намын Их Хурал, эсхүл намын төлөөллийн төв байгууллагын хурлыг 2020.05.15-16-ны өдрүүдэд зохион байгуулах нөхцөл боломжоор хангах.</p> <p>3. Дипломат ажилтнууд, тэдний гэр бүл болон зайлшгүй шаардлагаар улсын хил нэвтрүүлэх иргэдийн асуудлыг тухай бүр шийдвэрлэх, олон улсын ачаа тээврийн галт тэрэг, зүтгүүрийн бие бүрэлдэхүүн, автомашины жолооч нарт хорио цээрийн дэглэмийг чанд мөрдүүлж ажиллах.</p>	2020.12.31
17	2020.05.06	№164	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай	<p>1. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан улсын хэмжээний бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох 39 ААН, байгууллагын гадаадын ажиллах хүч, мэргэжилтэнд 2020 онд МУ-д хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг Улсын онцгой комиссын шийдвэрт үндэслэн эхний ээлжинд инженер, техникийн ажилтан, дараагийн ээлжинд гүйцэтгэх, туслах ажилтанд үе шаттайгаар зохих журмын дагуу олгох.</p> <p>2. Энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан 9 ААН, байгууллагын 1948 гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2020 онд ажлын байрны төлбөрөөс чөлөөлсүгэй.</p> <p>3. КОВИД-19-аас сэргийлэх зорилгоор гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг үзлэг, шинжилгээнд хамруулах, ажлын байранд нь тусгаарлах, тогтоосон онцгой нөхцөл, горимыг чанд мөрдүүлэх, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах.</p> <p>4. Энэ тогтоолын дагуу ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг</p>	

18	2020.05.06	№166	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	хөдөлмөр эрхлүүлэх, буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Улсын онцгой комисс, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тухай бүр мэдээлж байх.
19	2020.05.06	№167	КОВИД-19 цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай	<p>2020.04.15-ны өдрийн 139-р тогтоолд өөрчлөлт оруулах.</p> <p>1. Эдийн засгийг идэвхжүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг чанд сахиулсны үндсэн дээр хэрэгжүүлэх:</p> <p>1.1. алт олборлолт, нүүрс, газрын тосны экспортыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>1.2. гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх хилийн боомт, цэвэрлэх байгууламж, гэр хорооллын барилгажилт, автозамын зэрэг бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх;</p> <p>1.3. дотоодын ачаа тээврийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах замаар тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;</p> <p>1.4. газар тариалангийн салбарт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, нөөц бүрдүүлэх малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах;</p> <p>1.5. дотоодын аялал жуулчлалыг сэргээх, идэвхжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.</p> <p>2. Зочид буудал, жуулчны бааз, амралт, сувиллын үйлчилгээний газрын үйл ажиллагаанд тусгай горим тогтоож, үйл ажиллагааг хэвийн явуулах боломж бүрдүүлэх.</p> <p>3. Энэ тогтоолын 1, 2 дахь заалтыг хэрэгжүүлэхдээ үйлчилгээний байгууллагад үйлчлүүлэгч хоорондын зайг зохистой хэмжээнд тогтоож үйл ажиллагааны цар хүрээ, цагийн хуваарийг оновчтой хэлбэрээр зохион байгуулах, халдвараас урьдчилан сэргийлэх талаар иргэдийн ойлголт, ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллах.</p>



20	2020.05.06	№168	КОВИД-19 цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай	<p>4. Малчдын орлогыг нэмэгдүүлэх болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор МУ-ын 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор А дансанд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн, ноолуурын хэмжээг “Монгол ямааны үүлдэр, омог. Ерөнхий шаардлага” (MNS 0550:2011) стандартаар тооцож, нэг кг тутамд 20 000 төгрөгийн урамшууллыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олгох арга хэмжээ авах.</p> <p>5. Иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх:</p> <p>5.1. 18 хүртэлх насны хүүхэд бүрт олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлж 2020.04.01-2021.01.01-ний өдрийг хүртэлх хугацаанд сар бүр 100 000 төгрөг олгох;</p> <p>5.2. хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг нэмэгдүүлж 2020.05.01-10.01-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр нэг хүүхдэд 16 000 төгрөг, 2020.05.01-2021.01.01-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр насанд хүрсэн нэг гишүүнд 32 000 төгрөг тус тус олгох;</p> <p>5.3. нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж 2020.05.01-2021.01.01-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр 288 000 төгрөг олгох.</p> <p>6. Энэ тогтоолын 4, 5 дахь заалтад заасан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.2-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 оны төсөвт холбогдох зохицуулалт хийх замаар санхүүжүүлэх</p>	<p>2020.04.01-2021.01.01</p> <p>2020.05.01-2020.10.01</p>
				<p>1. КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийг хамарсан зарим үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг хязгаарласан, зогсоосонтой холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 оны батлагдсан төсөвт бий болсон дараах арга хэмжээний санхүүжилт, зардлын хэмнэлтийг эдийн засгийг идэвхжүүлэх, ажлын байрыг хадгалах, иргэдийн амьжиргааг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмд шаардлагатай</p>	

21	2020.05.27	№188	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах, журам батлах тухай	<p>бусад арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан төсвийн зохицуулалт хийж зарцуулах:</p> <p>1.1. Бүх шатны сургалтын үйл ажиллагаа, хурал семинар, баяр ёслол, урлаг, соёл, спортын арга хэмжээний зарим зардал;</p> <p>1.2. Боловсролын зээлийн сан, Соёл, урлагийг дэмжих сан, Кино урлагийг дэмжих сан, Спортыг дэмжих сан зэрэг зарим тусгай сангийн зардал;</p> <p>1.3. цалин, нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжээс бусад зарим урсгал зардлыг 20 хүртэл хувиар бууруулснаас бий болох хэмнэлт;</p> <p>1.4. гүйцэтгэл нь удаашралтай байгаа хөрөнгө оруулалтын зарим төсөл арга хэмжээний хэмнэгдсэн санхүүжилт;</p> <p>1.5. гадаадын зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлэх зарим зардал;</p> <p>1.6. КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах талаар “Их-20”-ын улсуудаас гаргасан “Өр хойшлуулах санаачилга”-ын дагуу тухайн улсуудад төлөх гадаадын зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөөс хойшлуулсан зардал.</p> <p>2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулах замаар энэ тогтоолын 1 дэх заалтад заасан төсвийн зохицуулалтыг тусган баталж мөрдүүлэх.</p> <p>3. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу төрийн үйлчилгээг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагааг зохион байгуулж төсвийн сахилга хариуцлагыг өндөржүүлэн ажиллах.</p>	2020.12.31
----	------------	------	---	---	------------

22	2020.05.27	№195	Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай	1. КОВИД-19 цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг хүүхдийн тоог, төрийн өмчийн их, дээд сургуулийн дэргэдэх болон төрийн бус өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тухайн хичээлийн жилийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг суралцагчийн тоог үндэслэн тооцож санхүүжүүлэх. 2. Хувьсах зардалд шаардагдах санхүүжилтийг 2020 оны батлагдсан төсвийн дүнд багтаан гаргах.	2020.12.31
23	2020.06.30	№234	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	1. Дэлхий нийтэд КОВИД-19 цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020.12.31-ний өдрийг дуустал сунгах.	2020.12.31
24	2020.07.10	№01	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	1. Дэлхий нийтэд КОВИД-19 цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгах.	2020.12.31
25	2020.07.29	№31	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	1. Дэлхий нийтэд КОВИД-19 цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгах.	2020.12.31
26	2020.08.25	№70	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	1. Дэлхий нийтэд КОВИД-19 цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгах.	2020.12.31

27	2020.09.14	№103	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	<p>1. Дэлхий нийтэд КОВИД-19 цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгах.</p> <p>2. КОВИД-19 цар тахлыг дотооддоо алдаагүй байгаатай холбогдуулан бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг 2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн хэвийн горимд шилжүүлэх, халдвараас урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нарт даалгах.</p> <p>3. Соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ, худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн хэвийн горимоор ажиллуулж, коронавируст халдвар КОВИД-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, ариутгал, халдваргүйтгэлийг заавар, зөвлөмжийн дагуу мэргэжлийн байгууллагуудтай хамтран тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд тогтмол зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгох.</p>	2020.12.31
28	2020.09.30	№126	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2020-167 тогтоол	<p>1. КОВИД-19 цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 167 дугаар тогтоолын 5.2 дахь дэд заалтын “насанд хүрсэн нэг гишүүнд” гэсний өмнө “2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд сар бүр” гэж нэмэх.</p>	2021.01.01
29	2020.10.28	№159	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	<p>1.Дэлхий нийтэд КОВИД-19 цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгах.</p>	2020.12.31

30	2020.10.30	№164	Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох тухай	1. КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монгол, Оросын хилийн Цагааннуур, Боршоо авто замын боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 2-ны өдрөөс мөн оны 11 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэл түр хааж, түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох.	2020.11.23
31	2020.11.04	№171	Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай	1. КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор энэ онд Шинэ жилийн баярыг нийтээр тэмдэглэн өнгөрүүлэхийг улсын хэмжээнд хязгаарлах.	2020.12.31
32	2020.11.11	№172	Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай	1. КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монгол, Оросын хилийн Алтанбулаг авто замын боомтоор улсын хил нэвтрэх ачаа тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэл түр зогсоох. 2. Хилийн Цагааннуур авто замын боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн сар бүрийн 2, 4 дэх долоо хоногт хуваарийн дагуу ажиллуулж, зөвхөн шатахуун тээвэрлэх авто машиныг улсын хилээр нэвтрүүлэх 3. Хилийн Тэс, Арцсуурь, Ханх, Ульхан, Эрэнцав авто замын боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс, Боршоо авто замын боомтыг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл түр хааж, түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох.	2021.04.01
33	2020.11.11	№178	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай	1. КОВИД-19 цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх. 2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.3, 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн	2020.11.17

				<p>удирдлагад, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.9-д заасан шаардлагад нийцүүлэн холбогдох удирдамжийг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатарт үүрэг болгох.</p> <p>3. Энэ тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жагсаалтыг хавсралт ёсоор батлах.</p> <p>4. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төмөр замын дамжин өнгөрөх болон улс, хот хоорондын ачаа тээвэр, эрдэс баялгийн экспортын хэвийн үйл ажиллагааг ариутгал халдваргүйжилтийн дэглэмийн хүрээнд зохион байгуулж явуулахыг холбогдох Засгийн газрын гишүүн, төрийн захиргааны байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах</p> <p>5. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн Засгийн газрын холбогдох шийдвэрийг мөрдөхгүй байхаар тогтоох.</p>	2020.12.01
34	2020.11.15	№181	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	<p>1. КОВИД-19 цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл сунгах.</p> <p>2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан салбар дундын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах эрхийг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатарт олгох.</p> <p>3. Их, дээд сургуулийн оюутны дотуур байранд байгаа оюутны нарийвчилсан судалгааг дахин гаргаж, оюутныг хоол хүнс, ариутгал, эрүүл мэндийн бүтээгдэхүүнээр хангах зардлыг цэцэрлэгийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн цайны зардлын хэмнэлтээс зарцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд П.Цэдэвсүрэнд зөвшөөрөх.</p> <p>4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-</p>	



35	2020.11.18	№182	Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох тухай	ний өдрийн 178 дугаар тогтоолын 1 дэх заалтын “11 дүгээр сарын 17-ны” гэснийг “12 дугаар сарын 01-ний” гэж өөрчлөх.	2020.12.01
36	2020.11.18	№183	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай	<p>1. Иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор 18 хүртэлх насны хүүхэд бүрт сар бүр олгох 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг олон нийтийн бөөнөрөл үүсгэхгүйгээр, халдвар, хамгааллын дэглэм, горимыг чанд сахиулсны үндсэн дээр ямар нэгэн хүндрэлгүй, түргэн шуурхай зохион байгуулж олгохыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар тус тус даалгах.</p> <p>2. Хуульд заасны дагуу ногдуулж, хугацаанд нь тайлагнасан боловч төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэлд тооцох алданги, торгуулиас хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд чөлөөлөх хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа даалгах.</p> <p>3. Тухайн төрлийн албан татварын хуульд заасны дагуу ногдуулж, хугацаанд нь тайлагнасан боловч төлөгдөөгүй албан татварт тооцох алданги, торгуулиас аж ахуйн нэгж, байгууллагыг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд чөлөөлөх хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар даалгах.</p> <p>4. Түрээсийн төлбөрөө бууруулсан нь холбогдох баримтаар тогтоогдож байгаа зах, худалдааны төвийн болон үйлдвэрлэл, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлэгчийн түрээсийн орлогод түрээсийн төлбөр бууруулсан хэмжээгээр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлтийг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд эдлүүлэх хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар даалгах.</p>	2021.12.31

	<p>5. Хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор импортлох бүх төрлийн хүнсний будаа, ургамлын тос болон 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардлагатай өвс, мал, амьтны тэжээл, тэжээлийн үр, хүнсний улаан буудай, улаан буудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас, Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсруулж дотооддоо борлуулсан хүнсний будаа, ургамлын тос, өвс, мал, амьтны бүх төрлийн тэжээлийг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд тус тус чөлөөлөх хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 3.Мэндсайхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгах.</p> <p>6. Хүнсний бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, савлалт, хүргэлт, түгээлт, борлуулалтын үйлчилгээг хэвийн явуулах арга хэмжээг Эрүүл мэндийн яамнаас баталсан халдвар хамгааллын дэглэм, горимыг чанд сахиулсны үндсэн дээр авч хэрэгжүүлж, энэ чиглэлийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэхийг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 3.Мэндсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгаж, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим (О.Амартүвшин)-д зөвлөх.</p> <p>7. Төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацааны үндсэн болон хүүгийн төлбөрийг зээлдэгчийн хүсэлтэд үндэслэн хойшлуулах, ингэхдээ үлдэгдэл төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр зээлийн гэрээний хугацааг сунгах зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар даалгаж, Монголбанк (Б.Лхагвасүрэн), Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-д тус тус зөвлөх.</p> <p>8. Банк, банкбүс санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооноос иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацааг зээлдэгчийн хүсэлтийг харгалзан нэмэгдүүлсэн хүү, торгууль, алданги тооцохгүйгээр зээлдэгчид ямар нэгэн дарамт үүсгэхгүй байхаар төлбөрийн чадварт нь нийцүүлэн гэрээнд өөрчлөлт</p>	
--	---	--



		<p>оруулах зохицуулалтын арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд авч хэрэгжүүлэхийг Монголбанк (Б.Лхагвасүрэн), Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-д тус тус зөвлөх.</p> <p>9. Ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүн экспортолгож аж ахуйн нэгжийг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд шилжүүлж, нийт ажиллагсдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, хамгаалах, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд үүрэг болгох.</p> <p>10. Монгол, Хятадын хилийн боомтод хэрэгжүүлж буй “Ногоон гарц”-ын үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигт малтмал, газрын тосны экспортыг хэвийн, тасралтгүй явуулах саналыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд дипломат шугамаар тавьж харилцан тохиролцохыг Гадаад харилцааны сайд Н.Энхтайван, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгах.</p> <p>11. Хилийн боомтуудыг халдвар, хамгааллын онцгой дэглэм, горимд бүрэн хүчин чадлаар ажиллуулах, Тавантолгойн бүлэг орд, Нарийнсухайтын бүлэг орд, Оюутолгойн ордын хүрээнд байгуулагдсан ариутгал, халдваргүйжүүлэлт, хамгаалалтын аюулгүйн бүсийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай уялдуулан Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор тээвэрлэлт хийж байгаа жолооч нарыг шинжилгээнд бүрэн хамруулж, эдгээр боомтыг “Ногоон бүс” болгон зарлаж, тээвэрлэлтийн дараалал үүсгэхгүй байхаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгах.</p> <p>12. Монгол Улсад ирж байгаа бүх төрлийн шуудан илгээмжийг ариутган халдваргүйжүүлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, Гаалийн ерөнхий газар (Б.Асралт)-т даалгах.</p> <p>13. КОВИД-19-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор 2021 оныг дуусталх хугацаанд импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан</p>
--	--	---

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

		<p>татвараас чөлөөлөх талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Гаалийн ерөнхий газар (Б.Асралт)-т даалгах</p> <p>14. Татвар төлөгчийн 2020 оны жилийн эцсийн татварын тайлангаар гарсан алдагдлыг татварын дараалсан 4 жилийн хугацаанд Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан журмын дагуу хасаж тооцох тухай зохицуулалтыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулахыг Татварын ерөнхий газар (Б.Заяабал)-т даалгах</p> <p>15. Татвар, гаалийн байгууллагын цахим шинэчлэлийг эрчимжүүлж, гаалийн бүрдүүлэлт хийх, татварын тайлан гаргах, татвар төлөх, иргэдэд үйлчлэх үйл ажиллагааг цахимжуулж, иргэдтэй аль болох зайнаас харьцаж ажиллахыг Татварын ерөнхий газар (Б.Заяабал), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт)-т даалгах.</p> <p>16. Татвар төлөгчийн хүсэлтээр тухайн татвар төлөгчийн улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийн авлага, бусад илүү төлөлтийг татварын өрөнд тухай бүр суутган тооцох арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвшөөрөх</p> <p>17. Бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд идэвхжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд даалгах</p> <p>18. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлбөрийг түргэн шуурхай барагдуулж ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгох</p> <p>19. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 101 дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгох</p> <p>20. Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах зорилгоор бэлэн байдал зарласан хугацаанд хүлээн авах бүх төрлийн сонгон шалгаруулалтын хугацааг 2020 оны 12 дугаар сарын</p>
--	--	--

			<p>4-ний өдөр хүртэл сунгахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгох</p> <p>21. Төсвийн хэмнэлтийн горимыг үргэлжлүүлэн, цалин, тэтгэвэр, нэг удаагийн тэтгэмжээс бусад зарлагыг эрэмбэлэн санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар даалгах.</p> <p>22. Салбарын хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэвийн явуулах санал боловсруулан Улсын онцгой комиссын хуралдаанд танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд даалгах.</p> <p>23. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас өгч байгаа зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх, олон нийтийн сэтгэл зүйг дэмжих, соён гэгээрүүлж, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх нэвтрүүлэг, контентыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах, нэвтрүүлэх, хүн хооронд 2 метрийн зай барих, амны хаалт тогтмол зүүлгэх, үйлчлүүлэгч, ажилчдын биеийн халууныг тогтмол үзэх, ариутгах бодисыг байршуулах, ариутгал, халдваргүйжүүлэлтийг өдөр тутам хийх ажлыг зохион байгуулж байхыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар, Соёлын сайд С.Чулуун, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян) болон холбогдох бусад албан тушаалтанд даалгах.</p> <p>24. Энэ тогтоолын 7 дахь заалтыг хэрэгжүүлэхдээ Засгийн газрын 2018 оны 369 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-ын 4.2.2, 4.2.8 дахь заалтуудыг мөрдөхгүй байхаар тогтоох.</p>
--	--	--	--

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

2.2. Засгийн газрын агентлаг, зөвлөл, хорооны тушаал, шийдвэр

№	Огноо	Байгууллага	Шийдвэрийн дугаар	Шийдвэрийн нэр	Агуулга
1	2020.07.08	Хадгаламжийн даатгалын үндэсний хорооны тогтоол	№105	Түр журам батлах тухай	КОВИД-19 цар тахлын үед мөрдөгдөх хадгаламжийн даатгалын хураамжийн түр журам
2	2020.07.08	Хадгаламжийн даатгалын үндэсний хороо	№106	Түр журам батлах тухай	Коронавируст халдварын үед мөрдөгдөх банкны тайлан болон мэдээ, мэдээлэл ирүүлэх түр журам Хавсралт 1. Хадгаламжийн даатгалын хураамж тооцох тайлан Хавсралт 2. Харилцах, хадгаламж эзэмшигчдийн тайлан
3	2020.08.27	Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга нарын хамтарсан тушаал	№ А/200, А/169	Журам батлах тухай	Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам
4	2020.09.10	Хадгаламжийн даатгалын үндэсний хороо	№114	Журам шинэчлэн батлах тухай	КОВИД-19 цар тахлын үед мөрдөгдөх даатгалын нөхөн төлбөр олгох түр журам

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



ГУРАВ. УЛСЫН ОНЦГОЙ КОМИССООС ГАРГАСАН ШИЙДВЭРҮҮД

3.1.Тогтоол

№	Огноо	Тогтоолын дугаар	Тогтоолын нэр	Тогтоолын үйлчлэх хугацаа	Холбоос
1	2020.02.01	№01	Хилийн зарим боомтыг түр хаасантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Хугацаа: 2020.02.01-03.02-ны өдрийг хүртэл.	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/02/Doc1.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/02/Doc1.pdf</a>
2	2020.02.26	№02	Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай	<ul style="list-style-type: none"> <li>- Тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох хугацааг 2020.02.27-ны өдрийн 08.00 цагаас 3 сарын 03-ны өдрийн 06.00 цаг хүртэл сунгах;</li> <li>- МУ-БНСУ-ын нислэгийн хугацааг 2020.02.27-03.11-ний өдрийг дуустал, МУ-Японы нислэгийн хугацааг 2020.02.28-03.11-ний өдрийг дуустал сунгах;</li> <li>- БНСУ, Япон, Итали улсад зорчсон гадаадын иргэнийг нэвтрүүлэхгүй байх, Монголд түр тусгаарлалтад байгаа иргэдийн зардлыг төлүүлэх;</li> <li>- ТАХ-ийг гадаадад томилолтоор зорчихыг 2020.02.27-03.30-ны өдрийг дуустал түр зогсоох зэрэг 10 заалттай.</li> <li>- Тээврийн хөдөлгөөнийг 2020.03.03-ны өдрийн 06.00 цагаас нээх;</li> <li>- УБ-Эрхүү-УБ, УБ-Улаан-Үүд-УБ нислэгийг 2020.03.02-11-ний өдрийг дуустал түр зогсоох;</li> <li>- БНСУ, Япон, БНИУ, Исламын БНИран Улсаас ОХУ-аар дамжин ирж байгаа иргэдээ 2020.03.02-03.30-ны өдрийг дуустал нэвтрүүлэх;</li> <li>- Эмэгтэйчүүдийн, Цэргийн, Наурызын баярыг тэмдэглэхгүй байх;</li> <li>- УОК-ын 2020 оны 2-р тогтоолд нэмэлт оруулах.</li> </ul>	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/03/УОК-ын-03-дугаар-тогтоол.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/03/УОК-ын-03-дугаар-тогтоол.pdf</a>  <a href="https://nema.gov.mn/n/97645">https://nema.gov.mn/n/97645</a>
3	2020.03.01	№03	Зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээх, зарим хязгаарлалтын арга хэмжээ авах тухай		<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/03/УОК-ын-03-дугаар-тогтоол.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/03/УОК-ын-03-дугаар-тогтоол.pdf</a>

4	2020.03.08	№04	Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай	<ul style="list-style-type: none"> <li>- МУ-Япон, МУ-БНСУ, УБ-Эрхүү-УБ, УБ-Улаан-Үүд-УБ нислэгийг түр зогсоосон хугацааг 2020.03.28-ны өдрийг дуустал сунгах.</li> <li>- Халдвартай улсаас ирсэн иргэнийг МУ-ын хилээр нэвтрүүлэхгүй байх.</li> <li>- Гэрээр тусгаарлах журмыг боловсруулж 2020.03.10-нд батлуулах.</li> <li>- Визний хугацааг сунгах.</li> </ul>	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/03/УОК-ын-4-р-тогтоол.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/03/УОК-ын-4-р-тогтоол.pdf</a>
5	2020.03.10	№06	Иргэд, зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай	<ul style="list-style-type: none"> <li>- МУ болон ОХУ, БНКУ, БНТУ-ын 2 талт нислэгийг 2020.03.11-ний өдрийн 12.00 цагаас 2020.03.28-ны өдөр хүртэл</li> <li>- Төмөр зам, олон улсын зорчигч тээвэр 2020.03.10-03.28-ны өдрийг дуустал</li> <li>- МУ болон ОХУ-ын зорчих хөдөлгөөнийг 2020.03.11-ний өдрийн 20.00 цагаас 03 сарын 31-ний өдрийг хүртэл</li> <li>- 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй ажилтанг гэрээр ажиллуулах. /2020.03.31-ний өдрийг хүртэл/</li> </ul>	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/03/Doc1-1.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/03/Doc1-1.pdf</a>
6	2020.03.10	№05	Зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох тухай	Агаарын болон замын хөдөлгөөнийг 2020.03.10-ны өдрийн 07.00 цагаас 3 сарын 16-ны өдрийн 07.00 цаг хүртэл.	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/03/Doc1.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/03/Doc1.pdf</a>
7	2020.03.30	№07	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	УОК-ын 2020 оны 6-р тогтоолын 3 дахь заалтад өөрчлөлт оруулах. Хугацаа: 2020.03.31-ний өдрөөс дагаж мөрдөх.	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/04/УОК-ын-2020-оны-7-р-тогтоол.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/04/УОК-ын-2020-оны-7-р-тогтоол.pdf</a>
8	2020.04.10	№08	2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагатай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Хугацаа: 2020.04.15-05.15-ны өдрийг дуустал	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/04/УОК-ын-2020-оны-8-р-тогтоол-1.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/04/УОК-ын-2020-оны-8-р-тогтоол-1.pdf</a>
9	2020.04.11	№09	Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх “Маскаа зүүцгээе” аян өрнүүлэх тухай	Хугацаа: 2020.04.13-05.31-ний өдрийг дуустал.	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/04/УОК-ын-2020-оны-9-р-тогтоол.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/04/УОК-ын-2020-оны-9-р-тогтоол.pdf</a>

10	2020.04.21	№10	Зорчигч тээврийн хөдөлгөөнийг хэсэгчлэн түр зогсоох тухай	Халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор УБ хот, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн орох гарах хөдөлгөөнийг түр зогсоох. Хугацаа: 2020.04.21 өдрийн 21.00 цагаас 2020.04.25 өдрийн 06.00 цаг хүртэл.	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/04/УОК-ын-2020-оны-10-дугаар-тогтоол.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/04/УОК-ын-2020-оны-10-дугаар-тогтоол.pdf</a>
11	2020.05.05	№11	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УОК-ын 2020 оны 7-р тогтоолын 1 дэх заалтад өөрчлөлт, УОК-ын 2020 оны 8-р тогтоолын 1.1 дэх хэсэгт нэмэлт оруулсан. Хугацаа: 2020.05.01-ний өдрөөс дагаж мөрдөнө.	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/05/УОК-ын-11-р-тогтоол.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/05/УОК-ын-11-р-тогтоол.pdf</a>
12	2020.11.11	№12	Зорчигч тээврийн хэрэгслийн гарах хөдөлгөөн, шатны боловсролын байгууллагын хичээл, сургалт, үзвэр үйлчилгээ, цахим болон хүүхдийн тогтоомын төвүүдийн үйл ажиллагааг түр зогсоох тухай	Замын хөдөлгөөн: агаарын болон газрын: 11 сарын 11 өдрийн 02.00 цагаас 11 сарын 13-ны өдрийн 23.00 цаг хүртэл Бүх чиглэлийн сургалтын үйл ажиллагаа: 11 сарын 11-14-ний өдөр хүртэл	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/11/Doc2-1.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/11/Doc2-1.pdf</a>

### 3.2. Албан даалгавар

№	Огноо	Дугаар	Албан даалгаврын нэр	Товч агуулга	Холбоос
1	2020.08.07	№02	Хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай	Засгийн газрын 2020 оны “Боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх: - Аймаг нийслэлийн Засаг дарга нарт (9 заалт) - Аймаг, нийслэлийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга нарт (5 заалт)	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/07/УОК-ын-албан-даалгавар-№2.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/07/УОК-ын-албан-даалгавар-№2.pdf</a>
2	2020.10.19	№04	КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Маскаа	Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Харилцаа холбооны зохицуулах хороонд:	

		зүүцгээе, гараа угаацгаая” 2 дугаар аяныг зохион байгуулах тухай	<ul style="list-style-type: none"><li>- Мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх;</li><li>- Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нар харьяа байгууллагаа идэвхтэй хамруулах;</li><li>- Аяныг 2020 оны 10 сарын 05-ны өдрөөс 12 сарын 31-ны өдрийг дуустал</li><li>- Албан даалгаврын хэрэгжилтийг тайлагнах.</li></ul>	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/10/албан-даалгавар-1.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/10/албан-даалгавар-1.pdf</a>
3	2020.11.13	№05  Хилийн боомтоор тээвэрлэлт хийх үеийн халдвар, хамгааллын арга хэмжээг эрчимжүүлэх тухай	<p>Засгийн газрын 2020 оны 178-р тогтоолуу хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, Дорнод, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд аймгийн Засаг дарга нар:</p> <ul style="list-style-type: none"><li>- Хилийн боомтын халдвар хамгааллын дэглэмийг эрчимжүүлэх тухай (9 заалт)</li><li>- Хилийн боомтод ажиллаж байгаа албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах (2 заалт)</li><li>- Албан даалгаврын хэрэгжилтийг тайлагнах</li></ul>	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/11/албан-даалгавар-.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/11/албан-даалгавар-.pdf</a>
4	2020.11.16	№06  Хилийн боомтоор ачаа тээвэрлэлт хийх үеийн халдвар, хамгааллын зарим арга хэмжээг чангатгах тухай	<p>Засгийн газрын 2020 оны 178-р тогтоолуу хэрэгжилтийг хангах зорилгоор Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Хилийн хяналтын байгууллага /ХХЕГ, МХЕГ, ГЕГ, ГИХГ/-ын дарга, Баян-Өлгий, Дорноговь, Дорнод, Сэлэнгэ аймгийн Засаг дарга, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн дарга нар:</p> <ul style="list-style-type: none"><li>- “Чингис Хаан”, “Алтанбулаг”, “Замын-Үүд” боомтоор орж ирэх МУ-ын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг зөвхөн УОК-ын зөвшөөрлийг үндэслэн улсын хилээр нэвтрүүлэх;</li><li>- “Замын-Үүд”, “Сүхбаатар”, “Эрэнцав” төмөр замын боомтоор улсын хил нэвтрэх ачааны галт тэрэгний машинист, хөлгийн ажилчид (агент)-ыг цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс бүрэн тусгаарлаж үүрэг гүйцэтгүүлэх, халдвар хамгааллыг сайжруулах талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллах;</li><li>- “Цагааннуур” авто замын боомтыг 2020.11.23-ны өдрөөс сар бүрийн 2, 4 дэх долоо хоногт нээн ажиллуулж</li></ul>	-

				<ul style="list-style-type: none"> <li>- зөвхөн шатахуун импортлох бэлтгэл ажлыг бүрэн ханган хорио цээрийн дэглэмийг сахиулах.</li> <li>- Албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг УОК-ын ажлын албанд 7 хоног бүрийн Баасан гарагт цахимаар болон албан бичгээр ирүүлэх.</li> </ul>	
--	--	--	--	---	--

### 3.3. Бусад шийдвэр

№	Огноо	Дугаар	Бусад шийдвэрийн нэр	Товч агуулга	Холбоос
1	2020.02.13	УОК-ын даргын тушаал №04	Удирдамж батлах тухай	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/02/УОК-ын-Даргын-тушаал№04.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/02/УОК-ын-Даргын-тушаал№04.pdf</a>
2	2020.03.20	Заавар	Баталсан: УОК-ын орлогч дарга, ОБЕГ-ын дарга, хошууч генерал Т.Бадрал. “Коронавирусын халдвараас сэргийлэх зорилгоор ажилтан, алба хаагчдыг гэрээр ажиллуулах түр заавар”		<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/03/заавар-1-1.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/03/заавар-1-1.pdf</a>
3	2020.04.16	Удирдамж	Баталсан: УОК-ын дарга Ө.Энхтүвшин “Амны хаалтаа зүүцгээ” аян өрнүүлэх удирдамж		<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/04/Амны-хаалтаа-зүүцгээ-аяны-удирдамж.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/04/Амны-хаалтаа-зүүцгээ-аяны-удирдамж.pdf</a>
4	2020.11.11	УОК-ын даргын тушаал №20	Удирдамж батлах тухай	Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний удирдамж	<a href="https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/11/удирдамж.pdf">https://nema.gov.mn/wp-content/uploads/2020/11/удирдамж.pdf</a>

## ДӨРӨВ. АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭС ГАРГАСАН ШИЙДВЭРҮҮД

### 4.1. Нийслэл /Улаанбаатар хот/

№	Тогтоол, захирамжийн нэр	Огноо	Дугаар	Тайлбар	Линк
1	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2020.01.27	A/108	Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд Нийслэлийн нутаг дэвсгэрт дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагуудад үүрэг болгох талаар болон бусад	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47003">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47003</a>
2	Халдварт урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2020.02.06	A/166	Нийслэлийн Авто тээврийн шалган нэвтрүүлэх Багануур дүүрэг Хэрлэнгийн гүүр, Багахангай дүүрэг Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо, Баянзүрх дүүрэг Хонхор, Хан-Уул дүүрэг Өлзийт, Морингийн даваа, Сонгинохайрхан дүүрэг Эмээлт, Баруунтуруу, Чингэлтэй дүүрэг Ар гүнт зэрэг байнгын ажиллагаатай товчоодод Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн байгууллагыг нэмэлтээр ажиллуулах талаар болон бусад	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47183">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47183</a>
3	Уриалга гаргах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай	2020.02.07	A/168	Шинэ коронавирусын халдвар болон Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг бусад халдварт өвчний эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс гудамж, зам талбай, нийтийн эзэмшлийн болон үйлчилгээний газар, орон сууцны орчны газарт нус, цэр, шүлсээ хаяхгүй байх, ил задгай бие засах болон хог хаягдлаар орчноо бохирдуулахгүй байх үүргээ биелүүлэхийг Нийслэл хотын иргэн бүртд уриалах болон хог хаягдал, гадна тохижилтын талаар болон бусад	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47077">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47077</a>



4	Өндөржүүлсэн бэлэн үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2020.02.13	A/191	Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр гарсан шийдвэрийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлэх “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийг нэгдүгээр, “Шинэ коронавирусийн халдвар, Шувууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний салбар дундын төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус батлах болон бусад.	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47195">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47195</a>
5	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай	2020.02.26	A/223	Томуу, томуу төст өвчний өвчлөл болон хөрш зэргэлдээ улсуудад КОВИД-19 цар тахлын тархалт буурахгүй байгаагай холбогдуулан нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн баар, спорт, соёл урлагийн газар /цанын бааз, заал, билиард, саун, бассейн, фитнес, бүжиг, иогийн клуб г.м/ болон амралт, жуулчны бааз, дэн буудлын үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг дуустал түр зогсоох тухай болон бусад	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47447">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47447</a>
6	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай	2020.03.10	A/333	Монгол Улсад дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн КОВИД-19 өвчний тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан тус өвчний тархалтыг саармагжуулж, урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа дор дурдсан байгууллагын үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл түр зогсоосугай. Үүнд: 1.1.Хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, ахуйн хэрэглээний худалдаанаас бусад бүх төрлийн зах, худалдаа, үйлчилгээний цэг, түүний салбарууд; 1.2.Халуун усны үйлчилгээнээс бусад бүх төрлийн ахуйн үйлчилгээний цэг, түүний салбарууд; 1.3.Дугуй засварын үйлчилгээнээс бусад бүх төрлийн авто засвар, үйлчилгээ, худалдааны газрууд.	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47627">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47627</a>

7	КОВИД-19-ийн халдвараас иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай	2020.03.30	A/436	<p>Дэлхий нийтэд тархаж байгаа КОВИД-19 цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд дараах үйл ажиллагааг дор дурдсанаар хязгаарласугай.</p> <p>1.1.Олон нийтийг хамарсан хурал, жагсаал, цуглаан, тэмцээн, уралдаан, аялал зугаалга, сургалт, урлаг, соёл, спортын арга хэмжээ, бүх төрлийн тоглоомын газар, спорт, шашин, урлаг соёл, үзвэр үйлчилгээний газар /сүм хийд, мөргөлийн газрууд, цанын бааз, заал, библиард, саун, бассейн, фитнес, бүжиг, иогийн клуб г.м/ болон амралт, жуулчны бааз, дэн буудлын үйл ажиллагааг түр зогсоох;</p> <p>1.2. Ресторан, кафе, зоогийн газар /сүлжээ хоолны газар/ болон согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг 07:00-22:00 цаг хүртэл хугацаагаар тогтоох.</p>	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47943">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=47943</a>
8	Иргэдийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай	2020.04.16	A/521	<p>Дэлхий нийтэд тархаж байгаа шинэ төрлийн КОВИД-19 халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлэхийн зэрэгцээ, улс, нийслэлийн эдийн засаг, хувийн хэвшлийн байгууллага, ажиллагсдын үйл ажиллагааг дэмжих талаар Засгийн газраас өгсөн үүрэг чиглэл, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтийг судалсны үндсэн дээр Нийслэлийн нутаг дэвсгэрт стандартын шаардлага хангасан амралтын газар, жуулчны бааз, буудал, саун, фитнес, иогийн клубийн үйл ажиллагааг нээхийг зөвшөөрөх болон бусад</p>	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=48486">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=48486</a>
9	Захирамжид өөрчлөлт оруулах тухай	2020.04.30	A/590	<p>Дэлхий нийтэд тархаж байгаа КОВИД-19 халдварт өвчинтэй тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн</p>	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=48676">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=48676</a>

				хугацааг сунгасантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/436 дугаар захирамжийн үйлчлэх хугацааг 2020 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд сунгах болон бусад.	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=48893">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=48893</a>
10	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний тухай	2020.05.04	A/616	Нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газруудын үйл ажиллагаа нь КОВИД-19 өвчинтэй тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан зөвлөмж, заавар, дүрэм, журмыг зөрчиж, өвчин тархах эрсдэлтэй нөхцөл байдлыг бий болгож байгаа тул бүх төрлийн баарны үйл ажиллагааг зогсоож, дээрх тусгай зөвшөөрөлтэй бусад байгууллагын үйл ажиллагааг 07:00-22:00 цаг хүртэл ажиллуулахаар хязгаарлах болон бусад	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=49458">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=49458</a>
11	Захирамжид өөрчлөлт оруулах тухай	2020.05.29	A/752	Дэлхий нийтэд тархаж байгаа КОВИД-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд гамшаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 590 дүгээр захирамжийн 1 дэх хэсгийн “05 дугаар сарын 31-ний” гэснийг “6 дугаар сарын 30-ны” гэж өөрчилсүгэй.	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=49943">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=49943</a>
12	КОВИД-19 цар тахлын үед эдийн засгийг дэмжих зарим арга хэмжээний тухай	2020.06.30	A/930	Дэлхий нийтэд тархаж байгаа КОВИД-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд гамшаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд олон нийтийг хамарсан жагсаал цуглаан, арга хэмжээ, РС тоглоомын газар, диско болон бүжгийн баарны үйл ажиллагааг түр зогсоосугай. Улс, нийслэлийн эдийн засаг, хувийн хэвшлийн байгууллага, ажиллагсдын үйл ажиллагааг дэмжих талаар Улсын Онцгой комиссын 2020 оны 24, 25	

13	КОВИД-19 цар тахлын Халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай	2020.11.11	A/1241	<p>дугаар хурлаас өгсөн үүрэг чиглэл, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын санал хүсэлтийг судалсны дагуу энэ захирамжийн 1-д зааснаас бусад баар, биллиард, хүүхдийн зуслан, тоглоомын газар, шашин, соёл урлаг, үзвэр үйлчилгээний газруудад халдварын эрсдэлийн үнэлгээ хийж, мэргэжлийн байгууллагын шаардлагыг хангуулан үе шаттайгаар нээх талаар болон бусад</p> <p>1. КОВИД-19 цар тахлын халдвар, томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын Онцгой комиссоос тогтоосон хугацаанд дор дурдсан үйл ажиллагааг хязгаарлаж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосугай.</p> <p>Үүнд:</p> <p>1.1. Олон нийтийг хамарсан хурал, жагсаал, цуглаан, тэмцээн, уралдаан, аялал зугаалга, сургалт, бүх төрлийн баар, тоглоомын газар, сүм хийд, мөргөлийн газрууд, урлаг соёл, үзвэр үйлчилгээний газар, спортын арга хэмжээ /цанын бааз, спорт заал, биллиард, саун, бассейн, фитнес, бүжиг, иогийн клуб г.м/ болон амралт, жуулчны бааз, дэн буудлын үйл ажиллагааг түр зогсоох;</p> <p>1.2. Сogтгууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хүнсний худалдаа, үйлчилгээний газар /ресторан, кафе, хайпермаркет, супермаркет, минимаркет, хүнсний дэлгүүр, бөөний төв, агуулах худалдаа/ болон нийтийн үйлчилгээтэй цайны газар, сүлжээ хоолны газар, сүлжээ хүнсний дэлгүүр, хүргэлтийн хоолны газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг 07:00-22:00 цаг хүртэл тогтоож, хязгаарласан хугацаанд согтгууруулах ундаагаар үйлчлэхгүй, худалдахгүй байх;</p>	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=51822">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=51822</a>
----	--	------------	--------	--	---

			<p>1.3.Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээг өглөө 06:00-10:00 цаг, орой 17:00-21:00 цагуудад тээвэр зохицуулалтын тусгай хуваарыг шилжүүлж, амны хаалтгүй иргэнд үйлчлэхгүй байх, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол зохион байгуулж ажиллах;</p> <p>1.4.Ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, бүх шатны сургалтын байгууллага, өдөр өнжүүлэх төв, цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг түр зогсоосон шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, бага насны хүүхдүүдийг болзошгүй эрсдэлээс сэргийлж, хараа хяналтгүй үлдээхгүй байх, олон нийтийн үйлчилгээний газраар дагуулж явуулахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах;</p> <p>1.5.КОВИД-19 цар тахлын халдвар, томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалт, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний талаарх бодит мэдээллийг иргэдэд нэгдсэн байдлаар тогтмол хүргэх ажлыг зохион байгуулах;</p> <p>1.6.Үйлчлүүлж байгаа иргэд болон ажиллагсдын биеийн халууныг үзэж нэвтрүүлэх, гарыг ариутгах, амны хаалтын хэрэглээг хэвшүүлэх, амны хаалтгүй, биеийн халуунаа үзүүлэхээс тагталзсан иргэдэд үйлчилгээ үзүүлэхгүй байх, томоохон зах, худалдаа, үйлчилгээний төвийн дотор, гадна орчинд халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх;</p> <p>2.Нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, аж ахуйн нэгж, байгууллагын 12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүд /ганц бие эцэг/-д байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр гэрээсээ цахимаар ажиллах боломжийг бүрдүүлж, цалин хөлсийг ажилласанд тооцож олгохыг дээрх байгууллагуудын удирдлагуудад зөвлөсүгэй;</p>
--	--	--	---

14	Бүх нийтийн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2020.11.12	A/1242	<p>1.КОВИД-19 цар тахлын халдварын тархалтыг хязгаарлах зорилгоор “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн хугацаанд хязгаарлалт тогтоохгүй хуулийн этгээд, үйл ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталж, дараах арга хэмжээг авч ажилласугай:</p> <p>1.1.Нийслэлийн нутаг дэвсгэрт хавсралтад дурдсанаас бусад үйл ажиллагааг зогсоосугай.</p> <p>1.2.Энэ захирамжийн хавсралтад заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс бусад тээврийн хэрэгслийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодод орох, гарах хөдөлгөөнийг хязгаарласугай.</p> <p>1.3.Нийтийн тээврийн үйлчилгээг тээвэр зохицуулалтын тусгай хуваарьт шилжүүлж өглөө 06:00-10:00, орой 17:00-22:00 цагийн хооронд нийтэд үйлчлэхээр тогтоосугай.</p> <p>1.4.Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй хүнсний худалдааны газар / хайпермаркет, супермаркет, минимаркет, хүнсний дэлгүүр/-ын ажиллах цагийн хуваарийг 07:00-21:00, хүнсний бөөний төв, агуулах, хүнсний захын ажиллах цагийн хуваарийг 06.00-19.00 цаг хүртэл тогтоож, хязгаарласан хугацаанд согтууруулах ундаа худалдахыг хориглосугай.</p> <p>1.5.Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд үйлчлүүлж байгаа иргэд болон ажиллагсдын биеийн халууныг үзэж нэвтрүүлэх, гарыг ариутгах, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж, цэвэрлэгээ, үйлчилгээ, халдваргүйжүүлэлтийн байдалд дотоодын хяналт тавьж ажилласугай.</p> <p>1.6. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд ажилтан албан хаагчдаа гэрээсээ цахимаар ажиллах боломжийг бүрдүүлж ажиллахыг зөвлөсүгэй.</p> <p>1.7.Зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд гэрээсээ гарахгүй байхыг нийт иргэд, оршин суугчдад уриалах тухай болон бусад</p>	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=51835">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=51835</a>
----	---	------------	--------	--	---



Захирамжид оруулах тухай	2020.11.18	A/1248	<p>1.Нийслэлийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/1242 дугаар захирамжийн 1.3-т заасан “Нийтийн тээврийн үйлчилгээг тээвэр зохицуулалтын тусгай хуваарьт шилжүүлж өглөө 06:00-10:00, орой 17:00-22:00 цагийн хооронд нийтэд үйлчлэхээр тогтоосугай” гэснийг “Нийтийн тээврийн үйлчилгээг тээвэр зохицуулалтын тусгай хуваарьт шилжүүлж өглөө 07:00-10:00, орой 17:00-20:00 цагийн хооронд нийтэд үйлчлэхээр тогтоож, бусад цагт явган хүн, автомашины хөдөлгөөнийг хязгаарласугай” гэж өөрчилсүгэй.</p> <p>2.Цагийн хязгаарлалтыг өөрчилсөнтэй холбогдуулан хүнсний үйлдвэрлэл, худалдаа /хайпермаркет, супермаркет, минимаркет, хүнсний дэлгүүр, бөөний төв, агуулах, хүнсний зах, мал, амьтны тэжээл/ эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагууд бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлтийг шөнийн 22:00-06:00 цагийн хооронд зохион байгуулж ажилласугай.</p>	<a href="https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=51962">https://ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=51962</a>
--------------------------	------------	--------	---	---

#### 4.2. Орон нутаг /Аймгууд/

№	Тогтоол, захирамжийн нэр	Огноо	Дугаар	Тайлбар	Линк
<b>Орхон аймаг</b>					
1	Хөрөнгө гаргах тухай	2020.02.12	A/84	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5/a/, 29.1.5/b/, 29.1.6/l/, 29.2.30 дугаар зүйлийн 30.1.3, 30.1.6 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1, 11.2.3, 13.6 дахь заалт Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 2.4.1 дэх заалт, УОК-ын 2020 оны 4 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн Захирамжлах нь:	<a href="http://www.erdenet.mn/lavlah/">http://www.erdenet.mn/lavlah/</a>

2	Шуурхай штаб байгуулах тухай	2020.02.14	A/89	<p>1.КОВИД-19-ийн халдварын эрсдэл өндөр байгаа тул болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах зорилгоор шаардлагатай бодис материал, хамгаалах хувцас хэрэгсэл худалдан авч нөөц бүрдүүлж ажиллахад шаардагдах зүйлсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.</p> <p>Бэлэн байдлыг хангах, бодис материал, хамгаалах хувцас хэрэгслийн нөөц бүрдүүлэхэд шаардагдах 35.000.000 /Гучин таван сая/ төгрөгийн зардлыг Онцгой комиссын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэст зөвшөөрсүгэй.</p> <p>3. Шаардлагатай бодис материал, хамгаалах хувцас хэрэгсэл худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Онцгой байдлын газарт үүрэг болгосугай.</p>	<p><a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qs1=lawid=200200053">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qs1=lawid=200200053</a></p>
---	------------------------------	------------	------	---	--

3	Ажлын тусгай горимд шилжүүлэх тухай	2020.02.17	A/102	<p>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/л/, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2, 32 дугаар зүйлийн 32.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоол, УОК-ын 2020 оны 02 дугаар сарын13-ны өдрийн тушаалыг тус тус үндэслэн Захирамжлах нь:</p> <p>Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд ажлын тусгай горимд шилжүүлсүгэй</p> <p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа/тусгайлсан болон онцгой чиг үүргийн байгууллага, эрүүл мэндийн байгууллага/-уудаас бусад төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн дарга, удирдлагуудад ажлын тусгай горимд шилжүүлсэнтэй холбогдуулан 0-5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчийн гаргасан хүсэлтийг үндэслэн ажлын өдрийн үргэлжлэх хугацааг 6 цагаар тогтоож холбогдох шийдвэрийг гарган, мөрдүүлж ажиллахыг үүрэг болгосугай.</p> <p>Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг шуурхай штабт даалгасугай.</p>	<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200200063">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200200063</a>
4	Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай	2020.02.21	A/129	<p>Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улс, хот хоорондын зорчигч тээврийн болон хувийн тээврийн хэрэгсэлийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 08 цагаас 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 08 цаг хүртэл хугацаанд түр зогсоосонтой холбогдуулан аймгийн хэмжээнд дараах арга хэмжээг авч, бэлэн байдлыг хангаж ажиллахыг холбогдох байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.</p>	<a href="http://www.erdenet.mn/lavlah/search">http://www.erdenet.mn/lavlah/search</a>

5	Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай	2020.02.26	A/130	Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улс, хот хоорондын зорчигч тээврийн болон хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 08 цаг хүртэл сунгасантай холбогдуулан арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэхийг даалгасугай.	<a href="http://www.erdenet.mn/lavlah/search">http://www.erdenet.mn/lavlah/search</a>
6	Гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх тухай	2020.03.24	A/189	1. Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх тэмцэх иргэдийг тусгаарлах, ажиглалтанд авах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах, аймгийн гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын хэсгийг баталсугай. 2. Гамшигаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч С.Батжаргалд даалгасугай.	<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=2003000078">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=2003000078</a>
7	Арга хэмжээ зохион байгуулах тухай	2020.03.27	A/192	Улсын онцгой комиссоос ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу аймгийн хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр, ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээг 2020 оны 04 дүгээр 01-ний өдрийн 13.00-18.00 цагийн хооронд тус тус зохион байгуулах.	<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=2003000048">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=2003000048</a>
8	Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай	2020.03.10	A/150	2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 07 цагаас 03 дугаар сарын 16-ны өдрийн 07 цаг хүртэл түр зогсоосонтой холбогдуулан аймгийн хэмжээнд зохион байгууллын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг аймгийн шуурхай албадад үүрэг болгосугай.	<a href="http://www.erdenet.mn/lavlah/search">http://www.erdenet.mn/lavlah/search</a>
9	Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай	2020.03.27	A/193	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5/а/, 29.1.5/в/, 29.1.6/л/, 29.2 дахь заалт Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1, 11.2.3 дахь заалт, Архидан согуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн	<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=2003000049">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=2003000049</a>

				6.5 дахь заалт Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11, 11.2, 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалт Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн		<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200400048">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200400048</a>
10	Хөрөнгө гаргах тухай	2020.04.14	A/234 A/237 A/236	Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн		<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200400072">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200400072</a>
11	Ажлын хэсэг байгуулах тухай	2020.04.23	A/265	Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дахь заалт, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт Эрүүл мэндийн сайдын 2020 оны Үйлчилгээний зарим байгууллагад мөрдөх эрүүл ахуйн халдвараас сэргийлэх түр журам батлах тухай 249 дүгээр тушаал, Аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн		<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200500007">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200500007</a>
12	Нэмэгдэл хөлс, урамшуулал олгох тухай	2020.04.27	A/270	Хяналтын постуудад үүрэг гүйцэтгэсэн иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлахад эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн, тусгаарлалтад байгаа иргэдэд хяналт тавьж ажилласан албан хаагчдад илүү цагаар ажилласан урамшуулал, нэмэгдэл хөлсийг байгууллагын төсөвт багтаан холбогдох журмын дагуу тооцон олгох тухай		<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200500001">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200500001</a>
13	Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай	2020.04.30	A/288	2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл түр зогсоосон хугацааг 2020 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгав.		<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200500001">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200500001</a>
14	Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай	2020.07.10	A/449	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургуулийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд 2020 оны 07 дугаар сарын 15-ны өдрийг дуустал зогсоосон хугацааг 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгав.		<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200500001">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=200500001</a>

15	Сургалт зохион байгуулах тухай	2020.10.07	A/590	КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний багийг бэлтгэх сургалтын удирдамжийн дагуу	<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=201000038">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=201000038</a>
16	Гамшгаас хамгаалах шуурхай штаб, хариу арга хэмжээний баг байгуулах тухай	2020.10.09	A/601	Шуурхай хариу арга хэмжээний бүлгүүдийг сургаж дадлагажуулах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангуулах ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Сүхээд үүрэг болгосугай.	<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=201000048">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=201000048</a>
17	Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай	2020.10.30	A/636	2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгав.	<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=201000049">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=201000049</a>
18	Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай	2020.11.11	A/665	2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 13-ний өдрийг дуустал сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд түр зогсоосугай.	<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=201100001">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=201100001</a>
19	Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай	2020.11.11	A/670	2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 08 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 24 цаг хүртэл Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдан борлуулдаг аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг түр зогсоов.	<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=201100002">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=201100002</a>
20	Аймгийн хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай	2020.11.11	A/671	2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06 цаг хүртэл гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсүгэй.	<a href="http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=201100003">http://erdenet.mn/report/printreport.php?fn=lawdetail.php&amp;qsl=lawid=201100003</a>
<b>Дорноговь аймаг</b>					
1	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай	2020.11.11	178	2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 26/16 дугаар зөвлөмж, Эрсдэлийн үнэлгээний 14 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас тогтоох нь	Аймгийн засаг даргын туслахаас авсан .
2	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2020.11.13	A/310	2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06 цаг хүртэлх хугацаанд 07-20 цаг хүртэл ажиллуулахаар цагийн хуваарийг тогтоосугай.	Аймгийн засаг даргын туслахаас авсан



3	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2020.11.16	A/826		Аймгийн төлөөлөгчөөс авсан.
4	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2020.11.17	A/311		
5	Шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай	2020.11.19	A/830		
<b>Дундговь аймаг</b>					
1	Зохион байгууллалтын арга хэмжээ авах тухай	2020.11.11	A/331	2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал түр хугацаанд соёл урлаг олон нийтийн үйл ажиллагааг түр хориглох боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоох, мөн архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.	<a href="https://www.dundgovi.gov.mn/data/main/main1605247544.pdf">https://www.dundgovi.gov.mn/data/main/main1605247544.pdf</a>
2	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	2020.11.12	A/332	Гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хот, аймаг, сум хоорондын тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнийг Улсын Онцгой комиссын зөвшөөрснөөс бусад тохиолдолд 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06 цаг хүртэл хугацаанд хориглосугай.	<a href="https://www.dundgovi.gov.mn/data/main/main1605247714.pdf">https://www.dundgovi.gov.mn/data/main/main1605247714.pdf</a>
3	Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах тухай	2020.11.13	A/337	Хүнсний худалдаа, түгээлтийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагад урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийн ажлыг орон нутгийн нөөц, мэргэжлийн байгууллагын оролцоотой зохион байгуулахыг сумдын засаг дарга нарт даатгасугай.	<a href="https://www.dundgovi.gov.mn/data/main/main1605260402.pdf">https://www.dundgovi.gov.mn/data/main/main1605260402.pdf</a>

4	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай	2020.11.16	A/339	2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06 цаг хүртэл зорчигч тээврийн хэрэгсэл болон архи согтууруулах ундаа худалдан борлуулах, соёл урлагийн үйл ажиллагаа, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосугай.	<a href="https://www.dundgovi.gov.mn/data/main/main16055517071.pdf">https://www.dundgovi.gov.mn/data/main/main16055517071.pdf</a>
<b>Сэлэнгэ</b>					
1	Иргэдийн эрүүл мэндийн хамгааллыг сайжруулах, зарим үйл ажиллагааг түр хязгаарлах тухай	2020.01.30	A/16	Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор “Согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй” худалдаа, үйлчилгээний газруудын ажиллах хуваарийг 2020 оны 02 сарын 01-ний өдрөөс эхлэн 2020 оны 03-р сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд 08.00 цагаас 22.00 цаг хүртэл ажиллах түр цагийг хязгаарлах тухай	<a href="http://selenge.gov.mn/beta/ur/beta/36/item/2683">http://selenge.gov.mn/beta/ur/beta/36/item/2683</a>
2	Шуурхай штаб байгуулж ажлын тусгай горимд шилжүүлэх тухай	2020.02.14	A/56	Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, гамшигаас хамгаалах алба, ангиудыг тусгай горимд шилжүүлж аймгийн шуурхай штабыг байгуулах тухай	<a href="http://selenge.gov.mn/beta/ur/load/files/15af318de838118fb1cb24d810c68532b.pdf">http://selenge.gov.mn/beta/ur/load/files/15af318de838118fb1cb24d810c68532b.pdf</a>
3	Иргэдийн эрүүл мэндийн хамгааллыг сайжруулах, зарим үйл ажиллагааг түр хязгаарлах тухай A/16 дугаар захирамжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2020.02.14	A/57	Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний байгууллагуудыг үйл ажиллагааг зогсоож, хүнсний дэлгүүр, худалдааны төвүүдийн архи, согтууруулах ундаа худалдах цагийн хуваарийг өглөөний 10.00 цагаас оройн 18.00 цаг хүртэл, хүнсний дэлгүүрийн үйл ажиллагааг өглөөний 08.00 цагаас оройн 22.00 цаг хүртэл ажиллуулах	<a href="http://selenge.gov.mn/beta/36/item/2705">http://selenge.gov.mn/beta/36/item/2705</a>

4	A16, A57 захирамжид өөрчлөлт оруулах, бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	2020.02.21	A/66	БНХАУ-д гарсан шинэ коронавирусын халдвар буурахгүй байгаатай холбогдуулан мөн Улсын Онцгой комиссын шийдвэрийг үндэслэн гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020.03.30-ны өдөр хүртэл сунгав. Мөн 2020 оны A99 тоот захирамжаар 04 сарын 30 хүртэл сунгасан 2020 оны A/134 тоот захирамжаар 05-р сарын 31 хүртэл 2020.06.03 өдрийн A/158 тоот захирамжаар 06-р сарын 31 хүртэл 2020.07.07 өдрийн A/188 захирамжаар 07-р сарын 15 хүртэл 2020.07.16 адрийн A/212 тоот захирамжаар 07-р сарын 31 хүртэл 2020.08.03 өдрийн A/220 тоот захирамжаар 08-р сарын 31 хүртэл 2020.08.31 өдрийн A/246 тоот захирамжаар 09-р сарын 15 хүртэл 2020.09.18 өдрийн A/256 тоот захирамжаар 10-р сарын 31 хүртэл сунгаж, соёл урлаг, нийтийн үзвэр, үйлчилгээний газрууд хэвийн горимд шилжсэн.	<a href="http://selenge.gov.mn/beta/upload/files/16d276ccd58d5986ecf9d8e695af253de.pdf">http://selenge.gov.mn/beta/upload/files/16d276ccd58d5986ecf9d8e695af253de.pdf</a>
5	Зорчих хөдөлгөөнийг түр зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай хязгаарлах тухай	2020.02.27	A/69	Улсын Онцгой комиссын 2020.02.26-ын өдрийн 02-р тогтоолыг үндэслэн 2020 оны 3-р сарын аймгийн засаг даргын захирамжаар зорчих хөдөлгөөнийг 3 дугаар сарын 3-ны өдрийн 06:00 цаг хүртэл хязгаарлалаа.	<a href="http://selenge.gov.mn/beta/beta/36/item/2711">http://selenge.gov.mn/beta/beta/36/item/2711</a>
6	КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай	2020.03.03	A/70	БНХАУ-д гарсан шинэ коронавирусын халдвар буурахгүй байгаатай холбогдуулан эзэнгүй муур, нохой устгах ариутгах, хог, хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж буй ААН, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, халдваргүйжүүлэх ажлыг сумдын засаг дарга нарт даалгах тухай	<a href="http://selenge.gov.mn/beta/upload/files/148d48dddae6008300240daac36501ba0c.pdf">http://selenge.gov.mn/beta/upload/files/148d48dddae6008300240daac36501ba0c.pdf</a>

7	КОВИД-19 цар тахлын үед тусгаарлах, ажиглалтын түр байранд байрлах иргэдийн нэг өдрийн зардлын хэмжээг тогтоох тухай	2020.03.17	A/86	УОК-ын 2020.02.26-ны өдрийн 02-р тогтоол, КОВИД-19 цар тахлын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журмыг үндэслэн нэг иргэнд ногдох зардлыг хавсралтаар баталсан.	<a href="http://selenge.gov.mn/beta/upload/files/1/0d5d982c5ba453dca39a608e4a7f0135.pdf">http://selenge.gov.mn/beta/upload/files/1/0d5d982c5ba453dca39a608e4a7f0135.pdf</a>
8	КОВИД-19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх “Амны хаалтаа зүүцгээ” аяныг өрнүүлэх тухай	2020.04.14	A/119	КОВИД-19-ийн халдварын болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг чангатгах зорилгоор аймгийн хэмжээнд 2020.04.14-05.31 хүртэл уг аяныг хэрэгжүүлэх тухай	<a href="http://selenge.gov.mn/beta/upload/files/1c8106044347d5f9aba170fa8d459b013.pdf">http://selenge.gov.mn/beta/upload/files/1c8106044347d5f9aba170fa8d459b013.pdf</a>
9	Зорчих хөдөлгөөнийг түр зогсоох тухай	2020.04.21	A/122	2020.04.21-ний өдрийн 21:00 цагаас 2020.04.25-ны өдрийн 06:00 цаг хүртэл аймаг, сумын төвөөс гарах, орох чиглэлд иргэд, автомашин, суудлын галт тэрэгний зорчих хөдөлгөөнийг түр зогсоох тухай	<a href="http://selenge.gov.mn/beta/upload/files/1/d8d7570723737ae6cd0a066b3f5ad727.pdf">http://selenge.gov.mn/beta/upload/files/1/d8d7570723737ae6cd0a066b3f5ad727.pdf</a>
10	A/115 тоот захирамжид нэмэлт өөрчлөлт оруулж, хугацаа сунгах тухай	2020.04.29	A/130	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хугацаанд хориглохыг 2020 оны 05-р сарын 31-ний өдөр хүртэл сунгах	<a href="http://selenge.gov.mn/beta/36/item/2968">http://selenge.gov.mn/beta/36/item/2968</a>
11	КОВИД-19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх “Маскаа зүүе, гараа угаая” 2 аян зохион байгуулах тухай	2020.10.29	A/188	КОВИД-19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх “Маскаа зүүе, гараа угаая” 2 аян зохин байгуулж телевиз, радио, сонин цахим хуудсаар сурталчлах ажлыг зохион байгуулах	<a href="http://selenge.gov.mn/beta/upload/files/1/aaa71d16bb2aa917f0c103815014b543.pdf">http://selenge.gov.mn/beta/upload/files/1/aaa71d16bb2aa917f0c103815014b543.pdf</a>
12	Зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн бүх шатны боловсролын байгууллагын хичээл сургалтын болон зарим төрлийн үйл ажиллагааг түр зогсоож, цагийн хязгаарлалт тогтоох тухай	2020.11.11	A/306	СЭЛЭНГЭ аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/306 дугаартай зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын болон зарим төрлийн үйл ажиллагааг түр зогсоож, цагийн хязгаарлалтыг 11-р сарын 11-ний өдрийн 08:00 цагаас 11-р сарын 13-ны 18 цаг хүртэл	<a href="http://selenge.gov.mn/beta/36/item/3168">http://selenge.gov.mn/beta/36/item/3168</a>

Завхан			
1	Завхан аймгийн Онцгой комиссын шийдвэр	2020.01.27	<p>Гуравдугаар сарын 02-ны өдрийг хүртэл олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглож, баар цэнгээний газар, караоке зэрэг үйлчилгээний газруудын үйл ажиллагааг түр зогсоохоор шийдвэрлэлээ.</p> <p>Ханиад томуунаас урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулах, ариутгал халдваргүйжүүлэлтийг сайтар хийх талаар айл өрх, албан байгууллагуудад зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.</p> <p>Аймгийн Эрүүл мэндийн газарт ард иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх “Нээлттэй утас” ажиллуулахаар боллоо.</p> <p>Орон нутаг руу чиглэсэн зорчих хөдөлгөөн ихэсч буйтай холбогдуулан эрүүл мэндийн байгууллагаас зорчигчдыг утгах, зөвлөх үйлчилгээг 1-р сарын 28-ны өдрөөс эхлэн зохион байгуулна.</p> <p>Ханиад томуугаар өвчилсөн хүүхдээ асрах шаардлагатай 0-5 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд 5 хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгоно. Ингэхдээ байгууллага бүр ажлын байрны онцлогтоо тохируулан шийдвэр гаргахыг төрийн өмчийн болон төсвийн байгууллагуудад үүрэг болгож, хувийн хэвшлийн байгууллагуудад “Уриалга” хүргүүлээ.</p> <p>Хүүхдийн тасгийг дулаан байлгах, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулах, орчны тохижилт соёлжилтод онцгой анхаарч ажиллахаар боллоо.</p> <p>Ачаалал нэмэгдсэн тохиолдолд нөөц ор гаргах, зарим тасгийг хүүхдийн эмчилгээний тасаг болгох үүргийг аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн удирдлагуудад өглөө.</p> <p>Эрсдэлийн үнэлгээ хийх, бэлэн байдлын төлөвлөгөө</p>

				<p>боловсруулж танилцуулахыг аймгийн Онцгой байдлын газар, ажлын хэсэгт даалгалаа. Албан байгууллага, айл өрхүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан аймгийн Засаг даргын “Албан даалгавар” гаргахаар болж, үйлчилгээний байгууллагуудын цагийн хуваарыг хязгаарлалт тогтоолоо. Ресторан, зоогийн газруудыг 20:00 цаг хүртэл, дэлгүүрийг 22:00 цаг хүртэл ажиллуулахаар шийдвэрлэв.</p>	<a href="http://zavkhan.gov.mn/151/item/3200">http://zavkhan.gov.mn/151/item/3200</a>
2	“Ажлын тусгай горимд түр шилжүүлэх тухай”	2020.02.14	A/68	<p>Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, гамшаас хамгаалах алба, ангиудыг тусгай горимд шилжүүлж аймгийн шуурхай штабыг байгуулах тухай</p>	<a href="http://zavkhan.gov.mn/151/item/3200">http://zavkhan.gov.mn/151/item/3200</a>
3	Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, байдлыг хангах зорилгоор аймгийн Онцгой комиссоос гаргасан шийдвэрүүд	2020.02.14		<ul style="list-style-type: none"> <li>- Сум бүрт эмч, хэсгийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй “Шуурхай штаб” байгуулах</li> <li>- Их-Уул суманд 24 цагийн ажиллагаатай хяналтын пост ажиллуулах</li> <li>- Шашны байгууллагуудын шашин номын хурал, цуглаан, зан үйлд иргэд олон нийтийг оролцуулахгүй байх</li> <li>- Зоогийн газар, ресторануудыг 18:00 цаг, дэлгүүр, худалдаа үйлчилгээний газруудыг 20:00 цагаас хойш ажиллуулахгүй байх</li> <li>- Бүх төрлийн үзэсгэлэн худалдаа, сар шинийн баяртай холбоотой зар сурталчилгааг хориглох</li> <li>- Байгууллагынхаа онцлогт тохируулан ажлын цагийг багасгах, ажлын цагийг нягтруулах замаар ажилтнуудынхаа гэр бүлдээ зарцуулах цаг хугацааг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх</li> <li>- Орон нутгийн хэмжээнд олон нийтийг алдаршуулах, шагнаж урамшуулах, үсэргээ уралдаан, сорил зохион байгуулахыг хориглох</li> </ul>	



					- Амны хаалт зүүгээгүй иргэдэд үйлчлэхгүй байхыг албан байгууллага, хувийн хэвшлийнхэнд тус тус даалгалаа.	<a href="http://zavkhan.gov.mn/151/item/3209">http://zavkhan.gov.mn/151/item/3209</a>
4	Аймгийн Онцгой Комисс	2020.02.21			2-р сарын 23-ны өдрийн 08:00 цагаас 27-ны өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд аймаг, сумын төвөөс гарах, орох хөдөлгөөнийг хязгаарлалаа	<a href="http://zavkhan.gov.mn/151/item/3211">http://zavkhan.gov.mn/151/item/3211</a>
5	Аймгийн Онцгой Комисс	2020.02.26			Хот хооронд, орон нутгийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлах тухай шийдвэрийг 2020 оны 3-р сарын 3-ны өдрийн 08:00 цаг хүртэл сунгах Баар, цэнгээний газруудын үйл ажиллагааг түр зогсоох, дэлгүүр, зоогийн газруудын ажиллах хугацааг богиносгосон шийдвэрийг гуравдугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгах	
6	Аймгийн Онцгой Комисс	2020.03.10			Аймаг, сумаас орох, гарах бүх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020.03.10-ны өдрийн 07:00 цагаас эхлэн 2020.03.16-ны өдрийн 07:00 цаг хүртэл хязгаарлах Хөдөлгөөн хаах хугацаанд аймгийн хэмжээнд 106 пост (24 сумын 96 пост, аймгийн хилийн дагуу 10 пост) 24 цагаар ажиллуулах, постын орчин нөхцөлийг стандартын дагуу бүрдүүлэхийг сумын Засаг дарга нарт даалгав	<a href="http://zavkhan.gov.mn/151/item/3220">http://zavkhan.gov.mn/151/item/3220</a>
7	Аймгийн Онцгой Комиссын шийдвэр	2020.03.15			Замын хөдөлгөөнийг 2020 оны 3-р сарын 16-ны өдрийн 07:00 цагт нээнэ. Аймгийн хэмжээнд ажиллаж буй 106 хяналтын цэгээс 97 хяналтын цэгийг буулгаж, Их-Уул, Тэлмэн, Сонгино, Отгон, Ургамал, Сархайрхан, Улиастай сумын 3, нийт 9 хяналтын цэг ажиллана Сум бүрт сумдын Засаг дарга нараар ахлуулсан “Хяналтын баг” ажиллаж, орох гарах хөдөлгөөнд хяналт тавина “Уугах-Зөвлөх” үйлчилгээг эхлүүлнэ. Нисэх онгоц, нийтийн тээврээр ирж буй иргэдийг аймгийн Эрүүл мэндийн газар, хувийн тээврийн хэрэгслээр ирж	<a href="http://zavkhan.gov.mn/151/item/3223">http://zavkhan.gov.mn/151/item/3223</a>

				буй иргэдийг аймгийн Мэргэжлийн хяналтын газар хариуцан зохион байгуулна. Улаанбаатар хот болон гадны аймгуудаас ирж буй иргэн бүрээр асуумж бөглүүлж, хяналтандаа авна.	<a href="http://zavkhan.gov.mn/151/item/3297">http://zavkhan.gov.mn/151/item/3297</a>
8	Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай	2020.04.21	A/174	Зоогийн газар /ресторан, кафе/ дэлгүүр, худалдааны цэгүүд 22:00 цаг хүртэл үйл ажиллагаагаа явуулж, зоогийн газар /ресторан, кафе/-ыг өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд архи, согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглох, фитнес, бассейн, сауны үйл ажиллагааг 2020 оны дөрөвдүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн явуулахыг зөвшөөрч, үйлчлүүлэгчийн биеийн халууныг хэмжих, гар ариутгал, амны хаалтын хэрэглээг хэвшүүлэх, ариутгал халдваргүйтгэлийг 2 цаг тутамд хийж, нэг дор 10-аас дээш хүний бөөгнөрөл үүсгэхгүйгээр, мэргэжлийн байгууллагаас гаргасан стандарт, зөвлөмж, шаардлагыг мөрдөж ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд Сум, орон нутгаас Улаанбаатар хот, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн чиглэлд явах нийтийн тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны дөрөвдүгээр сарын 21-ний өдрийн 23:00 цагаас 4-р сарын 25-ны өдрийн 06:00 цаг хүртэл түр зогсоох	<a href="http://zavkhan.gov.mn/151/item/3423">http://zavkhan.gov.mn/151/item/3423</a>
9	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, зарим арга хэмжээг эрчимжүүлэх тухай	2020.11.12	A/418	Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 2020.11.12-2020.11.17 өдөр хүртэл шилжүүлэв.	<a href="http://zavkhan.gov.mn/151/item/3425">http://zavkhan.gov.mn/151/item/3425</a>
10	Аймгийн Онцгой Комиссын шийдвэр	2020.11.16		Аймгийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд, иргэд, хуулийн этгээдийн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл сунгахаар шийдвэрлэв.	<a href="http://zavkhan.gov.mn/151/item/3425">http://zavkhan.gov.mn/151/item/3425</a>

			<p>Аймгийн хэмжээнд ажиглан тусгаарлах байр болон эмнэлгийн тусгаарлах байрыг бэлтгэх, ашиглах журмыг баталлаа.</p> <p>Ажиглан тусгаарлах байр, эмнэлгийн тусгаарлах байр бэлтгэх, ашиглахтай холбогдон гарах зардлыг тухайн жилийн төсөвтөө багтаан зохицуулалт хийх замаар ажиллуулахыг сумдын Засаг дарга нар, албан байгууллагын дарга нарт үүрэг болгов.</p> <p>Голомт бүхий эрдэлтэй бүс нутгаас ирж буй иргэдийн хяналтыг чангатгах, гэрийн тусгаарлалтад байгаа иргэдийн хяналтыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймгийн Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, сумдын Засаг дарга нарт үүрэг болголоо.</p> <p>“Чандмань-Эрдэнэ” лаборатори сургууль, Хөгжим бүжгийн коллеж, Политехник коллеж, Тосонцэнгэл сумын МСҮТ-ийн дотуур байранд байрлаж буй хүүхдүүдийг гэрт нь шилжүүлэх замаар дээрх сургуулиудын дотуур байрыг ажиглан тусгаарлах байр болгон бэлтгэхээр шийдвэрлэв.</p> <p>Хяналтын постуудын үйл ажиллагааг хариуцлагажуулах үүднээс ажиллах нөхцөлийг сайжруулах үүргийг Цэргийн анги, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн газар, ГХБХБГазарт тус тус чиглэл болгов.</p> <p>Улаанбаатар хотод амьдардаг иргэдэд нэг удаагийн зөвшөөрөл өгч гаргахаар шийдвэрлэв.</p> <p>Сумаас аймгийн төвд ирсэн иргэдэд хязгаарлалтын горим хэвээр үйлчилнэ.</p> <p>Идэш бэлтгэхээр сум руу явах иргэдийг гаргах боломжгүй. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн иргэн аймгийн ХХАА-н газарт нэгдсэн журмаар мэдээллээ өгснөөр сумаас идэш бэлтгэж хүргэх,</p>
--	--	--	--

				<p>аймгаас сумдад хүнс хүргэх тээврийн зохицуулалт хийх ажлыг Мал эмнэлгийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар зохион байгуулах замаар иргэдэд өвлийн идшээ бэлтгэх боломжийг олгохоор шийдвэрлэлээ. Өнөөдрийн байдлаар Улиастайн постууд дээр ирсэн байгаа малыг нэг удаа оруулж худалдан борлуулах боломжийг олгохоор тус тус шийдвэрлэв.</p>	<p><a href="https://www.facebook.com/zavkhanpolice.mn/">https://www.facebook.com/zavkhanpolice.mn/</a></p>
11	Мотоциклийн хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглох тухай	2020.11.18	A/423	<p>Замын хөдөлгөөнд оролцогчдыг осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд «МОТОЦИКЛ»-оор замын хөдөлгөөнд оролцохыг түр хугацаагаар хориглолоо.</p>	
<b>Өмнөговь</b>					
1	Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх тухай	2020.01.28	01	<p>Улсын Онцгой комиссын шийдвэрээр 3 дугаар сарын 2-ныг хүртэл сургууль, цэцэрлэгүүд болон олон нийтийн арга хэмжээнүүдийг улсын хэмжээнд хориглосонтой холбогдуулан аймгийн Засаг даргын албан даалгавар гаргаж аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх дараах үүрэг, чиглэлийг өгөв:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Урлаг соёл, спортын арга хэмжээнүүдийг цуцлах, хориглох</li> <li>- Хурал зөвлөгөөн, найр наадам, уралдаан тэмцээнүүдийг хийхгүй байх</li> <li>- Дугуйлан, секц, РС тоглоомын газрууд, мөсөн коток, фитнес, спорт заалны үйл ажиллагааг зогсоох</li> <li>- Шөнийн клуб, бүжиг, караоке зэрэг олон хүн цуглуулсан арга хэмжээнүүдийг хориглох</li> <li>- ААН, албан байгууллагууд, худалдаа үйлчилгээний газруудад ариутгал, халдваргүйжүүлэлт хийх</li> <li>- Эмийн сангууд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, үнийг үндэслэлгүйгээр нэмэхгүй байх</li> </ul>	<p><a href="http://www.omnogovi.gov.mn/i/1095">http://www.omnogovi.gov.mn/i/1095</a></p> <p><a href="http://www.omnogovi.gov.mn/i/1139">http://www.omnogovi.gov.mn/i/1139</a></p>

				<p>Зөвхөн аймгийн Эрүүл мэндийн газраас өвчний талаар үнэн бодит мэдээллээр иргэдийг хангах</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хилийн боомтуудын үйл ажиллагааг хаах саналыг Улсын Онцгой комисст хүргүүлэх, хил орчмын хяналт шалгалтыг сайжруулах</li> <li>- ЭМГ болон Мэргэжлийн хяналтын газарт нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэхэд зориулж аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөөс зардал шийдвэрлэх</li> <li>- Төрийн байгууллагууд хуваарь хийж Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор эргүүл хийх</li> </ul>	<a href="http://www.omnogovi.gov.mn/i/1137">http://www.omnogovi.gov.mn/i/1137</a>
2	Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах шуурхай ажлын хэсэг байгуулах тухай	2020.02.03	A/98	Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, гамшигаас хамгаалах алба, ангиудыг тусгай горимд шилжүүлж аймгийн шуурхай штабыг байгуулах тухай	<a href="http://www.omnogovi.gov.mn/i/1138">http://www.omnogovi.gov.mn/i/1138</a>
3	Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай	2020.02.03	A/101	МУ-ын ЗГ-аас Шивээхүрэн-Сэхээ, Гашуунсухайт-Ганцмод боомтоор хил нэвтрэх ачаа тээврийн автомашины хөдөлгөөнийг хязгаарлаж байгаагай холбогдуулан тус аймгийн Ханбогд, Гурвантэс, Ноён сумдын Сум дундын эмнэлгийг гамшиг хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэн.	<a href="http://www.omnogovi.gov.mn/i/1155">http://www.omnogovi.gov.mn/i/1155</a>
4	Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	2020.02.13	A/146	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж баталсан	<a href="http://www.omnogovi.gov.mn/i/1175">http://www.omnogovi.gov.mn/i/1175</a>
5	Зорчих хөдөлгөөнийг түр хязгаарлах тухай	2020.03.10	A/228	2020 оны 3-р сарын 16-ны 07:00 цаг хүртэл нийслэл, аймаг сумаас гарах хөдөлгөөнийг хязгаарлах 4-р сарын 01-нийг хүртэл Өмнөговь аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдахгүй, түүгээр үйлчлэхгүй байх	

6	Аймгийн Онцгой комисс ээлжит 14-ний өдрийн хуралдааны шийдвэр	2020.05.01	A/556	<p>Улс, аймгийн аварга малчин, тэргүүний сум багийн шагналыг 5-р сарын 1-ний өдрөөс эхлэн гардуулахаар боллоо. Ингэхдээ олон хүн цуглуулахгүй, мэргэжлийн байгууллагын өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.</p> <p>- Спорт заал, иог, фитнесийг Улсын Онцгой комисс, мэргэжлийн байгууллагуудын зөвлөмж шаардлагад үндэслэн шат дараатайгаар нээн ажиллуулахаар болов.</p> <p>- Өмнөговь аймгийн хэмжээнд 608 сурагч 12 дугаар ангийг төгссөн. Үүнээс 520 сурагч Элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөөр бүртгүүлсэн. Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар зэрэг холбогдох байгууллагын зөвлөгөө зөвлөмжийг хэрэгжүүлэн зай барих нэг ангид олноор цугларахгүй байх, амны хаалт зүүх, гарыг тогтмол угааж ариутгах зарчмаар ЭЕШ-д бэлтгэх сургалт, давтлагыг хийнэ.</p>	<a href="http://www.omnogovi.gov.mn/1305">http://www.omnogovi.gov.mn/1305</a>
7	Бүх шатны боловсролын байгууллагын хичээл сургалтын үйл ажиллагаа болон олон нийтийн арга хэмжээг түр хугацаагаар хязгаарлах тухай	2020.11.11	A1353	<p>Бүх шатны боловсролын байгууллагын хичээл сургалтын үйл ажиллагаа болон олон нийтийн арга хэмжээг 2020.11.11-ний өдрийн 13.00 цагаас 2020.11.14-ний өдрийг хүртэл түр хугацаагаар зогсоох тухай</p>	<a href="https://www.facebook.com/omnogovi.gov.mn/photos/pcb.3489293424473426/3489293424473426/?type=3">https://www.facebook.com/omnogovi.gov.mn/photos/pcb.3489293424473426/3489293424473426/?type=3</a>
8	Аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэхийг хориглох тухай	2020.11.11	A1353	<p>Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор Аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг 2020.11.11-11.14-ний өдөр хүртэл хориглов.</p>	<a href="https://www.facebook.com/omnogovi.gov.mn/photos/a.445051488897650/3489329257803176/">https://www.facebook.com/omnogovi.gov.mn/photos/a.445051488897650/3489329257803176/</a>
9	Аймгийн Онцгой комисс	2020.11.12		<p>Аймгийн хэмжээнд зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн орох гарах хөдөлгөөнийг 2020.11.12-ны өдрийн 06:00 цагаас 2020.11.17-ны өдрийн 06:00 цаг хүртэл бүрэн хаах шийдвэрийг гаргаж, зорчих хөдөлгөөнийг хаасан.</p>	<a href="https://www.facebook.com/omnogovi.gov.mn">https://www.facebook.com/omnogovi.gov.mn</a>



10	Зорчих хөдөлгөөнийг түр хязгаарлах тухай	2020.11.12	A/1361	аймгийн хэмжээнд зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн орох гарах хөдөлгөөнийг 2020.11.12-ны өдрийн 06:00 цагаас 2020.11.17-ны өдрийн 06:00 цаг хүртэл бүрэн хаах шийдвэрийг гаргаж, зорчих хөдөлгөөнийг хаасан.	<a href="https://www.facebook.com/omnogovi.gov.mn">https://www.facebook.com/omnogovi.gov.mn</a>
11	Аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэхийг хориглох тухай	2020.11.12	A/1365	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор уг хугацаанд Өмнөговь аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдахгүй байх, түүгээр үйлчлэхгүй байх шийдвэрийг сунгалаа.	<a href="https://www.facebook.com/omnogovi.gov.mn">https://www.facebook.com/omnogovi.gov.mn</a>
12	Зорчих хөдөлгөөнийг түр хязгаарлах тухай	2020.11.16	A/1366	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор аймгийн хэмжээнд зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн орох гарах хөдөлгөөнийг 2020.11.17-ны өдрийн 06:00 цагаас 2020.12.01-ний өдрийн 06:00 цаг хүртэл бүрэн хаах шийдвэрийг гаргаж, зорчих хөдөлгөөнийг хязгаарласан.	<a href="https://www.facebook.com/omnogovi.gov.mn">https://www.facebook.com/omnogovi.gov.mn</a>
<b>Сүхбаатар</b>					
1	Аймгийн Онцгой комисс	2020.01.27		<p>1. Сүхбаатар аймгийн хэмжээнд олон нийтийн арга хэмжээ, хурал цуглаан, спортын тэмцээн уралдаан, секц дугуйлангийн үйл ажиллагааг тодорхойгүй хугацаагаар хаах.</p> <p>2. Орон нутгийн Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нэг албан ёсны эх сурвалжид үндэслэн, баталгаат мэдээллийг олон нийтэд цаг алдалгүй хүргэж байх.</p> <p>3. Аймгийн хэмжээн дэх РС тоглоомын газруудын үйлчилгээг зогсоох. Мөн баар, ресторан, караоке зэрэг нийтийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.</p> <p>4. Шаардлагагүй тохиолдолд олон нийтийн газраар явахгүй байх, амны хаалт тогтмол хэрэглэж, гарын ариун цэврийг сайтар сахиж, илчлэг сайтай хоол хүнсийг тогтмол хэрэглэж иргэн бүр өөрөөс шалтгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p>	

	5. Амны хаалтын хэрэглээ, хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр ЭМГ, Эм ханган нийлүүлэх байгууллагууд хамтран ажиллаж, хомстол үүсгэхгүй байх тал дээр онцгой анхаарч ажиллах.				
2	Коронавирусын халдвар дэгдэхээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	2020.01.29	A/36	Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, гамшигаас хамгаалах алба, ангиудыг тусгай горимд шилжүүлж аймгийн шуурхай штабыг байгуулах тухай. Сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоох тухай	<a href="https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/pb.537200533564395/537200446897737/">https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/pb.537200533564395/537200446897737/</a>
3	Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрчимжүүлэх тухай албан даалгавар	2020.02.03	01	Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах зорилгоор албан даалгаврыг өгөв.	<a href="https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/pb.539438020007313/539437763340672/">https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/pb.539438020007313/539437763340672/</a>
4	Арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай	2020.02.13	A/126	Томоохон зах, худалдааны төвүүд, Согтуурал ундаагаа үйлчлэх ААН-н үйл ажиллагааг 2020.03.02-ны өдөр хүртэл түр зогсоох, Нийтийн хоол үйлдвэрлэлийн ААН-ыг 2020.03.02-ны өдөр хүртэл 08.00-20.00 цагийн хуваариар ажиллуулах, Дарьганга сумын нутагт орших Шилийн Богд уул чиглэлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглосон	<a href="https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/545124186105363">https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/545124186105363</a>
5	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай	2020.02.20	A/154	02-р сарын 23-ны өдрийн 08:00 цагаас 26-ны өдөр хүртэлх хугацаанд аймаг, сумын төвөөс гарах, орох хөдөлгөөнийг хязгаарлалаа. Дарьганга сумын нутагт орших Шилийн Богд уул чиглэлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020.03.09-ний өдөр хүртэл хориглосон шийдвэрийг сунгасан.	<a href="https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/549341675683614">https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/549341675683614</a>
6	Аймгийн Онцгой комисс	2020.02.27		Улсын Онцгой комисс, Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу аймаг, сумдын авто машин, зорчих хөдөлгөөнийг 02-р сарын 27-ны 08:00 цагаас 03-р сарын 03-ны 08:00 цаг хүртэл бүрэн хязгаарлалаа.	<a href="https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/553353238615791">https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/553353238615791</a>

7	Арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай	2020.03.08	A/174	Аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа борлуулах тусгай зөвшөөрөл бүхий хүнсний дэлгүүр, ААНБ-ын архи согтууруулах ундаа худалдах цагийн хуваарийг 08.00-17.00 цаг хүртэл, харин хүнсний худалдаанаас бусад буюу нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч, тусгай зөвшөөрөлтэй ААНБ-ын цагийн хуваарийг 08.00-20.00 цаг хүртэл байхаар тусгажээ. Энэхүү цагийн хуваарийн өөрчлөлт 03 дугаар сарын 30-ныг хүртэл үргэлжилнэ.	<a href="https://sukhbaatar.mn/news/m/109/show/873">https://sukhbaatar.mn/news/m/109/show/873</a>
8	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай	2020.03.10	A/198	Улсын Онцгой комиссын тогтоол, Аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу дараах хөдөлгөөнийг хязгаарлалаа. 1. Улаанбаатар хотчиглэлийн бүх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах. /Нийтийн тээвэр хамаарна/ 2. Дорноговь аймагтай хил залгаа Онгон, Баяндэлгэр, Түвшинширээ, Мөнххаан сумдын авто замын хөдөлгөөнийг бүрэн хаах 3. Аймгийн төв рүү орох, гарах бүх гарц замуудыг 2020.03.16-ны 07:00 цаг хүртэл тус тус хаах	<a href="https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/560533977897717">https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/560533977897717</a>
9	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосон тухай	2020.03.11	A/204	2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/204 дүгээр захирамжийн дагуу тусгай зөвшөөрөлтэй хүнсний дэлгүүр, зоогийн газруудад согтууруулах ундаа худалдах, үйлчлэх ажиллагааг 03-р сарын 11-ний өдрөөс 03-р сарын 16-ны өдөр хүртэл түр зогсоолоо.	<a href="https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/561594087791706">https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/561594087791706</a>
10	“Маскаа зүүцгээе, гараа угаая” 2-р аяныг зохион байгуулах аймгийн засаг даргын албан даалгавар	2020.11.06	05	“Маскаа зүүцгээе, гараа угаая” 2 дугаар аяныг 12-р сарын 31-нийг хүртэл үргэлжлүүлэх.	<a href="https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/pcb.726977321253381/726975321253581/">https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/pcb.726977321253381/726975321253581/</a>
11	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай	2020.11.11	A/588	Аймгийн хэмжээнд орох, гарах хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сар 11-ний өдрийн 06:00 цагаас 11 дүгээр сарын 13-ны өдрийн 23 цаг хүртэл зогсоох	

12	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	2020.11.12	A/596	Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүнсний дэлгүүрээсбусадбаранаызах,худалдааүйлчилгээний төв, сүм хийд, баар, зоогийн газар, ресторан, караоке зэрэг газруудын үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өглөөний 06:00 цагаас 11 дүгээр сарын 17-ны 06:00 цаг хүртэлх хугацаанд зогсоох. Дээрх хугацаанд архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулах үйл ажиллагааг хориглох	<a href="https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/">https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/</a>
13	Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай албан даалгавар	2020.11.13	06	0-12 настай хүүхэдтэй эцэг эх, ахмад настан, асаргаа сувилгаа шаардлагатай иргэнийг асарч буй албан хаагчид чөлөө олгох, цахим хэлбэрээр ажиллуулах зайлшгүй шаардлагатай тохиолдолд ажлын цагийг богиносгох	<a href="https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/pb.732516347366145/732516280699485/">https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/pb.732516347366145/732516280699485/</a>
14	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	2020.11.16	A/594	Аймгаас сумд руу гарах хөдөлгөөнийг 2020.11.16-ны өдрийн 16:00 цагаас сумдаас аймаг руу орох хөдөлгөөнийг 2020.11.17-ны өдрийн 00:00 цагаас 2020.12.01-ны өдөр хүртэл хаах	
15	Хэвийн, богиносгосон, зайнаас ажиллах байгууллагын жагсаалт батлах тухай	2020.11.18	A/603	Хэвийн, богиносгосон, зайнаас ажиллах байгууллагуудын жагсаалт	<a href="https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/pb.736802896937490/736802656937514/">https://www.facebook.com/Sukhbaatar.gov.mn/photos/pb.736802896937490/736802656937514/</a>
Хэнтий					
1	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай	2020.01.28	A/33	Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах Олон нийтийг хамруулах төрөл бүрийн арга хэмжээг харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд түр хугацаагаар хязгаарлахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгов. - Үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа газруудад урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулж, мэргэжлийн заавар	<a href="http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.01.28-A33.pdf">http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.01.28-A33.pdf</a>

				<p>зөвлөмж өгч ажиллахыг Аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар болон сумдын Засаг дарга нарт үүрэг болгов.</p> <p>- Иргэдэд үнэн зөв мэдээллийг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэж ажиллахыг холбогдох байгууллагын удирдлагууд, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгов.</p>	<p><a href="https://www.facebook.com/profile.php?id=100035577361957">https://www.facebook.com/profile.php?id=100035577361957</a></p>
2	Аймгийн Онцгой комисс	2020.01.27		<p>1.Олон нийтийн төрөл бүрийн арга хэмжээг түр хугацаагаар хязгаарлах /хурал цуглаан, үзвэр үйлчилгээ, тэмцээн уралдаан, сургалт гэх мэт/</p> <p>2.Үйлчилгээний олон нийтийн газруудад урдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, мэргэжлийн заавар зөвлөмж өгөх</p> <p>3.Иргэдэд үнэн зөв мэдээлэл өгч, урдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахыг мэргэжлийн байгууллагуудад үүрэг болголоо.</p> <p>4.Өвчлөлийн байдалд хяналт тавьж, бэлэн байдлыг хангах</p> <p>5.Шаардлагатай бодис, хамгаалах хэрэгслийг татан, нөөц бүрдүүлэх, худалдаанд гаргах чиг үүргийг холбогдох байгууллагуудад өгч,</p> <p>6.РС тоглоомын газрыг түр хугацаагаар хаах шийдвэр гаргалаа.</p> <p>Хятад улсад гараад буй коронавирусын талаар иргэд буруу ташаа мэдээлэлд авталгүй, мэргэжлийн болон хэвлэл мэдээллийн байгууллагаас үнэн зөв мэдээлэл авахыг анхааруулсан байна.</p>	<p><a href="http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.02.14-%D0%9071.pdf">http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.02.14-%D0%9071.pdf</a></p> <p><a href="http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.02.15-A78.pdf">http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.02.15-A78.pdf</a></p>
3	Шуурхай штаб байгуулах тухай	2020.02.14	A/71		
4	Урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай	2020.02.15	A/78		

5	Коронавирусын гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай	2020.02.21	A/105	Аймгийн хэмжээнд шинэ коронавирусын халдварын эрсдэлийг үнэлэх, даван туулах чадавхыг үнэлэх ажлын хэсэг байгуулах тухай	<a href="http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/20.02.21-A105.pdf">http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/20.02.21-A105.pdf</a>
6	Зорчигч тээврийн хөдөлгөөнийг хаах, зарим хязгаарлалтын арга хэмжээ авах тухай	2020.03.03	A/108	Зорчигч, тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнийг 2020.03.03 өдрийн 06 цагаас нээж хөдөлгөөнийг аюулгүй байдал хангах талаар	<a href="http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/20.03.03-A108.pdf">http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/20.03.03-A108.pdf</a>
7	Зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээх, зарим хязгаарлалтын арга хэмжээ авах тухай	2020.03.10	A/123	Зорчигч, тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнийг 2020.03.10-ны өдрөөс 2020.03.16-ныг хүртэл хааж хөдөлгөөнийг бүрэн зогсоох	<a href="http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.03.10-A123.pdf">http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.03.10-A123.pdf</a>
8	Шинэ Коронавирусын болзошгүй эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай	2020.03.13	A/136	Өргөн хэрэглээний барааны үнийн хөөрөгдөл үүсэхээс сэргийлж хүнс барааны нөөцийг бүрдүүлэх, Аймгийн нэгдсэн эмнэлэгт аппарат, тоног төхөөрөмж авахад шаардлагатай хөрөнгө шийдвэрлэх тухай	<a href="http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.03.13-A136.pdf">http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.03.13-A136.pdf</a>
9	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай	2020.03.17	A/146	Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор жирэмсэн болон 0-12 настай хүүхэдтэй эмэгтэй ажилтан, албан хаагчийг гэрээсээ ажиллах, цалинтай чөлөө олгох боломжоор төрийн байгууллага, ААН-ын удирдлагуудад даалгасан.	<a href="http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.03.17-A146.pdf">http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.03.17-A146.pdf</a>
10	Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай	2020.03.31	A/186	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020.04.30-ны өдөр хүртэл сунгах	<a href="http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.03.31-A186.pdf">http://khentii.mn/wp-content/uploads/2020/04/2020.03.31-A186.pdf</a>
11	КОВИД-19 вирусын халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хүмүүнлэгийн хариу арга хэмжээ аврах ажлын хэсэг байгуулах тухай	2020.04.21	A/215	Дэлхийн зөн Монголын Олон улсын байгууллагын “КОВИД-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх төслийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай	<a href="http://khentii.mn/wp-content/uploads/2020/09/20200421A215.pdf">http://khentii.mn/wp-content/uploads/2020/09/20200421A215.pdf</a>
12	Халдваргүйжүүлэлт хийх түр журам батлах тухай	2020.05.29	A/266	Коронавирусын халдварын үед орон нутгийн шалган нэвтрүүлэх цэгээр нэвтрэх тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийх түр журам баталсан.	<a href="http://khentii.mn/wp-content/uploads/2020/09/20200529A266.pdf">http://khentii.mn/wp-content/uploads/2020/09/20200529A266.pdf</a>



13	Аймгийн Онцгой комисс	2020.06.22	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд сунгалаа. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан зөвлөмж, шаардлагыг хангасан хүүхдийн тоглоомын газар, баар/диско болон бүжгийн баарнаас бусад/, шашин, соёл урлаг, үйлчилгээний байгууллагуудыг хэвийн ажиллуулахаар боллоо. Иргэн, хуулийн этгээдээс зохион байгуулах олон нийтийг хамарсан арга хэмжээ болон РС тоглоомын газар, диско болон бүжгийн баарны үйл ажиллагааг явуулахгүй байхаар шийдвэрлэлээ.	<a href="https://www.facebook.com/profile.php?id=100035577361957">https://www.facebook.com/profile.php?id=100035577361957</a>
14	Аймгийн комиссын шийдвэр	2020.11.11	1.Сургууль, цэцэрлэг, олон нийтийн үйл ажиллагааг өнөөдрөөс эхэлж 3 хоногийн хугацаанд зогсоох /Худалдааны төвийн үйл ажиллагаа хэвийн явагдана/ 2.Архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг 3 хоног хориглох 3.Улаанбаатар хотоос ирэх хөдөлгөөнийг хязгаарлах /Улаанбаатар хотруу явах болон сум хоорондын хөдөлгөөнийг хязгаарлахгүй/ 4.Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтнуудыг маск зүүх, масктай иргэдэд үйлчлэх. /Биелүүлээгүй тохиолдолд хатуу хариуцлага тооцно/ 5.Бараа бүтээгдэхүүний үнийг зохиомлоор хөөрөгдүүлсэн ААН-д хуулийн хариуцлага хүлээлгэх гэсэн шийдвэрүүд гарсан байна. Мөн мэргэжлийн байгууллагууд хамтран 11 сарын 8-аас өнөөдрийг хүртэлх хугацаанд Улаанбаатар хотоос Хэнтий аймаг руу ирсэн зорчигчдын судалгааг гаргахаар боллоо.	<a href="https://www.facebook.com/profile.php?id=100035577361957">https://www.facebook.com/profile.php?id=100035577361957</a>
15	Урьдчилан арга эрчимжүүлэх тухай	2020.11.11	Улаанбаатар хотруу орох хөдөлгөөнийг хязгаарлахгүй, ирэх хөдөлгөөнийг хязгаарлах Сургууль, цэцэрлэг, олон нийтийн үйл ажиллагааг зогсох 2020.11.11-2020.11.13-ны хооронд 3 хоногийн хугацаанд зогсоох зэрэг	<a href="https://www.facebook.com/profile.php?id=100035577361957">https://www.facebook.com/profile.php?id=100035577361957</a>

16	Аймгийн Онцгой комисс	2020.11.11	<p>1. 11 сарын 8-аас өнөөдрийг хүртэл Хэнтий аймагт ирсэн зорчигчдын судалгааг гаргах</p> <p>2. Улаанбаатар хот руу орох хөдөлгөөнийг хязгаарлахгүй, ирэх хөдөлгөөнийг хязгаарлах:</p> <p>3. Сургууль, цэцэрлэг, олон нийтийн үйл ажиллагааг өнөөдрөөс эхэлж 3 хоногийн хугацаанд хязгаарлах</p> <p>4. Архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг хориглох</p> <p>5. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтнуудыг маск зүүх, масктай иргэдэд үйлчлэх. Хэрэв биелүүлээгүй тохиолдолд хатуу хариуцлага тооцох</p> <p>6. Бараа бүтээгдэхүүний үнийг зохиомлоор хөөрөгдүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох</p> <p>7. Худалдааны төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах.</p>	<p><a href="https://www.facebook.com/profile.php?id=100035577361957">https://www.facebook.com/profile.php?id=100035577361957</a></p>
17	Аймгийн Онцгой комиссын 33-р хуралдааны шийдвэр болон Аймгийн засаг даргын Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан аврах арга хэмжээний тухай захирамж	2020.11.12	<p>Аймгийн хэмжээнд 2020.11.17-ны 06.00 цаг хүртэл “бүх нийтийн бэлэн байдал”-д шилжлээ. НЭГ. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа зохицуулах талаар</p> <p>Төрийн 24 байгууллагыг зайнаас ажиллуулах: Зөвхөн шаардлагатай ажилтнууд ажиллах 9 байгууллага</p> <p>Өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах байгууллагууд ХОЁР: Хөдөлгөөнийг хязгаарлах тухай:</p> <p>1.Аймаг, сум, тосгон, багаас орж гарах бүх хөдөлгөөнийг хязгаарлаж, зөвхөн буяны ажил, хүнс, шатахууны тээвэрлэлт, шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хөдөлгөөнийг нэвтрүүлнэ.</p> <p>2.Иргэд хүнс, эм тариа худалдан авах, эрүүл мэндийн үйлчилгээ авахаас бусад тохиолдолд гэрээсээ гарахгүй байх. Энэ хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар, Онцгой байдлын газарт даалгалаа.</p>	<p><a href="http://kheniti.mn/%d0%b0%a0%b9%a0%bc%a0%b3%a0%b8%a0%b9%a0%bd-%d1%85%a0%8d%a0%bc%a0%b6%a0%8a%a0%8d%a0%bd%a0%b4-2020-11-17-%d0%bd%a0%8b-06-00-%d1%86%a0%b0%a0%b3-%a0%85%a0%af%a0%80%a0%82%a0%8d%a0%bb-%a0%b1%a0%a2%a0%af%a0%85/">http://kheniti.mn/%d0%b0%a0%b9%a0%bc%a0%b3%a0%b8%a0%b9%a0%bd-%d1%85%a0%8d%a0%bc%a0%b6%a0%8a%a0%8d%a0%bd%a0%b4-2020-11-17-%d0%bd%a0%8b-06-00-%d1%86%a0%b0%a0%b3-%a0%85%a0%af%a0%80%a0%82%a0%8d%a0%bb-%a0%b1%a0%a2%a0%af%a0%85/</a></p> <p><a href="https://www.facebook.com/photo?fbid=2773679882958625&amp;set=pcb.2773695846290362">https://www.facebook.com/photo?fbid=2773679882958625&amp;set=pcb.2773695846290362</a></p>

	<p>3.Аймгийн хэмжээнд Эмийн сан, Хүнсний дэлгүүр /09-17 цагийн хооронд ажиллах, архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг хориглох/, Ундны ус түгээх цэг /худаг/, ШТС-аас бусад бүх аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дээрх хугацаанд бүрэн зогсоох</p> <p>ГУРАВ: Цахимаар ажиллах боломжийг бүрдүүлэх</p>		
	<p>1.Гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэргийн хугацааг Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12-р дугаар сарын нэгний өдрийн 06:00 цаг хүртэл сунгалаа.</p> <p>2.Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн ам олноор цугларах газрууд болох барааны зах, худалдааны төв, сүм хийд, бар, зоогийн газар, ресторан, караокены үйл ажиллагааг 11 дүгээр сарын 17-ны 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний 06:00 хүртэлх хугацаанд зогсоож, архи, согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг мөн хугацаагаар хориглов.</p> <p>3.Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Баян-Овоо, Баянхутаг, Галшар, Бор-Өндөр, Дархан, Баянмөнх сумдын аймаг, сум, баг, хот хоорондох тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тодорхойгүй хугацаагаар хязгаарлаж, мөн сумдын хүнсний дэлгүүрийг 09:00-19:00 цаг, эмийн сан, шатахуун түгээх станц, усан санг ердийн цагийн хуваариар ажиллуулах, Чингис хотын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон Эвт худалдааны төвийн түлээ нүүрсний худалдаанаас бусад худалдааг тодорхойгүй хугацаагаар хязгаарлав.</p> <p>4.Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгуллагууд, хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг ажлын тусгай горимд шилжүүлээ.</p>	<p>A/521</p> <p>2020.11.16</p>	<p>18 Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авах арга хэмжээний тухай</p>

<a href="https://www.facebook.com/photo?fbid=2778922815700221&amp;set=pcb.2778923539033482">https://www.facebook.com/photo?fbid=2778922815700221&amp;set=pcb.2778923539033482</a>	<p>5.Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын 0-12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдэд /ганц бие эцэг/ байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр гэрээсээ ажиллах боломжийг бүрдүүлж, цалин хөлсийг ажилласанд тооцож олгохыг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагад үүрэг болголоо.</p> <p>6.Төрийн байгууллагын ажиллах цагийн хуваарийг 09:00-12:00, 14:00-16:00 хүнсний дэлгүүр, хүнсний захын ажиллах цагийн хуваарийг 09:00-19:00 цагаар тогтоож, шатахуун түгээх станц, эмийн сан, усан санг ердийн цагийн хуваарийн дагуу халдвар хамгаалалтын дэглэмийг чанд мөрдүүлж ажиллуулсугай.</p> <p>7.Үзвэр, үйлчилгээний газрууд болон олон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тогтоосон хугацаагаар хязгаарласугай.</p> <p>8.Бүх нийтийн бэлэн байдлын үед бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомстол үүсгэхгүй байхыг аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч, хүнсний худалдаа эрхлэгч нарт үүрэг болтосугай.</p> <p>9.Хүнсний хэрэгцээт бараа худалдан авах, эмийн болон эмнэлгийн үйлчилгээ авахаас бусад тохиолдолд гэрээсээ гарахгүй байхыг нийт иргэдэд анхааруулсугай.</p> <p>10.Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан аймаг, сумдын шуурхай штаб, шалган нэвтрүүлэх цэгийн томилгоог 2020 оны 11 дүгээр сарын 17-ны 16:00 цагийн дотор хийж баталгаажуулахыг Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгалаа.</p>
---	--

## КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ТАРХАЛТ, ЭМНЭЛ ЗҮЙН ПРАКТИК: ГАДААД, ДОТООД НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТОЙМ

(2020 оны 11-р сарын 23-ны байдлаар)

Д.Амаржаргал (Ph.D), Ц.Ариунаа,  
Б.Туул


### КОВИД-19 ЦАР ТАХЛЫН МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

#### Цар тахлын дэгдэлт, өвчлөл, эдгэрэлт, нас баралт болон цагийн байдал

2020 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар Монгол Улсад 608 тохиолдол, 337 эдгэрэл бүртгэгдсэн байна. Эмнэлгээс эдгэрч гарсан 337 хүнээс 28 нь дараагийн шатны тусгаарлах байранд, 7 хүн орон нутаг руу нутаг буцсан, бусад нь гэрийн ажиглалтад байна.

Үүнээс зөөвөрлөгдсөн тохиолдол 377,<sup>96</sup> дотоодын халдвар 172 байгаа нь 2020 оны 11 сарын 22-ны байдлаар дэлхийд шинэ тохиолдлын тоогоор дээрээсээ 111-д жагсаж Куба ба Рванда улсуудын дунд орсон байна.<sup>97</sup>

(Зураг 1.<sup>98</sup> Монгол дахь өдөр тутмын шинэ тохиолдол 1 сая хүн тутамд )



Тархалтын байдлыг авч үзвэл, 2020.11.22-ны өдрийн 11.00 цагийн байдлаар нийслэл болон 5 аймагт кластер байдлаар вирус тархсан байна. Сэлэнгэ аймагт дайралтын түвшин (attack rate) 7 хувь, Улаанбаатарт дайралтын түвшин 4,9 хувь байна. 2020.11.21-нд 1305 хүнд шинжилгээ хийснээс Улаанбаатарт шинээр

<sup>96</sup> <https://covid19.mohs.mn/p/cat/post/57/>

<sup>97</sup> <https://www.worldometers.info/coronavirus/>

<sup>98</sup> <https://ourworldindata.org/coronavirus-data-explorer?zoomToSelection=true&time=earliest..latest&country=~MNG&region=World&casesMetric=true&interval=daily&perCapita=true&smoothing=0&pickerMetric=location&pickerSort=asc>

2 нийт 40, Сэлэнгэд шинээр 19 нийт 77, Дарханд шинээр 4 нийт 20 тохиолдол бүртгэгджээ. Сайн дураараа оношлуулах цэгээр нийт 41.810 хүн шинжилгээ өгсөн байна. Үүнээс хоёрдогч хавьтлын 7.500 хүн байгааг илрүүлсэн.

### ***Цар тахлын хариу арга хэмжээний үндсэн чиглэл***

КОВИД-19 цар тахлын үед Монгол Улсын Засгийн газар, УОК, Эрүүл мэндийн яамнаас дараах үндсэн гурван чиглэлд анхаарал хандуулан ажиллаж байна. Үүнд:

1. Тархалтыг хумих буюу барьж авч зогсоох,
2. Тандалт, хариу арга хэмжээ,
3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүчин чадал, чадавхыг нэмэгдүүлэх тал дээр төлөвлөгөөний дагуу хариу арга хэмжээ авч шуурхай ажиллаж байна.

### ***Цар тахлын оношилгоо, эмчилгээ***

#### **Манайд тохиолдож буй эмнэл зүйн онцлог**

Эмнэл зүйн шинж тэмдгийн хувьд, ханиах, толгой өвдөх, нусгайрах, амт үнэр мэдэхгүй болох тул энгийн ханиадтай андуурахгүй байхыг Эрүүл мэндийн яамнаас санууллаа. Манай улсад халдварын нууц үе нь 5,2 хоног байна. Одоогийн байдлаар кластер халдвар болох гэр бүлийн 43 хүн илрүүлснээс бусдад тараасан байх эрсдэлтэй 23 хүн байна.

#### **Эмнэлгээс гарсны дараах хяналт**

Эдгэрч гарч буй өвчтөнүүд эмнэлгээс гарахдаа 5 төрлийн шинжилгээ өгдөг ба вирус илрэхгүй болсон тохиолдолд эмнэлгээс гаргаж байна. Дараагийн шатанд 14 хоног тусгаарлах байранд байлгаж хяналт тавин, дахин вирусийн шинжилгээнд хамруулж, сөрөг гарвал гэртээ харьж байна. Эмнэлгээс эдгэрч гарсан бүх иргэд хяналтад байгаа ба хамт байдаг гэр бүл ойр дотны хүмүүсээс байнгын шинжилгээ авч, хяналтандаа байлгаж байна.<sup>99</sup>

#### **Оношлуурын хүртээмж**

Оношлуурын тухайд, БНСУ-д үйлвэрлэсэн 2 төрлийн баталгаат оношлуур авч хэрэглэж байгаа ба нийслэлд 18 цэгт сайн дурын шинжилгээ авах цэг ажиллаж байна.<sup>100</sup> Монгол Улс дотооддоо оношлуур үйлдвэрлэж хэрэгцээгээ бүрэн хангах боломжтой хэдий ч одоогоор энэ асуудал шийдвэрлэгдээгүй байна. Тухайлбал, ХБНГУ-ын Мюнхений Техникийн их сургуулийн Эрдэм шинжилгээний багийн ахлагчаар ажиллаж буй доктор Д.Нямбаярын боловсруулсан оношлуурыг Монголд хийх зардал ердөө 1,000 төгрөг хүрэхээргүй байгаа ба гаднаас импортоор авч буй оношлуураас 7 дахин хямд зардлаар үйлдвэрлэх боломжтой гэсэн тооцоо гарсан.<sup>101</sup> Тэрбээр коронавирусийн оношлуурыг дотооддоо үйлдвэрлэж, хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын тушаалаар байгуулсан ажлын хэсэгт багтаж ажилласан эрдэмтдийн нэг юм.

Цар тахлын үед Монгол эрдэмтдийн бүтээсэн оношлуурыг хурдан шуурхай, хүрэлцэхүйц хэмжээгээр үйлдвэрлэх нь тархалтыг хянах, хорио цээрийг

<sup>99</sup> <https://www.mohs.mn/news/4786>

<sup>100</sup> 2020.11.22 11.00 цагийн ЭМЯ мэдээлэл

<sup>101</sup> [https://ikon.mn/opinion/21gy?fbclid=IwAR01b1rWfTGA0KVMi55n1gyOlInSPh4bGdrg-gxNqcg8M\\_5oVDCxNP4gBW0](https://ikon.mn/opinion/21gy?fbclid=IwAR01b1rWfTGA0KVMi55n1gyOlInSPh4bGdrg-gxNqcg8M_5oVDCxNP4gBW0)



чангатгах болон сулруулах (шинэ тохиолдлын тоо 14 хоногийн турш буурч, нийт тестийн 5%-с дооших нь эерэг гарсан тохиолдолд сулруулах) зэрэг нэн чухал ач холбогдолтой байгаа тул энэ тал дээр боловсон хүчин, лабораторийн баазыг бүрдүүлэн Монгол эрдэмтдийн гарган авсан оношлуурын олон улсын баталгаат байдлыг шалгуулж, цаг алдалгүй хэрэглээнд нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна.

### Монгол Улсаас дэлхийн бусад орнууд, олон улсын байгууллагуудаас эмнэлзүйн чиглэлээр авч буй тусламж дэмжлэг

Shape Mongolia ТББ-аас Монгол Улсад цар тахалтай тэмцэхэд зориулан олон улсын байгууллагуудаас олгосон зээл тусламжийг дараах байдлаар нэгтгэн гаргажээ. (Зураг 2) . Монгол Улс нийтдээ 1,9 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний тусламж дэмжлэгийг гадаадаас авсан бай ба үүнээс эрүүл мэндийн салбарт зориулсан тусламж 861,884,800,000 төгрөг болсон байна.

Зураг 2. МУ-ын цар тахалтай холбогдуулж авсан зээл тусламж

МУ-ын КОВИД-д зориулж олон улсын байгууллагаас авсан зарим зээл тусламж				
Албан Байгууллага	Date	Amount	Tugruk	Purpose/M
АНУ	3/24/20	\$ 1,200,000	3,360,000,000	
АХБ	3/1/20	\$ 1,000,000	2,800,000,000	Эмнэлгийн багаж төхөөрөмж *
Дэлхийн Банк	3/25/20	\$ 2,200,000	6,160,000,000	Эмнэлгийн багаж төхөөрөмж *
Дэлхийн Банк	4/2/20	\$ 26,900,000	75,320,000,000	Эмнэлгийн багаж төхөөрөмж *
Дэлхийн Банк	4/24/20	\$ 41,000,000	114,800,000,000	УБ- халууны шугам шүлжээ
Дэлхийн Банк	4/24/20	\$ 12,000,000	33,600,000,000	330 сумын хөгжил
Европийн Холбоо	5/29/20	\$ 43,000,000	145,598,000,000	Залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажлын байр бий болгоход зориулсан
Европийн Холбоо	5/29/20	\$ 16,000,000	54,176,000,000	Эдийн засгийн хөгжилтөнд
АХБ	5/12/20	\$ 100,000,000	280,000,000,000	Эдийн засаг/эрүүл мэнд *
Хятад Улс	5/16/20	\$ 13,000,000	36,400,000,000	Эрүүл мэнд *
АХБ	5/30/20	\$ 30,000,000	84,000,000,000	яаралтай агуулах барих, дунд шатны эмнэлгүүдэд ариутгалын тасгийг шинэчлэх *
Япон Улс	6/12/20	\$ 9,316,000	26,084,800,000	Эдийн засаг/эрүүл мэнд *
Дэлхийн Банк	6/3/20	\$ 99,000,000	277,200,000,000	Эдийн засаг/эрүүл мэнд *
Дэлхийн Банк	6/19/20	\$ 20,000,000	56,000,000,000	Ажлын байр бий болгох
АХБ	6/23/20	\$ 26,400,000	73,920,000,000	Эмзэг бүлэг болон эмэгтэйчүүдийн эдийн засаг/эрүүл мэнд *
НҮБ	7/25/20	\$ 1,000,000	2,800,000,000	
АХБ	9/3/20	\$ 1,500,000	4,200,000,000	
Япон Улс	10/10/20	\$ 230,000,000	644,000,000,000	
		\$ 673,516,000	1,920,418,800,000	

(\* Эрүүл мэндийн чиглэлээр авсан зээл тусламж)

2020 оны 11 дүгээр сарын 16-нд Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч Сергей Диордица нар ХӨСҮТ болон Цэргийн төв эмнэлэгт ДЭМБ-аас хандивлаж буй 96 мянган ам.долларын үнэ бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног, төхөөрөмжийг гардуулан өгсөн.

Одоогийн байдлаар цэргийн төв эмнэлэгт 440 ор, ХӨСҮТ-д 400 ор, Яармагийн шинэ төрөх эмнэлэгт 500 орыг бэлтгэсэн. Шаардлагатай тохиолдолд эдгээрийн 10 хувийг эрчимт эмчилгээний зориулалтаар ашиглана. ДЭМБ-аас эмч, ажилчдын хамгаалах хувцас, амьсгалын аппарат, монитор зэрэг шаардлагатай

тоног төхөөрөмжүүдийг хүлээн авч, эмнэлгүүдэд хүлээлгэн өгөв.<sup>102</sup> Мөн манай улсад 167 ширхэг амьсгалын аппарат бэлэн байгаа ба Дэлхийн банкнаас МУЗГ-ын хүсэлтийн дагуу нэмж 50 амьсгалын аппаратыг хүлээлгэн өгсөн. Одоогоор манай улсад амьсгалын аппаратанд орсон хүндрэлтэй өвчтөн байхгүй байгаа тухай 2020 оны 11 дүгээр сарын 22-ны 17.00 цагийн ЭМЯ ны мэдээлэлд дурдав.

**Эрүүл мэндийн яам, холбогдох мэргэжлийн байгууллагуудаас цар тахлын эмнэлзүйн практикт дагаж мөрдөхөөр гаргасан заавар, зөвлөмжүүд**

2020.11.22-ны ЭМЯ-ны мэдээллээр, Монгол Улс ДЭМБ-ын гишүүн орны хувьд тус байгууллагаас гаргасан удирдамжийн дагуу коронавирусийн эмчилгээ хийж байгаа тухай мэдээлсэн. Эмчилгээг дараах 3 үе шатаар хийж байна. Үүнд:

1. Вирусийн эсрэг эмчилгээ
2. Дархлаа дэмжих эмчилгээ ( энэ нь 2 төрөлтэй ба энгийн дархлаа дэмжих аргад спортоор хичээллэх, бүрэн унтаж амрах, эрүүл хооллох зэрэг аргууд ордог бол өвөрмөц аргад вакцинжуулалтыг хамааруулж ойлгоно. Манай улс одоогоор дэлхийн нийт хүн амын 20 хувийг вакцинжуулах КОВАКС хөтөлбөрт элсэн ороод байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжинд эрсдэлтэй бүлэг болох эмч, эмнэлгийн ажилчид, цагдаа, гааль, онцгой байдлын алба хаагчид ба өндөр настан, архаг хууч өвчтэй хүмүүсийг хамруулах ба дараагийн ээлжинд нийт иргэдийн 60 хувийг хамруулахаар Засгийн газраас төлөвлөсөн)
3. Хүндрэлийн эсрэг эмчилгээ

Иргэдэд коронавирусийг ямар эмээр эмчлэх тухай зарлахгүй байгаа нь иргэд гэрээр өөрийгөө эмчлэх ородлого хийж олон хүнд халдвар тараахаас сэргийлж байгаа хэмээн ЭМЯ-ны мэдээлэлд дурьдав.

**КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн орчин**

Монгол Улсын Их Хурлаас КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 оны 4 сарын 29-нд баталсан.<sup>103</sup>

Хуулийн зорилго нь коронавирусийн халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдсэн.

Уг хуульд зааснаар Монгол Улсын Их Хурал цар тахлын онцгой нөхцөлд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд :

- a. Цар тахлын үед шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг дараалал харгалзахгүйгээр хэлэлцэн шийдвэрлэх;
- b. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу шуурхай хянан хэлэлцэх;

<sup>102</sup> <https://www.mohs.mn/news/4783>

<sup>103</sup> <https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312>

- с. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд тогтмол хяналт тавих.

**Эрүүл мэндийн яамнаас батлан гаргасан халдварт цар тахлын үед дагаж мөрдөх тушаал, албан даалгавар, заавар, зөвлөмжүүд (ЭМЯ-ны цахим хуудаснаас авав):<sup>104</sup>**

1. Коронавируст халдварын үеийн эмнэлзүйн түр заавар (2020.02.12-ны эрүүл мэндийн салбарын эрдэмтэд болон ДЭМБ-аас хамтран гаргасан “Шинэ коронавируст (КОВИД-2019) халдварын тандалт, оношилгоо эмчилгээний түр заавар”-ын хүрээнд боловсруулсан)
2. Шинэ коронавирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын хангах тухай албан даалгавар (ЭМС-ын 2020.01.22-ны 19 дүгээр албан даалгавар)
3. Коронавируст халдварын үед эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зураглал батлах тухай (ЭМС-ын 2020.02.18-ны 101 дүгээр тушаал)
4. Тархвар зүйн багийн бүрэлдэхүүн ажиллах чиглэл батлах тухай (ЭМС-ын 2020.02.03 А-55 дугаар тушаал)
5. Коронавирусийн халдварын сэжигтэй болон хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн хүнийг гэрээр хянах эмчлэх тухай түр заавар (ЭМС-ын 2020.04.17-ны А-247 дугаар захирамжийн хавсралт)
6. Монгол Улсын хилээр орж ирж байгаа зорчигчдыг тусгаарлах хяналтад авах зөвлөмж (2020.03.04 ХӨСҮТ-ийн ерөнхий захирал Д.Нямхүү)
7. Коронавирусийн халдварын үеийн эмнэлзүйн түр заавар шинэчлэн батлах тухай (2020.08.21-ны ЭМС-ын А-406 дугаар захирамжийн хавсралт)
8. Шуурхай хариу арга хэмжээний баг байгуулах тухай (2020.03.13-ны ЭМС-ын А-175 дугаар тушаал)
9. Шуурхай мэдээлэл, тохиолдлын удирдлагын тогтолцооны талаар авах зарим арга хэмжээний талаар (2017.12.13-ны ЭМС-ын А-508 дугаар тушаал)
10. Коронавируст халдвартай хүнд хэлбэрийн уушгины хатгааны үеийн амьсгалын замын эмчилгээ, сувилгаа, ажилбар хийх халдварын сэргийлэлт, хяналтын зөвлөмж (2020.02.23-ны ЭМЯ, ХӨСҮТ хамтарсан зөвлөмж)
11. Эмнэлзүйн зөвлөх багийн ажиллах журам, чиглэл батлах тухай (2020.01.24-ны А-32 дугаар ЭМС-ын тушаал)
12. Коронавируст халдвараас сэргийлэх бэлэн байдлыг хангах ажлын хэсэг байгуулах тухай (2020.01.25-ны А-41 дүгээр ЭМС-ын тушаал)
13. Шинэ коронавирусийн халдварын үед яаралтай бэлэн байдлыг хангах хариуцлагатай жижүүр томилон ажиллуулах тухай (2020.01.29-ны А-50 дугаар ЭМС-ын тушаал)
14. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай (2020.01.13-ны А-93 дугаар ЭМС-ын тушаал)
15. Түр заавар батлах тухай (2020.02.21-ний А-135 дугаар ЭМС-ын тушаал)

<sup>104</sup> <https://www.mohs.mn/news/4577>

16. Эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах тухай (2020.02.28-ны А-145, 57, 37 дугаар ЭМС, ХЗДХС, БХС нарын хамтарсан тушаал)
17. Голомтод халдваргүйжүүлэлт хийх түр заавар (2020.03.28 А-188 дугаар ЭМС-ын тушаал)
18. Эмнэлзүйн заавар шинэчлэн батлах тухай (2020.03.30-ны А-205 дугаар ЭМС-ын тушаал)
19. Коронавируст халдварын үед жирэмсэн эмэгтэй, хүүхдэд эмнэлгийн тусламж үзүүлэх үйлчилгээг зохицуулах түр журам батлах тухай (ЭМС-ын 2020.04.06 ны А-222 дугаар тушаал)
20. Түр заавар батлах тухай (2020.04.17 А-247 дугаар ЭМС-ын тушаал)
21. Эрүүл мэндийн байгууллагын анхан шатны бэлэн байдал хангах тухай түр заавар журам батлах тухай (2020.04.18-ны А-248 дугаар ЭМС-ын тушаал)
22. Үйлчилгээний зарим байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдварын сэргийлэлтийн журам (2020.04.17-ны А-249 дүгээр ЭМС-ын тушаал)
23. Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам шинэчлэн батлах тухай (2018.12.11-ны А-517 дугаар ЭМС-ын тушаал)

## КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### ***Цар тахлын дэгдэлт, өвчлөл, эдгэрэлт, нас баралт болон цагийн байдал***

Цар тахлын дэгдэлтийн 2 дахь давалгаанд эрчимтэй өртөж байгаа эхний 5 орны байдлыг авч үзвэл:

**АНУ**-д 2020.11.21-ны байдлаар коронавирусийн халдвар нийт 11 сая давсан ба тус улсад ганцхан долоо хоногт 1 сая шинэ тохиолдол бүртгэгдсэн.

**Их Британи**-д 2020.11.20-ны байдлаар цар тахалтай холбоотой нас баралт 598-аар нэмэгджээ. Энэ нь 5 дугаар сарын 12-ноос хойших өдрийн хамгийн өндөр өсөлт болсон байна. Их Британид нийт өвчлөлийн тоо 1,410,732-д хүрсэн байна.

**Испани Улсад** Ковидын нас баралт 435-аар нэмэгдсэн нь тус улсын хоёр дахь коронавирусийн давалгаанд гарсан хамгийн өндөр нас баралтын үзүүлэлт боллоо. Нийт халдварын тоо 1.5 сая давж, 1.510.023 тохиолдол бүртгэгдээд байна.


**Итали Улс** 2020.11.20-ны байдлаар сүүлийн 24 цагийн дотор шинээр 32191 халдвар бүртгэгдэв. Өмнөх өдрийн нас баралт 504-ээс 731 болж өссөн байна. Улс даяар бүрэн хөл хорио тогтоосон (2020.04.03)-оос хойш хамгийн өндөр өсөлт болов.

**Иран Улс** 2020.11.20-ны байдлаар сүүлийн 24 цагийн дотор шинэ коронавирусийн халдвар 13352-д хүрснийг Засгийн газар зарлав. Нас барсан хүний тоо 482-аар нэмэгдэж нийт нас баралт 42.461-д хүрч, Ойрхи Дорнодын хамгийн өндөр үзүүлэлт болов.

Нийт халдварын тоогоор тэргүүлж буй орнууд<sup>105</sup>:

1. АНУ
2. Энэтхэг
3. Бразил
4. Франц
5. ОХУ


**Зураг 3. Нийт халдварын тоогоор тэргүүлж буй орнуудын давалгаа<sup>106</sup>**



Нийт нас баралтаар тэргүүлж буй орнууд:

1. АНУ
2. Бразил
3. Энэтхэг
4. Мексик
5. Англи


**Зураг 4. Нийт нас баралтаар тэргүүлж буй орнуудын нас баралт сая хүн тутамд**



Нэг өдрийн шинэ тохиолдлын тоогоор тэргүүлж буй орнууд:

1. Америк
2. Энэтхэг
3. Итали
4. ОХУ
5. Англи

**Зураг 5. Шинэ тохиолдлоор тэргүүлж буй орнуудад нэг өдрийн шинэ тохиолдлын тоо сая хүн тутамд<sup>107</sup>**



<sup>105</sup> <https://www.worldometers.info/coronavirus/>

<sup>106</sup> <https://ourworldindata.org/coronavirus-data-explorer?zoomToSelection=true&time=earliest..latest&country=USA~RUS~FRA~MNG~BRA~IND&region=World&casesMetric=true&interval=daily&perCapita=true&smoothing=0&pickerMetric=location&pickerSort=asc>


<sup>107</sup> <https://ourworldindata.org/coronavirus-data-explorer?zoomToSelection=true&time=earliest..latest&country=MNG~BEL~MEX~PAK~KAZ~KGZ&region=World&casesMetric=true&interval=daily&perCapita=true&smoothing=0&pickerMetric=location&pickerSort=asc>



2020.11.20-нд Монгол Улс шинээр илэрсэн тохиолдлын тоогоор дээрээсээ 116 дугаарт жагсаж байсан бол 11 сарын 22-д 111-т орж байна.<sup>108</sup>

### Цар тахлын оношилгоо

Nature ба JAMA сэтгүүлд хэвлэгдсэн судалгаанаас харахад, КОВИД-19 халдвар авсан хүн шинж тэмдэг эхлэхээс өмнө дараагийн хүнд халдварлуулах чадвартай болдог ба бусдад халдварлуулах оргил үе нь шинж тэмдэг эхлэхийн өмнөх үе байдаг.<sup>109</sup> Өөрөөр хэлбэл шинж тэмдэг эхлэхээс 2 өдрийн өмнө халдварлуулах чадвар хамгийн өндөр байх ба шинж тэмдэг эхэлснээс 7-10 өдрийн дараа бусдад халдаах чадвар үгүй болно.<sup>110</sup> Тиймээс ойрын хавьтагчийг илрүүлэхдээ шинж тэмдэг эхлэхээс 2 өдрийн өмнөх хугацааг харгалзах шаардлагатай.



### Австри Улс

Австри Улсад одоо хэрэгжиж буй хатуу хөл хорионы хязгаарлалттай хамт нийт хүн амыг коронавирусийн шинжилгээнд хамруулах болсон байна. Үүнд эхлээд сургууль, цэцэрлэгийн багш нарыг хамруулах юм. Энэ шинжилгээ нь сайн дурын үндсэн дээр хийгдэх ба Австрийн эрх баригчид хагас тэрбум кроны өртөгтэй долоон сая түргэн оношлуур захиалсан ба үүнээс ч илүүг худалдаж авахаар төлөвлөж байна.

Одоогийн байдлаар Австри Улс бүх нийтийн хөл хорионы хоёр дахь үе шатаа хэрэгжүүлж байна. Эхний иж бүрэн шинжилгээг 12 дугаар сарын эхний амралтын өдрүүдэд зохион байгуулах төлөвлөгөөтэй байна. Засгийн газрын төлөвлөгөөний дагуу Австрийн батлан хамгаалах салбар цэргүүдийн тусламжтайгаар ложистик, зохион байгуулалтыг хийж байна. Аврах алба болон сайн дурынхан зохион байгуулалтад оролцож байгаа бөгөөд шинжилгээг эмнэлгийн эмч мэргэжилтнүүд гардан хийнэ.

Түргэн оношлуураар 15 минутын дотор хариу гарах бөгөөд коронавирус тээгч эсэхийг тодорхойлох юм. Энэ нь PCR шинжилгээ шиг найдвартай биш боловч туршилт нь урьдчилан сэргийлэх ач холбогдолтой гэж мэргэжилтнүүд үзэж байна.

### Тохиолдол бүртгэгдээгүй орнууд

Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Кирибати Улс одоогоор ямар нэгэн халдварын тохиолдол бүртгэгдээгүй байна.<sup>111</sup>

<sup>108</sup> <https://www.worldometers.info/coronavirus/>

<sup>109</sup> He, X., Lau, E. H., Wu, P., Deng, X., Wang, J., Hao, X., ... & Mo, X. (2020). Temporal dynamics in viral shedding and transmissibility of COVID-19. *Nature medicine*, 26(5), 672-675.

<sup>110</sup> Cheng, H. Y., Jian, S. W., Liu, D. P., Ng, T. C., Huang, W. T., & Lin, H. H. (2020). Contact tracing assessment of COVID-19 transmission dynamics in Taiwan and risk at different exposure periods before and after symptom onset. *JAMA internal medicine*.

<sup>111</sup> <https://www.theguardian.com/world/live/2020/nov/17/coronavirus-live-news-vaccine-progress-encouraging-says-who-south-korea-at-critical-crossroads>



## **Цар тахлын эмчилгээний мэдээлэл**

### **ДЭМБ**

Ремдесивир (remdesivir) эмийг коронавирусийн эмчилгээнд амьсгалын замын халдварыг дарахад хамгийн үр нөлөөтэй<sup>112</sup> хэмээн хэрэглэж байсан ба 11 сарын 20-нд ДЭМБ-аас энэ эмийг коронавирусийн халдварын эмчилгээнд хэрэглэж болохгүй гэсэн зөвлөмж гаргалаа.<sup>113</sup> АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп өвдөх үед энэ эмээр эмчилж байсан бөгөөд олон улсад найдвар төрүүлээд байсан юм. Харин хамгийн сүүлд ДЭМБ-ын хийсэн 7.000 хүн оролцсон 4 эмнэл зүйн туршилт судалгааны дүнд энэ эм нь өвчтөний нас баралт, амьсгалын аппаратанд орох, эдгэрэх хугацаа зэрэгт нөлөөлдөггүй болох нь тодорхой болжээ.

### **ОХУ**

Оросын эмч нар өвчтөн эмчлэх тусгай хөтөлбөрийг ашиглаж байна. Левофлоксацин, азитромициний антибиотик ба умифеновир зэрэг вирусийн эсрэг эмнүүд үүнд багтаж байна. Албаны хүмүүс эдгээр антибиотик ба вирусийн эсрэг эмнүүд цаашид хүрэлцээ муутай болж байгаа талаар мэдэгдэв.

### **Вакцин үйлдвэрлэл, туршилт, эмнэлзүйн практик, гаж нөлөө, эрсдэл, худалдан авалтын боломжууд**

Одоогийн байдлаар олон улсын түвшинд Германы Pfizer ба АНУ-ын биотехнологийн Moderna фирмийн КОВИД-19-ийн вакцинууд 95%-аас дээш үр дүнтэй гэж мэдэгдээд байна.

### **COVAX- Гави Вакцины Холбоо<sup>114</sup>**

COVAX бол Засгийн газар, үйлдвэрлэгчидтэй хамтран КОВИД-19-ийн вакциныг дэлхийн бүх орнуудад хүртээмжтэй байлгах чиглэлээр хамтран ажилладаг цорын ганц байгууллага юм. COVAX нь өндөр хөгжилтэй, хөгжиж буй орны вакцин үйлдвэрлэгчид, НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн банк, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэн ажилладаг.

COVAX AMC (Advance Market Commitment) нь бага дунд хөгжилтэй 92 оронд КОВИД-19-ийн вакциныг хүн амынх нь 20%-д хүрэлцэхүйц хэмжээгээр олгохоор болсон ба үүнд Монгол Улс багтсан. Харин үүнээс цааших тунг тухайн орны санхүүгийн байдал, халдварын зэрэг, яаралтай нөхцөл байдлаас шалтгаалан олгоно.<sup>115</sup>

КОВИД-19-ийн вакцины тэгш хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор бага болон дунд эдийн засагтай орнуудад зориулж 2 тэрбум долларын сан босгосон боловч 2021 онд дахин 5 тэрбум долларыг нэмж босгох шаардлагатай байна. Билл ба Мелинда Гейтсийн сан нь КОВИД-19-ийн вакцины судалгаа болон боловсруулалтыг дэмжих зорилгоор Цар тахлын бэлэн байдлын инновацийн эвсэлд (Coalition for Epidemic Preparedness Innovations - CEPI) нэмэлтээр 20

<sup>112</sup> Beigel, J. H., Tomashek, K. M., Dodd, L. E., Mehta, A. K., Zingman, B. S., Kalil, A. C., ... & de Castilla, D. L. (2020). Remdesivir for the treatment of Covid-19—preliminary report. The New England journal of medicine.

<sup>113</sup> <https://www.who.int/news-room/feature-stories/detail/who-recommends-against-the-use-of-remdesivir-in-covid-19-patients>

<sup>114</sup> <https://www.gavi.org/news/media-room/over-us-2-billion-raised-support-equitable-access-covid-vaccines-additional-us-5>

<sup>115</sup> <https://www.gavi.org/news/media-room/92-low-middle-income-economies-eligible-access-covid-19-vaccines-gavi-covax-amc>

сая ам доллар хандивласан. Энэхүү чухал санхүүжилт нь аюулгүй, үр дүнтэй КОВИД-19-ийн вакцинтай болох үед бага дунд хөгжилтэй орнуудыг хоцроохгүй байх зорилготой.

2021 оны эцэс гэхэд дор хаяж таван тэрбум ам доллар шаардлагатай тул Gavi COVAX -д улс орнууд хандив өгсөөр байна. Үүнд:

- Европын Комиссын Ерөнхийлөгч бага орлоготой орнуудад вакцины хүртээмжийг дэмжих зорилгоор 100 сая евро буюу (ойролцоогоор 120 сая доллар)
- Франц улс 100 сая евро буюу 120 сая доллар
- Испани 50 сая евро буюу 60 сая доллар
- Билл & Мелинда Гэйтсийн сан нь Гавигийн санд 50 сая доллар, COVAX AMC санд 106 сая доллар нийт 156 сая доллар, вакцины судалгаанд зориулж CEPI-д 20 сая ам доллар
- БНСУ 10 сая долларыг тус тус хандивлахаар болжээ.

### Европын Холбоо

Pfizer-BioNTech ба CureVac-ийн боловсруулж буй КОВИД-19-ийн вакцинаас 425 сая тунг 10 тэрбум гаруй доллараар худалдаж авахаар боллоо. Pfizer-BioNTech вакцин нь 95%-ийн үр дүнтэй<sup>116</sup> гэж үзсэн ба нэг тунд \$18.34 төлөхөөр болжээ.<sup>117</sup> Харин CureVac вакцин нь эмнэл зүйн туршилт судалгааны төгсгөлийн үедээ хараахан орж амжаагүй ба 2 дахь шатанд 90%-ийн үр дүнтэй<sup>118</sup> гэж үзсэн байна. Европын холбоо энэ вакцины нэг тунг \$11.84-ээр худалдан авахаар болжээ.<sup>119</sup> Туршилт судалгаагаар эдгээр вакциныг хийлгэсний дараа хэсэг газрын өвдөлт, халуурах тохиолдол илэрсэн ба 48 цагийн дотор гаж нөлөө арилсан байна.

### Испани Улс

Испанийн хүн амын 70 хувь нь 2021 оны эхний хагаст вакцинд хамрагдана гэж тус улсын Ерөнхий сайд Педро Санчес мэдэгдсэн ба ямар хүмүүс түрүүлж вакцин хийлгэхийг тогтоох тусгай хороог байгуулсан байна.

### Украин Улс

Украин ирэх оны эхний хагаст 8 сая тун вакцин авахаар төлөвлөж байна. 12 дугаар сарын 7-н гэхэд холбогдох техникийн баримт бичигт гарын үсэг зурахаар төлөвлөөд байна. Эхний ээлжинд 1.2 сая тун байх бөгөөд хамгийн эрсдэлтэй бүлэгт голчлон хэрэглэнэ гэжээ. Украин Улс вакцины бүх үйлдвэрлэгчид, ханган нийлүүлэгчидтэй яриа хэлэлцээр хийж, төсвийн хөрөнгийг худалдан авалтад зориулж хуваарилсан гэдгээ хэлэв.

### ОХУ

ОХУ-ын анхны вакцин Спутник V гэж нэрлэсэн вакцины туршилт 92% үр дүнтэй тухай мэдэгджээ. 11 дүгээр сард ойролцоогоор 500,000 тун үйлдвэрлэх болно

<sup>116</sup> <https://www.pfizer.com/news/press-release/press-release-detail/pfizer-and-biontech-include-phase-3-study-covid-19-vaccine>

<sup>117</sup> <https://www.irishtimes.com/business/health-pharma/eu-could-pay-more-than-10bn-for-covid-19-vaccines-1.4414493>

<sup>118</sup> <https://www.fiercebiotech.com/biotech/curevac-climbs-vaccine-data-despite-tolerability-questions>

<sup>119</sup> <https://www.irishtimes.com/business/health-pharma/eu-could-pay-more-than-10bn-for-covid-19-vaccines>

гэжээ. Сибирийн Вектор институтын бүтээсэн хоёр дахь вакцин болох EpiVac Corona-ийн бүртгэлийн дараах туршилтууд үргэлжилж байна.

### **Бельги Улс**

Бельги коронавирусийн эсрэг вакциныг хүн амын 70 орчим хувь буюу 8 сая орчим хүнд үнэ төлбөргүй хүргэхээр төлөвлөж байна. 11.5 сая хүн амтай Бельги улсад ойролцоогоор 540.000 коронавирусийн тохиолдол бүртгэгдэж, 14.000 гаруй хүн нас баржээ.

### **БУСАД ОРНУУДЫН ЭМНЭЛЗҮЙН САЙН ТУРШЛАГУУД**

**Австрали Улс** Холбооны Засгийн газраас эрт авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн нэг нь австраличуудыг эрүүл мэндийн теле үзлэгт хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ байв. Ингэснээр өвчтөнүүд эмнэлгийн мэргэжилтнүүдтэй дүрс бичлэгээр болон утсаар холбогдож зөвлөгөө авах боломж бүрджээ. Австраличууд теле үзлэгийг маш таатай хүлээн авсан бөгөөд уг шийдвэр хэрэгжиж эхэлсэн эхний таван долоо хоногт гурван сая өвчтөн 4.3 сая гаруй үйлчилгээг авчээ. 1000 гаруй ерөнхий эмч нарын дунд явуулсан судалгаагаар 99 хувь нь теле үзлэгийн үйлчилгээг санал болгож байгааг тогтоожээ.

**British Airways компаний туршилт**<sup>120</sup> British Airways компани Америкийн гурван нисэх буудлаас Их Британи руу зорчиж буй зорчигчдод коронавирусийн сайн дурын шинжилгээг хийх гэж байна. British Airways агаарын тээврийн компани American Airlines-тэй хамтран АНУ-аас Хитроу хүртэл тодорхой чиглэлд шинжилгээг туршиж үзэх болно гэж мэдэгджээ.

Зорчигчдыг нисэхээс 72 цагийн өмнө, дараа нь Лондонгийн нисэх онгоцны буудал дээр ирээд гурван өдрийн дараа шинжилгээнд хамруулна. Туршилтын үр дүнг Их Британи, АНУ-ын Засгийн газруудтай хуваалцах ба British Airways компани зорчигчдыг турших нь хорио цээрийг сулруулахад дөхөм болно гэж найдаж байгаагаа илэрхийлэв.

### **ЦАР ТАХЛЫН ЭМНЭЛЗҮЙН ПРАКТИКТ ДАГАЖ МӨРДӨХ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДААС ГАРГАСАН ЗААВАР ЗӨВЛӨМЖ, УДИРДАМЖ**

#### **Эмийн эмчилгээ ба КОВИД-19 ДЭМБ-ын удирдамж**

Энэ удирдамж нь КОВИД-19-ийн эсрэг эмийн эмчилгээний талаарх эмнэл зүйн туршилт- судалгааны нэгдсэн тойм бөгөөд 2020.11.20-д шинэчлэгдэн хэвлэгдсэн.<sup>121</sup> Удирдамжид олон улсад коронавирусийн эмчилгээг судлахад зориулан хийгдэж буй нийт 2.800 гаруй эмнэл зүйн туршилт судалгаа бүртгэгдсэн ба олон улсын тавцан дахь томоохон платформууд болох RECOVERY, WHO SOLIDARITY, DISCOVERY судалгаанууд ч багтсан.

Эдгээр туршилтууд нь одоогоор ремдесэвир, кортикостероидууд, гидроксхлорокин, лопинавир-ритонавир, бусад эдгэрсэн хүний цусны сийвэн, дархлаа зохицуулах эмчилгээний үр дүнг гаргасан судалгааг нэгтгэн мета-анализ хийж дүгнэлт өгөхийг зорьсон.

<sup>120</sup><https://www.theguardian.com/world/live/2020/nov/17/coronavirus-live-news-vaccine-progress-encouraging-says-who-south-korea-at-critical-crossroads>

<sup>121</sup> <https://www.who.int/publications/i/item/therapeutics-and-covid-19-living-guideline>

## **ДЭМБ ба Олон улсын эмийн зохицуулах байгууллагуудын эвслээс (International Coalition of Medicines Regulatory Authorities, ICMRA) хамтран гаргасан мэдэгдэл**

ICMRA ба ДЭМБ нь КОВИД-19-ийн өвчтөнүүдийг аюулгүй, үр дүнтэй эмээр хангахын тулд шинжлэх ухааны хатуу стандарт бүхий эмчилгээ, вакцины үнэлгээг хийж аюулгүй байдлын хяналтыг тогтмол явуулахад хамтран ажиллана. Энэхүү<sup>122</sup> хамтарсан мэдэгдэлдээ КОВИД-19-ийг эмчлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор аюулгүй, үр дүнтэй, чанарын баталгаатай эмийг тэгш хүртээмжтэй байлгах чиглэлээр тодорхой арга хэмжээ авахаа амласан байна.

Олон улсад КОВИД-19-ийн олон төрлийн вакцин, эмчилгээг хөгжүүлж байгаа бөгөөд түргэн шуурхай худалдаанд гаргах шаардлагатайг харгалзан ДЭМБ болон ICMRA нь нэгдэж, бүх улс орнуудын зохицуулалтын үйл явцыг уялдуулахыг дэмжих замаар хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр үүрэг болгов. Үүнд:

- Найдвартай үр дүн бүхий сайн хийгдсэн эмнэлзүйн туршилтуудыг эрэмбэлэх;
- Эмнэлзүйн туршилт судалгаагаар амьдралд буухуйц шинжлэх ухааны үндэслэлтэй үр дүн гарсан эсэх, цуглуулсан өгөгдөл нь аюулгүй, хангалттай хугацаанд явагдсан эсэхийг баталгаажуулах;
- Олон орны зөвшөөрлийг хөнгөвчлөх зорилгоор тухай бүрд нь зохицуулагч байгууллагуудын дунд мэдээллийг хуваалцах;
- ICMRA-ийн гишүүд ба ДЭМБ-ын гишүүн орнуудын эмийн зохицуулах зарчмуудын дагуу үйл явц, бодлогыг хэрэгжүүлэх, онцгой байдалд тохирсон түргэн шуурхай хариу үзүүлэх;
- Зохицуулалтын шийдвэр гаргахад нь туслахын тулд эмнэл зүйн туршилтын үр дүнг бүрэн ил тод байлгах, эрх баригчдад итгэх олон нийтийн итгэл, вакцинд итгэх итгэлийг баталгаажуулах;
- Зайлшгүй шаардлагатай эм, вакцины хомсдолоос урьдчилан сэргийлэх, тийм хомсдолыг багасгахад хамтран ажиллах;
- КОВИД-19 эмчилгээ, вакциныг зөвшөөрсөн тохиолдолд тэдгээрийн хэрэглээг хянах, аюулгүй байдал, үр дүнтэй холбоотой асуудлуудыг шийдэхэд үргэлжлүүлэн хамтран ажиллах;
- Өвчтөний амь насанд аюул учруулж болзошгүй нотлогдоогүй эмчилгээ, хуурамч нэхэмжлэлтэй холбоотой эрсдлийг бууруулах.

## **КОВИД-19 цар тахалтай тэмцэх үеийн хувийн мэдээлэл ба нууцыг хамгаалах НҮБ-ын тогтоол**

Мэдээллийг цуглуулах, хуваалцах, боловсруулах нь коронавирусын тархалтыг хязгаарлаж, цахим хэлбэрээр хавьтагчийг илрүүлэх нь нийгэм хэвийн байдалдаа хурдан буцаж орж болохыг олон улсын жишээ харуулж байна. Жишээлбэл, хүмүүс гар утас, имэйл, банк, олон нийтийн сүлжээ, шуудангийн үйлчилгээг ашиглах үеийн хөдөлгөөнт байдлын өгөгдлийг цуглуулж вирусийн тархалтыг хянахад тусалж, НҮБ-ын заавар зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дөхөм болж байна.<sup>123</sup>

<sup>122</sup><https://www.who.int/news/item/06-11-2020-who-icmra-joint-statement-on-the-need-for-improved-global-regulatory-alignment-on-covid-19-medicines-and-vaccines>

<sup>123</sup>[https://www.who.int/publications/i/item/WHO-2019-nCoV-Ethics\\_Contact\\_tracing\\_apps-2020.1](https://www.who.int/publications/i/item/WHO-2019-nCoV-Ethics_Contact_tracing_apps-2020.1)

Гэсэн ч эдгээр өгөгдөл нь хувь хүний мэдээллийг ихээр агуулж буй тул КОВИД-19 цар тахалтай тэмцэх үеийн хувийн мэдээлэл ба нууцыг хамгаалах тогтоолыг 2020.11.09-д баталсан байна. Үүнд дараах агуулгууд багтана.

- КОВИД-19 цар тахлын эсрэг авч буй арга хэмжээнүүд хууль ёсонд нийцэх ёстой ба тодорхой цаг хугацаа, хамрах хүрээ тодорхой байх;
- Дээрх зорилгын дагуу цуглуулсан мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж, заасан хугацаанд хадгалах, өгөгдлийг зохих ёсоор устгах ажлыг баталгаажуулах;
- Аливаа өгөгдөл хуваалцахдаа мэдээлэл хамгаалах, нууцлалын зарчмуудыг дагаж мөрдөх ёстой ба эрсдэлийн үнэлгээнд суурилан мэдээллийг ашиглах;
- Аливаа өгөгдлийг зөвхөн зориулалтын дагуу ашиглах ба цар тахлын эсрэг авах арга хэмжээнд ашиглах шаардлагагүй болмогц цуглуулахаа зогсоох;
- Өнөөгийн болон ирээдүйн үйл ажиллагаанд олон нийтийн итгэлийг хадгалахын тулд өгөгдлийг хэрхэн ашиглах явцаа ил тод байлгах.<sup>124</sup>



<sup>124</sup> <https://www.who.int/news/item/19-11-2020-joint-statement-on-data-protection-and-privacy-in-the-covid-19-response>

**КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМИЙГ СУЛРУУЛСНААС  
ҮҮДЭН ГАРСАН СУРГАМЖ: АЗИ НОМХОН ДАЛАЙН БОЛОН ЕВРОПЫН  
БҮСИЙН ОРНУУДЫН ТУРШЛАГАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

(Аналитик тойм, орчуулга)

*О.Билгүүтэй, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа,  
Г.Уянга, О.Нарантуяа, С.Золжаргал,  
Б.Батцэцэг*

**АГУУЛГА**

УДИРТГАЛ

ТАНИЛЦУУЛГА

ЕРӨНХИЙ ХАНДЛАГА

ХАЛДВАР ТАРХАЛТЫН БАЙДАЛ

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАДАВХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН СИСТЕМИЙН ЧАДАВХ

ХИЛИЙН ХЯНАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

ДҮГНЭЛТ

ХЯТАД УЛС КОВИД-19 ЦАР ТАХЛЫГ ХЭРХЭН АМЖИЛТТАЙ ХЯНАЛТАНДАА  
ОРУУЛСАН БЭ?

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН



# Судлаачид:

Saw Swee Hock School of Public Health, National University of Singapore, Singapore (E Han MSc, MMJ Tan MSc, AR Cook PhD, LYHsu MBBS, YY Teo PhD, H Legido-Quigley PhD);

Department of Nursing and Health Sciences, University of South East Norway, Drammen, Norway (E Turk PhD);

Medical Faculty, University of Maribor, Maribor, Slovenia (E Turk);

College of Medicine and Veterinary Medicine, University of Edinburgh, Edinburgh, UK (D Sridhar PhD);

LKS Faculty of Medicine, The University of Hong Kong, Hong Kong Special Administrative Region, China (G M Leung MD);

Institute for Population Health, King's College London, London, UK (K Shibuya DrPH);

Asia Pacific Observatory on Health Systems and Policies, World Health Organization Regional Office for South-East Asia, New Delhi, India (N Asgari MD);

College of Medicine, Seoul National University, Seoul, South Korea (J Oh PhD);


ISGlobal, Hospital Clinic, Universitat de Barcelona, Barcelona, Spain (AL Garcia-Basteiro PhD);

Centro de Investiga3ro em Sa3de de Manhi3a, Maputo, Mozambique (A L Garcia-Basteiro);

Department of Global Health and Development (J Hanefeld PhD, H Legido-Quigley), Department of Infectious Disease Epidemiology (D Heymann DTM&H), and Department of Health Services Research and Policy (M McKee DSc),

London School of Hygiene & Tropical Medicine, London, UK; Centre for International Health Protection, Robert Koch Institute, Berlin, Germany (J Hanefeld); and The Helen Clark Foundation, Auckland, New Zealand (H Clark MA)

Correspondence to: Dr Helena Legido-Quigley, Saw Swee Hock School of Public Health, National University of Singapore, Singapore 117549 ephhlq@nus.edu.sg



## Удиртгал

УИХ-ын Тамгын газрын Парламентын судалгааны хүрээлэнгээс олон улсад нэр хүнд бүхий “Эрүүл мэндийн бодлого” эрдэм шинжилгээний сэтгүүлийн 2020 оны 11-р сарын 7-ны өдрийн 396-р дугаарт нийтлэгдсэн “КОВИД-19 цар тахлын хорио цээрийн дэглэмийг сулруулсанаас үүдэн гарсан сургамж: Ази Номхон Далай, Европын бүсийн орнуудын туршлагад хийсэн дүн шинжилгээ” сэдэвт судалгааны өгүүллийг орчуулаад байна. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэл нь Сингапур, Норвеги, Словени, Англи, Хонгконг, Солонгос, Испани, Мозанбек, Герман, Шинэ Зеланд улсын нэр хүнд бүхий их дээд сургууль, судалгааны хүрээлэнгийн 17 эрдэмтний хамтарсан бүтээл юм. Судалгаанд цар тахал өргөн хүрээнд, хурдацтай тархсан 9 оронд хорио цээрийн дэглэмийг тогтоох болон сулруулах арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлсэн талаар судлаж, үр дүнг нь харьцуулан, зөвлөмж гаргасан байна.

Өнөөдөр (2020.11.23) Монгол улсад мөрдөгдөж байгаа бүх нийтийн бэлэн байдал, хөл хорионы дэглэмийг сулруулахын тулд бусад орнуудын туршлага, сургамжийг судлах, цаашид авах авах арга хэмжээг төлөвлөхдөө анхааран үзэх шаардлага байгааг харгалзан энэхүү судалгааны мэдээллийг орчуулан шийдвэр гаргагчдад хүргүүлж байна.

## Судалгааны агуулга

КОВИД-19 цар тахал нь урьд өмнө тохиолдож байгаагүй дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямралыг үүсгээд байна. Олон улс орнууд амьсгалын замын цочмог халдварт коронавирусийн тархалтыг удаашруулах, эрүүл мэндийн системийг хэт ачааллахаас сэргийлэх зорилгоор хүн амын хөдөлгөөнд хязгаарлалт тогтоон, зарим улс орнууд бүхэлдээ болон хэсэгчлэн хөл хорио тогтоосон. Гэсэн хэдий ч КОВИД-19 цар тахлыг эмчлэх үр дүнтэй арга, урьдчилан сэргийлэх вакцин гарах байх гэсэн хүлээлттэйгээр хэрэгжүүлж байгаа хөл хорио болон бусад хатуу чанга арга хэмжээнүүдийг удаан хугацаанд үргэлжлүүлэх боломжгүй болоод байна. Улс орнуудын Засгийн газрууд одоо хөл хорио, хязгаарлалтаа сулруулахын зэрэгцээ эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үүсээд байгаа олон асуудлуудаа шийдвэрлэх шаардлагатай тулгараад байна. Улс орнуудад харилцан биенээсээ суралцахад туслах зорилгоор энэхүү Эрүүл мэндийн бодлогын судалгаа нь КОВИД-19 цар тахлын хязгаарлалтыг сулруулж эхлээд байгаа өндөр хөгжилтэй 9 орон болон бүс нутгуудад хэрэгжүүлж буй арга хэмжээг судлах зорилготой болно.

Эдгээр 9 улсын 5 нь Ази Номхон Далайн бүс (Хонконг (Засаг захиргааны онцгой бүс), Япон, Шинэ Зеланд, Сингапур, Өмнөд Солонгос), 4 нь Европын улсууд (Герман, Норвеги, Испани, ИБУИНВУ) байна. Энэхүү харьцуулсан шинжилгээ судалгаа нь эдгээр орнууд, бүс нутгуудын туулсан жишээ, сургамжаас суралцах боломжийг олгохыг зорьж байгаа юм. Ирээдүйд вирус яах нь тодорхойгүй байгаа тул улс орнууд хуримтлуулсан туршлагаа хуваалцах, эрсдэлтэй байгаа ард иргэдээ сэргийлэх, ард иргэдийнхээ амь насыг хамгаалахын тулд халдварын тархалтыг таслан зогсоох шаардлагатай байна.

## Танилцуулга

КОВИД-19 цар тахал нь урьд өмнө тохиолдож байгаагүй дэлхий нийтийг хамарсан аюул юм. 2020 оны есдүгээр сарын дунд хүртэл дэлхий даяар 22 сая гаруй батлагдсан тохиолдол бүртгэгдэж, үүнээс 930000 хүн нас барсан байна.<sup>125</sup>

<sup>125</sup> www.thelancet.com Vol 396 November 7, 2020

186 улс амьсгалын замын цочмог халдварт коронавирусийн тархалтыг удаашруулах, эрүүл мэндийн системийг хэт ачааллахаас сэргийлэх зорилгоор хүн амын хөдөлгөөнд янз бүрийн төвшинд хязгаарлалт тогтоосон бөгөөд үүнээс 82 улс нь хөл хорио тогтоосон. Хэдийгээр авч хэрэгжүүлж байгаа эдгээр арга хэмжээнүүд нь ард иргэдийн амь насыг тодорхой хэмжээгээр хамгаалсан байх талтай ч нийгэм, эдийн засагт хүнд цохилт үзүүлсэн.

Дэлхийн Банкнаас хийсэн урьдчилсан дүгнэлтээр Дэлхийн II дайнаас хойш сая сая хүнийг ажилгүйдэл, ядууралд оруулж буй хамгийн ноцтой хямрал үүсээд байна гэсэн байна. Хөл хорио болон бусад хатуу арга хэмжээнүүд нь КОВИД-19 цар тахлыг эмчлэх үр дүнтэй эмчилгээ болон урьдчилан сэргийлэх вакцин гартал удаан хугацаагаар үргэлжлэх боломжгүй болоод байна. Үнэндээ энэ хязгаарлалт нь улс орнуудад өвчний тохиолдлуудыг багасгах, халдвар тархахаас сэргийлэхээс гадна халдварыг хянах үр дүнтэй, тогтвортой арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацааг гарган өгч байгаа юм.

Улс орныхоо эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт тулгараад буй асуудлуудыг хэрхэн зүй зохистойгоор шийдвэрлэн, хэзээ, хэрхэн яаж өвчний эсрэг хэрэгжүүлж байгаа арга хэмжээгээ сулруулах нь дэлхийн улс орнуудын засгийн газруудын өмнө тулгараад буй хүндхэн сорил болоод байна. Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаас, яаран хөл хориог цуцлах нь халдварын тархалтыг эрс нэмэгдүүлэх төдийгүй, эдийн засагт хөл хорионд байсан үеэс илүү хүнд, урт хугацааны турш үргэлжлэх хохирол үзүүлэх болно гэж сэрэмжлүүлж байна. Раваф болон бусад судлаачид улс орон бүр хөл хорио болон өвчний эсрэг авч буй арга хэмжээгээ сулруулахдаа баримталвал зохих нийгмийн эрүүл мэндийн дөрвөн зарчмыг тодорхойлсон байна. Үүнд:

- Халдвар тархалтын байдал;
- Олон нийт хүлээн зөвшөөрөх байдал;
- Нийгмийн эрүүл мэндийн чадавх;
- Эрүүл мэндийн тогтолцооны хүчин чадал зэрэг багтана.

Эдгээр зарчмуудыг баримтлах болон цаашид бий болгож ажиллахын тулд бид нэмэлт болон дэд хэсгүүдээс бүрдсэн бодлогын бүтцийг боловсруулаад байна.

Энэхүү судалгаа нь КОВИД-19 цар тахлын эсрэг хатуу хариу арга хэмжээ авсан 9 өндөр хөгжилтэй оронд хөл хорио, хязгаарлалтаа сулруулах талаар хэрхэн ажиллаж байгааг харьцуулан судалсан болно. Эдгээр улс орнуудыг цар тахлын тархалтын эсрэг хэрэгжүүлж буй ариутгал халдваргүйжүүлэлтийн олон төрлийн ажлууд, хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ зэргээс нь шалтгаалан судалгаанд сонгосон. Таван улсыг Ази Номхон Далайн бүсээс (Хонконг (Засаг захиргааны онцгой бүс), Япон, Шинэ Зеланд, Сингапур болон Өмнөд Солонгос) дөрвөн улсыг Европоос (Герман, Норвег, Испани болон ИБУИНБУ) сонгон авсан болно. Ази Номхон Далайн бүсээс сонгосон зарим орнууд нь Цочмог халдварт амьсгалын замын хам шинж (SARS) болон Ойрхи Дорнодын амьсгалын замын халдварт хам шинж (MERS) өвчнийг даван гарсан туршлагатай юм. Харин Европ тивээс сонгосон орнуудад КОВИД-19 цар тахлын эхний давалгаанд хүндээр өртсөн (Испани болон ИБУИНБУ) болон арай хөнгөн туссан (Герман, Норвеги) улсуудыг сонгон авлаа. Эдгээр улс орнуудын цар тахлын үеэр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн мэдээлэл дээр үндэслээд хорио цээрийг сулруулахад баримтлах нэгдсэн, тодорхой, тууштай бодлого байхгүй байгааг анзаарсан.

**Хэлэлцүүлгийн сэдэв: КОВИД-19 цар тахлын хөл хорио, хязгаарлалтаас хэрхэн гарах тухай улс орнуудад хэрэгжүүлж буй бодлогын харьцуулалт**

Халдвар тархалтын талаарх мэдлэг мэдээлэл

- Ариутгал, халдваргүйтлийг хянах үзүүлэлтүүд

Олон нийтийн оролцоо

- Аюулгүй байдлаа хангах үүднээс амны хаалт зүүх болон зай барих
- Сургууль болон ажлын байран дээр урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх арга хэмжээ авах
- Олон нийтийн итгэлийг хүлээж, хамтын ажиллагааг бэхжүүлэх харилцаа холбоог сайжруулах
- Эрсдэлт бүлгийн ард иргэдийг хамгаалах
- Нийгэм, эдийн засгийн тусламж дэмжлэг үзүүлэх

Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах боломж бололцоо

- Оношлох, өвчтэй иргэдийг хайж илрүүлэх болон тусгаарлах
- Эмч, мэргэжилтнүүдийн үүрэг

Эрүүл мэндийн тогтолцооны боломж бололцоо

- Эмчилгээ үйлчилгээ
- Эмнэлгийн тоног төхөөрөмж
- Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчин

Хилийн хяналт, хил дээр хэрэгжүүлж буй арга хэмжээ

- Гадаадаас ирэх аялагчдыг хязгаарлах

Бид КОВИД-19 цар тахлын эсрэг олон нийтийн хөл хорио болон хязгаарлалтыг сулруулахад зайлшгүй шаардагдах 5 хүчин зүйлсийг энэхүү судалгаагаар тогтоолоо: халдвар тархалтын талаарх мэдлэг мэдээлэл, олон нийтийн оролцоо, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чадавх, эрүүл мэндийн тогтолцооны чадавх болон хилийн хяналт, хамгаалалт, хорио цээр зэрэг болно. Бидний сонгон авсан 9 улс нь тус бүрдээ эдгээр асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж, ямар арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласаныг энд тодорхойлох болно. Эдгээр улсуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг даган дуурайх нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал нь ялгаатай улс орнуудын хувьд боломжгүй буюу ач холбогдолгүй байж болох юм. Тиймээс улс орнууд өөрийн улсын дотоод нөхцөл байдал, нөөц бололцоонд тулгуурлан, тохиромжтой бодлогын хувилбарыг сонгон эсхүл өөр бусад улс орнуудын шинээр боловсруулсан шийдлүүдийг туршин үзэх боломжтой юм.

## Ерөнхий хандлага

Улс орон бүрт хөл хориог үргэлжлүүлэх болон сулруулах хугацаа нь үндэсний хариу арга хэмжээнээс хамаараад харилцан адилгүй байна. Улс орнууд халдварын тархалт, нийгэм эдийн засагт үзүүлэх үр дагаврыг судлан үзэж хөл хориог сулруулах арга хэмжээ авч байна. Ямар ч үед Засгийн газрын зорилго тодорхой, гаргах шийдвэр ил тод байж, авах арга хэмжээ нь ерөнхий




Figure 1: Timeline for imposing and easing of restrictions

стратегийн нэг хэсэг нь болох учиртай. Япон зэрэг хэд хэдэн улсад халдварын нөхцөл байдал, эмнэлгийн үйлчилгээний болон тандалт судалгааны тогтолцоонд анхаарах хүчин зүйлсийн үзүүлэлтийг хянах мэдээллийн самбарыг (dashboards of indicators) бүтээсэн байна. Испани улс эпидемиологийн хөдөлгөөнт байдал нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг багтаасан шалгуур үзүүлэлтийн мэдээллийн хянах самбар гаргасан боловч шийдвэр гаргах явцад тодорхой үр нөлөө үзүүлэхгүй байна. Шийдвэр гаргахад хоёр үндсэн арга зам байна. Сингапур, Норвеги, Испани, Их Британид улс төрчид нь эрдэмтэн шинжээчдийн зөвлөгөөг үндэслэн хэзээ, ямар хөл хориог сулруулахыг олон нийтийн шалгуургүйгээр шийдвэрлэж байна. Сингапурын Засгийн газрын хувьд бага эрсдэлээс өндөр эрсдэлтэй үйл ажиллагаанд шилжих 3 үе шаттайгаар хөл хориог цуцлахдаа зөвшөөрөгдөх үйл ажиллагааг урьдчилан тодорхойлсон байна. Гэсэн хэдий ч тухайн эрсдэлийг үнэлэх үндэс нь урьдчилан таамаглах тодорхойлох нөхцөл бололцоо байхгүй бөгөөд халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд үзүүлэх нөлөөний (aerosol-related transmission) талаарх ойлголт хомс байна. Их Британийн дөрвөн үндэстэн (Англи, Уэльс, Умард Ирланд, Шотланд) тус бүр 3 сарын дунд үе хүртэл өөрсдийн хэмжээнд авсан арга хэмжээгээ сулруулж, тусгай хөл хорионоос гарах стратеги хэрэгжүүлсэн. Япон, Герман, Өмнөд Солонгос, зарим тохиолдолд Их Британи эпидемиологийн тархалтын байдлыг үндэслэн хөл хориог цуцалж, эсвэл шинэчилж байна. Жишээлбэл: Германы Засгийн газар “Орон нутгийн эх баригчид нь тухайн бүс нутагт 7 хоног дараалан 100,000 оршин суугч тутамд 50-иас дээш шинэ тохиолдол бүртгэгдвэл хөл хорио тогтоох эрхтэй ба хөл хориог сулруулах, шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ” гэсэн захирамж гаргасан байна. Энэ захирамж нь махны үйлдвэрт гарсан халдвараас үүдэлтэй халдвар тархсан цөөн хэдэн дүүрэгт хэрэгжсэн байна. Хонконгт өвчний тархалт эхэлснээс хойш үүнтэй төстэй хөл хориог чангатгах, сулруулах стратеги боловсруулж тархалтын нөхцөл байдлыг харгалзан хөл хориог чангаруулж сулруулж байна. Гэхдээ энэ арга нь өвчний тархалт хэсэг газар эсвэл цөөн хэдэн хүмүүс дунд байсан ч бүхэл бүтэн бүс нутгийн хувьд дахин хөл хорио тогтоох эрсдэлийг дагуулж байна. Шинэ Зеландын 4 түвшний анхааруулгын системээс тандан судалгааны ач холбогдол тодорхой харагдана. 2020 оны 3 сарын сүүлчээр улсын хэмжээнд зарласан 4-р түвшний хөл хорионоос 2020 оны 6-р сарын эхэн үед 1-р түвшин буюу хамгийн бага түвшинд шилжсэн боловч одоо Шинэ Зеланд улсын хэмжээнд 2-р түвшин, харин Оклендын хувьд 3-р түвшний хөл хорионд эргэн орох нөхцөл байдал үүсжээ. Түүнчлэн Өмнөд Солонгос, Их Британи улсууд үе шатлалт анхааруулгын системтэй боловч (alert-level systems) үр дүнтэй ашиглагдаж байгаа нь эргэлзээтэй байна.

### ***Халдвар тархалтын байдал***

Өндөр чанарын хянан шалгах системийг бий болгож, халдвар дарагдаж байгаа гэдгийг баталгаажуултал улс орнууд тайвширч болохгүй юм. Харамсалтай нь зарим улсууд энэ зарчмыг хэрэгсэхгүй байсаар байна. Энэхүү зарчим нь нэг хүнээс халдвар авсан хүмүүсийн дундаж тооноос (reproduction number R) хамаарч өвчин хаана үргэлжлэн тархаж байгааг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Хонконг, Япон, Герман, Норвеги, Испани, Их Британийн эрх баригчид хөл хориог сулруулахын тулд R-ийн тооцоо нь нэгээс бага байвал аюулгүй гэж мэдээлж байна. 2020 оны 2-р сараас хойш Хонконг халдвар авсан хүмүүсийн тоо (R), вирусийн тархалтын бодит түвшинг тооцоолоход хамгийн бага түвшинд байна. Улс болон бүс нутаг бүр харилцан адилгүй илрүүлэх, турших, мөшгөх, тусгаарлах, эмчлэх ажлыг системтэйгээр хэрэгжүүлж байна. Өмнөд Солонгос,



Хонконг зэрэг Азийн зарим бүс нутагт цар тахлын эхэн үед сайн ажилласан тогтолцоотой байсан бөгөөд Герман зэрэг улсууд нөөцөө дахин хуваарилан ажиллаж чадсан бол Их Британи, Испани зэрэг улс хүндрэлтэй нүүр тулж байна.

### **Олон нийтийн оролцоо**

Нийгмийн үйл ажиллагааг эргээд хэвийн байдалд оруулахад иргэд олон нийт өөрсдөө идэвхтэй оролцож, халдвараас өөрсдийгөө сайн хамгаалах шаардлагатай. Эрх баригчид ч бодит нөхцөл байдал дээр тэдний гаргасан шийдвэр хэрхэн хүмүүст хүрч байгааг сайн ойлгож тэдний гаргаж буй зөвлөмж, мэдээлэл нь үнэн зөв байхад анхаарах хэрэгтэй. Хүн хоорондын аюулгүй зайг барьж, эрсдэлтэй нөхцөлд зарим байгууламжуудыг нээхгүй байх арга хэмжээг дэлхий даяар авч байна. Хүн хоорондын аюулгүй зайг Норвеги, Сингапур, Хонконг-д 1 метр, Герман Испани-д 1.5 метр, Япон, Солонгос Англид 2 метр гэж тус тус тогтоосон байна. Шинэ Зеландад олон нийтийн газарт 2 метр, сургууль, ажлын байранд 1 метр зайтай байхыг зөвлөж байна. Шинэ Зеландад зарим хүмүүсийг өөр хоорондоо ойр байхыг хамгийн анх зөвшөөрсөн ба үүнийг social bubble Model хэмээдэг байна. Хөл хорионы үед ойр байх шаардлагатай хэсэг бүлэг хүмүүс (гэр бүл ойр дотны найз нөхөд)-г хамт байхыг зөвшөөрсөн энэ санааг Англид 2020 оны 6 сараас мөн авч хэрэгжүүлжээ. Улс орнууд нүүрний хаалт буюу маск зүүх тал дээр ялгаатай хандаж байна. Хонконг, Япон, Өмнөд Солонгос улсуудад амьсгалын замын өвчтэй хүмүүс цар тахал гарахаас өмнө ч улирлын чанартай вирус эсвэл агаарын бохирдлоос хамгаалах зорилгоор маск зүүдэг байсан. Харин бусад улс орнуудын хувьд энэхүү туршлагыг хэрэгжүүлэхдээ удаан байлаа. Сингапурт өвчлөөгүй бол маск зүүхгүй байж болохыг зөвлөж байсан ч 2020 оны 4-р сараас эхлэн хүн бүр гадуур явахдаа заавал маск зүүхийг үүрэг болгож ард иргэдээ олон удаа хэрэглэх даавуун маскаар хангасан байна. Сүүлийн 5 сарын хугацаанд Герман, Испани улсууд нь нийтийн тээврийн хэрэгсэл, дэлгүүр зэрэг зай барих боломжгүй газруудад, Их Британид олон нийтийн газарт, Норвегит насанд хүрэгчид, залуучууд нийтийн тээврээр зорчихдоо амны хаалт зүүхийг шаардаж байна. Харин Шинэ Зеланд улс заавал амны хаалт зүүхийг зөвлөхгүй байна. Амны хаалтны хэрэглээний талаарх янз бүрийн эргэлзээтэй мэдээллүүд, эргэж буцсан шийдвэрүүд нь олон нийтийг төөрөгдүүлж, улс орнууд шууд авч хэрэгжүүлэхэд түвэгтэй байдал үүсгэсэн юм.

Судалгаанд хамрагдсан орнуудад ерөнхий боловсролын сургууль болон ажлын байранд халдвараас урьдчилан сэргийлэх төрөл бүрийн арга хэмжээг авчээ. Улсууд аль болох гэрээсээ ажиллахыг илүүд үзэж, заавал ажлын байран дээрээ ажиллах шаардлагатай бол эрүүл ахуйн дүрэм журмыг дагаж мөрдөхийг зөвлөсөн байна. Сингапур, Өмнөд Солонгос улсуудад ажлын байран дахь урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, ажилчдын эрүүл мэндийг тогтмол хянах үүрэг бүхий менежерийг томилж ажиллуулсан байна. Азийн орнуудад ажлын байр, сургууль дээр амны хаалт зүүх, халуун хэмжих ажлыг хэвшүүлээд байна. Сургуулиуд сурагчдаа үе шаттайгаар эргүүлэн хичээлд нь оруулсан бөгөөд улс орон, бүс нутгуудад ямар насныханд илүү ач холбогдол өгч байгаа нь өөр өөр байна. Сингапур, Өмнөд Солонгос, Герман зэрэг улсуудад хичээлийн тасалдлыг багасгах зорилгоор ахлах ангийн (15-18 насныхан) сургалтаа түрүүлж эхэлсэн байна. Харин Шинэ Зеланд, Норвеги, Англи улсуудад бага насны хүүхдүүд, тухайлбал бага сургуулийн (5-12 насныхан) хичээлийг эхлүүлсэн байна. Гэхдээ энэ нь хүүхдүүдийн боловсролыг илүүд үзсэн үү эсвэл эцэг эхчүүдэд ажилдаа эргэж орох боломжийг олгохыг чухалчилсан уу гэдэг нь тодорхойгүй юм.



Ази, Номхон далайн улсууд						
Улс	Ерөнхий стратеги	Халдварын төлөв	Олон нийтийн төлөв	Олон нийтийн эрүүл мэндийн чадавх	Эрүүл мэндийн системийн чадавх	Хил гаалийн хяналтын арга хэмжээ
Хонгконг	Засгийн газраас халдварыг доод түвшинд барьж эргэн сэргэх стратеги (Suppress and lift strategy)	2020 оны 2 сараас халдварын тархалтын дата тооцоолсон (Real-time R) (R- нэг хүнээс халдвар авсан дундаж тоо)	Хэдийгээр улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газартаа итгэл алдарсан ч хүн хоорондын 1 м зай барьж, маскаа зүүн, төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээг дагаж иргэд өөрсдөө хамтын хариуцлагаа сайн биелүүлсэн.	Өдөр тутамд авах PCR-н шинжилгээг 4500-с 10000 болгон нэмэгдүүлж хөл хорионд орсон иргэдийг ухаалаг бугуйвч болон гар утасны аппликейшнаар хянаж, цагдаагийн компьютерийн системийг хавьтлыг хянахад ашигласан.	2-р түвшний тусгаарлалтын байруудад ор болон эд зүйлс нэмж байрлуулсан ба эмч сувилагч эмнэлгийн ажилчдыг халдвараас сэргийлэх арга хэмжээ авсан.	Хилээр аялагч, зочдыг нэвтрэхийг хориглосон, бусад тохиолдолд хилээр нэвтрэгчийн эрүүл мэндийн байдал, биеийн халуун, шинжилгээг авч 14 хоног хөл хорионд тусгаарласан.
Япон улс	Эхний (эрсдэлт) тохиолдлыг ашиглан хянаж тархалтыг таслах (Trigger-based approach)	Шалгуур үзүүлэлт нөлөөллийн түвшин өмнөх 7 хоногт 100.000 хүн тутмын нийт халдварын тоо ≤0.5 байх (One indicator is an incidence rate of ≤0.5 cumulative infections per 100 people in the past week)	Хүн хоорондын зай 2 метр, маскаа зүүх, өөр хоорондоо ойртохгүй, биед хүрэхгүй байх, хүн цугларсан газар очихгүй байх арга хэмжээнүүдийг авсан ба иргэд сайн биелүүлсэн	Өдөр тутмын PCR-н шинжилгээг 6000- аас 22000 болгон нэмэгдүүлж уламжлалт аргаар тархалтыг хянахаас гадна 2020 оны 6 сард гар утасны аппликейшн бүтээжээ.	Эхлээд бүх өвчтнүүдийг эмнэлэгт хүлээн авч байсан ч эмнэлгийн хүрэлцээнээс болж дунд, хүнд өвчтнүүдийг авч хөнгөн өвчтнүүдийг гэрээр болон өөр боломжит байруудад эмчилгээ хийжээ.	Гаднаас ирсэн бүх хүмүүсийг 14 хоног тусгаарлаж, аяллаар ирэгсдийг бүрэн хориглож, зайлшгүй шалтгаантай хүмүүсийг шинжилгээнд хамруулан нэвтрүүлсэн.

<b>Шинэ Зеланд</b>	4 түвшний анхааруулгын систем (Four-level alert system)	Олон нийтэд тодорхой шалгуур тавиагүй	Дээр дурдсан (social bubble approach) шаардлагатай иргэдийг өөр хоорондоо ойр, хамт байхыг зөвшөөрсөн.	Шинжилгээ авах хүчин чадлыг нэмэгдүүлж байна. Тархалтыг уламжлалт болон апп ашиглан хянаж байна.	Түргэн тусламжийн төвүүдийн ор, материал, болон боловсон хүчнийг нэмэгдүүлсэн.	Аялагчдыг нэвтрүүлэхийг хориглосон ба нийт шаардлагатай иргэдээс шинжилгээ авч 14 хоног тусгаарлалтад оруулсан байна.
<b>Сингапур</b>	3 шатны төлөвлөгөө (Three-phase plan)	Олон нийтэд тодорхой шалгуур тавиагүй	Хүн хоорондын зай 1 метр, маск зүүх шаардлагатай. Застгийн газраас хувь хүн хариуцлагатай байхыг анхааруулж зарим бодлогын өөрчлөлт хийсэн.	Өдөр тутмын PCR-н шинжилгээг 13000- аас 40000 болгон нэмэгдүүлж уламжлалт аргаар тархалтыг хянахаас гадна гар утасны аппликейшн ашиглаж байна.	Эмнэлэг болон түргэн тусламжийн хүчин чадал хэтэрсэн тохиолдолд гэрээр эмчлэх арга хэмжээ авч байна.	Аялагчдыг нэвтрүүлэхийг хориглосон ба нийт шаардлагатай иргэдээ шинжилгээ авч 14 хоног гэрээр тусгаарлалтад оруулсан байна.
<b>Солонгос улс</b>	Эхний тохиолдлыг дата сан ашиглан хянах тархалтыг таслах (Trigger-based approach), 3 түвшний зай барих арга хэмжээ (three-level physical distancing scheme )	1-р шат өдөрт 50-аас бага өвчлөлт, 2-р шат өвчлөлт, 50 -100 өвчлөлт, 3-р шат 100 дээш өвчлөлт.	Хүн хоорондын зай 2 метр, маск зүүх шаардлагатай. Застгийн газар нээлттэй мэдээлэл, зөвлөмжөөр хангаж, тархалтын байрлалыг цацаж, веб хуудас, гар утас апп зэргийг ашиглаж байна.	Өдөр тутмын PCR-н шинжилгээг 20 000 болгон нэмэгдүүлсэн ба үүнд машинтай иргэдээс зам дээр шинжилгээ авах, багтсан. Халдварын тархалтыг эзэлийн картын мэдээллээр хянах, болон уламжлалт аргуудыг ашиглаж байна.	Өвчтний хүнд хөнгөнөөс хамаарч эмнэлэг болон тусгай байруудаад эмчилж байна.	Хилээр нэвтрэгчид бүгд эрүүл мэндийн хуудас бөглөж, 14 хоног тусгаарлалтад орж гар утасндаа апп суулгаж мэдээллээ оруулах шаардлагатай байна.
<b>Европ</b>						
	Ерөнхий стратеги	Халдварын төлөв	Олон нийтийн төлөв	Олон нийтийн эрүүл мэндийн чадавч	Эрүүл мэндийн системийн чадавч	Хил гаалийн хяналтын арга хэмжээ

<b>Англи</b> ( <i>England</i> )	Гурван шатлалт төлөвлөгөө	R буюу (нэг хүнээс халдвар авсан дундаж тоо)-г тооцоолж, мэдээлэв	Хүн хоорондын 1 м зайн барьж, зарим газарт байшингийн дотор нүүрээ халхлах мөн зарим маргаантай асуудлууд нь засгийн газарт үзүүлэх олон нийтийн дэмжлэгийг бууруулсан.	Онолын хувьд өдөрт > 200,000 PCR-ын туршилт хийх хүчин чадал байдаг боловч ложистикийн томоохон бэрхшээлүүд байдаг, төвлөрсөн туршилт, мөшгих системийг хүчтэй шүүмжилж, орон нутгийн нийгмийн эрүүл мэндийн байгууллагууд зарим мөшгих ажлыг гүйцэтгэсэн; програм хөгжүүлэх анхны оролдлого амжилтгүй болсон; Шотланд, Умард Ирландад өөрсдийн гэсэн аппликейшнийг хэрэгжүүлсэн.	Түр эмнэлгүүд ажиллуулсан; эмнэлгүүд COVID-19 халдвар авсан өвчтөнүүдэд үйлчлэхийн зэрэгцээ ердийн эрүүл мэндийн үйлчилгээгээ аажмаар сэргээж байна.	Тодорхой улс орноос ирсэн хүмүүс холбоо барих хаягаа өгч, гэртээ 14 хоногийн турш өөрийгөө тусгаарлах ёстой болсон
<b>Герман</b> ( <i>Germany</i> )	Эхний (эрсдэлт) тохиолдлыг ашиглан хянаж тархалтыг таслах (Trigger-based approach)	100,000 оршин суугчид ногдох тархалтын тоо ба 7 хоногийн өвчлөлийн түвшинг үзүүлэлт болгон ашигласан	1,5 метрийн зай гаргах шаардлагатай бөгөөд аюулгүй зай барих боломжгүй тохиолдолд нүүрний хаалт хийх шаардлагатай; байнга өөрчлөгдөх;	Өдөрт 150000 гаруй PCR-ын туршилт хийх хүчин чадлыг нэмэгдүүлэх; энгийн (уламжлалт) аргаар мөшгөхөөс гадна 2020 оны 6-р сард гар утасны шинэ аппликейшнийг гаргасан.	Эрчимт эмчилгээний хэсгүүдийн хүчин чадал хүрэлцээгүй, хамаалалтын хэрэгслийн хомсдолтой байна.	Эрсдэлтэй бүс гэж тогтоосон улсаас Герман руу нэвтрэх эсвэл буцаж ирсэн хүмүүсийг хорио цээрийн дэглэмд хамруулах шаардлага тавьсан.

<b>Норвеги (Norway)</b>	Багц арга хэмжээнүүдэд тодорхой цаг хугацаанд өөрчлөлт оруулах урт хугацааны хуваарь	Тархалтын үзүүлэлтийг тооцоолж мэдээлэх	хоорондоо зөрчилтэй мэдээллүүд болон муж улсуудын ялгаатай бодлогууд олон нийтийг төөргөдүүлсэн	Өргөн хүрээнд шинжилгээ хийгээгүй, шинж тэмдэгтэй хүмүүс, эрүүл мэндийн ажилтнууд, эмзэг бүлгийн хүмүүст шинжилгээ хийж, гарын авлага гаргаж, апп-д суурилсан мөшгөх ажиллагааг явуулсан.	Мужууд болон эмнэлгүүдийн нөөц харилцан адилгүй байгаа боловч улс орны хувьд орон нутгийн түвшинд нь халдварын нөхцөл байдлыг зохицуулах хангалттай эрүүл мэндийн ажилтнуудтай юм.	Халдварын тархалт багатай Нордикийн бүс нутгуудад хилээ нээсэн; эдгээр бүс нутгаас бусад газраас ирэхэд 10 хоногийн хорио цээрийн дэглэм тогтоов.
-------------------------	--	---	---	---	--	---

Испани (Spain)	Дөрвөн үе шатлалт төлөвлөгөө	Олон нийтэд тодорхой үзүүлэлтийг зарлаагүй	1,5 м зай барих, боломжгүй тохиолдолд нүүрний маск зүүхийг шаардаж байна	2020 оны 4-р сарын байдлаар өдөрт 40000 хүнд PCR- ын шинжилгээ хийх хүчин чадалтай байсан бөгөөд энэхүү хүчин чадал нэмэгдэж байна	2020 оны 3, 4-р сарын сүүлчээр олон эмнэлгүүдийн эрчимт эмчилгээний тасгийн хүчин чадал хэтэрсэн; бусад тасгуудад хүнд өвчтэй өвчтөнүүдийг шилжүүлсэн; халдварын түвшин өндөр байгаагаас эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний чадал хүрэлцэхгүй болсон.	2020 оны 7-р сарын 1-ээс хилээ бүрэн нээж (ирсэн аялагчдыг хорио цээрийн дэглэмд хамруулахгүй)
-------------------	------------------------------------	---	---	---	--	---

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН




Figure 2: Key measures in place to allow safe easing of restrictions  
Detailed data sources are available in the appendix (appendix pp 1-16). \*New Zealand adopts a so-called social bubble model that allows defined groups of people to have close contact with each other while maintaining safe distancing with other groups.

Хонгконг, Испани улсууд зай барих болон хувийн ариун цэвэр сахиx дүрэм журмыг илүү сайн мөрдөх магадлалтай хэмээн үзэж ахлах сургуулийн хичээлийг (15-18 насныхан) түрүүлж нээсэн байна. Японд мөн төгсөх ангийнхны хичээлийг түрүүлж эхлүүлсэн. Улс орнууд сургуулиудыг эргэж нээхэд бэлтгэх, цахимаар суралцах боломжоор хангах зэрэгт илт ялгаатай арга хэмжээ авч байна.

Герман, Шинэ Зеланд, Норвеги, Шотланд, Өмнөд Солонгос зэрэг орнуудаас бусад зарим улсад төр засгийн удирдагчид нь иргэдийнхээ итгэлийг олж авах, цаашид ч үргэлжлэх амьдралын хэв маягийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрүүлэхэд хүндрэлтэй байна. Нийтлэг байдлаас нь харахад эрэгтэй удирдагчтай орнуудаас илүү эмэгтэй удирдагчидтай улсад ард иргэд нь удирдагчиддаа итгэх, шинэ гарсан дүрэм журмыг мөрдөх нь сайн байна. Хонконгд улс төрийн эмх замбараагүй байдал үргэлжилсээр байгаа нь засгийн газарт итгэх иргэдийн итгэлийг бууруулсан ч иргэд 2003 онд болсон SARS-аас авсан сургамжаар халдвар хамгааллын дүрэм журмыг сайтар мөрдөж байна. Харин Өмнөд Солонгосын засгийн газар олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор халдвар авсан хүмүүсийн мэдээллийг засгийн газрын цахим хуудсаар зарлах, иргэдэд мессэж илгээх зэргээр ил тод нээлттэй мэдээлэл харилцааны стратеги баримталж, MERS-тэй тэмцсэн өмнөх туршлагадаа тулгуурлан ажиллаж байна. Шинэ Зеланд улсын Ерөнхий сайд, Эрүүл мэндийн байгууллагын ерөнхий захирал нар нь телевизээр албан ёсны танилцуулга хийж, нийгмийн сүлжээнд шууд нэвтрүүлгүүд (livestreaming)-ээр ард түмэнд тогтмол мэдээлэл өгч байгаа нь дотооддоо болон олон улсад талархал хүлээсэн амжилттай арга хэмжээ болоод байна.

КОВИД-19 нь эмзэг бүлгийг хамгаалах, эрүүл мэндийн тэгш бус байдлыг арилгахын ач холбогдолыг ялангуяа өмнө нь энэ асуудалд төдийлөн анхаарал хандуулдаггүй байсан улс орнуудад сануулж, анхааруулга өглөө. Их Британи болон бусад орнуудад гэр оронгүйчүүд, өнгөт арьстнууд болон азиуд, угсаатны цөөнх, бага орлоготой иргэдийн дунд КОВИД-19-өөс шалтгаалсан нас баралт нь маш өндөр байна. Эдгээр тэгш бус байдал өөр бусад орнуудад ч байх магадлалтай өндөртэй боловч Герман зэрэг орнуудын мэдээлэл цуглуулагдаагүй байна. Сингапур улсад батлагдсан 58000 тохиолдлын бараг 95% нь дотуур байранд олноороо нэг дор амьдардаг цагаач ажилчид байна. Иймээс засгийн газрын зүгээс халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сайжруулж, эмчилгээ, эмнэлгийн үйлчилгээг газар дээр нь үзүүлж, 45-аас дээш насны ажилчдыг одоо амьдарч байгаагаас нь төвлөрөл багатай орон байраар хангах зэргээр хамгаалах арга хэмжээ авсан байна. Судалгаанд хамрагдсан есөн орон болон бүс нутагт асрамжийн газруудад тогтмол шинжилгээ хийж, шинж тэмдэгтэй асруулагчид болон ажилтнуудыг тусгаарлах, эргэлтийг хязгаарлах болон хориглох, гарын ариун цэврийг сахиулах, хамгаалах хэрэгслүүдээр хангах зэргээр халдвар тархахаас сэргийлэх арга хэмжээг авсан байна.



Цар тахлын ард иргэдэд учруулах хор нөлөөг бууруулах зорилгоор эдийн засгийн дэмжлэг үзүүлж дээрх есөн улс, бүс нутагт бизнесийг дэмжих, ажлын байрыг хамгаалах, иргэд болон өрхийн санхүүгийн хүндрэлийг багасгах зорилгоор ихээхэн хэмжээний төсөв зарцуулахаа засгийн газрууд зарласан юм. Ази номхон далайн бүсийн 5 оронд энэхүү эдийн засгийн дэмжлэгийн хүрээнд нэг удаагийн мөнгөн тусламжийг иргэддээ олгосон байна. Япон улс энэхүү яаралтай дэмжлэгийн санхүүжилтээр бусад орнуудыг тэргүүлж хамгийн их буюу ДНБ-ийхээ 42%-тай тэнцэх санхүүжилтыг зарцуулсан бөгөөд нийт оршин суугчидад тус бүр 100,000 иен (930USD) олгосон байна. Гэсэн хэдий ч ажилгүйдлийн тэтгэмж болон орон тооны цомхтголоо хойшлуулсны төлөөх нөхөн олговор олгох арга хэмжээний хууль зүйн үндэслэл тодорхойгүй байгаа нь ихээхэн шүүмжлэлд өртсөн.

Харин Европын орнууд одоогийн нийгмийн хамгааллын тогтолцоогоо бэхжүүлэх замаар урт хугацааны дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг сонгосон байна. Испанид КОВИД-19-ийн хямрал нь сарын орлогын доод хэмжээг 462 евро (500 доллар) болгох шийдвэр гаргах явцыг хурдасгаж өгсөн. Энэхүү төлөвлөгөөний үр шимийг 2,5 сая хүн хүртэх бөгөөд үүнд жил бүр 3 тэрбум евро зарцуулагдах болно. Их Британид 2020 оны 10-р сарын 31 хүртэл 6 сая гаруй ажилчдын цалинг төлөхийн зэрэгцээ нийгмийн даатгалын нөхөн олговор болон бага орлоготой иргэдэд үзүүлдэг халамжийн хэмжээг жилд 1040 фунт стерлингээр (ойролцоогоор 1320 доллар) нэмэгдүүлсэн байна.

### Нийгмийн эрүүл мэндийн чадавх

Өмнө дурдсанчлан, КОВИД-19-ийн хязгаарлалтаас гарах үр дүнтэй стратегийн цөм нь халдварын идэвхтэй тохиолдлыг илрүүлэх, халдварын сэжигтэй бүх хүмүүсийг шинжлэх, тэдний ойрын хавьтлыг хайх, халдвартай нь батлагдсан хүмүүсийг тусгаарлах болон тусгаарласан хүмүүсийг дэмжих (эмчлэх) зэргийг багтаасан хяналт шалгалтын системтэй байх ёстой. Азийн орнууд, бүс нутагт халдвартай нь батлагдсан бүх хүмүүсийг эмнэлэг болон бусад байгууллагад тусгаарлаж эмчилсэн бол Европын орнуудад хөнгөн шинж тэмдэг илэрсэн хүмүүсийг ихэвчлэн гэрт нь тусгаарласан. Улс орнуудын шинжилгээ хийх, хянах стратеги нь харилцан адилгүй байна.

Тархалт эхлэхэд олон улс орнууд зөвхөн шинж тэмдэг илэрсэн хүмүүст шинжилгээ хийхээр хязгаарласан бөгөөд Япон болон Европт шинжилгээ нь ерөнхийдөө хүнд шинж тэмдэгтэй хүмүүст чиглэж байв. Гэхдээ шинжилгээний шалгуур үзүүлэлт нь орон нутаг болон дэлхий нийтийн нөхцөл байдал, шинжлэх ухааны шинэ шинэ




Figure 3: Contact-tracing tools in the nine countries and regions. Detailed data sources are available in the appendix (appendix pp 1-16).

нотолгоонуудын хамт хөгжиж, өөрчлөгдөж байна. Норвеги улс халдварын түвшин бага, буруу оношлогдох магадлал өндөр байгаа тул өргөн хүрээнд шинжилгээ хийхийг зөвлөөгүй бөгөөд асрамжийн газрын ажилтнууд болон тэнд амьдардаг хүмүүс, батлагдсан тохиолдлуудын хавьтлын хүмүүсийг шинж тэмдэг илэрсэн эсэхээс үл хамаарч шинжилгээнд хамруулж байсан. Харин

2020 оны 8 дугаар сараас эхлэн сэжигтэй хүн бүрийг орон нутгийн эмчийн анхан шатны үзлэг хийлгүйгээр шинжилгээнд хамруулах боломжийг олгосон шинэ журам нэвтрүүлсэн. Харин энэ үед Өмнөд Солонгост КОВИД-19 өвчтэй хүмүүсийн оролцсон арга хэмжээ болон олон нийтийн газарт очсон хүмүүс, тэдэнтэй хавьтал үүссэн байж болзошгүй хүмүүсийг шинж тэмдэг илэрсэн эсэхээс үл хамааран нийтэд нь шинжилгээнд хамруулж байлаа. Өдөрт 20000 гаруй хүнд шинжилгээ хийх хүчин чадалтай 638 хяналтын төв, төрийн болон хувийн хэвшлийн 118 шинжилгээний байгууламжтай болсноор бүх нийтийн шинжилгээг хийх боломжтой болсон. Японд шинжилгээг голчлон засгийн газрын нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний хүрээнд хийж байгаа тул шинжилгээний чадавх хараахан хангалттай өсөөгүй байна.

Өмнөд Солонгос, Герман улсын машинтай явж байгаа хүмүүсийн (drive-through) шинжилгээ, Их Британи болон Хонгконгт гэрт нь очиж шинжилгээ (home-based testing) хийх зэрэг шинэ загварууд нь эмнэлгийн халдвар дамжуулалтыг бууруулахын зэрэгцээ шинжилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. Өдөр тутамд авах шинжилгээний мянган хүнд ногдох тоо нь 9 улс, бүс нутагт харилцан адилгүй боловч шинжилгээ нь өөр өөр стратегид тулгуурладаг тул мэдээллийг тайлбарлахдаа анхааралтай хандах шаардлагатай.

Цар тахал хурдацтай тархаж байгаа нь олон улс орнууд бэлтгэл муутай байсан гэсэн үг юм. Азийн орнууд болон бүс нутагт тархалтыг эрт хянахад голчлон эрүүл мэндийн ажилтнууд хавьтлыг гар аргаар тогтоох ажиллагааны хүчин чармайлтаас үүдэлтэй байсан бол үүнээс хойш олон улс орон, бүс нутагт гар арга (manual methods)-ыг дижитал аргуудтай хавсарч байна (зураг 3). Өмнөд Солонгост өвчнийг бодитойгоор тогтоох, хүрээг хязгаарлах зорилгоор цахим эрүүл мэндийн бүртгэл, банкны картаар хийсэн гүйлгээний бүртгэл, гар утсанд суурилсан байршлын системийн мэдээлэл болон CCTV ашиглаж өвчтнөөс ярилцлага авахдаа эргэн санахад нь туслаж байв. Өмнөд Солонгосын туршлагаас харахад халдвар авсан хүмүүсээс гэрт нь очиж асуумж авах аргачлал (shoe-leather epidemiology) нь ихээхэн ач холбогдолтой байна. Эхэндээ Англид энэ систем нь утсаар ярих замаар хүмүүсийг мөшгөх, камерын хяналтын (CCTV) системийг ашигласан боловч энэ нь төдийлөн амжилтад хүрээгүй бөгөөд олон газарт орон нутгийн эрүүл мэндийн багууд энэхүү үүргийг гүйцэтгэхэд хүрсэн байна. Хонгконгт ихэвчлэн гэмт хэрэгтнийг мөрдөн шалгах, мөшгөх, хянах, зураглахад ашигладаг цагдаагийн супер компьютер системийг хэрэглэж байна. Япон, Герман, Сингапур, Шинэ Зеланд болон Норвеги улсууд КОВИД-19-той өвчтөнтэй маш ойрхон очсон хүмүүсийг олж тогтоох, мэдэгдэх, байршил тодорхойлох QR код эсвэл байршил тогтоох системээр хянах, Bluetooth дохио ашигладаг ухаалаг гар утасны программыг гаргасан байна. Их Британи ижил төрлийн программ хөгжүүлж эхэлсэн ч хөгжүүлэлтээ зогсоож Apple–Google-ийн системд шилжихээр шийдвэрлэсэн. Шотланд улс энэхүү систем дээр суурилсан NHS Protect Scotland программыг гаргаад байна. Эдгээр есөн улсад ойрын хавьтагчдыг тогтоосны дараа утасны дуудлага болон программ (application)-аар дамжуулан мөрдөх, шинж тэмдэг болон өөрийгөө тусгаарлах явцыг хянаж байна.

Хонгконг, Япон, Шинэ Зеланд, Испани болон Их Британийн Засгийн газрууд цар тахлыг удирдах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөгөө өгөх нийгмийн эрүүл мэнд, тархвар судлал, эмнэлзүйн шинжээчдээс бүрдсэн түр хороог байгуулсан байна. Японд өндөржүүлсэн бэлэн байдал зарлах (the state of emergency) үед шинжээчдийн зөвлөлийн өгсөн зөвлөгөө болон засгийн газрын шийдвэр хоёрын хоорондын холбоо тодорхойгүй байв. Их Британид

Онц байдлын үе дэх шинжлэх ухааны зөвлөгөө өгөх баг (the Scientific Advisory Group for Emergencies)-ийг гишүүнчлэлээ зарлах хугацааг хойшлуулсан болон өгсөн зөвлөгөөг шүүмжилжээ. Үүний хариуд Засгийн газрын шинжлэх ухааны ахлах зөвлөх илүү өргөн хүрээний нэр хүнд бүхий эрдэмтэдээс бүрдсэн Онцгой байдлын үед зөвлөгөө өгөх бие даасан эрдэм шинжилгээний баг (Independent Scientific Advisory Group for Emergencies)-ийг байгуулсан. Шотландын засгийн газар мөн 2020 оны 3 сарын сүүлээр хөл хорио тогтоох арга хэмжээ авах талаар зөвлөх шинжлэх ухаан КОВИД-19 зөвлөх баг (scientific Covid-19 advisory group)-ийг байгуулсан.

Герман, Сингапур, Өмнөд Солонгос болон Норвеги улсад нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгүүд, халдварт өвчин судлалын шинжээчид шинжлэх ухааны нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээж байна. БНСУ-ын өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх газар болон Норвегийн нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн нь КОВИД-19-т хариу үзүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Эрүүл мэндийн яамныхаа харьяанд ажиллаж байгаа ч Норвегийн хүрээлэнгийн захирал нь зарим тохиолдолд засгийн газартай санал зөрөлдөж байгаагаа олон нийтэд илэрхийлж байсан байна. Үүнээс гадна дээрх орнуудын эрдэмтэд засгийн газартаа зөвлөмж бэлтгэн өгөх санаачлага гарган ажиллаж байна. Германы үндэсний нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн болон Роберт Кох (Robert Koch)-ын хүрээлэн нь хараат бус гэгддэг боловч Германы эрүүл мэндийн яамнаас санхүүждэг бөгөөд харьяанд нь байдаг. Улс орнуудын харилцан ялгаатай туршлагауд нь бүх юм бүрэн тодорхойгүй байхад шийдвэр хэрхэн гаргах вэ гэдэг сонирхолтой асуултыг бий болгож байгаа юм. Урьдчилан сэргийлэх арга замуудыг хэрэглэхээс өмнө батлагаатай баримт нотолгооны эрэл хайгуул хийх нь чухал шийдвэрүүдийг хойшлуулах болов уу?

### **Эрүүл мэндийн системийн чадавх**

Эрүүл мэндийн системийн чадавх, хүчин чадал нь хөл хорио цуцалсны дараа халдварын давлагаа дахин гарвал түүнтэй тэмцэхэд маш чухал юм. Энэ чадавхад хангалттай эмчилгээний байгууламжтай байх (жишээлбэл, эрчимт эмчилгээний тоноглогдсон тасгаас эхлээд олон нийтэд үзүүлэх үйлчилгээ хүртэл), эмнэлгийн тоног төхөөрөмж (өвчтөнд зориулсан амьсгалын төхөөрөмжөөс эхлээд ажилтнуудын хувийн хамгаалах хэрэгсэл хүртэл), эрүүл мэндийн салбарын ажиллагчид хамаарна. Цар тахлаас өмнө эрүүл мэндийн салбарт хангалттай хөрөнгө оруулалт хийгээгүй байдал нь авч хэрэгжүүлэх арга хэмжээний боломжуудыг хязгаарлаж байна. Эрүүл мэндийн системд хөрөнгө оруулалт хийх нь ирээдүйд ямар ач тустайг Герман улсын туршлага харуулж байна. КОВИД-19 өвчний дэгдэлт эхлэхээс өмнө тус улс 100,000 хүн тутамд 34 эрчимт эмчилгээний ор (critical care bed)-той байсан бол Испанид 9-7, Японд 5-2 байсан. Тиймээс Германы эрчимт эмчилгээний тасгууд нь өвчний дэгдэлтийн оргил үед ч ор хангалттай байснаараа бусад хүнд өвчтөнүүдийг эмнэлгийн бусад тасаг, орон зайд шилжүүлж байсан Европын орнуудаас ялгарч байлаа. Германаас бусад бүх улс орнууд зөвхөн хүнд өвчтөнүүдийг эмнэлэгт эмчлэхээр, хөнгөн хэлбэрийн өвчтэй хүмүүсийг түр зуурын байрууд эсвэл гэрт нь хянах тогтолцоог нэвтрүүлсэн. Хонгконг, Сингапур, Өмнөд Солонгос болон Их Британи улсууд хурлын заал гэх мэт томоохон тайлбайг олон нийтийн эмчилгээний газар хэлбэрээр ажиллуулахаар дахин төлөвлөсөн. Гэсэн хэдий ч Их Британид ажиллах хүч дутмаг байснаас энэ талбайг гүйцэд ашиглаагүй байна. Эдгээр орнуудад Халдвар авагчийн тоо буурсан тул шаардлагатай тохиолдолд эдгээр

байгууламжуудыг дахин нээхээр бэлэн байдалд байлгаж байна. Энэ цар тахлын үед олон орны эрүүл мэндийн систем боловсон хүчний асуудалтай нүүр тулсан нь ажилтнуудын тоо буурсан (халдвар авсан эсвэл өөрийгөө тусгаарласан эмнэлгийн ажилтнууд) болон хэрэгцээ шаардлага нэмэгдсэн аль аль нь байв. Үүний хариуд эрүүл мэндийн ажилтнуудыг шинээр томилох, сайн дурын ажилтнууд элсүүлэх болон яаралтай тусламжийн бүс эрүүл мэндийн үйлчилгээг бууруулах эсвэл зогсоох хүртэл арга хэмжээг авсан байна. Халдварын тархалтын оргил үе өнгөрсөний дараа хэрэв шаардлагатай бол дараагийн давлагааны үед нөөцийг хурдан шуурхай дахин төлөвлөх чадвараа хадгалахын зэрэгцээ ердийн үйлчилгээгээ сэргээх нь чухал юм. Хонгконг, Сингапур, Өмнөд Солонгос, Норвеги болон Их Британи улсын зарим эмнэлгүүд нүүр тулж уулзахгүйгээр өвчтөнд тусламж үзүүлэх алсын зайн хяналт болон харилцаа холбооны үйлчилгээг санал болгож эхэлжээ. Зарим оронд хувийн хамгаалах хэрэгслийн дутагдалтай байдал нь эмнэлгийн ажилтнууд хангалттай хамгаалалтгүйгээр ажиллахад хүргэсэн бөгөөд агааржуулалтын системийн хангалтгүй байдал нь ажилтнуудын нормын талаар шийдвэр гаргахад хүндрэлтэй тулгарч байсан. Испанид КОВИД-19-ийн тохиолдлын 10 гаруй хувийг эмнэлгийн ажилтнууд эзэлж байна. Үүний эсрэгээр Хонгконг, Өмнөд Солонгос болон Сингапур улсад эрүүл мэндийн ажилтнуудыг халдвараас хамгаалах аюулгүй ажиллагааны журмыг мөрдөж, хувийн хамгаалах хэрэгслийг зохистой ашиглах сургалт зохион байгуулахын зэрэгцээ хүн хүчний нөөц нь хангалттай байсан. Бүх улс орон, бүс нутагт засгийн газар шаардлагатай эм, тоног төхөөрөмжийг гадаадын болон дотоодын компаниудаас худалдан авах замаар чадавхаа нэмэгдүүлсэн байна.

### ***Хилийн хяналтын арга хэмжээ***

Улс орон, бүс нутгууд хилээ аажмаар нээж байгаа тул КОВИД-19 халдвартай хүн бүс нутагт нэвтрэх эрсдлийг бууруулахаар аялагчдын урсгалыг зохицуулах (хянах) шаардлага тулгарч байна. Ази, Номхон далайн бүс нутгийн таван улс хилийн хяналтын хатуу арга хэмжээ хэрэгжүүлж Хонконг, Шинэ Зеланд, Сингапур улс ихэнх зорчигчид хилээ хаалттай байлгаж байна. Эдгээр гурван улс болон Өмнөд Солонгост нэвтрэх бүх хүмүүс заавал КОВИД-19 шинжилгээнд хамрагдаж, гэртээ эсвэл тогтоосон байранд 14 хоног байх хорио цээрийн дэглэм сахих ёстой юм. Японд ирсэн бүх хүмүүст 14 хоногийн хорио цээрийн дэглэм тогтоож, эрсдэлтэй бүс гэж тооцогддог орнуудаас ирсэн хүмүүсийг нэвтрэхийг хориглох эсвэл шинжилгээнд хамрагдахыг шаардаж байна. Харин Европын орнуудад хил нэвтэрч буй аялагчдаас шинжилгээ авах шийдвэр гаргах ажил удаашралтай байсан байна. 2020 оны 6-р сарын байдлаар Испани Европын холбооны иргэдийг хорио цээрийн шаардлагаас чөлөөлсөн бол, Норвеги Нордикийн бүс нутгаас ирсэн хүмүүсийг халдвар дамжуулах түвшин харьцангуй бага (өөрөөр хэлбэл 100000 оршин суугч тутамд 20-оос цөөн тохиолдол батлагдсан тохиолдол, сүүлийн 2 долоо хоногт авсан шинжилгээний 5% -иас бага нь эерэг буюу өвчтэй байсан бол) хэмээн хорио цээр тогтоогоогүй бөгөөд энэхүү хөнгөлөлтөө өргөжүүлж 2020 оны 7-р сарын 15-ны өдрөөс Шенгений бүсийн иргэдийг хамруулсан. Герман улсад эрсдэлтэй бүс гэж заасан орноос Герман руу нэвтрэх болон буцаж ирэхэд нь хорио цээрийн дэглэм тогтоогоод байна. Их Британи 14 хоногийн турш бие дааж тусгаарлах шаардлагыг зарим орноос ирж байгаа хүмүүст цуцалсан боловч эргээд нэлээн хэдэн орнуудаас ирсэн аялагчдад энэхүү шаардлагаа дахин тавиад байна. 2020 оны 6-р сарын сүүлчээр Европын холбоо дотооддоо хилээ нээсэн бөгөөд Испани 2020 оны 7-р сарын 1-ээс эхлэн бүх улс оронд хилээ бүрэн нээлээ. Өвчин зөөвөрлөгдөх (импортлогдох) болзошгүй

тохиолдол нэмэгдэхээс урьдчилан сэргийлэхийн тулд Испани улс эрүүл мэндийн мэдүүлгийг компьютерээр авах, зочдын халууныг автоматаар шалгах, дулааны зураглал бүхий камерыг нэвтрүүлэх гэх мэт Хонконг, Сингапур зэрэг Азийн олон оронд хэдийнээ хэрэгжүүлээд байгаа арга хэмжээг авч эхэлсэн байна.

### **Дүгнэлт**

КОВИД-19-ийн эсрэг хязгаарлалтын арга хэмжээг зогсоохдоо цар тахлын өмнөх энгийн байдал руугаа шууд орох биш харин аажмаар, болгоомжтойгоор шинэ амьдралын хэв маяг руу шилжих, шаардлагатай тохиолдолд арга хэмжээг дахин авахад бэлэн байх ёстой. Гэвч улс орнууд эдгээр ижил төстэй арга хэмжээг авах цар хүрээ, хурд, эрчимтэй байдлаараа ялгаатай байгаа нь Ази болон Европын улс орнуудын жишээн дээрээс ажиглагдаж байна. Жишээ нь, Японоос бусад маш олон Азийн орнууд тархалт гарч эхэлмэгц хурдан хугацаанд олон хүнийг хамарсан шинжилгээ болон ажиглалт хийж, КОВИД-19-ийн зөвхөн хүндэрсэн тохиолдол биш харин илэрсэн бүх тохиолдлуудыг тусгаарлаж, мэдээллийн технологийн тусламжтайгаар маш сайн хяналт шалгалт хийж чадсан бол Германаас бусад ихэнх Европын орнууд эдгээр арга хэмжээг нэлээд хожуу хэрэгжүүлсэн юм. Түүнчлэн Азийн орнуудад ихэвчлэн эмнэлгийн байгууллагад тусгаарлаж байсан бол Европт гэртээ тусгаарлагдахыг зөвлөж байжээ. Мөн Азид бусдын аюулгүй байдлын төлөө нийтээрээ амны хаалт зүүж хэвшсэн байсан бол Европт тэгж чадаагүй юм. Эдгээр ялгаанууд нь улс орнууд өмнө нь туулж байсан цар тахлын үеийн туршлага, өнөөдрийн хямралыг хүртэл олон жилийн турш хэрэгжүүлж ирсэн эдийн засгийн бодлогууд нь ямар байдгаас шууд хамаарч байгаа юм. Олон арван жилийн турш Европын олон орнуудад хэрэгжсэн эдийн засгийн хэмнэлтийн бодлого нь эмнэлгийн салбар болон нийгмийн хамгааллын чадавхыг маш ихээр доройтуулсан байна. Эсрэгээрээ, 2003 онд гарсан SARS, 2015 гарсан MERS зэрэг тахалт өвчнүүд Азийн олон орнуудыг дайрсанаар эдгээр орнууд эмнэлгийн салбараа бэхжүүлэхийн төлөө хөрөнгө оруулж, тахалт өвчин гарах үед хүн амыг хамгаалахын тулд нийгмийн эрүүл мэндийн дэд бүтцийг маш сайн болгосон юм. Мөн тахалт өвчин өмнө нь гарч байсан орнуудын иргэд халдварт өвчин гарч байгаагүй орны иргэдийг бодвол хатуу хөл хорио, эрчимтэй тандалт судалгааг сайн биелүүлж байсан ба хувь хүний эрх ашгийг хойш тавьж, нийтийн сайн сайхныг нэгдүгээрт тавихыг зөвшөөрч байсан юм. Хэдийгээр өнөөдрийн байдлаар КОВИД-19-ийн цаашдын хандлага тодорхойгүй байгаа ч, улс орнууд хамгийн муу байдалд бэлдэж төлөвлөх хэрэгтэй. Одоо ч гэсэн дараах туршлагаудыг авч хэрэгжүүлэхэд оройтоогүй билээ.

**Нэгдүгээрт**, энд дурьдсанчлан, улс орнууд өвчний тархалтыг цаашид судлан, судалгаан дээр үндэслэн тархалтын аль хүчин зүйлүүдийг хамгийн чухалд тооцох тухай маш тодорхой төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй. Энэ төлөвлөгөө нь хөл хориог ямар зэрэгт суллах, дэглэмийн дараагийн шат руу хэзээ орох эсэх, мөн бүх шатанд авах тусгаарлалтын арга хэмжээг тодорхой болгох ёстой юм.

**Хоёрдугаарт**, улс орнууд өвчний тархалтыг нарийн хянах сайн системтэй болтлоо хязгаарлалтын арга хэмжээг цуцлахгүй байх хэрэгтэй. Шийдвэр гаргахдаа нэг хүнээс халдвар авсан дундаж тоо (R)-ийг ашиглах тухай нэлээн тайлбарласан ч, үүний тулд бодит бөгөөд чанартай дата хэрэг болдог (Хонгконг-ийн R ашигласан жишээ бий) бөгөөд өвчний тархалт судлалын түвшинд (epidemiology) сайн ойлгосны дараа тайлбарлах хэрэгтэй байдаг. Жишээ нь, жижиг хотын нэг тохиолдол илрэхэд R утгыг нийт улсын хэмжээнд нэмэгдүүлэх ч гэсэн, үндэсний хэмжээнд тусгаарлагдана гэсэн утга биш юм.



**Гуравдугаарт,** халдварыг намжаах арга хэмжээг тодорхой хугацаанд үргэлжлүүлэх хэрэгтэй. Жишээ нь, Шинэ Зеландад анх санаачилсан “Social Bubble” нь хүмүүсийн хоорондын харилцааг цөөн хүний хүрээнд болгон хумиж зөвшөөрснөөр халдварыг бууруулах давуу талтай. Мөн амны хаалт нь хүнээс хүнд халдварлах халдварыг бууруулах нь нотлогдсон бөгөөд Германы нэг судалгаанд амны хаалт нь нэг өдрийн халдварын хэмжээг 40-60%-аар бууруулсан байна гэжээ. Хамгийн чухал нь, засгийн газар нийгмийн бүхий л бүлгийн гишүүд ялангуяа эмзэг бүлгийн хүмүүст цар тахлын эсрэг арга хэмжээ авах мэдээлэл өгөх, тэдний оролцоог хангах, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг олон нийт хүлээн зөвшөөрөх эсэх таамаглалд үндэслэн шийдвэр гаргаснаас илүүтэй иргэдийг өөрсдийг нь оролцуулан тухайн орон нутгийн нөхцөл байдалд тохируулан хамтын шийдвэр гаргах нь зүйтэй.

**Дөрөвдүгээрт,** улс орон бүр өвчнийг илрүүлэх, шинжилгээ хийх, мөшгих, тусгаарлах, дэмжлэг үзүүлэх зэрэг системтэй болох хэрэгтэй. Шинжилгээний урьдчилсан дата нь үхлийн хэмжээ болон эмнэлгийн ачааллыг эрс бууруулах чухал ач холбогдолтой байдаг. Солонгос улсад хэрэгжүүлсэн машинтай болон гудамжаар явж буй иргэдээс авсан шинжилгээ нь өвчтнийг илрүүлэх сайн арга байсан. Азийн орнуудад эмнэлэг хүрэлцэхгүй үед тусгай зориулалтын байранд өвчтнүүдийг эмчилсэн нь гэрээр эмчилгээ хийснээс илүү үр дүнтэй байв. Хавьтагчдыг мөшгөх арга хэмжээний хувьд нийт хүн амын 56% нь мөшгөлтийн аппликейшнийг ашиглахад тархалтыг зогсоох бол үүнээс бага тохиолдолд ч гэсэн тархалтын удаашруулах үр дүнтэй байх болно. Гэвч цахим мөшгилтөөр уламжлалт аргыг бүрэн солих (халах) боломжгүй юм. Мэдээлэл нотолгоо тодорхой болох тусам эдгээр стратегиуд нь улс орнуудад халдварын тархалтыг барьж бүрэн хөл хорионд орохоос зайлсхийхэд нь туслах болно. Үндсэндээ энэхүү илрүүлэх, шинжилгээ хийх, мөшгих, тусгаарлах, дэмжлэг үзүүлэх (эмчлэх) систем нь нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн салбарт тоног төхөөрөмж, эм тариа, хүн хүчээр байнга хангах тогтвортой санхүүжилтыг шаардаж байдаг. ДЭМБ, ОУВС хамтран засгийн газруудад эрүүл мэндийн салбарын зардлыг нэн тэргүүнд тавихдаа эдийн засгийг сэргээх ур чадвартай ажилчдыг бэлтгэх ажлыг мөн зэрэгцүүлэн хийхийг уриалсан. Эцэст нь дотоодын тархалтыг зогсоох зорилготой Zero-Covid стратегийг баримталж байгаа улс орнуудад энэ талаарх маргаан нь илүү хүчтэй байгаа юм. КОВИД-19 тусаж эмчлэгдсэн хүмүүст төсөөлснөөс урт хугацаанд шинж тэмдэг нь илэрч байгаа нь хэдийн тодорхой болоод байгаа энэ үед улс орны хувьд ачааллыг нэмэгдүүлэх нь тодорхой учир Шинэ Зеландын энэхүү стратеги нь хэцүү боловч маш чухал зорилго байх болно гэж үзэж байна.

Олон улс орнууд хилээ нээх тусам тандалтын төхөөрөмж, хөл хорионы арга хэмжээнүүд нь улам бүр зайлшгүй болж болзошгүй тохиолдлыг илрүүлж иргэдийн дунд тархахаас сэргийлэх болно. Энэхүү хяналтыг үр дүнтэй байлгахын тулд улс орнууд эдгээр арга хэмжээнүүдээ байнга, тогтмол шалгаж, тохируулж (шинэчилж) байх нь чухал. Энэхүү олон улсын хамтын бүтээл нь КОВИД-19-ийн хорио цээрийн дэглэмийг сулруулахад тулгарах түвэгтэй бөгөөд хүндхэн үүргийг хэрэгжүүлэхдээ эдгээр 9 орноос авч болох сургамжаас танилцууллаа.

Шинэ Зеландын туршлагаас харахад хөл хориог бууруулахад анхаарал, болгоомж менежмент шаардлагатай байгаа бол Испани, Герман, Их Британи зэрэг улсууд КОВИД-19 цар тахлын эсрэг цогц хамгаалалт хийгээгүйгээс халдварын тархалт дахин сэргэх асар их эрсдэл байгааг сануулж байна.

(Нэмэлт мэдээлэл)



**Хятад улс КОВИД-19 цар тахлыг хэрхэн амжилттай хяналтандаа оруулсан бэ?**

*Дэлхий нийт КОВИД-19 цар тахлыг хяналтандаа оруулахын төлөө тэмцэж байхад Хятад улс энэхүү цар тахлыг аль хэдийнээ шуурхай бөгөөд үр дүнтэй хяналтандаа оруулж чаджээ. Үүнийг хэрхэн хийж чадсан бэ?*

*Талха Буркийн мэдээлэл.*

АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп 2020 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейд хандсан шийдэмгий дайчин үгэндээ амьсгалын замын ноцтой аюултай коронавирус 2 (SARS-CoV-2) өвчнийг “Хятадын вирус” хэмээн нэрлэсэн юм. Улмаар тэрээр Хятадыг энэхүү цар тахлыг дэлхий нийтэд тараасныхаа хариуцлагыг хүлээхийг шаардсан юм. Харин Трампын дараагаар Ерөнхий Ассамблейд Хятадын Ерөнхийлөгч Ши Жиньпин үг хэлсэн бөгөөд тэрээр КОВИД-19 цар тахалд нэрвэгдсэн улс орнуудыг “шинжлэх ухааныг удирдамж болгон дагаж....энэхүү цар тахлыг дарахад олон улсын хамтын хүчийг нэгтгэхийг” санал болгосон юм. Мөн тэрээр “асуудлыг улстөржүүлэх, эсхүл гутаан доромжлох аливаа оролдлогоос татгалзах ёстой” хэмээн өгүүлжээ. Үүнээс 9 хоногийн дараа Трамп SARS-CoV-2 өвчний шинжилгээгээр эерэг хариутай гарсан юм.

“Pew” судалгааны төвийн (Pew Research Center) долдугаар сарын судалгаагаар Америкчуудын гуравны хоёр нь Хятадыг КОВИД-19 цар тахалтай тэмцэх талаар муу ажилласан гэж үзэж байжээ. Энэ бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын үзэл бодол биш байсан нь тодорхой хэрэг юм. Учир нь ДЭМБ-ын Эрүүл мэндийн онц байдлын хөтөлбөрийн гүйцэтгэх захирал Майк Райн есдүгээр сард зохион байгуулагдсан хэвлэлийн хурлын үеэр “өвчнийг ийм бага түвшинд хүртэл бууруулахын төлөө цуцашгүй, тууштай зүтгэсэн Хятадын тэргүүн эгнээний эрүүл мэндийн ажилтнууд болон тэдэнтэй хамтран ажилласан хүн ардад...гүн талархал” илэрхийлж баяр хүргэсэн байна.

2020 оны 10 дугаар сарын 4-ний байдлаар Хятадад КОВИД-19 өвчний тохиолдол 90604, нас барсан тохиолдол 4739 тус тус бүртгэгдээд байгаа бол АНУ-д өвчний тохиолдол 7382194, нас барсан 209382 тохиолдол тус тус бүртгэгдээд байна. Их Британы Нэгдсэн Вант Улсын хүн ам Хятадынхаас 20 дахин бага байтал КОВИД-19 өвчний тохиолдол нь тав дахин, харин нас баралтын тохиолдол нь бараг арав дахин их байна. Энэ бүхнээс урган гарч ирж буй асуулт нь: Хятад улс хэрхэн энэ цар тахлыг хяналтандаа авч чадав аа? юм.

Хятад нь КОВИД-19 цар тахалд хамгийн анх нэрвэгдсэн газар боловч энэхүү өвчний тархалтыг зогсоон барих тал даар дээгүүр байранд орж байна. Энэ улс эпидемик өвчинтэй тэмцэх төвлөрсөн системтэй. Хятадын насанд хүрсэн хүн амын дийлэнх нь SARS CoV титэмт вирусийн өвчин болон түүний нас баралтын хувь хэмжээ өндөр байсныг сайн санацгааж байгаа. “Коронавирус дэгдсэнээр юу тохиолдох вэ гэдэг асуудалд манай нийгэм даяараа үнэхээр түгшицгээсэн юм... ..Бусад улс орнуудад цар тахлын талаарх ийм гүн гүнзгий ой санамж байгаагүй юм.” гэж Ши Чэн хэлжээ (Yale School of Public Health, New Haven, Connecticut, USA). Өндөр настнууд ихэвчлэн хүүхдүүдтэйгээ хамт, эсхүл бүр ганцаар амьдардаг байсан ч хүүхдүүдтэйгээ ойрхон амьдарцгаадаг. Хятадын өндөр настнуудын ердөө 3% л асрамжийн газарт амьдардаг. Гэтэл барууны хэд хэдэн орны иймэрхүү асрамжийн газрууд нь халдварын гол томоохон голомт болж байсан юм.

Маёо Клиник (Mayo Clinic)-ийн Вакцины судалгааны бүлгийн захирал Грегори Полэнд (Gregory Poland): “Хятадын хариу арга хэмжээний хурд нь маш чухал хүчин зүйл байв... Тэд халдварын тархалтыг зогсоох талаар маш хурдтай ажилласан. Гэтэл бусад улс орнууд вирусийн халдвар тэдэнд хүрч, тархахыг хүртэл бэлтгэлээ базаах хугацаа илүү ихтэй байсан хэдий ч хариу арга хэмжээ хурдан авалгүй саатсан. Энэ нь тэд хэдийнээ хяналтаа алдсан гэсэн үг л дээ” (Rochester, Minnesota, USA) гэж тайлбарласан юм. КОВИД-19 гэх энэ өвчний анхны тохиолдлууд 2019 оны 12 дугаар сарын сүүлчээр Хубэй мужийн Ухань хотод бүртгэгдсэн. Хятад улс 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр энэхүү вирусийн геномийн бүтцийг нийтэд зарлаж, тухайн сарынхаа сүүлчээс эхлэн түүнийг зогсоох хэд хэдэн хатуу арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн юм.

Ухань хотод 76 хоногийн турш үргэжилсэн хатуу хөл хорионы дэглэмийг авч хэрэгжүүлсэн. Нийтийн тээврийг зогсоосон ба үүнтэй адил арга хэмжээг Хубэй мужийн бусад том хотуудад ч нэн даруй авч хэрэгжүүлсэн юм. Улс орон даяарх нийтийн тээврийн сүлжээ газруудад нийт 14 000 эрүүл мэндийн үзлэгийн цэгүүдийг байгуулан, сургуулиудын өвлийн амралт дуусаад эхлэх байсныг хойшлуулж, хүн амын зорчих хөдөлгөөнийг эрс бууруулав. Хэдэн арван хотуудад айл өрхийн гадуур явах хөдөлгөөнийг хориглож, нэг өрхөөс зөвхөн нэг хүнд хэдэн хоног өнжөөд хэрэгцээний зүйлсээ цуглуулах зөвшөөрөл олгохоор болгосон байдаг. Цөөн хэдэн долоо хоногийн дотор Хятад улс Ухань хотын 9 сая иргэнийг SARS-CoV-2 өвчний шинжилгээнд хамруулж чадсан юм. Мөн хавьтлыг мөшгин тогтоох талаар маш үр дүнтэй улсын системийг бий болгосон байна. Гэтэл Их Британий халдварын хавьтлыг тогтоох хүч чадал тус улсад вирусний халдвар дэгдэн тархсан даруйд л шавхагдсан байдаг юм.

Хувийн хамгаалалтын хэрэгслийн хувьд дэлхийн хамгийн том үйлдвэрлэгч улсын хувиар эмнэлгийн хувцас, мэс заслын амны хаалт зэргийн үйлдвэрлэлийн тоо хэмжээг эрс нэмэгдүүлэх нь Хятадын хувьд харьцангуй амар хялбар байсан байх талтай. Үүнээс гадна Хятадуудын хувьд амны хаалтыг төвөггүй хэрэглэж заншсан байдаг. Амны хаалт хэрэглэх зааврын “хэрэгжилт маш өндөр байсан” гэж Чэн өгүүлсэн байна. Тэрээр үүнийг АНУ-тай харьцуулан өгүүлэхдээ, “халдвар бүр эрчимтэй өсөж байсан 6, 7 дугаар саруудад гэхэд л хүмүүс нь амны хаалт хэрэглэхээс татгалзсан хэвээр байв. Бүр 9 дүгээр сарын сүүлчээр Жое Байдены амны хаалт зүүснийг ерөнхийлөгч Трамп нь инээдтэй сул дорой байдал гэж шоолсоор байсан билээ” гэжээ. Чанга яригч суурилуулсан дронүүд нисэлдэж дүрэм зөрчсөн иргэдэд сануулга өгч байв. Төрийн мэдлийн Синхуа агентлаг нь дронтой холбоотой мэдээ цацаж байлаа. “Тийм ээ эгч ээ, энэ дрон таньтай яриад байна” гэхчлэн нэгэн нисдэг төхөөрөмж Өвөр Монголд гайхсан нэгэн эмэгтэйтэй ярьж байв. “Та амны хаалтгүй гадуур яваад байж болохгүй. Гэртээ харь, гараа сайн угаахаа мартав аа” гэхчлэн зааварчилж байгаа бичлэг цацагдсан. Тэгвэл Их Британид тус улс хорио цээрийн дэглэм тогтоохоос ердөө 10 хоногийн өмнө буюу 3 дугаар сарын дундуур 150 000 хүнд морин уралдаанд оролцох зөвшөөрөл өгч байв. 8 дугаар сард 460 000 америкчууд Өмнөд Дакотагийн Стургист мотоциклийн уралдаан үзэхээр цуглацгааж байсан юм.

2020 оны 2 дугаар сарын 5-нд Уханьд гурван түр (Fangcang) эмнэлэг нээсэн. Цөөн хэдэн долоо хоногийн дараа гэхэд л 13 өөр ийм эмнэлгийг нээж ажиллуулав. Стадион, үзэсгэлэнгийн төв гэх зэрэг нийтийн үйлчилгээний өөр бусад газруудыг ашиглан эмнэлгүүдийг нээж, КОВИД-19 өвчний хөнгөн шинж тэмдэгтэй хүмүүсийг тусгаарлан эмчилж байв. Мөн өвчний ноцтой шинж тэмдэгтэй хүмүүсийг маш

хурдан нийтийн эмнэлэгт шилжүүлж байжээ. Түр байгуулсан эмнэлгийн сүлжээ нь 13 000 ортой тул КОВИД-19-ийн өвчтөнүүд нь гэртээ тусгаарлагдахгүй, ингэснээр тэдний гэр бүлийнхэн халдвар авах эрсдлийг бууруулж байсан байна. Ингээд 2020 оны 3 дугаар сарын 10-ны байдлаар түр эмнэлгийн хэрэгцээ шаардлагагүй болжээ. Энэ үеэс Хятадын хариу арга хэмжээний анхаарал дотоод тархварыг хянахаас гадаад орнуудаас импортлогдон орж ирэх вирусийн тохиолдолоос урьдчилан сэргийлэх рүү шилжив. Ийнхүү тус улсад зорчин ирэгсэд шинжилгээ өгч тусгаарлагддаг болов.

Чэний хамтран зохион байгуулсан загварчилсан тооцооллын судалгаагаар бол Хятад улсын 1 дүгээр сарын 29-нөөс 2 дугаар сарын 29-нийг хүртэлх нийтийн эрүүл мэндийн талаарх энэхүү арга хэмжээний үр дүнд 1,4 сая халдвар ба 56 000 үхлийн тохиолдлоос тус тус урьдчилан сэргийлж чадсан байна. Гэсэн хэдий ч Хятадын цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бүх нийтэд нэгэн адил даган баримтлах албагүй юм. Лондон Импераал Коллежийн Хан Фу: “улс орон бүр өөрийн эрүүл мэндийн систем ба эпидемик эргэлттэй, нэг оронд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нөгөө бусдад тийм ч амархан хуулбарлагдан хэрэглэгдэх боломжгүй байж болох юм” гэж хэлжээ. “Бусад хүчин зүйлсийн хувьд засгийн газрын секторууд ба иргэний хууль журмыг дагаж мөрдөх хоёрын хоорондох хамтын ажиллагаа нь хариу арга хэмжээ үр дүнтэй байхад бас ихээхэн нөлөөлдөг”. Бас тухайн орон бүрийн иргэний эрх чөлөөний тухай ойлголт концепцоос маш их шалтгаална.

“Хятадад хүн амын нэг хэсэг нь амьсгалын замын халдварыг ноцтой хэмээн үзэж байхад нөгөө хэсэг нь эмнэлзүйн бус интервенц хэрэгжүүлэхийг хүсэж буй. Харин Засгийн газар нь хүний эрх чөлөөг ихэнх барууны орнуудад хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнээс хавьгүй ихээр хязгаарлаж чадах тийм л улс” гэж Полэнд нэмж өгүүлэв. “Илүү агуу сайн сайхныг эрхэмлэх нь соёлд нь гүн гүнзгий шингэсэн байдаг; Хятадад АНУ-ын хүн ардын зан чанар болсон хэт өндөр индивидуализм огт байхгүй нь коронавирустай тэмцэх арга хэмжээг эсэргүүцэх ихэнх хүчин зүйлээс тэднийг ангижруулж байгаа хэрэг.” Энэчлэн Полэнд хятадууд өвчнийг хянах нь шинжлэх ухааны асуудал гэдэг ойлголтыг хүлээн зөвшөөрдөг болохыг тэмдэглэжээ. Энэ талаар тэрээр хэлэхдээ: “АНУ дахь КОВИД-19-тэй тэмцэх ажлыг нурааж буй вакцины эсрэг, шинжлэх ухааны эсрэг хөдөлгөөн шиг зүйлс Хятадад байхгүй” гэжээ.

8 дугаар сард Ухань хот нь маш том хэмжээний усан сангийн үдэшлэг зохион байгуулсан юм. Энэ талаар зарим гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр шүүмжилж байв. Гэтэл төрийн мэдлийн Global Times нь үүнийг огтхон ч тоосонгүй. Тиймээс энэхүү арга хэмжээг “вирусээс урьдчилан сэргийлэх хатуу арга хэмжээ авч тэмцсэн орнууд хариу төлбөрөө авч байгаагийн жишээ” болж байна гэж тайлбарлаж байлаа. Тус сонинд өнгөрөгч 4 дүгээр сард цар тахлын улмаас дампуурах болов уу гэж айж байсан орон нутгийн нэгэн иргэний яриаг иш татан бичсэн байна. Тэрээр: “Тэр үед жуулчдын талаар дурдаад ч хэрэггүй, бүр орон нутгийнхан ч тийм олон биш байлаа. Гэтэл одоо хот маань бүрэн сэргэхийн хэрээр миний бизнес цэцэглэж байна” гэжээ<sup>126</sup>.

<sup>126</sup> Published Online October 8, 2020 [https://doi.org/10.1016/S1473-3099\(20\)30800-8](https://doi.org/10.1016/S1473-3099(20)30800-8)

This online publication has been corrected. The corrected version first appeared at [thelancet.com/infection](https://www.thelancet.com/infection) on October 22, 2020

**КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ  
БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ДЭЛХИЙН БУСАД ОРНУУДАД  
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУРШЛАГА**

(2020 оны 11-р сарын 30-ны байдлаар)

*О.Билгүүтэй, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа,  
О.Нарантуяа, Г.Уянга, С.Золжаргал,  
Б.Батцэцэг, Б.Долгормаа*

**АГУУЛГА**

**УДИРТГАЛ**

**СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ТОЙМ**

Татвар төлөгчдийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

**СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

Нэг. Улс орнуудын цар тахлын тархалтыг хяналтанд авах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Хоёр. Улс орнуудын эдийн засгийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Гурав. Улс орнуудын нийгмийн хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Дөрөв. Улс орнуудын КОВИД-19-ийн эсрэг хариу арга хэмжээний эрх зүйн орчин

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

## УДИРТГАЛ

Энэхүү судалгаанд КОВИД-19 цар тахлын онцгой нөхцөл байдлын үед халдварын тархалтыг хяналтанд авах, хорио цээрийн дэглэмийн улмаас эдийн засаг, нийгэмд учирч буй хүндрэл бэрхшээлүүдийг даван туулах, хүн амын амьжиргааг дэмжих хариу арга хэмжээний хүрээнд дэлхийн улс орнуудад ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаарх туршлагыг тоймлон харуулахыг зорилоо.

### **Судалгааны хамрах хүрээ**

Судалгаанд олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудаас улс орнуудын туршлагыг нэгтгэн гаргасан КОВИД-19-ийн нөлөөллийг сааруулах хариу арга хэмжээний тайлан мэдээлэл, холбогдох хууль эрх зүйн акт, дүн шинжилгээний материал, зөвлөмжүүдийг ашиглав.<sup>127</sup> Мэдээллийг харьцуулан судалсны дүнд КОВИД-19 цар тахал өргөн хүрээнд, хурдацтай тархсан боловч тархалтыг хяналтандаа авч, үүсч буй нөхцөл байдалд оновчтой хариу арга хэмжээ авч чадсан гэж үзэн Хятад, Өмнөд Солонгос, Япон, Сингапур, Тайвань, Вьетнам, Шинэ Зеланд, Нидерланд, Эстони, Словени, Норвеги зэрэг Ази, Европын зарим орнуудыг сонгон авч хамруулав.

Цар тахлын идэвхтэй дэгдэлтийн энэ цаг үед дэлхийн улс орнууд КОВИД-19 цар тахлын дэгдэлт болон хариу арга хэмжээний талаарх мэдээллийг нэг дороос авах, харьцуулан судалж нийтлэг арга хэмжээний цар хүрээг тодорхойлох, дүн шинжилгээ хийх ажлууд олон улсын хэмжээнд хийгдэж байгаа бөгөөд энэ хүрээнд ОУВС, ЭЗХАХБ, ДЭМБ болон бүс нутгийн байгууллагууд ихээхэн үүрэгтэй байгаа ба дэлхий нийтээр КОВИД-19-ийн хор нөлөөг хохирол багатай даван туулах боломжуудыг эрэлхийлж байна.

### **Судалгааны үр дүнгийн тойм**

Судалгаанд авагдсан орон тус бүрийн мэдээллийг нэгтгэн дүгнэж үзвэл, дэлхийн улс орнууд цар тахлын эсрэг хариу арга хэмжээний хүрээнд төсвөөс ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулж, цар тахлын дэгдэлтийг хяналтанд авах, нийгэм-эдийн засагт үүсч буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх, ард түмний амьжиргааг дэмжихэд чиглэсэн арга хэмжээний санхүүжилтийг хийж, зорилтот болон олон талт төсөл хөтөлбөрүүдийг эрчимтэй хэрэгжүүлж байгаа нь харагдаж байна. Судалгааны үр дүнг дараах байдлаар багцлан гаргалаа.

**Цар тахлын тархалтыг зогсоох, хяналтанд авах арга хэмжээний тухайд**, улс орнууд ихэвчлэн хөл хорио тогтоох, хилийн хэсэгчилсэн болон бүрэн хязгаарлалт хийх, амны хаалт зүүх, хүн хоорондын зай барих, халдвар хамгааллын дэглэм сахих, хорио цээрийн дэглэм тогтоох, өвчлөлийг илрүүлэх болон хянах зайн төхөөрөмж ашиглах зэрэг арга хэмжээнүүдийг нийтлэг байдлаар авч хэрэгжүүлж байна. Өвчний дэгдэлт, тархалтын байдлаас хамааран хатуу хөл хорио тогтоох, эсхүл тодорхой хяналттайгаар хэвийн амьдралын горимыг дагаж мөрдөх стратеги улс орон бүрт харилцан адилгүй байна. Хатуу хөл хорио тогтоох уу, хөл хорионы дэглэмийг сулруулах уу гэдэг бодлогын шийдвэр нь тухайн улс орон дахь халдварын тархалтын байдал, нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо, эрүүл мэндийн салбарын хүчин чадлаас гадна иргэдийн өөрсдийнх нь санаа бодол, хүлээн зөвшөөрөх байдлаас шалтгаалж байна, иймд хөл хорионы дэглэмийг сулруулах шийдвэр гаргахдаа засгийн газрууд дээрх 4 хүчин зүйлийн нөлөөлөл

<sup>127</sup> <https://www.oecd.org/tax/covid-19-tax-policy-and-other-measures.xlsm>, болон <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>



болон эрсдэлийг үнэлж, тодорхой нөхцөл бүрдүүлэх шаардлагатай гэж хөл хорионы дэглэмийг сулруулсан орнуудын туршлага, сургамжид дүн шинжилгээ хийсэн олон улсын шинжээчдийн баг үзсэн байдаг.<sup>128</sup> Энэ хүрээнд судалгаанд авагдсан орнуудын нөхцөл байдал ямар байгаа, ямар арга хэмжээ авсныг тоймлон дурьдвал:

- Халдварын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш хатуу хөл хорио тогтоож байгаад мөн хоригоо сулруулсны дараагаар халдварын тоо огцом болон аажмаар нэмэгдсэн тул хориогийг бүхэлд нь болоод хэсэгчлэн сэргээж, хязгаарлалтын зарим арга хэмжээ авч байгаа, эдийн засаг-нийгмийн амьдрал нь дотооддоо хэвийн үргэлжлэхэд төвөгтэй байгаа орнууд (Нидерланд, Словени, Норвег)
- Халдварын анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш бэлэн байдлын маш өндөр зэрэгт шилжиж хатуу хязгаарлалт тогтоосон бөгөөд хилийн болон хорио цээрийн шаардлагыг хэвээр хадгалж, бүсчилсэн байдлаар хэсэгчилсэн хориг тавих, техник-зохион байгуулалтын ухаалаг шийдэл ашиглах зэргээр тархалтыг хяналтандаа авч, хязгаарлалтын (alert level) түвшинг өндөрөөс нам зэрэглэлд аажмаар буулгах, өсгөх уян хатан арга хэмжээ авч байгаа, эдийн засаг-нийгмийн амьдрал нь дотооддоо бараг хэвийн үргэлжилж байгаа орнууд (Шинэ зеланд-NZ КОВИД Tracer app, БНСУ, Вьетнам Bluezone app, БНХАУ, Япон, Тайвань)

**Эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулах хариу арга хэмжээний тухайд**, цар тахлын улмаас улс орны эдийн засагт учирч буй хор хөнөөлийг багасгах, эрсдэлд өртөх магадлалтай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон эдийн засагт онцгой ач холбогдол бүхий стратегийн зарим салбаруудад дэмжлэг үзүүлэх, иргэдийн цалин хөлс, орлогын баталгаатай байдлыг хангах, болзошгүй хямралаас сэргийлэх үүднээс дэлхийн улс орнууд КОВИД-19 цар тахлын үеийн төсөв, татвар, мөнгө-зээлийн тусгайлсан бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж, ДНБ-ний тодорхой хувьтай (19,5% хүртэл) тэнцэхүйц хэмжээний хөрөнгө мөнгийг КОВИД-19 цар тахлын нөлөөг багасгах, эдийн засгийг эрчимжүүлэх зорилтот хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтэнд зориулан төсвөөс гаргах, нэмэлт төсөв батлах зэргээр ажиллаж байна. Эдгээрээс зарим нийтлэг арга хэмжээнүүдийг багцлан дурьдвал:

- жижиг дунд аж ахуйн нэгжүүд, иноваци-гарааны бизнес эрхлэгчид болон зорилтот салбаруудыг дэмжих санхүүжилтийн багц хөтөлбөр хэрэгжүүлэх (ЖДҮ-ийг дэмжих сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зээлийн хүү бууруулах, шалгуур үзүүлэлтийг зөөлрүүлэх, батлан даалт олгох, тогтмол зардлын санхүүжилтэнд дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн салбарын чадавхыг бэхжүүлэх, аялал жуулчлал, зам тээвэр, дэд бүтэц, хүнс, хөдөө аж ахуй, боловсрол, орон сууц, ачаа тээвэр, боловсруулах болон экспортын үйлдвэрлэл зэрэг чухал салбаруудад зориулсан санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэт)
- татвар төлөгчдийг дэмжих татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, татвар төлөх хугацааг сунгах, компаниудын мөнгөн урсгалыг сайжруулах зэрэг татварын багц арга хэмжээ авч хэрэгжүүлэх (татвар төлөлтийг хойшлуулах, торгууль ногдуулахгүй байх, хүлээгдэж байгаа болон

<sup>128</sup> “КОВИД-19 цар тахлын хорио цээрийн дэглэмийг сулруулсанаас үүдэн гарсан сургамж: Ази Номхон Далайн болон Европын бүсийн орнуудын туршлагад хийсэн дүн шинжилгээ”, ПСХ, 2020.10.23



- буурсан орлогын түвшинг харгалзан татвар тооцох, НӨАТ болон түрээсийн татварын хөнгөлөлт үзүүлэх гэх мэт)
- ажлын байрыг хадгалах, хөдөлмөрийн нөхцөлийг хангах зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих багц арга хэмжээ авах (орлого нь тодорхой хэмжээгээр буурсан, КОВИД-19 цар тахлын нөлөөнд өртсөн, орон тоогоо цомхотгохоос аргагүй байдалд орсон ААН, байгууллагуудад цалингийн болон ажилгүйдлийн нөхөн олговор олгох, ажлын байр нэмэгдүүлсэнд урамшил олгох, ажил олгогч болон хөдөлмөр эрхлэгчдэд чиглэсэн мөнгөн урамшуулал олгох хөтөлбөр хэрэгжүүлэх, цар тахлаас үүдэн ажилгүй болсон, цомхотголд орсон, 3-аас дээш сар сул зогссон иргэдэд буцалтгүй мөнгөн тусламж олгох гэх мэт )
  - Хөнгөлөлттэй зээл олгох, өр төлбөрийг хөнгөлөх, хугацаа хойшлуулах, зээлийн баталгаа гаргах зэрэг мөнгө-зээлийн багц арга хэмжээ авах (Банкны заавал байлгах нөөцийн шаардлагыг бууруулах, зээл, хүүгийн төлбөрийн хугацааг хойшлуулах, зарим салбарын эргэлтийн хөрөнгийг түр хугацаагаар санхүүжүүлэх, моргежийн зээл, хүүг царцаах, ажилгүйдэл ихтэй, хил орчмын бүс нутгийн компаниудад бичил зээл олгох, хүүгүй, барьцаагүй зээл олгох, орон сууц ашиглалтын төлбөрийг хойшлуулах гэх мэт)
  - Иргэдийн цалин, орлогыг бууруулахгүй байх, нөхөн олговор, тэтгэмж олгох зэрэг иргэдийн амьжиргааг дэмжсэн нийгмийн хамгааллын багц хөтөлбөр хэрэгжүүлэх (цалин, тэтгэмжийн нөхөн олговор олгох, НДШ-ээс чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээг сунгах, хямралын үеийн нэмэгдэл олгох, халдвар авсан хүнд цалин, нөхөн олговор олгох, онцгой нөхцөлд ажиллаж байгаа хүмүүст нэмэлт цалин, урамшуулал олгох, зайнаас ажиллуулах, ажлын цагийг уян хатан зохион байгуулах, групп, тэтгэвэр, өвчний чөлөө олгох, ядуу буурай айл өрх, эмзэг бүлгийн иргэд, цалингүй чөлөө авсан, хөдөлмөрийн гэрээгүйгээр ажилласан, ажлын цаг нь богиноссон, бага орлоготой, цар тахлаар өвчилсөн өрхийн бизнес эрхлэгчид зэрэг зорилтот бүлгийн хүмүүс, КОВИД-19 цар тахлын нөлөөнд өртсөн иргэдэд мөнгөн тусламж үзүүлэх гэх мэт )

**Нийгмийн хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухайд,** цар тахлын нөхцөл байдлаас үүдсэн ажилгүйдэл, ажиллах хүчний ажлын нөхцөл байдал, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, ажил олгогч ба ажилтны нийгмийн харилцаа, ажил эрхлэлтийг дэмжих чиглэлээр үе шаттай зорилтот хөтөлбөрүүд хэрэгжүүлж, ажилтнуудын ажлын байрыг хадгалах, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох, ажлын байранд шаардагдах ур чадвар олгох сургалт зохион байгуулах, зөвлөгөө мэдээллээр хангах, иргэдийнхээ цалин, орлогыг бууруулахгүй байх арга хэмжээнүүдийг нийтлэг авч хэрэгжүүлж байна. Эдгээрээс зарим чухал арга хэмжээнүүдийг тоймлон дурьдвал:

- Ажлын байр орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр (ажлын байрыг хадгалах шинэ нөхцөл байдалд зохицон ажиллахад туслах хөтөлбөр хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт хийх, зээл, батлан даалт гаргах, нэмэлт сургалт зохион байгуулах, эмзэг бүлгийн иргэдийг сургах, одоо байгаа ур чадварыг сайжруулах г.м)
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр (зайнаас ажиллуулах, ажлын цагийг уян хатан зохион байгуулах, цалинтай чөлөө, өвчний чөлөөний хугацааг сунгах, ажилгүйдлийн нөхөн олговор олгох, эмч, сувилагч гэх мэтийн хүнд нөхцөлд ажиллаж байгаа хүмүүст цалин

нэмэгдүүлэх, орлого багатай, олон ам бүлтэй гэр бүл, тэтгэвэр авагчдад 1 удаагийн буцалтгүй тусламж олгох, халдвар авсан эмчлүүлж байгаа хүмүүст цалингийн 90% хүртэл олгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх г.м)

- Эмзэг бүлгийг хамгаалах чиглэлээр (эмзэг бүлгийн иргэдийг сургах, ур чадварыг сайжруулах, амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх, бодит түвшнээс дордуулахгүй байх бодлого барих, амьжиргааны болон эрүүл мэндийн тэтгэмж олгох, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах г.м)
- Хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр (гэр бүлийн хүчирхийллээс урьчилан сэргийлэх болон хохирсон тохиолдолд мэдээлэх, зөвлөгөө өгөх төвүүдийг хүртээмжтэй байршуулан ажиллуулах, сэтгэлзүйн болон бусад зөвлөгөө тусламжийн цахим хуудас, утсыг ажиллуулах, тэдэнд нөхцөл байдлыг даван туулах аливаа сургалт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах г.м)
- Суралцагчийг дэмжих чиглэлээр (шинэ нөхцөл байдлын улмаас орлого буурсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, амьжиргааны тэтгэлэг олгох г.м)

**Татвар төлөгчдийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухайд,** Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (Organisation for Economic Co-operation and Development OECD) гаргасан КОВИД-19 цар тахлын эсрэг улс орнуудын хэрэгжүүлсэн татварын бодлогын арга хэмжээг хүснэгтээр түүвэрлэн гаргав.<sup>129</sup> Энэхүү мэдээлэлд татварын бодлогын арга хэмжээнүүдээс гадна тэтгэмж, тэтгэмжийн эрхийн өөрчлөлт (Changes in benefits and benefits entitlements) зэрэг арга хэмжээнүүдийг хамруулан жагсаав. Мөн КОВИД-19 хямралын үеийн татварын бодлоготой холбоотой татварыг хойшлуулах, татвараас чөлөөлөх, эсвэл татварын буцаан олголтод өөрчлөлт оруулахтай (deferral or waiving of taxes or of changes to tax refunds) холбоотой арга хэмжээг оруулсан болно.

Доорх хүснэгтэд Heat map буюу хямралын үеийн шуурхай арга хэмжээг улс бүрээр оруулсан ба үүнд эдийн засгийг сэргээх арга хэмжээ багтаагүй болно. Мөн КОВИД-19 цар тахлын эсрэг улс орнуудын хэрэгжүүлсэн татварын арга хэмжээг ангилсан тойм хэсгийг оруулсан.

*OECD-ээс гаргасан энэхүү мэдээнд зээлийн мэдүүлгийн хугацааг сунгах, хугацаа хэтрүүлсэн тохиолдолд ногдуулах торгуулийн өөрчлөлт, татвар төлөгчдөд үйлчлэх арга хэмжээ, өр зэрэг татварын албаны арга хэмжээ (tax administration measures) оруулаагүй болно. Түүнчлэн төсвийн нэгтгэх стратегийн (fiscal consolidation strategies) дагуу хямралын эсрэг шуурхай хэрэгжүүлсэн арга хэмжээг эдийн засгийг сэргээх арга хэмжээнээс ялган харуулсан.*

<sup>129</sup> <https://www.uschamber.com/international-affairs-division/covid-dashboard>

**КОВИД-19 цар тахлын эсрэг Улс орнуудын авч буй татварын арга хэмжээ**

**Тайлбар:** (VAT)-Value added tax, (CIT)-Corporate Income Tax (PIT)-Principal, interest and taxes, (SSC)-Social security contributions

Улс	Татварын төрөл	Шуурхай арга хэмжээний төрөл	Шуурхай арга хэмжээн нэмэлт мэдээлэл	Тайлбар	Тухайн арга хэмжээг зарласан өдөр
<b>Хятад</b>	Нэмэгдсэн өртгийн албан татвар (VAT)  Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (CIT) Үндсэн зээл, хүүгийн татвар (PIT),	Татварын бодлого - Хэрэглээг дэмжих	Татвараас чөлөөлөх	Эмнэлгийн үйлчилгээ, нийтийн хоол, байрны төлбөр, үсчин, угаалга гэх мэт "хувийн үйлчилгээ", мөн нийтийн тээврийн хэрэгсэл, хувь хүний өдөр тутмын үйлчилгээ"-г НӨАТ-аас чөлөөлсөн. (ердийн үед 6% -иар тооцдог). Тодорхой салбарууд (тээвэр, нийтийн хоол, байр, аялал жуулчлал) -ын хямралд өртсөн бизнес эрхлэгчдэд 2020 онд учирсан алдагдлыг буцаан олгоно. КОВИД-19-тэй тэмцэх чиглэлээр ажилладаг эмнэлгийн ажилтнуудад олгох урамшуулал, үндсэн зээл хүүгээс чөлөөлөх.	3/23/2020
<b>Эстони</b>	Бусад	Уян хатан мөнгөний шилжүүлэг More generous cash transfers	Ажил олгогчдод өгсөн цалингийн зардлын татаас (тэтгэмж) Wage subsidy paid to the employers	КОВИД-19 цар тахлын үед ажилгүйдлийн даатгалын сангаас ажилчдын цалингийн 70 хувь хүртэлх нөхөн олговрыг төлсөн байна. Энэ нөхөн олговрыг санхүүгийн хүндрэлтэй, цалин тавьж чадахгүй ажилчдаа халах эрсдэлтэй байгаа бүх компани авах боломжтой. Тухайн компани нь 2020 оны 3-5-р сар хүртэлх хоёр сарын хугацаанд энэ арга хэмжээнд хамрагдах боломжтой; Хамгийн ихдээ нэг ажилтанд 1,000 евро өгөх; Уг тэтгэмжийг журмын дагуу өмнөх 12 сарын хугацаанд ажилтны дундаж цалингийн 70 хувьтай тэнцэх хэмжээгээр олгох ба нэмээд тухайн компани ажилтандаа хамгийн багадаа 150 евро төлдөг байна. <sup>130</sup>	3/19/2020

<sup>130</sup> [www.tootukassa.ee/eng/content/temporary-subsidy-program](http://www.tootukassa.ee/eng/content/temporary-subsidy-program)

<b>Норвеги</b>	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (CIT)	Бизнесийн бэлэн мөнгөний урсгалыг сайжруулах арга хэмжээ	Сайжруулсан алдагдлыг нөхөх заалт	Аж ахуйн нэгжийн татварын журамд өөрчлөлт оруулж, алдагдалтай ажиллаж байгаа компаниуд 2020 оны алдагдлаа 2018, 2019 онд ногдуулсан татварын илүүдлээс (алдагдлыг нөхөх нөхцөл) дахин хуваарилсан.	3/13/2020
<b>Словени</b>	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (CIT), үндсэн зээл, хүүгийн татвар (PIT),	Бизнесийн бэлэн мөнгөний урсгалыг сайжруулах арга хэмжээ	Татварын мэдүүлгийн хугацааг сунгах, татвар төлөхийг хойшлуулах	(1) Үйл ажиллагааны орлогоос ногдох хувь хүний орлогын албан татварын урьдчилгаа төлбөрийн татварын тайланг өгөх хугацааг хойшлуулах, ААНОАТ-ын тайланг 2 сараар хойшлуулах; (2) Коронавирусийн халдварын улмаас орлого алдсантай холбогдуулан татварын урьдчилгаа төлбөр, суутгал 2 жил хүртэлх хугацаанд хүү тооцоггүйгээр хойшлуулах; (3) Коронавирусийн тархалтын улмаас орлого алдсантай холбоотой татварын төлбөрийг 2 жил хүртэл хойшлуулах.	3/17/2020
<b>Япон</b>	Олон талт татвар Multiple taxes	Татварын бодлогын бусад арга хэмжээ	Татварын мэдүүлгийн хугацааг сунгах, татвар төлөхийг хойшлуулах	3-р сарын дунд үеэс 4-р сарын дунд хүртэл хувь хүний орлогын албан татвар, бэлэг дурсгалын болон хэрэглээний татвар (H&AT) -ын мэдүүлэг, төлбөр төлөх хугацааг сунгах; КОВИД-19-цар тахлаас үүдэлтэй хямралд орсон, аж ахуйн нэгжийн татварын төлбөрийг хойшлуулах.	27/02/2020  09/03/2020
<b>Шинэ Зеланд</b>	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (CIT),	Татварын бодлого - хөрөнгө оруулалтыг дэмжих	Татварын хорогдлын заалтыг түргэсгэх буюу сайжруулах (Accelerate or enhanced tax depreciation provisions)	Арилжааны болон аж үйлдвэрийн барилга байгууламж, түүний дотор зочид буудал, зочид буудлын элэгдлийн суутгалыг 2% -иар бууруулсан; 2020 оны 2-р сарын 14-ний өдрөөс татвараа хожимдуулсан төлбөрт хүүг хасах; КОВИД-19 цар тахлын нөлөөлөлд өртсөн бизнес эрхлэгчдийн татварын төлбөрийг хойшлуулах.	3/17/2020

<b>Нидерланд</b>	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (CIT), үндсэн зээл, хүүгийн татвар (PIT),	Бизнесийн бэлэн мөнгөний урсгалыг сайжруулах арга хэмжээ	Татвар төлөх хугацааг хойшлуулах	КОВИД-19 цар тахлын нөлөөлөлд өртсөн бизнес эрхлэгчдэд ХХОАТ-ын төлбөрийг хойшлуулах. Бизнес эрхлэгчид хямралд өртсөн дүгнэлтийг өөрсдөө гаргах КОВИД-19 цар тахлын нөлөөлөлд өртсөн бизнес эрхлэгчдэд үндсэн зээл, хүү, татварын төлбөрийг хойшлуулах. Бизнес эрхлэгчид хямралд өртсөн дүгнэлтийг өөрсдөө гаргах	3/23/2020
<b>Испани</b>	Нийгмийн даатгалын шимтгэл (SSC)  Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (CIT),  Нэмэгдсэн өртгийн албан татвар (VAT)	Татварын бодлого - хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Татвараас чөлөөлөх	КОВИД-19 цар тахалд нэрвэгдсэн ажил олгогчид: Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөх, ажил олгогч ажилчдынхаа ажлын байрыг баталгаажуулсан тохиолдолд: ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлээс 75% бууруулах; 50-аас доош ажилчинтай компаниудад 100% чөлөөлөх. 6 сая еврогоос хэтрэхгүй эргэлтийн хөрөнгөтэй аж ахуйн нэгжид 5-р сарын 30 хүртэл Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлбөрийг хойшлуулах (6 сар, эхний 3 сард хүүгүй). 6 сая еврогоос хэтрэхгүй эргэлтэй хувь хүн, аж ахуйн нэгжид ХХОАТ-ын суутгалыг 5-р сарын 30 хүртэл хойшлуулах (6 сар, эхний 3 сард хүүгүй). 6 сая еврогоос хэтрэхгүй эргэлтэй хувь хүн, аж ахуйн нэгжийн НӨАТ-ын төлбөрийг 5-р сарын 30 хүртэл хойшлуулах (6 сар, эхний 3 сард хүүгүй).	3/17/2020
<b>Сингапур</b>	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (CIT),	Татварын бодлого - хөрөнгө оруулалтыг дэмжих	Татварын хорогдлын заалтыг түргэсгэх буюу сайжруулах	Аж ахуйн нэгжүүдэд үйлдвэр, тоног төхөөрөмжид оруулсан хөрөнгө оруулалтанд хөнгөлөлт өгөх; Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 25%-р хөнгөлөх.	2/18/2020

<b>Солонгос</b>	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (CIT), Үндсэн зээл, хүүгийн татвар (PIT), Нэмэгдсэн өртгийн албан татвар (VAT)	Бизнесийн бэлэн мөнгөний урсгалыг сайжруулах арга хэмжээ	ААНОАТ-ын хэмжээг бууруулах	17/03/2020
<b>Герман</b>	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (CIT), Үндсэн зээл, хүүгийн татвар (PIT), Нэмэгдсэн өртгийн албан татвар (VAT)	Бизнесийн бэлэн мөнгөний урсгалыг сайжруулах арга хэмжээ	Татвар төлөх хугацааг хойшлуулах	6/3/2020

Халдвартай бүсэд орших жижиг, дунд бизнес эрхлэгчдэд татварын тусгай хөнгөлөлтийг хоёр дахин нэмэгдүүлсэн. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд татварын тусгай хөнгөлөлтийн дээд хэмжээг хоёр дахин (15%-30%) нэмэгдүүлсэн. Энэ нь орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн албан татварыг жижиг бизнес эрхлэгчдийн 60%, дунд бизнес эрхлэгчдийн 30%-иар бууруулжээ. Үүнд баар, ресторан үл хөдлөх хөрөнгийн түрээсийн бизнес гэх мэт бүх салбарууд хамаатай.

Үндсэн зээл, хүү, татвар (PIT), Түрээслэгч нь сайн дураараа түрээсийн төлбөрийг бууруулсан тохиолдолд 2020 оны эхний хагаст түрээсийн төлбөрийн 50%-тай тэнцэх хэмжээний татварыг орлогын албан татвар эсвэл корпорацийн албан татвараас суутгана. Нэмэгдсэн өртгийн албан татвар (VAT) жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан НӨАТ-ын журамд эргэлтийн босгыг 2021 оныг дуустал 30 сая воноос 80 сая вон болгон өсгөсөн. Үүнээс гадна 48 сая воноос доош эргэлттэй бизнес эрхлэгчдийг НӨАТ-аас чөлөөлнө.

КОВИД-19-ийн нөлөөлөлд өртсөн бизнес эрхлэгчдэд ХХОАТ-ын төлбөрийг хойшлуулах. Бизнес эрхлэгчид хямралд өртсөн дүгнэлтийг өөрсдөө гаргах

КОВИД-19-ийн нөлөөлөлд өртсөн бизнес эрхлэгчдэд Үндсэн зээл, хүүгийн татварыг хойшлуулах. Бизнес эрхлэгчид хямралд өртсөн дүгнэлтийг өөрсдөө гаргах

Долдугаар сарын 1-нээс оны эцэс хүртэл НӨАТ-ын стандарт хүүг 19 хувиас 16 хувь болгон бууруулах. Хоол хүнс, эм тариа, сонин гэх мэт зүйлд НӨАТ-ыг таван хувь болгон бууруулсан.



КОВИД-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн шуурхай арга хэмжээнүүд

(Heat map IMMEDIATE CRISIS RESPONSE MEASURES)

Улс	Үндсэн зээл, хүүгийн татвар (PIT)	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (CIT)	Нийгмийн даатгалын шимтгэл (SSCs)	Хөрөнгийн татвар (Property taxes)	Нэмэгдсэн өртгийн албан татвар (VAT)	Бусад хэрэглээний татвар (Other consumption tax)	Бусад (Other)
Хятад							
Эстони							
Норвег							
Словени							
Япон							
Шинэ Зеланд							
Нидерланд							
Испани							
Сингапур							
Солонгос							
Герман							

Тайлбар: Тухайн орны КОВИД-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн шуурхай арга хэмжээг ногоон өнгөөр тэмдэглэсэн.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### НЭГ. УЛС ОРНУУДЫН ЦАР ТАХЛЫН ТАРХАЛТЫГ ХЯНАЛТАНД АВАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

#### НИДЕРЛАНД /Голланд/ УЛС

Голланд улсад анхны тохиолдол 2 дугаар сарын 28-д батлагдсан. Нийт тохиолдол 518.910, нас баралт-9349, шинээр нэмэгдсэн-5585 байна. (11 сарын 30-ны байдлаар)

Эрх баригчид коронавирусийн тархалтыг хязгаарлах зорилгоор сургууль, нийтийн хоолны аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хааж, аль болох олон нийтийн харилцаанаас татгалзаж, гэрээсээ ажиллахыг зөвлөж байсан.

5 дугаар сарын 11-ээс Засгийн газраас хатуу хөл хориог сулруулах арга хэмжээг аажмаар авч эхэлсэн. Тухайлбал, хүүхэд харах үйлчилгээ, бага, дунд сургуулиуд болон ихэнх бизнес эрхлэгчид (үүнд үсчин, ресторан, кафе болон соёлын байгууллагууд)-ийн үйл ажиллагааг нээсэн. Үүнээс гадна хаалттай талбайд 100-аас илүүгүй хүн цугларахыг зөвшөөрсөн бөгөөд кино театр, кафе, ресторанд орох хүний тоог хязгаарлаагүй бөгөөд Европын холбооноос бусад 14 орны аялагчдын зорчих эрхийг цуцалсан. Гэсэн хэдий ч халдварын тоо аажмаар нэмэгдсэн тул хязгаарлалт бүхий хэд хэдэн хориг арга хэмжээг дахин зарласан. Улсын хэмжээнд хэсэгчилсэн хоригийг 10 дугаар сарын 14-өөс 12 сарын дунд үе хүртэл сэргээж, дараах хязгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- бүх хүнсний болон ундааны цэгүүдийг хаах (зөвхөн авахыг зөвшөөрнө);
- жижиглэнгийн дэлгүүрүүд 20.00 цагт хаах;
- ихэнх олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглох;
- боломжтой бол гэрээсээ ажиллах;
- 20.00 цагаас хойш олон нийтийн газар согтууруулах ундаа, эм (soft drugs) хэрэглэхгүй байх;
- өөр өөр гэр бүлийн 4-өөс дээш хүн цугларахыг хязгаарласан.

11 сарын 4-өөс эхлэн халдварыг цаашид хязгаарлах зорилгоор хоёр долоо хоногийн турш нэмэлт хязгаарлалт тогтоосон. Үүнд: музей, кино театр, цэцэрлэгт хүрээлэнг хааж, цугларалтыг өөр өөр гэр бүлийн 2-оос илүүгүй хүн байхаар хязгаарлалт тогтоосон. Халдварын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан 1 дүгээр сарын дунд үе хүртэл гадаадад аялахгүй байхыг зөвлөж байна.

#### ШИНЭ ЗЕЛАНД УЛС

Тус улсад анхны тохиолдол 2 дугаар сарын 28-нд бүртгэгдсэн. Одоо нийт тохиолдол-2050, нас баралт-25, эмчлэгдсэн-1956, эмчлэгдэж байгаа-69 байна. (11 сарын 30-ны байдлаар)<sup>131</sup>

Вирус дотооддоо халдварласны дараа 3 сарын 25-д тус улс 4 дүгээр түвшний хязгаарлалт (Alert Level 4) руу шилжсэн. Эрх баригчид улсын хэмжээнд бэлэн байдал (state of emergency) зарлаж нэн шаардлагатай бус бизнесийн үйл ажиллагааг хааж, бүх арга хэмжээ, цугларалтыг цуцлаж, сургуулиудыг хаах зэрэг хүчтэй хязгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн. 3 сарын 19-ний өдөр бүх хилээ оршин суугчдаас бусад хүмүүст хаасны дараа буцаж ирсэн иргэдэд 4 сарын 10-аас хойш хоёр долоо хоногийн хугацаанд тусгаарлалтын дэглэм тогтоосон

<sup>131</sup> [https://www.worldometers.info/coronavirus/?utm\\_campaign=homeAdvegas1?](https://www.worldometers.info/coronavirus/?utm_campaign=homeAdvegas1?)

бөгөөд одоог хүртэл хил хаасан болон хорио цээрийн шаардлага хэвээрээ үйлчилж байна. Окландад дараах түвшний хязгаарлалтуудыг зарласан.

- 8 сарын 12-нд 3 дугаар түвшин
- 8 сарын 30-нд 2.5 дугаар түвшин
- 9 сарын 24-нд 2 дугаар түвшин
- 10 сарын 22-нд 1 дүгээр түвшний хязгаарлалтад шилжсэн.

Одоо нийгмийн амьдрал бараг хэвийн шахуу үргэлжилж байгаа бөгөөд олон нийтийн газар маск зүүхийг шаардахгүй байгаа ч маскаа тогтмол зүүхийг зөвлөж байна.

Тус улс КОВИД-19 цар тахлын халдварыг хянах зорилгоор ажиглагч төхөөрөмж программ (NZ COVID Tracer app)-ыг ашиглаж байна. 11 сарын 27-ны байдлаар 2,384,300 хүн бүртгүүлсэн байна. Тус программаар иргэд өөрийн явсан газар болон биеийн байдлын талаар мэдээллээ оруулж сүүлийн 2 долоо хоногийн мэдээллээ хянахад тусалдаг байдаг.

### **БНСУ**

Тус улсад КОВИД-19-ийн анхны батлагдсан тохиолдол 2020 оны 1-р сарын 20-нд бүртгэгдсэн. Одоо нийт тохиолдол-33.824, нас баралт-523, эмчлэгдсэн-27.542, эмчлэгдэж байгаа-5759 байна. (11 сарын 29-ны байдлаар)<sup>132</sup>

БНСУ нь КОВИД-19-ийн тархалтын үед хамгийн оновчтой түргэн шуурхай шийдвэр гаргасан орнуудын нэг бөгөөд өнөөдрийн байдлаар (2020.11.29) Өмнөд Солонгос улсад нийт 3.046.971 удаа шинжилгээ хийснээс (Tests Performed) КОВИД-19-ийн батлагдсан тохиолдол 33.824, тусгаарлалтаас гарсан иргэдийн тоо 27.542, тусгаарлалтад байгаа иргэдийн тоо 5759, нас барсан иргэдийн тоо 523 хүрээд байна.<sup>133</sup> БНСУ-ын Засгийн газар КОВИД-19 цар тахлын тархалтын эсрэг тогтвортой, урт хугацааны нийгэм болон эдийн засагт сөрөг нөлөөгүй, иргэдийн өдөр тутмын амьдралд саад учруулахгүй байх шийдвэрүүд гаргахыг зорилго болгосон байна.

БНСУ-д КОВИД-19-ийн батлагдсан тохиолдлын тоо хурдацтай өсч буй үед бүс нутгийн тархалтыг хязгаарлахын тулд Засгийн газраас олон хүн цуглардаг арга хэмжээ, уулзалтад оролцохгүй байх, гадагшаа гарахаас татгалзах, гэрээсээ ажиллахыг ард иргэддээ журам болгосон. 2020 оны 6 сарын 28-ны өдрөөс эхлэн олон янзын хориг тавих нэршлийг “Нийгмийн харилцаанаас зай барих” гэж нэгтгэн КОВИД-19 тахлын онцгой байдал болон хорио цээрийн арга хэмжээний эрчээс хамааран 1-3 үе шатад хуваан хэрэгжүүлсээр ирсэн.

2020 оны 11 сарын 1-ний өдөр Засгийн газраас КОВИД -19-ийн урт хугацааны туршид хорио цээрийн тогтолцоог бий болгох шаардлагатай гэсэн шийдвэрийн дагуу 3-5 үе шатад (1.5, 2.5 үе шатыг шинээр бий болгосон) хувааж нийгмийн харилцаанд зай барих төлөвлөгөөг зарласан бөгөөд Ерөнхий сайд Жон Сэг Юн “Нийгмийн харилцаанаас зай барих” 5 үе шаттай өөрчлөлтийг танилцуулсан. Энэ нь 11 сарын 7-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн ба үе шатыг дээшлүүлэх хэмжүүр нь улам хатуу чанд болж нийт үндэстний гэхээс илүүтэйгээр бүс нутаг бүрийг тусад нь авч үзэх болсон байна.

<sup>132</sup> [https://www.worldometers.info/coronavirus/?utm\\_campaign=homeAdvegas1?](https://www.worldometers.info/coronavirus/?utm_campaign=homeAdvegas1?)

<sup>133</sup> <http://ncov.mohw.go.kr/en>

**Нийгмийн харилцаанаас зай барих системийг өөрчлөн  
байгуулсан шат дараалал**

1-р үе шат	1.5-р үе шат	2-р үе шат	2.5-р үе шат	3-р үе шат
<b>Халдвараас урьдчилан сэргийлэх үе</b>	<b>Бүс нутгийн тархалтын үе шат</b>		<b>Улс нийтийн тархалтын үе шат</b>	
Нийгэм дэхь зай барилт	Бүс нутгийн тархалтын эхлэл	Бүс нутгийн тархалт түргэсэх, улсын хэмжээнд тархалт эхлэх	Улсын хэмжээнд бүрэн тархах	Улс даяар тархах

(Эх сурвалж: БНСУ-ын Эрүүл мэнд Халамжийн яам)

Нийгмийн харилцаанаас зай барих үе шатыг урьдчилан сэргийлэх (1-р үе шат), бүс нутгийн тархалтын үе шат (1.5, 2-р үе шат), улс нийтийн тархалтын үе шат (2.5, 3-р үе шат) гэж ерөнхийд нь хувааж, бүс нутгийн тархалтын үе шат болон улс даяарх тархалтын үе шатыг дотор нь 1.5 болон 2.5 гэсэн үе шатыг нэмэн нийт 5 үе шат болгон хуваасан байна. Нийгмийн харилцаанд зай барих үе шатыг дээшлүүлэх шалгуурыг бүс нутаг тус бүрээр хүнд байгаа өвчтнүүдийн орны хүрэлцээ болон долоо хоног тутмын тархалтын байдлыг харгалзан тогтоодог.<sup>134</sup>

Эрчимт эмчилгээний орны тоонд хүрэлцэхүйц батлагдсан тохиолдлын долоо хоногийн дундаж тоог гол үзүүлэлт болгодог бөгөөд халдварын нөхөн үржихүйн индекс гэх мэт бусад туслах үзүүлэлтийг хамтад нь авч үздэг байна.

### **ВЬЕТНАМ УЛС**

2020 оны 1 дүгээр сард КОВИД-19-ийн анхны тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнөөг хүртэл нийт 1341 тохиолдол бүртгэгдсэнээс 35 хүн нас барж, 127 хүн одоогийн байдлаар эмчлэгдэж байна.<sup>135</sup> 16000 гаруй хүн хорио цээрийн дэглэмд, үүнээс тодорхой тооны хүмүүс гэртээ тусгаарлалтанд байна. Тус улсад сүүлийн 78 хоногийн хугацаанд шинээр тохиолдол бүртгэгдээгүй байна.

Хүн ам олноор бөөгнөрсөн том хотуудад эрсдлээс хамгаалах, халдварын тохиолдлоос сэрэмжлэх гар утасны аппликейшнийг ашиглах боломжтой бөгөөд одоогоор нийт хүн амын 60% нь энэхүү аппликейшнийг суулгасан байна. Шинээр зохион бүтээгдсэн, халдвартай иргэдийн хавьтлуудыг тогтоох Bluezone аппликейшнийг 4 долоо хоногийн дотор 20 сая иргэн буюу хүн амын 20% суулгасан байна.

2020 оны эхний 9 сард ДНБ сүүлийн 20 жилийн хугацаанд хамгийн доод төвшин буюу 2.12%-д хүрч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд, ялангуяа тээвэр, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдэд хүндээр туссан байна.

2020-04-23-нд улс даяар тогтоосон онц байдлыг цуцалсан боловч Да Нанг болон Хой Ан мужуудад ахин гарсан тархалтын улмаас 7 дугаар сарын 28-нд эдгээр мужуудад дахин хөл хорио тогтоон, зай барих журмыг мөрдөж эхэлсэн байна.

Үүний дараа хэд хэдэн мужуудад мөн зай барих журмыг мөрдөж эхэлсэн байна. Да Нанг болон Хай Дуонг мужуудад 5 долоо хоногийн турш мөрдсөн дотоод аяллын

<sup>134</sup> Covid-19 Цар Тахлын Үед Бнсу-Ын Хариу Апра Хэмжээ Авсан Бодлого Б.Урангоо

<sup>135</sup> <https://www.worldometers.info/coronavirus/#countries>

хоригийг 9 дүгээр сарын 05-аас цуцалсан байна. Есдүгээр сарын сүүлээр зай барих хоригийг цуцалж, нэн яаралтай бус үйлчилгээний хоригийг мөн цуцалсан байна. Хүмүүсийн өдөр тутмын амьдралыг хэвийн горимд шилжүүлэх зорилгоор цар тахлын тархалтаас сэргийлэх шинэ удирдамжийг боловсруулан гаргасан байна. Олон улсын аялал жуулчлалын хориг өнөөг хүртэл хэвээр мөрдөгдөж байна. Гэвч Засгийн газраас 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн зарим мужуудад олон улсын худалдааны аяллыг тодорхой хязгаартайгаар зөвшөөрсөн ба богино хугацаагаар ирсэн гадаадын иргэдийг 14 хоногийн карантинд байлгах журам тогтоосон байна. Засгийн газраас КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх бодлогыг чангатгаж, 2020-11-15-ны өдрөөс олон нийтийн газар амны хаалтгүй яваа иргэдийг 1 сая Вьетнам Донг VND (43 ам доллар)-оос 3 сая VND (120 ам доллар) хүртэл торгууль ногдуулахаар шийдвэрлэсэн байна.

### **СЛОВЕНИ УЛС**

Тус улсад 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдөр КОВИД-19 цар тахлын анхны тохиолдол батлагдсан. 11 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар 2.079.056 удаагийн шинжилгээ хийснээс 75 370 тохиолдол батлагдаж, тусгаарлалтаас гарсан 53 687, тусгаарлалтад байгаа 20 299, нас барсан 1432 байна.

2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр тус улсад дахин хөл хорио тогтоож, бүх шатны боловсролын байгууллага, бизнесийн байгууллага, худалдаа, үйлчилгээний газруудыг хааж, КОВИД-19 цар тахлын улмаас Словени улс руу шилжин суурьших, аялахыг хязгаарлаж, Дотоод хэргийн яам Хорват улсаас хууль бусаар хил нэвтрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хилээ хаах шийдвэр гаргажээ. Мөн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүмүүсийн орогнол хүсэх эрхийг түр түдгэлзүүлэв.

### **НОРВЕГИ УЛС**

Норвеги улсад 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдөр КОВИД-19 цар тахлын анхны тохиолдол батлагдсан бөгөөд 11 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар 2,224,045 удаагийн шинжилгээ хийснээс нийт 35,546 тохиолдол батлагдаж, тусгаарлалтаас гарсан 20,956, тусгаарлалтад байгаа 14,262, нас барсан 328 байна.

**Үндэсний арга хэмжээ**<sup>136</sup> /11 дүгээр сарын 10-ны өдрөөс/

- Амины орон сууц, цэцэрлэг, зуслангийн байшинд олон нийтийн цугларалт зохион байгуулах, зочлоход өрхийн гишүүдээс гадна таваас хэтрэхгүй байх;
- Олон нийтийн газар зохион байгуулагдах хувийн арга хэмжээнд оролцогчдын тоо дээд тал нь 50-аас хэтрэхгүй байх;
- Номын сангаас бусад соёл, амралтын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг хаах;
- Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг бүх газрыг хаах;
- Ресторан, хоолны газрууд 22 цаг хүртэл ажиллах;
- Худалдааны төв болон хүнсний дэлгүүрийг хэвийн ажиллуулж, харин үйлчлүүлэгчид бие биеэсээ хоёр метрийн зай барих;
- Ахлах сургуулиудад халдвар хамгааллын арга хэмжээ авч бүх чиглэлээр суралцаж буй оюутнууд алсын зайнаас хичээллэхэд бэлэн байх;

<sup>136</sup> <https://www.ilo.org/global/topics/coronavirus/regional-country/country-responses/lang--en/index.htm#NO>

- Хотын захиргаанаас оршин суугчдад долоо хоногт арваас дээш хүнтэй нийгмийн харилцаанд орж болохгүй гэсэн үндэсний арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

### **БНХАУ**

Тус улсад КОВИД-19-ийн анхны тохиолдол 2019.12.29-нд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хатуу хорио цээрийн дэглэмийг тогтоон, хорио цээрийн дэглэм зөрчсөн хүмүүст авах арга хэмжээг чангатгаж хэрэгжүүлсэн, худал мэдээлэл тараах явдалтай хатуу тэмцэн, вирусийн халдварын тархалтыг тогтоох, хянах улсын системийг бий болгосон.

Коронавирусийн өндөр тархалттай 1-2 дугаар саруудад техник технологийн дэвшлийг өргөн ашиглан (дрон хөөргөж хяналт, ухуулга сурталчилгаа хийсэн, хүнд ноцтой өвчтөн рүү робот оруулсан гэх зэрэг) иргэдийн хөдөлгөөнийг хянасан, зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд халдвар тархаахгүй байх тал дээр онцгой анхаарсан, түр эмнэлгүүдийг богино хугацаанд байгуулж тэдгээрт хөнгөн өвчтнүүдийг хэвтүүлэн тусгаарлаж, хот суурин газар болон халдвар тархсан газруудын ариутгал халдваргүйжүүлэлтийг сайн хийсэн, халдвар тархсан газарт хэрэглэгдэж байсан мөнгөн дэвсгэртүүдийг хүртэл ариутгаж, тусгаарласан гэх мэт ажлуудыг шуурхай авч хэрэгжүүлсэн. Мөн улс орон даяарх нийтийн тээврийн сүлжээ газруудад нийт 14 000 эрүүл мэндийн үзлэгийн цэгүүдийг байгуулан, сургуулиудын эхлэх хугацааг хойшлуулж, хүн амын зорчих хөдөлгөөнийг эрс бууруулсан төдийгүй цөөн хэдэн долоо хоногийн дотор Ухань хотын 9 сая иргэнийг SARS-CoV-2 өвчний шинжилгээнд хамруулсан. Мөн хавьтлыг хайж тогтоох талаар маш үр дүнтэй улсын системийг бий болгосон байна. Энэ үед Хубэй мужийн Чаньжян хот (1 сая орчим оршин суугчтай)-ын дарга вирусийн халдвар авсан байж болзошгүй хүний талаар мэдээлэл өгч, шинжилгээгээр халдвар авсан нь тогтоогдсон нөхцөлд 10 мянган юань /1425 ам.доллар/-ийн урамшуулал олгох шийдвэр гаргасан. Ийнхүү халдварын голомттой бүсэд (Хубэй мужийн Ухань болон бусад 15 хот, 50 сая хүн ам) карантин тогтоох, олон нийтийн тээвэр, үүнд автобус, галт тэрэг, нисэх онгоц, усан онгоц зэргийн хөдөлгөөнийг түр хааж, хөл хорио тогтоосноос гадна үйлдвэр, сургууль, оффисуудын үйл ажиллагааг түр зогсоож, ажлаа гэрээсээ хийхийг уриалсан зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.<sup>137</sup>

Хятад улсын 1 дүгээр сарын 29-нөөс 2 дугаар сарын 29-нийг хүртэлх нийтийн эрүүл мэндийн талаарх энэхүү арга хэмжээний үр дүнд 1,4 сая халдвар ба 56 000 үхлийн тохиолдлоос тус тус урьдчилан сэргийлж чадсан байна.

3-р сараас дотоодын халдварыг хяналтандаа авч гадаадаас импортлогдсон халдварын тохиолдлын эсрэг арга хэмжээ авч эхэлсэн. Улмаар 6 дугаар сар гэхэд халдварын тохиолдлуудыг бүрэн хяналтандаа авсны дараагаас эдийн засгийг сэргээх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх шат руу шилжсэн байна.

### **ЯПОН УЛС**

Япон улсад КОВИД-19-ийн анхны тохиолдол 2020 оны 1 сарын 16-нд бүртгэгдсэн. 11 сарын 29-ний өдрийн 23:59 цагийн байдлаар<sup>138</sup> нийт халдвар авсан хүний тоо 147568, биеийн байдал хүнд 462, нас барсан 2139, эдгэрсэн хүний тоо 122550 байна.

<sup>137</sup> <https://www.weforum.org/agenda/2020/03/chinas-response-shows-how-bold-decision-making-can-contain-coronavirus/>

<sup>138</sup> Япон дахь халдвар авсан хүмүүсийн тоо (NHK-ийн тойм)



Тухайн үед Засгийн газрын эрх баригчид уг вирусийн дэгдэлтийн эсрэг эрүүл мэндийн болон хилийн хорионы тодорхой арга хэмжээнүүдийг авсан ба 2-р сарын 27-ны өдрийн 00 цагаас эхлэн Япон улсын хилээр нэвтрэхээс өмнө 14 хоногийн хугацаанд зарим нэг нэр дурдсан улсуудад зорчсон зорчигчдыг тодорхой бус шалтгаанаар хил нэвтрэхийг хориглосон. Үүний дараа Ерөнхий сайд Абэ Шинзо нь Японы 7 мужид 4 дүгээр сарын 7-ны өдөр “Онц байдал” зарлаж, ард иргэдийг гэртээ байх, сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоох, нийтийн үйлчилгээний газруудыг хаан бусад эмнэлэг эрүүл мэндийн төв, эм ханган нийлүүлэх байгууллага, хүнс хангамжийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж байсан. 5 сарын 4-ний өдөр Ерөнхий сайд нь Онц байдлыг улс орон даяар 5-р сарын 31-ний өдөр хүртэл зарласан. Мөн Олимпийн арга хэмжээг 2021 оны 7-р сарын 23-ны өдрөөс 8 сарын 8-ны өдөр болгон хойшлуулсан.

*Бүс нутаг бүрт халдварын өөр "үе шатууд":*

Засгийн газрын дэд хорооноос халдварын нөхцөл байдлыг үе шат болгон хуваан арга хэмжээ авч байсан боловч муж бүрийн халдварын үе шатууд өөр өөр байгаагаас шалтгаалан авч буй арга хэмжээ төдийлөн үр дүнгүй байсныг анхаарч наймдугаар сард дараах үе шатуудад хуваан ангилсан.<sup>139</sup>

- Халдвар үе үе тохиолдох "1-р үе шат"
- Халдвар аажмаар нэмэгдэх "2-р үе шат"
- Халдвар хурдацтай нэмэгдэх "3-р үе шат"
- Халдвар хүчтэй тархах "4-р үе шат"
- Эдгээр үе шатуудыг дүгнэхдээ олон тооны индексүүдийг харгалзан үздэг.

## **ТАЙВАНЬ УЛС**

2003 онд хөрш зэргэлдээх улс оронд амьсгалын цочмог хам шинж /SARS/ дэгдсэн тухай бодит мэдээллийг нуун дарагдуулсны улмаас Тайваньд асар их хор хохирол учруулсан ба Тайванийн 73 иргэн амьсгалын цочмог хам шинжийн /SARS/ улмаас амь насаа алдаж байсан.

Шинж тэмдэг илэрсэн оршин суугчид эсвэл зорчигчид дотроос 14 хоног гэрийн хорио цээр сахих шаардлагатай иргэдэд Тайванийн Засгийн газраас байршил тогтоогчтой утас тарааж хяналт тавьсан. Бүх иргэдэд маск тараасан.

## **СИНГАПУР УЛС**

Сингапурт өвчлөөгүй бол маск зүүхгүй байж болохыг зөвлөж байсан ч 2020 оны 4-р сараас эхлэн хүн бүр гадуур явахдаа заавал маск зүүхийг үүрэг болгож ард иргэдээ олон удаа хэрэглэх даавуун маскаар хангасан байна.

Сингапур улсад ажлын байран дахь урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, ажилчдын эрүүл мэндийг тогтмол хянах үүрэг бүхий менежерийг томилж ажиллуулсан байна.

Өдөр тутмын PCR-ийн шинжилгээг 13000-40000 болгон нэмэгдүүлж уламжлалт аргаар тархалтыг хянахаас гадна гар утасны аппликейшн ашиглаж байна.

Аялагчдыг нэвтрүүлэхийг хориглосон ба шаардлагатай иргэдээс шинжилгээ авч 14 хоног гэрээр тусгаарлалтад оруулсан байна.

<sup>139</sup> <https://www3.nhk.or.jp/news/special/coronavirus/committee/>

## ХОЁР. УЛС ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

### НИДЕРЛАНД УЛС

Цар тахлын дэгдэлт эхэлснээс хойш төсвийн цуврал арга хэмжээг авч эхэлсэн бөгөөд энэ өвчний дэгдэлтээс үүдсэн эдийн засгийн үр нөлөөг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Эхний хоёр дэмжлэгийн багцад (3, 5 сард тус тус зарласан) 2020 онд 33 тэрбум евро (ДНБ-ий 4.2%)-тай тэнцэх зардлын арга хэмжээг багтаасан. Тухайлбал:

1. Орлого нь 20 ба түүнээс дээш хувиар буурна гэж таамаглаж буй компаниудад зориулж цалингийн зардлын 90 хүртэлх хувийн нөхөн олговор;
2. Нөлөөнд өртсөн салбаруудын нөхөн олговор (эмнэлэг, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, соёл урлаг болон бусад);
3. Жижиг дунд болон хувиараа бизнес эрхлэгчид, гарааны бизнес, инновацийн жижиг компаниудад үзүүлэх дэмжлэг;
4. Богино хугацааны ажлын төлөвлөгөөг өргөжүүлэх (ажилтнуудаа дор хаяж 20 хувь бууруулах шаардлагатай компаниудын ажилгүйдлийн тэтгэмжийн нөхөн олговор олгох);
5. Тогтмол зардлаа санхүүжүүлэхэд нь зориулж ЖДҮ эрхлэгчдийн дэмжлэг<sup>140</sup> гэх мэт.

*Эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийг сэргээх:*<sup>141</sup>

Цар тахлын дэгдэлтийн үеийн эдийн засгийн нөлөөллийг бууруулах төсвийн багц арга хэмжээ зарласан. Энэхүү багцад дараагийн гурван сарын хугацаанд ойролцоогоор 10-20 тэрбум евро (ДНБ-ий 1-2 хувь) зарцуулах арга хэмжээнүүдийг багтаасан. Нэмж дурдахад, компаниуд татварын төлбөрийг торгуульгүйгээр хойшлуулж, хүлээгдэж байгаа болон буурсан үйл ажиллагааны түвшинг үндэслэж түр татварыг тооцох боломжтой. Эдгээр арга хэмжээг 9 сарын сүүл хүртэл авч хэрэгжүүлсэн байна. Бүх татварын үндсэн хөрөнгийн татвар болон нөхөн сэргээлтийн хүүг 2020.10.1 хүртэл 0.01 хувь болгон бууруулсан. Татварын бусад арга хэмжээнүүд, тухайлбал хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн цагийн шалгуурыг хөнгөлөх болон моргежийн зээлийн төлбөрийн хөнгөлөлтийг мөн 2020 оны 9 сарын сүүл хүртэл сунгасан. Мөн хамгийн эмзэг компаниудад хөрвөх чадварын асуудлыг зохицуулахад нь олон нийтийн баталгааны төлөвлөгөө, ялангуяа Жижиг, дунд бизнес эрхлэгчийн зээлийн санг өргөжүүлсэн.

- Нидерландын Төв банкнаас зээл олгоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор гурван том банкны системийн нөөцийн шаардлагыг бууруулсан. Томоохон банкууд ЖДҮ эрхлэгчдэд зээлийн төлбөрөө зургаан сараар хойшлуулахыг зөвшөөрчээ.
- Хөдөө аж ахуй, байгаль орчин, хүнсний чанарын яам нь тариалан эрхлэгчдэд олгосон эргэлтийн хөрөнгийг түр хугацаагаар санхүүжүүлэх, жижиг дунд фермерийн аж ахуйд зориулсан ЖДҮ-ийн зээлийн баталгааны төлөвлөгөөний нэг хэсэг болох цэцэрлэгжүүлэлтийн компаниуд болон фермерийн аж ахуйд олгосон зээлийн батлан даагчийн үүрэг гүйцэтгэнэ.

<sup>140</sup> Policy Responses to COVID19 (imf.org)

<sup>141</sup> Country policy responses (COVID-19 and the world of work) (ilo.org)

- Соёлын байгууллагуудыг дэмжих зорилгоор 300 сая еврогийн багцыг нэмсэн.
- 4 сарын 28-нд Засгийн газраас санхүүгийн дэмжлэгийг өргөжүүлж, ЖДҮ эрхлэгчдийн зээлийн баталгааны төлөвлөгөөний дагуу шалгуур үзүүлэлтийг зөөлрүүлсэн бөгөөд зээлийн хугацааг 4 жил болгосон.
- Гарааны болон жижиг компаниуд (scale-ups)<sup>142</sup> 9 сарын сүүлч хүртэл Corona Bridging Loan-ийн зээлийн хүсэлт гаргаж болох бөгөөд өнгөрсөн хугацаанд маш олон бизнес эрхлэгч өргөдөл ирүүлсэн тул Засгийн газраас 5 сарын 20-нд хоёр дахь ээлжийн санхүүжилт (150 сая евро)-ийг зарласан.
- Европын холбоо дунд болон том компаниудын хувьд 400-10 тэрбум еврогийн Коронагийн үеийн бизнесийн зээлийн баталгааны төлөвлөгөө (Corona Business loan guarantee scheme)-ний дагуу сунгахыг зөвшөөрсөн. Засгийн газар том болон дундаж компаниудын банкны зээл (компани тус бүрийн доод тал нь 1.5 сая, дээд тал нь 150 сая еврогоор сунгах)-д баталгаа гаргаж байна. Зээлийн хугацаа 6 жил.
- Бичил зээлийн үйлчилгээ үзүүлэгч (microcredit<sup>143</sup> provider) Qredits-аас зээл авсан ЖДҮ эрхлэгчид зээлээ 6 сарын хугацаанд төлөх шаардлагагүй. Энэ хугацаанд хүүг 2% болгон бууруулна. Засгийн газар Qredits-ийг 6 сая еврогоор дэмжиж байна.
- Засгийн газар жижиг, дунд бизнес эрхлэгч болон жижиг, дунд бизнесийн салбарт 750 сая еврогийн зээл олгохоор болсон. Энэхүү зээлийн хэмжээ нь 10-50 мянган еврогийн санхүүжилт шаардлагатай жижиг бизнес эрхлэгчид авах боломжтой. Төрөөс 713 сая еврогийн зээлийн батлан даагч болж байна.
- Орон нутгийн сонин, өргөн нэвтрүүлэг, цахим хуудас болон гэрт хүргэгддэг сонин (door-to-door newspapers)-д зориулж 11 сая еврогийн түр дэмжлэг олгох, Усан онгоцоороо далайд гарч чадахгүй байгаа загасчдад 5 долоо хоног хүртэлх хугацаанд санхүүгийн нөхөн олговор олгох (9 сая евро авах боломжтой) зэрэг арга хэмжээнүүдийг мөн авч байна.

### **ШИНЭ ЗЕЛАНД**<sup>144</sup>

2020-2021 оны төсөв болон өмнөх төсвийн багц хуулиудын дагуу Засгийн газар 2023-2024 оны хооронд 58.5 тэрбум шинэ зеланд доллар (NZ\$) (ДНБ-ий 19.5 хувь)-той тэнцэх хэмжээний санхүүгийн арга хэмжээ авахаа мэдэгдсэн. Нэгдсэн дүнд КОВИД-19 хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх сан багтдаг бөгөөд 14.1 тэрбум NZ\$-ийг хоёрдахь шатны болзошгүй нөхцөл байдалд төлөвлөсөн. Төсвийн зарласан арга хэмжээнд дараах арга хэмжээнүүд хамаарна:

1. Эрүүл мэндтэй холбоотой чадавхыг бэхжүүлэх зардлууд (NZ\$8 тэрбум буюу ДНБ-ий 0.3 хувь)
2. Эмзэг бүлгийн иргэдийг хамгаалах нийгмийн хамгааллын зардлын байнгын өсөлтөд (NZ\$2.4 тэрбум буюу ДНБ-ий 0.8 хувь)
3. КОВИД-19-ийн нөлөөнд ноцтой өртсөн ажил олгогчдыг дэмжих цалингийн татаас (NZ\$14.8 тэрбум буюу ДНБ-ий 4.9 хувь)

<sup>142</sup> A scaleup (company) is a company who has an average annualized return of at least 20% in the past 3 years with at least 10 employees in the beginning of the period (OECD, 2007)

<sup>143</sup> Microcredit is a business loan up to €50,000.

<sup>144</sup> Policy Responses to COVID19 (imf.org)

4. Ажилгүй болсон иргэдийг дэмжих орлогын тэтгэмжийн төлбөр (NZ\$0.6 тэрбум буюу ДНБ-ий 0.2 хувь)
5. Мөнгөн гүйлгээнд туслах бизнесийн татвар дахь байнгын өөрчлөлтийн төлбөр (NZ\$2.8 тэрбум буюу ДНБ-ий 0.9 хувь)
6. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт (NZ\$3.8 тэрбум буюу ДНБ-ий 1.3 хувь)
7. Тээврийн төслүүд (NZ\$0.6 тэрбум ДНБ-ий 0.2 хувь)
8. Татварын алдагдлыг нөхөх түр төлөвлөгөө (NZ\$1 тэрбум буюу ДНБ-ий 1.0 хувь)
9. Нисэхийн салбарыг дэмжих (NZ\$0.6 тэрбум буюу ДНБ-ий 0.2 хувь)
10. Аялал жуулчлалыг сэргээх багц (NZ\$0.4 тэрбум буюу ДНБ-ий 0.1 хувь)
11. Засгийн газрын орон сууцжуулах хөтөлбөр (NZ\$0.7 тэрбум буюу ДНБ-ий 0.2 хувь)
12. Сургуулийн дэд бүтцийг шинэчлэх (NZ\$0.2 тэрбум буюу ДНБ-ий 0.1 хувь) гэх мэт.

Засгийн газар ачаа тээврийн үйл ажиллагаа, дотоодын болон олон улсын хязгаарлагдмал нислэгийг үргэлжүүлэхэд зориулж Шинэ Зеландын агаарын тээвэр (Air New Zealand)-тэй NZ\$0.9 тэрбумийн өрийн санхүүжилтийн гэрээг байгуулсан. Засгийн газар 2023 оныг дуустал 50 ба түүнээс бага ажилтантай жижиг бизнес эрхлэгчдэд 100 мянган NZ\$ хүртэлх зээл олгоно.

Шинэ Зеландын нөөцийн банк 5 дугаар сарын 26-аас эхлэн 6 сарын хугацаанд 3 жилийн хугацаатай 0.25 хувийн хүүтэй урт хугацааны санхүүжилтийн төлөвлөгөөг нэвтрүүлсэн. 8 сарын 26-аас хугацаатай зээлийн нөхцөл (TLF)-ийн зээлийн хугацааг 5 жил болгон сунгаж, уг нөхцөлийг 2021.02.01 хүртэл сунгасан. Зээлийн эрсдлийн 80 хувийг Засгийн газар хариуцдаг тул шаардлага хангасан барьцаа хөрөнгө шаарддаг. 8 сараас Бизнесийн санхүүгийн баталгааны төлөвлөгөөг өргөжүүлж зээлийн дээд хэмжээг NZ\$ 0.5-5 сая болгон нэмэгдүүлж, хамгийн дээд хугацааг 3-5 жилээр сунгаж, дунд хэмжээний компаниудад зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг олгосон. Бизнесийн санхүүгийн баталгааны төлөвлөгөө банкуудад зээл олгоход нь туслах зорилгоор банкуудын үндсэн санхүүжилтийн харьцааг 75 хувиас 50 хувь болгон бууруулсан.

Засгийн газар, Шинэ Зеландын нөөцийн банк (The Reserve Bank of New Zealand), Шинэ Зеландын банкуудын холбоо, ЖДҮ болон орон сууцны эздийг дэмжих чиглэлээр санхүүгийн зарим арга хэмжээ авахаа мэдэгдсэн. Үүнд: КОВИД-19 ба Бизнесийн санхүүгийн баталгааны төлөвлөгөө (BFGS)-ний нөлөөлөлд өртсөн ЖДҮ болон моргежийн зээлдэгчдэд олгох үндсэн зээл, хүүгийн төлбөрийг зургаан сарын хугацаатай хойшлуулсан.

Засгийн газраас санхүүгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулах бусад арга хэмжээний хүрээнд орон сууцны төлбөрийг зургаан сарын хугацаанд царцаах, түрээсийн хугацааг 3-6 саруудад хязгаарлах арга хэмжээг авсан. Бизнес эрхлэгчид одоо байгаа өр төлбөрөө долоон сарын хугацаагаар хойшлуулах боломж олгосон.

### **БНСУ**

Үндэсний Ассамблей КОВИД-19 цар тахлын үед эдийн засгийн нөлөөллийг зохицуулах зорилгоор нийт 3 удаа 35 их наяд вонын (ойролцоогоор 29 тэрбум ам доллар) нэмэлт төсвийг баталжээ. Энэ нь 1972 оноос хойш Үндэсний Ассамблей нэг жилийн хугацаанд гурван нэмэлт төсвийг баталсан анхны тохиолдол болсон байна. (02.25.2020)

Халдвартай бүсэд орших жижиг, дунд бизнес эрхлэгчдэд татварын тусгай хөнгөлөлтийг хоёр дахин нэмэгдүүлсэн. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд татварын тусгай хөнгөлөлтийн дээд хэмжээг хоёр дахин (15% -иас 30%) нэмэгдүүлсэн. Энэ нь орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн албан татварыг жижиг бизнес эрхлэгчдийн 60%, дунд бизнес эрхлэгчдийн 30% -иар бууруулжээ. Үүнд баар, ресторан, үл хөдлөх хөрөнгийн түрээсийн бизнес гэх мэт бүх салбарууд хамаарна.

Үндсэн зээл, хүү, татвар (PIT): Түрээслэгч нь сайн дураараа түрээсийн төлбөрийг бууруулсан тохиолдолд 2020 оны эхний хагаст түрээсийн төлбөрийн 50%-тай тэнцэх хэмжээний татварыг орлогын албан татвар эсвэл корпорацийн албан татвараас суутгана.

Нэмэгдсэн өртгийн албан татвар (VAT) жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан НӨАТ-ын журамд эргэлтийн босгыг 2021 оныг дуустал 30 сая воноос 80 сая вон болгон өсгөсөн. Үүнээс гадна 48 сая воноос доош эргэлттэй бизнес эрхлэгчдийг НӨАТ-аас чөлөөлнө.<sup>145</sup>

## СЛОВЕНИ УЛС

### Эдийн засгийг эрчимжүүлэх арга хэмжээ<sup>146</sup>

- Банкны зээлээс үүсэх өр төлбөрийг 12 сараар хойшлуулах;
- ЖДҮ-дэд төрөөс хөнгөлттэй зээл олгох;
- Татварын мэдүүлэг, жилийн тайлан ирүүлэх, татвар төлөх хугацааг хойшлуулах, хугацааг сунгах;
- Хүнсний үйлдвэрүүдэд эргэлтийн хөрөнгийн зээл олгох;
- Экспортын бэлтгэлийн нэмэлт даатгалын зээлийг санал болгож, ингэснээр коронавирустэй холбоотой арилжааны болон арилжааны бус эрсдэлийн даатгал, давхар даатгалд хамруулах боломжийг олгох;
- Хөрвөх чадварын зээлийг аялал жуулчлал, автомашин, тээврийн салбар болон бусад үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг бичил компаниуд, ЖДҮ эрхлэгчдэд тулгарч буй асуудлыг арилгахад зориулагдсан (40 сая еврогоос 125,000 евро хүртэлх) зээл олгох;
- Ажилгүйдэл ихтэй, хил орчмын бүс нутгийн компаниудад зориулсан бичил зээл (5,000 еврогоос 25,000 евро хүртэлх) олгох.

Үндсэн үзүүлэлтүүд	2018	2019	2020	2021
ДНБ (тэрбум ам.доллар)	54.06	53.75	51.80	59.48
ДНБ (Тогтмол үнэ, жилийн хувь өөрчлөлт)	4,1	2,4	-6,7	5,2
Нэг хүнд ногдох ДНБ (ам.доллар)	26	25	25	28
Засгийн газрын ерөнхий тэнцэл (ДНБ-ний хувиар)	0,4	0,3	-6,8	-2,6
Улсын ерөнхий өр (ДНБ-ний хувиар)	70,4	66,1	81,0	78,0
Инфляцийн түвшин (хувь)	1,7	1,6	0,5	1,8
Ажилгүйдлийн түвшин (Ажиллах хүчний хувиар)	5,1	4,6	8,0	6,0
Одоогийн данс (тэрбум ам.доллар)	3,17	3,05	2,34	2,33
Урсгал данс (ДНБ-ний хувиар)	5,9	5,7	4,5	3,9

Эх сурвалж: ОУВС - Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын мэдээллийн сан  
Тэмдэглэл: (Ө) Тооцоолсон мэдээлэл

<sup>145</sup> Overview of Country Tax Policy measures in response to Covid-19 crisis

<sup>146</sup> <https://www.nordeatrade.com/en/explore-new-market/slovenia/economical-context>

Словени Улсын парламентаас 2020 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр баталсан “Коронагийн эсрэг” хуулиар дараах асуудлыг зохицуулжээ. Үүнд:

- Цалин тэтгэмжийн нөхөн олговор;
- Нийгмийн шимтгэлийг чөлөөлөх;
- Групп болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг чөлөөлөх;
- Өвчний чөлөө;
- Хямралын үед олгох нэмэгдэл;
- Ажлын цагийг богиносгох;
- Эдийн засагт туслах арга хэмжээ;
- Аялал жуулчлалын салбарт үзүүлэх санхүүжилт;
- Хөдөө аж ахуй салбарт үзүүлэх санхүүжилт;
- Цар тахлын үеийн хөдөлмөрийн гэрээ сунгах;
- Хилээр нэвтрэх;
- Халдвар авсан хүнд цалин хөлс, нөхөн олговор олгох;
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч, ЖДҮ-дэд туслах;
- Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад зориулсан нэмэлт цалин хөлс;
- Боловсролын байгууллагуудад зориулсан санхүүжилт;
- Тээврийн хэрэгслээр үйлчилдэг байгууллагуудын зардлыг нөхөх;
- Нийтийн тээврийн хэрэгслийг зогсоосон, мөн хил хаасны улмаас ажил хийж чадахгүй болсон ажилчдад цалин хөлс, нөхөн олговор олгох;
- Цар тахлын үеийн нөхцөл байдлаас үүссэн ажлын байранд түр хөдөлмөрийн гэрээ байгуулах (зөвхөн төрийн байгууллага);
- Зайнаас ажиллуулах, ажлын цагийг уян хатан зохион байгуулах.

## **ВЬЕТНАМ УЛС**

Вьетнам Улсын Засгийн газар эдийн засгийг дэмжих зорилгоор 284 их наяд VND буюу ДНБ-ий 3.6%-тай тэнцэх багцыг баталсан байна.

Засгийн газрын 41/СР тогтоолоор баталсан энэхүү багцад:

- нэмэгдсэн өртгийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон газрын түрээсийг 5 сараар хойшлуулах;
- хувь хүний орлогын албан татварыг оны эцэс хүртэл хойшлуулах шийдвэрийг тус тус гаргасан байна.

2020 оны 8-12 хүртэл сарын хугацаанд шинээр хэрэгжүүлж буй арга хэмжээнд, албан татварыг 50%-аар бууруулах, дотооддоо үйлдвэрлэсэн авто машины онцгой татварыг хойшлуулах, газрын түрээсийг 15%-аар бууруулах, байгаль орчныг хамгаалах татварыг 30%-аар бууруулах, жижиг болон бичил бизнес эрхлэгчдийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 30%-аар бууруулах болон бусад төрлийн татвар, төлбөрийг тодорхой хэмжээгээр бууруулах зэрэг арга хэмжээнүүд багтсан байна.

2020-02-15-аас эхлэн эмнэлгийн тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлж, бизнесийн бүртгэлийн хураамжийг бууруулж (дөнгөж эхэлж буй өрхийн бизнесийн бүртгэлийн татварыг 1 жил хүртэл хугацаагаар чөлөөлж, Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бүртгэлийн хураамжийг эхний 3 жилийн хугацаанд чөлөөлөх), компани, аж ахуйн нэгж болон ажилтнуудын тэтгэврийн сангийн хураамжийг хүү тооцолгүйгээр 3 сараар хойшлуулах зэрэг арга хэмжээнүүдийг Засгийн газраас хэрэгжүүлж байна.



Засгийн газрын 42/СР тогтоолын дагуу 36 их наяд VND (ДНБ-ий 0.5%-тай тэнцэх) мөнгөн тусламжийн багцыг КОВИД-19 цар тахалд өртсөн иргэд, айл өрхөд 2020 оны 4-6 сар хүртэл хугацаанд оногдуулахаар шийдвэрлэсэн байна. Энэхүү мөнгөн тусламжид Вьетнамын хүн амын 10% багтсан байна. Тус багцад хувийн сургуулийн багш нарыг мөн хамруулсан байна. Засгийн газраас боловсрол, эрүүл мэнд гэх мэт төрөөс хөрөнгө оруулалт шаарддаг салбаруудад 686 их наяд буюу ДНБ-ий 9%-тай тэнцэх хөрөнгийг зарцуулахаар баталсан байна. Гэвч эхний 10 сарын байдлаар энэхүү үйл ажиллагаанд төсөвлөсөн хөрөнгөнөөс 68% нь олгогдоод байна.

Хятадаас орж ирж буй импортын түүхий эдэд тавьсан хориг болон аялал жуулчлалын хоригос шалтгаалан хүндрэл учирсан нэхмэл, бөс бараа, компьютер, электрон бараа, аялал жуулчлал болон тээврийн салбаруудын үйл ажиллагааг дэмжихийн тулд Вьетнамын Төрийн банк арилжааны банкуудад зээл төлөлтийн хугацааг хойшлуулах эрх олгосон байна.

КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газар нь 23 сая ам доллартай тэнцэх санхүүгийн тусламжийг төв засгийн газрын төсвөөс эрүүл мэндийн салбарт зориулж баталсан байна.

#### **Дээрх багцуудын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа:**

- 2020 оны 4-6 сар хүртэлх 3 сарын хугацаанд ядуу буурай айл өрх бүрт сар бүр 1 сая VND (43 ам доллар)-ын мөнгөн тусламж үзүүлсэн.
- Ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй, ажилгүй болсон иргэд болон цар тахлын улмаас хоорондын зай барих журмын дагуу цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болсон аж ахуйн нэгжүүдэд ажлын гэрээгүй ажиллаж байсан ажиллагсдад зориулан 2020 оны 4-6 сар хүртэлх хугацаанд сар бүр 1 сая VND (43 ам доллар)-ын мөнгөн тусламж олгох шийдвэр гаргасан.
- Цалингүй чөлөөнд хамрагдсан болон ажлын цаг нь богиноссон ажилтнуудад улсын төсвөөс 3 сарын хугацаанд сар бүр 1.8 сая VND-тэй тэнцэх санхүүгийн тусламж үзүүлсэн. Энэхүү 3 сарын хугацаанд ажилчдын авч буй цалингийн нийт хэмжээ тухайн бүс нутгийн цалингийн доод хэмжээний 85%-аас багагүй байх ёстой байна.
- Ажил олгогчид нь 12 сараас дээшгүй хугацаанд зээлийг 0%-ийн хүүтэй авах боломжтой байна.
- Жилийн 100 сая VND (4248 ам доллар)-оос бага орлоготой гэж тогтоогдсон, цар тахалд өртсөн өрхийн бизнес эрхлэгчдэд 2020 оны 4-6 сар хүртэлх хугацаанд сар бүр 1 сая VND (43 ам доллар)-ын мөнгөн тусламж олгох зэрэг шийдвэрүүд багтсан байна.

#### **НОРВЕГИ УЛС<sup>147</sup>**

*Жижиг дунд үйлдвэрүүдэд чиглэсэн арга хэмжээ (төсөв 98 тэрбум):*

- Цар тахлын хямралаас болж орлого нь 30 хувь буурсан тогтвортой бизнес эрхлэгчдэд олгох түр хугацааны нөхөн олговор;
- Хүүхэд харах чөлөөг 3-аас 10 хоног болгох;
- Цалинтай чөлөөг 3-16 хоног болгох;
- Татвар төлөх хугацааг хойшлуулах;

<sup>147</sup> <https://www.regjeringen.no/en/topics/the-economy/economic-policy/economic-measures-in-norway-in-response-to-covid-19/id2703484/>

- Агаарын тээврийн зорчигчдын татварыг түдгэлзүүлэх;
- Барилгын салбарын үйл ажиллагааг дэмжих;
- Улирлын чанартай бизнесийн зардлын нөхөн олговор олгох.

*Бизнес эрхлэгчдэд чиглэсэн арга хэмжээ (төсөв 130 тэрбум)*

- Аж ахуйн нэгжүүдэд олгох банкны зээл;
- Норвегийн бондын зах зээл дэх хөрвөх чадвар, хөрөнгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын бондын санг сэргээн ажиллуулах;
- Инновацийн зээлийн санхүүжилт;
- Нисэхийн салбарыг дэмжих зээл;
- Аялал жуулчлалын операторуудад цар тахлын улмаас цуцлагдсан аяллын нөхөн төлбөрийн 80 хүртэлх хувийг зээл олгох;
- Зээлийн даатгалын үйлчилгээ эрхлэгчдэд учрах эрсдлийг арилгах зээл орно.

*Иргэдэд чиглэсэн арга хэмжээ (төсөв 27 тэрбум)*

- Хязгаарлалт тогтоосон өдрөөс тэтгэмж олгох;
- Өдрийн тэтгэмжийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн тэтгэмжийг өсгөх;
- Түр хугацаагаар ажлаас халагдсан иргэдэд 3 дахь өдрөөс цалинтай болтол 100 хувийн нөхөн олговор олгох;
- Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдаагүй хувиараа хөдөлмөр эрхлэгчид түр зуурын тэтгэмж өгөх;
- Орлогын алдагдлаа нотолсон орлогогүй иргэд болон оюутнуудын зээлийг буцалтгүй тусламж болгох зэрэг багтана.

*Дэд бүтцийн салбарт чиглэсэн арга хэмжээ (төсөв 23 тэрбум)*

- Тэтгэмжийг нэмэгдүүлэх, ажил олгогчдын татварыг түр хугацаагаар бууруулах;
- Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн шинжилгээний зардлыг нөхөх санхүүжилтийг нэмэх;
- Тэтгэврийн журмыг түр хугацаагаар өөрчилж, тэтгэвэрт гарсан эрүүл мэндийн мэргэжилтнийг дайчлан ажиллуулах;
- Цар тахлын дэгдэлтээс үүдэн орлогын алдагдалд орсон төсвийн байгууллагуудад нөхөн олговрыг олгох;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын санхүүгийн байдлыг дэмжих.

*Бусад арга хэмжээ (төсөв 13 тэрбум)*

- Соёл, спорт, сайн дурын арга хэмжээг цуцалсан эсвэл хойшлуулсны нөхөн төлбөр;
- Нийтийн тээврийн орлого алдагдсантай холбогдуулан олгох нөхөн олговор;
- Насанд хүрэгчдэд зориулсан дунд боловсрол, мэргэжлийн сургалт, ур чадварын санхүүжилт;
- Хэлний мэдлэг, урт хугацааны интеграцчилал, нэвтрүүлэх хөтөлбөр, дунд боловсролтой холбоотой интеграцийг бэхжүүлэх арга хэмжээ.

**ТАЙВАНЬ УЛС**<sup>148</sup>

Эдийн засгийн хувьд зөөлөн бодлого явуулж, хэтэрхий өргөн хүрээтэй хориглолт хязгаарлалтаас татгалзсан ч халдварын тархалтыг барьж чадаж байгаагаараа Тайвань улсын онцлог нь бусад улс орнуудаас ялгарч чадаж байна.

*Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой арга хэмжээ:*

- Ажлын цагийг багасгах
  - Сургалтын хөтөлбөр: NTD\$18,960 /1,898,363₮/ хүртэлх мөнгөн тусламж
  - Хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө: NTD\$11,000 /1,100,926₮/ хүртэлх цалин хөлсний мөнгөн тусламж
  - Шуурхай ажлын төлөвлөгөө: NTD\$11,000 /1,100,926₮/ хүртэлх цалин хөлсний мөнгөн тусламж
- Ажилгүйчүүдэд
  - Ажилгүйдлийн давуу тал: Даатгалтай дундаж сарын цалингийн 60% хүртэлх мөнгөн тэтгэмж
  - Суралцагчдын сургалтын төлбөрийн татаас: Ахлах сургуулийн сурагчдад NTD\$6000 /600,721₮/, Их сургууль коллежийн оюутнуудад NTD\$24000 /2,402,885₮/
- Корпорациуд
  - Ажиллах орчныг сайжруулахад олгох мөнгөн тэтгэмж: Ажлын аюулгүй орчин болон эрүүл мэндийн тоног төхөөрөмжийн сайжруулалтад олгох мөнгөн тусламж NTD\$2сая /200,248,622₮/
  - Ажилчдын амьдралын тэнцвэр: асрагчийн цагийн хөлсний NTD\$200,000 хүртэлх тэтгэмж
  - Хөдөлмөрийн даатгал болон тэтгэврийн төлөлтийг хойшлуулах:
  - Төлбөрийг ямар нэгэн торгуульгүйгээр хойшлуулах
  - Сургалтын хөтөлбөр: NTD\$3 сая /300,380,310₮/ хүртэлх мөнгөн тусламж

*Эдийн засгийг сэргээх арга хэмжээ:*

Банкнаас олон нийтэд тусламж үзүүлэх гурван бодлого баримталсан. Үүнд:

- Зээлийн бодлогын багц: Бизнесийн үйл ажиллагааг дэмжихэд жижиг дунд үйлдвэрийн сангийн дэмжлэг үзүүлэх;
- Зээлийн хугацааг сунгах: Компаниуд эсвэл иргэд зээлийн үндсэн төлбөрийг хойшлуулах эсвэл зээл сунгуулах хүсэлт гаргаж болно.
- Зээлийн картын төлбөрийг хойшлуулах: Иргэд өөрсдийн зээлийн картын төлбөрийг торгууль болон хүүгүйгээр хойшлуулах хүсэлт гаргаж болно.

*Банкнуудын зээлийн хүүг бууруулах арга хэмжээ:*

- Орон сууцны зээл (Бүх зээлийн хувьд): 2020/9/30 оноос хойш 0.25% -иар бага байна
- Хэрэглээний зээл (Бүх зээлийн хувьд): 2020/9/30 оноос хойш 0.25%-иар бага (зээлийн карт, барьцаагүй зээл, автомашины зээл орно)

<sup>148</sup> <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/taiwan-government-and-institution-measures-in-response-to-covid.html>

**Арилжааны банкуудаас санал болгож буй санхүүжилтийн хоёр багц:**

- NTD 100 тэрбум долларын багц (КОВИД-19 цар тахлын нөлөөлөлд өртсөн бүх бизнесийн хувьд)
  - NTD\$10 тэрбумын төсөл
  - Банкнаас NTD\$100 тэрбумын зээл олгох
  - LTV харьцаа 80% ~ 100%
- Хүүгийн татаасын багц (Зөвхөн нөлөөлөлд өртсөн ЖДҮ эрхлэгчдэд зориулагдсан)
  - Хойшлуулсан зээл
  - Бизнесийн зээл
  - Урамшууллын зээл

**Арилжааны банкуудын санхүүжилтийн багцын арга хэмжээ**

	NTD\$100 billion	Зээлийн татаас	
	Барьцаа хураамжгүй	Зээлийн хүү	Зээлийн хугацаа
Хойшлуулсан зээл	Барьцааны хувь	0.81%	1 жил
	100%	Хүсэлт тус бүрт NTD\$220,000	
Бизнесийн зээл (цалин болон түрээс хамрагдана)	Барьцааны хувь	1.845%	6 сар
	100%	Хүсэлт тус бүрт NTD\$55,000	
Урамшууллын зээл	Барьцааны хувь	0.845%	1 жил
	100%	Хүсэлт тус бүрт NTD\$220,000	

Тайвань улсын Засгийн газар КОВИД-19-ийн дараа эдийн засгийг сэргээх зорилгоор "Tripe stimulus voucher хөтөлбөр" хэрэгжүүлэхээр NTD\$51.1 тэрбум төсөвлөсөн байна. Уг хөтөлбөрт Тайвань улсын иргэн болон тэдгээрийн гадаад улсын иргэншилтэй эхнэр/нөхөр тус бүр хамрагдана. Нийт NTD3,000 /300,000₮/ нэрлэсэн үнэтэй зардлын эрхийн бичгийг NTD 1.000/100,000₮/ үнээр худалдан авах боломжийг олгосон байна. Эрхийн бичгийг дараах зүйлээс бусад бүх зардалд ашиглаж болно:

- Ус, цахилгаан эрчим хүчний төлбөр;
- Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн үндсэн төлбөр, хүү, зээлийн картан үлдэгдэл болон бусад санхүүгийн үйлчилгээний төлбөр;
- Хувьцаа, компанийн бонд, опцион, даатгал болон бусад санхүүгийн бүтээгдэхүүнийг эзэмших;
- Засгийн газрын торгууль, хураамж, татвар, нийгмийн даатгалын шимтгэл болон бусад хуулиар хүлээсэн үүргийн төлбөр;
- Тамхи, бараа (эсвэл үйлчилгээний) ваучер болон урьдчилж төлсөн бусад зээлийн төлбөр.

**БНХАУ<sup>149</sup>****Төсвийн бодлогын арга хэмжээ:**

Тус улс КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засаг дахь нөлөөллийг бууруулах зорилгоор 4.8 их наяд юанийн (эсвэл ДНБ-ий 4.7 хувь) дүнтэй төсвийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээ зарласан байна. Гол арга хэмжээнд дараах зүйлс багтана:

<sup>149</sup> <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>

- (i) дэгдэлтээс урьдчилан сэргийлэх болон хяналт тавихад зарцуулах зардлыг нэмэгдүүлэх;
- (ii) эмнэлгийн тоног төхөөрөмж үйлдвэрлэх;
- (iii) ажилгүйдлийн тэтгэмж олголтыг түргэсгэх, мөн үүнийг цагаач ажилчдад олгох;
- (iv) татварын хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх;
- (v) төсвийн нэмэлт хөрөнгө оруулалт. Автомат тогтворжуулагчид төсвийн дэмжлэгийг улам нэмэгдүүлдэг байна.

Төрийн удирдлагын салбарын нийт дэмжлэг илүү өндөр байх төлөвтэй байна. Жишээлбэл, төсвөөс гадуурх дэмжлэгт ЖДҮ эрхлэгчдэд 400 тэрбум юанийн (ДНБ-ний 0.4 хувь) нэмэлт баталгаа, зам, боомт, цахилгаан гэх мэт зүйлсийг ашигласны төлбөр болон тарифын 900 гаруй тэрбум юанийн хөнгөлөлт (ДНБ-ий 0.9 хувь) багтана.

*Мөнгөн болон макро-санхүүгийн арга хэмжээ:*

- Хятадын ардын банк нь мөнгөний бодлогын дэмжлэг үзүүлж, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа билээ. Гол арга хэмжээнүүдэд дараах зүйлс багтана:
  - (i) нээлттэй зах зээлийн хэрэгслүүд (урвуу репо болон дунд хугацаатай зээлийн сан)-ээр дамжуулан банкны системд хөрөнгө шилжүүлэх;
  - (ii) эмнэлгийн хэрэгсэл, өдөр тутмын хэрэгцээний үйлдвэрлэгчид, бичил, жижиг, дунд оврын пүүсүүд болон хөдөө аж ахуйн салбарыг дэмжих зорилгоор дамжуулан зээлдүүлэх, хөнгөлөлт үзүүлэх хөтөлбөрийг 1.8 их наяд юаниар өргөжүүлэх бөгөөд дамжуулан зээлдүүлэх хөтөлбөрийн (re-lending facilities) хүүг 50 суурь нэгжээр, дамжуулан хөнгөлөлт үзүүлэх хөтөлбөрийн (re-discounting facilities) хүүг 25 суурь нэгжээр бууруулах;
  - (iii) 7 ба 14 хоногийн урвуу репогийн хүүг 30 суурь нэгжээр бууруулж мөн 1 жилийн дунд хугацаатай зээлийн сангийн хүүг 30 суурь нэгжээр, зорилтот зээлийн сангийн хүүг 20 суурь нэгжээр тус тус бууруулах;
  - (iv) бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих санхүүжилтийн шалгуурыг хангасан том, дунд банкуудад заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувийг 50-100 суурь нэгжээр бууруулж, шаардлага хангасан хувьцаат банкуудад ЗБН-ийн хувийг нэмэлт 100 суурь нэгжээр бууруулж, мөн адил ЖДҮ-ийг дэмжих зорилгоор жижиг, дунд банкуудад ЗБН-ийн хувийг нэмэлт 100 суурь нэгжээр бууруулах;
  - (v) илүүдэл нөөцийн хүүг 72 суурь нэгжээс 35 суурь нэгж болгон бууруулах,
  - (vi) бодлогын банкуудын зээлийн шугамыг хувийн фирмүүд болон бичил, жижиг бизнес эрхлэгчдэд сунгах (350 тэрбум юань);
  - (vii) бичил, жижиг бизнес эрхлэгчдийн зээлийг дэмжих шинэ хэрэгслийг нэвтрүүлэх, үүнд: орон нутгийн банкуудын шинэхэн барьцаагүй зээлийн 40 хувийг санхүүжүүлэх болон зээлийн үндсэн төлөлтийг 1 хувиар хөнгөлөх (40 тэрбум юань) замаар банкуудын шаардлага хангасан зээлүүдийн төлбөрийн амралтын хугацааг уртасгахыг урамшуулах зээлийн тэг хүүтэй “зээлийг санхүүжүүлэх” схем (400 тэрбум юань).

- Засгийн газар нь санхүүгийн нөхцөл байдал хүндрэхээс сэргийлэх олон арга хэмжээ хэрэгжүүлсэн. Тухайлбал, зээлийн эргэн төлөлтийг хийхэд хүндрэлтэй болсон айл өрх, байгууллага, бүс нутгуудад санхүүгийн тусламж үзүүлэх зорилгоор хэмжээст өршөөлийг олгох зэрэг арга хэмжээ авсан байна. Гол арга хэмжээнүүдэд:
  - (i) ЖДҮ-ийн зээлийг хөхиүлэн дэмжих, үүнд: орон нутгийн банкуудад ЖДҮ-ийн барьцаагүй зээл олгоход туслах, томоохон банкуудын бичил, жижиг бизнес эрхлэгчдэд олгох зээлийн өсөлтийн зорилтыг 30 хувиас 40 хувь болгох, банкуудад бичил, жижиг бизнес эрхлэгчдэд зээл олгох үнэлгээний системийг бий болгох тус тус орно.
  - (ii) зээлийн төлбөрийг хойшлуулж, хугацааг 2021 оны 3-р сарын эцэс хүртэл сунгах, онлайн зээлийн хэмжээний хязгаарлалтыг хөнгөвчлөх, шаардлага хангасан ЖДҮ эрхлэгчид болон өрхүүдэд зээлийн дэмжлэг үзүүлэх бусад арга хэмжээ авах;
  - (iii) өндөр чанаргүй зээлийн өршөөлийг ихэсгэх болон чанаргүй зээлд шаардлагатай чадамжийн шалгуурыг бууруулах;
  - (iv) ЖДҮ-ийн зээлийг санхүүжүүлэх зорилгоор санхүүгийн байгууллагуудаас бонд гаргахыг дэмжих,
  - (v) корпорациудын бонд гаргахыг нэмэгдүүлэх замаар (үүнд бондын хөрөнгө оруулалтын даатгагчдын журмыг хөнгөвчлөх мөн орно) корпорациудад нэмэлт санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх;
  - (vi) зээлийн баталгааны төсвийн дэмжлэгийг нэмэгдүүлэх;
  - (vii) хөрөнгийн менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлэх уян хатан байдал;
  - (viii) орон нутгийн засаг захиргааны орон сууцны бодлогыг хөнгөвчлөх зэрэг арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлжээ.

## **ЭСТОНИ УЛС**

### *Төсвийн бодлогын арга хэмжээ:*

Эстони улсын парламент 2020 оны 4-р сарын 15-ны өдөр цар тахлын улмаас үүссэн нийгэм, эдийн засгийн үр нөлөөг шийдвэрлэх зорилгоор нэмэлт төсвийг баталсан. Энэхүү төсвийн хүрээнд Засгийн газар төсвийн нэрлэсэн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 9 хувиас дээш түвшинд хүргэх 2 тэрбум орчим еврогийн (ДНБ-ий 7 хувийг эзэлнэ) тусламжийн багц арга хэмжээг хэлэлцжээ. Тусламжийн багц арга хэмжээнүүд нь эрүүл мэндийн байгууллагын хангамжийг сайжруулах, ажилчид болон бизнес эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагаанд туслах болно. Багцад дараах дэмжлэгүүд багтана: цалингийн орлого буурсан иргэдэд зориулж ажилгүйдлийн даатгалын санд 250 сая евро; эрүүл мэндийн даатгалын санд 213 сая евро; хөдөө орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд бизнесийн зээл олгох зорилгоор хөдөө орон нутгийн хөгжлийн санд 200 сая евро; банкны зээлийн төлбөрийг хойшлуулах боломжийг олгох зорилгоор банкны зээлийн баталгаа/барьцаа хөрөнгөд 1 тэрбум евро; аж ахуйн нэгжүүдийн хөрөнгийн хөрвөх чадварыг дэмжихэд зориулагдсан бизнесийн зээлд 500 сая евро; орон нутгийн эрх баригчдад дэмжлэг үзүүлэх 130 сая евро; аж ахуйн нэгжүүдэд олгох хөрөнгө оруулалтын зээлд 50 сая евро; цуцлагдсан соёл, спортын арга хэмжээний шууд зардлын нөхөн төлбөрт 3 сая евро зэрэг орсон байна.

Засгийн газар нь мөн тэтгэврийн тогтолцооны хоёр дахь тулгуурын тэтгэврийн санд төлөх төлбөрийг түр зогсоосон.



Мөн Засгийн газар Нордикийн хөрөнгө оруулалтын банкаас 15 жилийн хугацаатай 750 сая еврогийн зээл авчээ. 2020 оны 6-р сарын 3-нд Засгийн газар нь жилийн 0.125 хувийн хүүтэй, 10 жилийн хугацаатай Евро бондыг гаргах замаар 1.5 тэрбум еврог (анх 1 тэрбум евро босгохыг төлөвлөж байсан) амжилттай босгожээ. Засгийн газар нь орон нутгийн үйл ажиллагааны хямралыг бууруулах арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор Европын хөгжлийн банк (СЕВ)-аас 200 сая еврогийн зээл авсан байна.

*Мөнгөн болон макро-санхүүгийн арга хэмжээ:*

Эстониин Төв банк (Eesti Pank) 2020 оны 3-р сарын 25-ны өдөр зээлийн алдагдал болон шинэ зээлүүдэд хөрөнгө чөлөөлөх зорилгоор арилжааны банкуудын системийн эрсдлийн хамгаалалтыг (systemic risk buffer) 1 хувиас 0 хувь болгон бууруулжээ. Энэхүү арга хэмжээ нь банкуудад 110 сая орчим еврог чөлөөлөх төлөвтэй байна. Эстониин Төв Банк өөрсдийн боломжит дээд хэмжээ болох 2019 оны ашгийн ¼-ийг (18.9 сая евротой тэнцэх хэмжээний мөнгө) КОВИД-19 цар тахлын үед улсын төсвийг дэмжихэд хуваарилахаа мэдэгдсэн байна.

### **СИНГАПУР УЛС<sup>150</sup>**

2019 онд Сингапур улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн S\$508 тэрбумд хүрсэн ба 2018 онтой харьцуулахад 3.4%-р буурсан байна. 2020 оны ДНБ 0.5%-2.5%-р буурна гэж 2019 оны 11-р сард Сингапурын Худалдаа Аж Үйлдвэрийн Яамнаас (Singapore's Ministry of Trade and Industry MTI) таамагласан байна. Гэвч КОВИД-19 халдварын дэгдэлт энэхүү таамаглалыг өөрчилсөн ба СХАЖҮЯ-наас ДНБ-ний хэлбэлзлийг долоо хоногийн дотор -0.5% to 1.5% буюу бүтэн нэг пунктээр бууруулсан байна.

Сингапур улсын сангийн сайд 2020 оны 2 сарын 18 ны өдөр орон нутгийн бизнес эрхлэгч болон ажилчдад зориулсан нийт 4 тэрбум сингапур долларын өртөгтэй “Тогтворжуулалт ба Дэмжлэгийн багц”-ийг /Stabilization and Support Package/ танилцуулсан байна.

*Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой арга хэмжээ:*

Тус улсын Засгийн газраас КОВИД-19 цар тахлаас үүдсэн ажилгүйдлийг багасгах, тогтоон барих, ажлын байрыг нэмэгдүүлэхийн тулд, 5 төрлийн зорилтот бүлгүүдэд хамрагдах ажил олгогч болон хөдөлмөр эрхлэгч нарт чиглэсэн мөнгөн урамшууллын хөтөлбөрийг боловсруулсан. Үүнд:

- Цалингийн зээлийн тогтолцоог сайжруулах хөтөлбөр;
- Гадаадын ажилчдад зориулсан хөтөлбөр;
- Ажлын байрын ур чадварын багц;
- КОВИД-19 дэмжлэгийн буцалтгүй тусламжийн багц хөтөлбөр;
- Ажлын байрыг нэмэгдүүлэх урамшууллын багц;
- Цагаачлалын холбогдолтой арга хэмжээний хөтөлбөр.

Ажил олгогч болон ажилтан бүрт 2019 оны 10-р сараас 2019 оны 12-р сар, 2020 оны 2-р сараас 2021 оны 3-р сар хүртэлх сарын нийт цалингийн эхний 4600 сингапур доллар хүртэлх мөнгөн тэтгэмжийг олгосон ба үүнд зөвхөн Сингапур улсын иргэн болон байнгын оршин суугчдад хамаарна. Үүнд:

<sup>150</sup><https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/singapore-government-and-institution-measures-in-response-to-covid.html>

Ажилтан бүрт олгох сарын нийт цалингийн эхний 4600 сингапур долларын татвараас чөлөөлсөн мөнгөн тэтгэмж	Бүх салбар (тодорхойлсон салбараас бусад)	Нисэх /Агаар мандал судалгаа болон аялал жуулчлал / Бага хурал/ үзэсгэлэнгийн үйлчилгээ	Хоол хүнс, жижиглэн худалдаа, урлаг, үзвэр үйлчилгээ, замын тээвэр, тэнгисийн болон хилийн чанад дахь үйлчилгээ
2019 оны 10-р сараас 2019 оны 12-р сар хүртэл 2-р сараас 2020 оны 3-р сар 6-р сараас 2020 оны 8-р сар хүртэл	25%	75%	50%
2020 оны 4, 5-р сар		75%	
2020 оны 9-р сараас 2021 оны 3-р сар хүртэл	10%	50%	30%

*Ажлын байрыг нэмэгдүүлэх урамшуулал:*

Засгийн газраас ажлын байрыг нэмэгдүүлэхийн тулд 1 тербум сингапур долларыг зарцуулах болсон ба ажилтны цалинг ажил олгогчтой хамтран төлөх арга хэмжээг авсан. Үүнд:

- 40 ба түүнээс дээш насны болон хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөр эрхлэгчдэд сарын цалингийн 50% хүртэл;
  - 40-өөс доош насны хөдөлмөр эрхлэгчдэд: сарын цалингийн 25% хүртэл;
- (Уг урамшуулалд хамрагдахын тулд ажил олгогчид ажлын байрны тоог нэмэгдүүлэх мөн сарын цалингийн хэмжээг 1400 сингапур доллароос багагүй байлгах шаардлагатай.)

*КОВИД-19 дэмжлэгийн буцалтгүй тусламж:*

- Цар тахлаас үүдэн ажилгүй болсон, цомхотголд орсон, гурваас доошгүй сар сул зогсолттой байгаа, сүүлийн 3 сар дараалан сарын цалингийн 30% аа-с дээш хувь буурсан 16-аас дээш насны Сингапур улсын иргэд буюу байнгын оршин суугчид тусламжид хамаарна. Гэхдээ ажилгүй болсон хугацаанаас хойш идэвхтэй ажил хайж байгаа, нэгээс дээшгүй үл хөдлөх хөрөнгөтэй байх шалгуурууд мөн тавигдаж байна.
- Цар тахлаас үүдэн ажлаас чөлөөлөгдсөн бол 3 сарын хугацаатай 800 сингапур долларын мөнгөн тусламжийг олгоно.
- Дараалан гурван сар орлогын хэмжээ нь 30% -иар буурсан бол 3 сарын хугацаатай 500 сингапур долларын мөнгөн тусламжийг олгоно.

*Эдийн засгийг сэргээх арга хэмжээ<sup>151</sup>*

Засгийн газар жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үндсэн зээлийн эргэн төлөлтийг 1 жилийн хугацаатайгаар хойшлуулах хүсэлтийг гаргах боломж олгосон.

Сингапур улсын эрх баригчид цар тахлаас үүдсэн хямралын эсрэг 2-р сарын 18, 3-р сарын 26, 4-р сарын 6, 4-р сарын 21, 5-р сарын 26, 8-р сарын 17-ны өдрүүдэд нийт 100 тэрбум сингапур долларын дэмжлэг үзүүлэхээ мэдэгдсэн. Үүнд:

<sup>151</sup> <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19#T>

- Өрх бүрт үзүүлэх мөнгөн тусламж (20-оос доош насны хүүхэдтэй гэр бүлд илүү өндөр байна) болон бага орлоготой болон ажилгүй иргэдэд нэмэлт дэмжлэг үзүүлнэ.
- Бизнеспэрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгт цалингийн татаас багтаж байна.
- Түрээсийн төлбөрийн дэмжлэг
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон цар тахлын нөлөөлөлд өртсөн салбаруудад (нисэх, аялал жуулчлал, барилга, тээвэр, урлаг, соёл) дэмжлэг олгоно.
- Эрх баригчид урьдчилан тааварлаагүй нөхцөл байдлын сангийн хэмжээг нэмэгдүүлж, мөнгөний урсгалын бэрхшээлтэй тулгарч буй аж ахуйн нэгж, иргэдэд зээл, даатгалын хураамж төлөхөд нь туслах зорилгоор 20 тэрбум сингапур долларын зээлийг хуваарилсан.
- Сингапур улсын мөнгөний удирдлагын газраас (Monetary Authority of Singapore) бизнес эрхлэгч хувь хүмүүс, жижиг дунд эрхлэгч нарын зээл болон даатгалын төлбөрийн дэмжлэгт зориулсан багцыг бүрэлдүүлсэн.

## **ЯПОН УЛС**

*Төсвийн бодлогын арга хэмжээ:*

- 2020 оны 4-р сарын 7-ны өдөр Японы засгийн газар 117.1 их наяд иен (2019 оны ДНБ-ий 21.1 хувь)-ий хэмжээтэй КОВИД-19 цар тахлын эсрэг Эдийн засгийн онцгой байдлын багц арга хэмжээг баталсан бөгөөд энэ нь урд өмнө зарлагдсан багц арга хэмжээнүүдийн үлдэгдлийг багтаан оруулсан (2020 оны 1-р сард баталсан эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээ болон 2-р сарын 13, 3-р сарын 10-ны өдрүүдэд батлагдсан КОВИД-19 цар тахлын эсрэг багц арга хэмжээ тус тус багтана). Дөрөвдүгээр сард батлагдсан энэхүү багц арга хэмжээнүүд нь дараах 5 зорилтыг агуулж байгаа. (i) халдвар дэгдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, эмчилгээний чадавхыг бэхжүүлэх (2019 оны ДНБ-ий 0.5 хувьтай тэнцэх зардал), (ii) хөдөлмөр эрхлэлт болон бизнес эрхлэгчдийг хамгаалах (2019 оны ДНБ-ий 16.0 хувь), (iii) хорио цээрийн дараа эдийн засгийн үйл ажиллагаагаа сэргээх (2019 оны ДНБ-ий 1.5 хувь), (iv) уян хатан эдийн засгийн бүтцийг сэргээн байгуулах (2019 оны ДНБ-ий 2.8 хувь), (v) ирээдүйн бэлэн байдлыг сайжруулах (2019 оны ДНБ-ий 0.3 хувь). Гол арга хэмжээ нь хувь хүн, үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгжүүдэд бэлэн мөнгө тараах, татварын төлбөр болон нийгмийн даатгалын шимтгэлийг хойшлуулах, төрийн болон хувийн санхүүгийн байгууллагуудаас хөнгөлөлттэй зээлээс олгохоос бүрдэнэ.
- 2020 оны 5-р сарын 27-ны өдөр Японы засгийн газар 2020 оны санхүүгийн жилийн хоёр дахь нэмэлт төсвийн төслийг өргөн барьсан (6-р сарын 12-ны өдөр баталсан).

117.1 их наяд иен (2019 оны ДНБ-ий 21.1 хувь)-ийн хэмжээтэй энэхүү багцад (i) эрүүл мэндийн салбарын арга хэмжээ, (ii) бизнес эрхлэгчдийг дэмжих, (iii) өрхүүдэд дэмжлэг үзүүлэх, (iv) орон нутгийн засаг захиргаанд санхүүжилт шилжүүлэх, (v) КОВИД-19 цар тахлын нөөцийн сангийн дээд хэмжээг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүд орно. Тодорхой арга

хэмжээнүүдэд нь: цалингийн татаасыг өргөжүүлэх, төрийн санхүүгийн байгууллагуудаас хоёрдогч өглөгийг үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгжүүдэд олгох, мөн эдгээр аж ахуйн нэгжүүдэд түрээсийн төлбөрийн татаас өгөх зэрэг орно.

## **ГУРАВ. УЛС ОРНУУДЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ**

### **НИДЕРЛАНД УЛС**

*Аж ахуйн нэгж, ажлын байр орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр:*

Засгийн газраас эдийн засаг, ажлын байрыг аврахад чиглэсэн арга хэмжээнүүдийг 3 сарын 17-наас эхлүүлсэн. 10 сарын 1-ээс 3 дахь тусламжийн багцийг хэрэгжүүлж байна. Энэхүү шинэ багц нь 2021 он хүртэл хэрэгжих бөгөөд дэмжлэг, шинэ нөхцөл байдалд дасан зохицоход туслах болон хөрөнгө оруулалт гэсэн гурван тулгуурт суурилсан. Нийт өртөг ойролцоогоор 11 тэрбум еврогийн нэмэлт зардал, 1.5 тэрбум еврогийн эрт үеийн хөрөнгө оруулалтаас бүрдэнэ. Баталгаа, зээл, батлан даалтын сангийн үйл ажиллагаа 10 сарын 1-ээс хойш үргэлжилнэ. Хугацаа хэтэрсэн татварын хүүг бараг “тэг” болгож түр бууруулахыг 2021 оны 12 сарын 31 хүртэл сунгасан.

### **Төлөвлөгөө-3**

2021.07.01 хүртэл 9 сараар сунгаж, нөхөн төлбөрийн хэмжээг аажмаар 3 сараар гурван үе шатаар бууруулна:

1. Хувиараа бизнес эрхэлдэг мэргэжилтнүүдэд зориулсан түр зуурын арга хэмжээ (TOZO)<sup>152</sup>

- 2021.07.01-ний өдрийг хүртэл 9 сараар боломжит хөрөнгийг ашиглах;
- 2021.01.01-ээс эхлэн хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нэмэлт сургалт, давтан сургах, чиг баримжаа олгох боломжийг олгож байна.

2. ЖДҮ-ийн тогтмол зардлыг нөхөн төлөх төлөвлөгөө (Reimbursement of Fixed Costs for SMEs-TVL)-ний хүрээнд

- 2021.07.01 хүртэл сунгаж үе шаттайгаар зогсоно. Энэ хугацаанд компаниуд болон ажилчид дасан зохицох боломжтой болно.
- Нэг компанид ногдох дээд хэмжээг 90 мянган евро болгон нэмэгдүүлэх.

3. Засгийн газраас эмзэг бүлгийн иргэдийг сургах, одоо байгаа ур чадварыг дээшлүүлэх, нэмэлт дэмжлэг үзүүлэхэд зориулж нэг тэрбум еврогийн нэмэлт нийгмийн халамжийн багц олгохоор төлөвлөж байна.

### **СЛОВЕНИ УЛС**

*Хөдөлмөр, нийгэм хамгааллын талаарх арга хэмжээ:*<sup>153</sup>

- Зайнаас ажиллуулах болон ажлын цагийг уян хатан зохион байгуулах дүрэм журмыг хялбаршуулах, богиносгосон цагаар болон цахимаар ажилласан хүмүүсийн цалин хөлсийг 100 хувь олгохоор болсон;
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан хүний өвчтэй байсан 31 хүртэл өдрийн цалинтай чөлөөг олгодог байсныг цар тахлын үед бүх ажилчид цалинтай, өвчний чөлөө авч болохоор болгосон;

<sup>152</sup> A temporary bridging measure for self-employed professionals (TOZO).

<sup>153</sup> <https://www.karanovicpartners.com/news/slovenia-employment-situation-covid-19/>

- Цар тахлаас үүдэн ажилгүй болсон иргэд, нийтийн тээвэр зогссон, хөрш орнуудтай хилийн хязгаар тогтоосны улмаас ажил хийж чадахгүй болсон иргэдэд төсвөөс ажилгүйдлийн нөхөн олговрыг олгохоор болсон. Нөхөн олговор нь ажиллагсдын сүүлийн гурван сарын дундаж цалингийн 80 хувьтай тэнцэх хэмжээний буюу 940.58 еврогоос доошгүй байна;
- Ажил Олгогчдын Холбоо (ZDS) нь ажил олгогчдод зориулсан КОВИД-19 цар тахлын талаарх мэдээлэл, зөвлөгөөг өгдөг тусгай вэбсайтыг бий болгосон;
- Эмч, сувилагч гэх мэт хүнд нөхцөлд ажиллаж буй хүмүүсийн цалин хөлсийг нэмэгдүүлж, харин төрийн өндөр албан тушаалтны цалингахал үргэлжлэх хугацаанд 30 хувь бууруулах шийдвэр гаргасан;
- Сарын тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нь 700 еврогоос бага оюутнууд, олон ам бүлтэй гэр бүл болон бусад тэтгэвэр авагчдад нэг удаагийн санхүүгийн тусламж үзүүлэхээр болсон;
- Халдвар авсны улмаас эмчлүүлж байгаа хүнд тусгаарлагдсан эхний өдрөөс нь тооцож, цалингийн 90 хувийг олгохоор шийдвэрлэсэн.

## **ЭСТОНИ УЛС**

Тус улсад онцгой нөхцөл байдлын улмаас үүсч буй нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор 4-р сараас хэрэгжүүлсэн стратегийн хүрээнд ажиллах хүчнийг дэмжих, сургах, нөхөн олговор олгох, гэрээс ажиллах боломжийг хангах зэргээр олон ажлуудыг шат дараатай авч хэрэгжүүлсэн. Засгийн газраас 11-р сарын 19-ний өдрийн хуралдаанаараа КОВИД-19-ийн хөдөлмөрийн зах зээлийн сөрөг нөлөөллийг бууруулахад туслах хөдөлмөр эрхлэлтийн шинэ хөтөлбөрийг<sup>154</sup> баталжээ. Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр нь Эстоний Ажилгүйдлийн даатгалын сангаас хөдөлмөрийн зах зээлийн үйлчилгээ, дэмжлэгийг авах боломжийг олгож байна.

Хөтөлбөр нь 2021-2023 онд хөдөлмөр эрхлэлтийн одоо байгаа үйлчилгээнүүдээс гадна ажил эрхлэхэд хүндрэлтэй байгаа хүмүүст байнгын дэмжлэг үзүүлэх боломжийг олгосон. Ажил олгогчдыг сургахад дэмжлэг үзүүлэх, бизнес эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх үйлчилгээ, ажил хайгчдад зориулсан хөдөлмөрийн зах зээлийг сургах нөхцөл боломжийг бүрдүүлж байна. Тухайлбал, ажил олгогчид ажилчдынхаа тоог нэмэгдүүлэх, мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр сургалтын дэмжлэгийг нэмэгдүүлэх ба үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэх, ажилгүй болсон менежерүүдэд зориулсан хөгжлийн сургалт явуулах, зөвлөгөө өгөх үйлчилгээг хялбаршуулах, бизнес эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэмжээг 6000 еврогоор нэмэгдүүлэхээр болсон.

Мөн дэмжлэгийн түвшинг тухайн сургалтын зардлын 80 хүртэлх хувьтай уялдуулж, дээд хэмжээг 2500 евро болгон нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажилд авахад дэмжлэг үзүүлэх сургалтын зардлын 100 хүртэлх хувийг, эсвэл 2500 хүртэлх еврог нөхөн олгохыг зөвшөөрнө. Тэтгэлэг авах сургалтын доод хэмжээг 80 цагаас 50 цаг болгож бууруулсан.

2021 оны 1-р сарын 1-ээс 12-р сарын 31-ний хооронд хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийн санхүүгийн хэмжээ 56.7 сая евро, 2022 онд 58.8 сая евро, 2023 онд 55.8 сая евро хүртэл байна. Үүнд: хөдөлмөрийн зах зээлийн үйлчилгээ үзүүлэх, тэтгэлэг, аялал жуулчлал, байрны тэтгэмж төлөхөд зориулж төлөвлөсөн мөнгөн дүн орно.

<sup>154</sup><https://tooeu.ee/et/uudised/COVID-19-ja-tooelu/2806/koroonaviirus-sars-cov-2-lisa-takse-tookeskkonna-bioloogiliste-ohutegurite-nimekirja>

11-р сарын 1-ний байдлаар 50.487 бүртгэлтэй хүн иргэд байгаа бөгөөд энэ нь онцгой байдлын эхэн үетэй ойролцоогоор 37% -иар өссөн үзүүлэлттэй байна.

Мөн Нийгмийн яамнаас Биологийн аюулын тухай журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг яам, түнш байгууллагуудад батлуулахаар хүргүүлсэн байна. Нэмэлт, өөрчлөлтөөр ажлын орчин дахь биологийн аюулын эрсдлийн бүлгүүдийн жагсаалтад шинэ биологийн аюул болох коронавирус SARS-CoV-2-ийг багтаасан. Энэ нь ажлын байран дахь ажилчдын эрүүл мэндийг зохих ёсоор хамгаалах, вирусийн тархалтын үед аюулгүй байдлыг хангах боломжийг бүрдүүлнэ.

## **ВЬЕТНАМ УЛС**

Үйлдвэрчний эвлэл нь ажил олгогчидтой санал солилцон, КОВИД-19 цар тахлын үеэр сургууль, цэцэрлэг хаасантай холбогдуулан ажилтнуудад хүүхдээ асрах боломжийг олгох асуудлаар амралт болон ажлын цагийг уян хатан байдлаар зохицуулах, ажлын ээлжийг зүй зохистой зохион байгуулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Хөл хорионд гэрээсээ ажиллаж буй иргэдэд цалингийн 70%-ийг олгох эсхүл хуульд зааснаар бүс нутгийн хэмжээнд мөрдөж буй цалингийн хамгийн доод хэмжээнээс багагүйгээр цалинг тооцож олгох, эсхүл ажилчдад амралтыг нь олгох талаар мөн ажил олгогчидтой хэлэлцсэн байна.

## **ЯПОН УЛС**

*Нийгэм, эдийн засгийн хувьд авсан арга хэмжээ<sup>155</sup>*

### **✓ Амьжиргааны халамжийн сангийн зээлийн систем**

Шинэ коронавирүсийн нөлөөгөөр чөлөө авахаас өөр аргагүйд хүрсэн эсвэл ажилгүй амьжиргааны эх үүсвэрээ алдсан иргэдийг дэмжих "амьжиргааны халамжийн сангийн зээлийн тогтолцоо"-г бий болгосон. Энэ тогтолцооны дагуу дэмжлэгийн хэмжээ нь тухайн хүн чөлөө авсан, эсвэл ажилгүй байгаа хугацаанаас хамаарч харилцан адилгүй байна.

- “Амралт”-ын улмаас орлогоо алдаж, түр зуурын хөрөнгө шаардагдах хүмүүс 100,000 иен хүртэл зээл авах;
- “Ажилгүйдэл”-ийн улмаас орлогогүй болсон ганц бие хүмүүст сард 150,000 иен, хоёр ба түүнээс дээш гишүүнтэй өрхүүд 200,000 иен хүртэл зээл авах боломжтой бөгөөд тус бүр нь гурван сарын хугацаатай хүүгүй зээлэх боломжийг бүрдүүлсний зэрэгцээ зээлийн эргэн төлөлтөд уян хатан хандахаа Засгийн газар мэдэгдсэн.

### **✓ Нийтийн үйлчилгээний төлбөрийг хойшлуулах**

Хэрэв хэрэглээний төлбөрөө төлөхөд хэцүү байгаа тохиолдолд төлбөрийг хойшлуулах боломжийг бүрдүүлсэн.

- Цахилгаан эрчим хүчний болон хийн томоохон компаниуд төлбөрийн хугацааг нэг сараар сунгах арга хэмжээ авч сунгасан. Нэмж дурдахад, засгийн газар цахилгаан эрчим хүчний байгууллагуудаас уян хатан арга хэмжээ авахыг шаардаж байгаа тул төлбөр хойшлогдвол цахилгаан, хийг шууд зогсоохгүй байхаар зөвлөлдсөн.
- Утасны төлбөрийг 5-р сарын сүүл хүртэл сунгасан.

<sup>155</sup> <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>



✓ Тэтгэврийн шимтгэлээс чөлөөлөх тусгай арга хэмжээ

Цар тахлын тархалтаас болж орлого нь эрс буурсан хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн шимтгэлийн төлбөрийг нэн даруй чөлөөлөх тусгай арга хэмжээ авах боломжтой болсон.

✓ Татвар төлөх хугацааг хойшлуулах, чөлөөлөх

Японы Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийн яаралтай арга хэмжээнд татварын арга хэмжээ багтдаг бөгөөд зарим тохиолдолд татвар төлөх хугацааг хойшлуулж эсвэл чөлөөлж болно.

Хувиараа бизнес эрхлэгчид, түүний дотор орлого нь эрс буурсан чөлөөт бизнес эрхлэгчдийг орлогын албан татвар, хэрэглээний татвар гэх мэт татвараа төлөх, үндсэн хөрөнгийн татвар зэрэг орон нутгийн татварыг “нэг” жилээр хойшлуулсан.

Энэ нь 2-р сараас хойш нэг сар гаруй хугацаанд орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20% ба түүнээс дээш хувиар буурсан тохиолдлуудад хамаарна.

Ердийн үед татвар төлөх, хураах асуудлыг хойшлуулахдаа зарчмын хувьд барьцаа хөрөнгө өгөх шаардлагатай байдаг ба хожимдсон татвар, хугацаа хэтэрсэн төлбөрийг мөн ногдуулдаг боловч энэ удаад онцгой тохиолдолд хоёуланг нь чөлөөлнө.

Хэрэв энэ чөлөөлөлтийг олговол тэтгэвэр, эрүүл мэндийн даатгал зэрэг нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийг хойшлуулах болно.

✓ Тэтгэмж өгөх

Хөдөлмөрийн стандартын тухай хуулийн дагуу тухайн компанийн нөхцөл байдлаас шалтгаалан ажилчдаа ажлаас нь халсан тохиолдолд компани дундаж цалингийн 60 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний "чөлөөний тэтгэмж" төлөх бөгөөд Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн яам нь дундаж цалингийн хэмжээг бүрэн хэмжээгээр төлдөг.

✓ Сургуулийн амралтын татаас /дэмжлэгийн сан

Ажил эрхэлж буй хүмүүс нь Бага сургууль, цэцэрлэг, яслийг түр хугацаагаар хааснаас болж хүүхдээ асрахын тулд ажлаасаа завсарлага авах шаардлагатай бол асран хамгаалагч нь жилийн цалинтай амралтаас гадна амралт авбал өдрийн хэмжээ 8330 иенээр тооцож олгоно.

✓ Орон сууцны төлбөрийн асуудал /түрээс/

Өрхийн орлого, хадгаламжийн тодорхой стандартууд байдаг бөгөөд бүс нутгаас хамааран харилцан адилгүй байдаг.

✓ Судалгааг дэмжих систем

- Өрхийн төсөв нь гэнэт буурсан оюутнууд тэр дундаа технологийн коллежид суралцаж байгаа оюутнуудад сургалтын төлбөрийг бууруулж, хөнгөлөлт, тэтгэмжийн тэтгэлэг олгодог "Суралцах шинэ системийг дэмжих" тэтгэмж байна.
- Яаралтай тусламжийн үеийн оюутны дэмжлэг болох тэтгэмж нь хэрэв коллежийн оюутан эсвэл бусад оюутан чөлөө авсны улмаас цагийн ажил эрхлэхээ больж, үргэлжлүүлэн суралцахад хэцүү болсон бол дээд тал нь 200,000 иен авах боломжийг бүрдүүлсэн.

✓ Хүчирхийллийн эсрэг

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан DV=гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон хохирсон тохиолдолд мэдээлэх, зөвлөлдөх цэгүүдийг орон даяар байршуулан ажиллуулж байна.

## **ДӨРӨВ. УЛС ОРНУУДЫН КОВИДЫН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

### **НИДЕРЛАНД УЛС**

Парламентаас КОВИД-19 цар тахлын талаар дараах хууль тогтоомжийг баталсан байна.

- КОВИД-19 цар тахлын эсрэг Арга хэмжээний түр хууль<sup>156</sup> (2020.03.16)
- Энэхүү хууль нь коронавирусийн тархалт буюу түүний шууд аюул заналхийлэлтэй тэмцэхийн тулд ойрын хугацаанд шаардлагатай арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлсэн. Энэхүү хууль нь 12 дугаар сарын 1 хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- КОВИД-19 цар тахлын Арга хэмжээний түр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (дамлуурлын хүсэлтийг түдгэлзүүлэх болон нөхөн сэргээх арга хэмжээг үргэлжлүүлэх) (2020.11.24)<sup>157</sup>

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр дампуурлын хүсэлт гаргасан зээлдэгчийн хүсэлтийг түдгэлзүүлэх, зээлдэгчид нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх, төлбөрийг түр хугацаагаар хойшлуулах талаар тусгасан. Мөн өмнө хэрэгжүүлж байсан арга хэмжээг үргэлжлүүлэхээр тогтоосон.

### **ШИНЭ ЗЕЛАНД**

3 дугаар сарын 25-нд парламент цөөн тооны гишүүдийн бүрэлдэхүүнтэй хуралдаж Ерөнхий сайдаас КОВИД-19 цар тахлын тархалтын талаарх албан ёсны мэдээллийг хүлээн авч хэлэлцсэн бөгөөд энэ үед сөрөг хүчний парламентын гишүүдтэй хамтран “тархалтын хариу арга хэмжээний хороо-Epidemic Response Committee”-г 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Мөн Засгийн газарт шаардлагатай санхүүжилтийн арга хэмжээ авах эрх олгох хуулийн төслийг баталсан.<sup>158</sup>

Шинэ Зеландын парламентын сонгууль 10 дугаар сарын 17-ны өдөр болсон бөгөөд шинээр сонгогдсон парламент буюу 53 дахь удаагийн парламентын нээлт 11 дүгээр сарын 25-д болсон.<sup>159</sup>

КОВИД-19 цар тахлын дэгдэлт эхэлсэн 2 дугаар сараас хойш тус улсын парламентаас дараах хууль тогтоомжийг батлан гаргасан байна. Үүнд:<sup>160</sup>

- КОВИД-19 нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний тухай хууль (2020.03.13)

<sup>156</sup> <https://globalcompliancenews.com/netherlands-temporary-covid-19-act-allows-virtual-meetings-for-legal-entities-05102020/>

<sup>157</sup> <https://www.natlawreview.com/article/amendments-to-temporary-act-covid-19-tijdelijke-wet-covid-19-suspension-bankruptcy>

<sup>158</sup> <https://www.ipu.org/country-compilation-parliamentary-responses-pandemic#N>

<sup>159</sup> <https://www.parliament.nz/en/>

<sup>160</sup> <https://covid19.govt.nz/updates-and-resources/legislation-and-key-documents/>

- КОВИД-19 нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2020.08.16)
- КОВИД-19 Сэргээх тухай хууль (2020.07.06) Covid-19 Recovery (Fast-track Consenting) Act
- КОВИД-19 Хариу арга хэмжээ (цаашдын менежментийн арга хэмжээ)-ний хууль тогтоомжийн хууль (2020.05.15)
- КОВИД-19 Хариу арга хэмжээ (цаашдын менежментийн арга хэмжээ)-ний хууль тогтоомжийн хууль-2 (2020.08.06)
- КОВИД-19 Хариу арга хэмжээ (аж ахуйн нэгжид тавигдах шаардлага-өөрчлөлт ба хөнгөлөлт)-ний тухай хууль (2020.05.15)
- КОВИД-19 Хариу арга хэмжээ (татварын болон бусад яаралтай арга хэмжээний тухай)-ний хууль (2020.04.30)
- КОВИД-19 Хариу арга хэмжээ (яаралтай менежментийн арга хэмжээ)-ний хууль тогтоомжийн тухай хууль (2020.03.25)
- Цагаачлал (КОВИД-19 хариу арга хэмжээ)-ын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2020.05.15)
- Зээлийн нийлүүлэлтийн (2019/20 оны гуравдахь) тухай хууль (2020.03.25)
- Гадаадын хөрөнгө оруулалт (яаралтай арга хэмжээнүүд)-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2020.06.02)
- Нөхөн олговрын удирдлага (КОВИД-19 арга хэмжээ)-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2020.05.15)
- Нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2020.06.02)

## **ЭСТОНИ УЛС**

Эстонийн Парламент 2020.04.13-нд Үндсэн хуулийн хороо нь Рийгикогууд алсын зайнаас ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан өргөн барьсан<sup>161</sup> ба 2020.06.02-нд Парламентын дэг, дотоод журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн баталсан байна.

## **БНСУ**

БНСУ-ын Үндэсний Ассамблей 2-р сарын 26-аас КОВИД-19-ийн халдвар хурдацтай нэмэгдсэнтэй холбогдуулан хариу арга хэмжээ авах зорилгоор гурван хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Үүнд: Халдварт өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх хууль (Infectious Disease Control and Prevention Act), Хорио цээрийн тухай хууль (Quarantine Act), Эмнэлгийн үйлчилгээний тухай хуулиудад (Medical Service Act) нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Нэмэлт, өөрчлөлт нь Засгийн газар болон эрүүл мэндийн байгууллагуудад цаашид вирусийн тархалтаас урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн байна. Жишээлбэл, Халдварт өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр төрөөс шинжилгээнд хамрагдахаас татгалзсан сэжигтэй өвчтөнүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хорио цээрийн журам зөрчсөн тохиолдолд дээд тал нь нэг жилийн хорих ялаар шийтгэх эсвэл торгох (ойролцоогоор 1000 USD) шийтгэлийг оногдуулахаар болжээ.

<sup>161</sup> <https://www.riigikogu.ee/pressiteated/pohiseaduskomisjon-et-et/pohiseaduskomisjon-algas-seadusemuudatused-riigikogu-kaugtoo-voimaldamiseks/>

**СЛОВЕНИ УЛС**<sup>162</sup>

Ассамблей нь коронавирусийн халдвар илэрсэн даруйд шуурхай хуралдаж, 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр “Коронагийн эсрэг” хуулийг баталжээ. Парламентын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай үндсэн болон бусад ажилтнуудыг эс тооцвол Үндэсний Ассамблейн олонх ажилтнууд цахим хэлбэрээр зайнаас ажиллаж байна. Парламентын 49 дүгээр ээлжит бус чуулганаар КОВИД-19 цар тахлын хоёр дахь давалгааны үр дагаврыг бууруулах зорилгоор “Коронагийн эсрэг” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Уг нэмэлт, өөрчлөлтөөр КОВИД-19 цар тахлын үеийн эдийн засаг, хөдөлмөр, нийгэм хамгаалал, эрүүл мэндийн салбарт үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах зохицуулалтыг оруулсан байна.

**ТАЙВАНЬ УЛС**

Тус улс цар тахлын дэгдэлт, тархалтыг зогсоох зорилгоор Халдварт өвчнийг хянах тухай хууль<sup>163</sup> (The Communicable Disease Control Act (CDCA)) ийг 2019 шинэчлэн баталсан. Уг хуулийн зорилго нь халдварт өвчнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, тархалтыг сааруулах зорилготой. Харин КОВИД-19 цар тахлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2020 оны 2-р сарын 25-ны өдөр шинээр батлагдсан “Шинэ төрлийн хүнд хэлбэрийн уушгины хатгалгаа үүсгэгч өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэтгэмж олгох, сэргээх арга хэмжээний тухай тусгай хуулиар”<sup>164</sup> (Special Act for Prevention, Relief and Revitalization Measures for Severe Pneumonia with Novel Pathogens) зохицуулж өгсөн байна.

Халдварт өвчнийг хянах тухай хууль нь нийт 7 бүлэг 77 зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- Бүлэг 1: Нийтлэг зүйл
- Бүлэг 2: Халдварт өвчний хяналтын систем
- Бүлэг 3: Халдварт өвчнийг хянах арга хэмжээ
- Бүлэг 4: Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
- Бүлэг 5: Хөл хорионы арга хэмжээ
- Бүлэг 6: Торгууль
- Бүлэг 7: Нэмэлт заалтууд

Шинэ төрлийн хүнд хэлбэрийн уушгины хатгалгаа үүсгэгч өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэтгэмж олгох, сэргээх арга хэмжээний тухай тусгай хууль нь нийт 19 зүйлээс бүрдэнэ. Энэхүү хууль нь КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хянах, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчлөлөөс үүссэн дотоодын эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор түр хугацаанд батлагдсан. Жишээлбэл, уг хуульд Эрүүл мэндийн төв эрх бүхий байгууллага нь эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлдэг эмнэлгийн ажилтнуудад татаас, тэтгэмж олгох, хуульд заасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх явцад хүнд хэлбэрийн уушгины хатгалгаа өвчнөөр өвчилсөн бол Эрүүл мэндийн эрх бүхий төв байгууллага нь нөхөн төлбөр олгож, төрөл бүрийн төлбөр эсвэл тэдний хүүхдүүдийн боловсролын зардалд татаас олгох талаар зохицуулж өгсөн байна.

<sup>162</sup> <https://www.gov.si/en/state-authorities/government/>

<sup>163</sup> <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=L0050001>

<sup>164</sup> <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=L0050039>

**СИНГАПУР УЛС**<sup>165</sup>

КОВИД-19 Түр зуурын арга хэмжээ авах тухай хууль<sup>166</sup> /Covid-19 (temporary measures) act 2020/ нь 2020 оны 4-р сарын 9-нд батлагдсан. Энэхүү хуулийн зорилго нь цар тахалтай холбоотой түр зуурын арга хэмжээ авах болон аж ахуйн нэгж байгууллагуудын асуудлыг шийдэх зорилготой. Одоогийн байдлаар цар тахлын үед зохицуулах арга хэмжээнүүдийн тухай нэн шаардлагатай гэж үзсэн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай хуулиудад дараах чиглэлийг баримтална. Үүнд:

- Гэрээний үүргээ биелүүлэх чадваргүй болох үеийн түр зуурын дэмжлэг
- Түрээсийн тусламжийн тухай
- Санхүүгийн хүндрэлтэй хувь хүмүүс болон бизнес эрхлэгчдэд зориулсан түр зуурын тусламж үзүүлэх тухай
- Хурал, уулзалтын түр арга хэмжээ
- Барилгын ажлын зогсолтыг зохицуулах
- КОВИД-19 цар тахлын нөлөөнд ихээхэн нөлөөлсөн бизнес эрхлэгчдийн гэрээг дахин хэлэлцэх тухай

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>165</sup> <https://sso.agc.gov.sg/Act/COVID19TMA2020>

<sup>166</sup> <https://sso.agc.gov.sg/Act/COVID19TMA2020>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <https://www.endcoronavirus.org/countries>
- <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/COVID-Lending-Tracker#AFR>
- <https://www.imf.org/en/About/FAQ/imf-response-to-covid-19>
- <https://www.uschamber.com/international-affairs-division/covid-dashboard>
- [www.tootukassa.ee/eng/content/temporary-subsidy-program](http://www.tootukassa.ee/eng/content/temporary-subsidy-program)
- [https://www.worldometers.info/coronavirus/?utm\\_campaign=homeAdvegas1?](https://www.worldometers.info/coronavirus/?utm_campaign=homeAdvegas1?)
- [https://www.worldometers.info/coronavirus/?utm\\_campaign=homeAdvegas1?](https://www.worldometers.info/coronavirus/?utm_campaign=homeAdvegas1?)
- <http://ncov.mohw.go.kr/en>
- Covid-19 Цар Тахлын Үед Бнсу-Ын Хариу Арга Хэмжээ Авсан Бодлого Б.Урангоо
- <https://www.worldometers.info/coronavirus/#countries>
- <https://www.ilo.org/global/topics/coronavirus/regional-country/country-responses/lang--en/index.htm#NO>
- <https://www.weforum.org/agenda/2020/03/chinas-response-shows-how-bold-decision-making-can-contain-coronavirus/>
- Policy Responses to COVID19 (imf.org)
- Country policy responses (COVID-19 and the world of work) (ilo.org)
- A scaleup (company) is a company who has an average annualized return of at least 20% in the past 3 years with at least 10 employees in the beginning of the period (OECD, 2007).
- Policy Responses to COVID19 (imf.org)
- Overview of Country Tax Policy measures in response to Covid-19 crisis <https://www.nordeatrade.com/en/explore-new-market/slovenia/economical-context>
- <https://www.regjeringen.no/en/topics/the-economy/economic-policy/economic-measures-in-norway-in-response-to-covid-19/id2703484/>
- <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/taiwan-government-and-institution-measures-in-response-to-covid.html><https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>
- <https://home.kpmg/xx/en/home/insights/2020/04/singapore-government-and-institution-measures-in-response-to-covid.html>
- A temporary bridging measure for self-employed professionals (TOZO). <https://www.karanovicpartners.com/news/slovenia-employment-situation-covid-19/>
- <https://tooelu.ee/et/uudised/COVID-19-ja-tooelu/2806/koroonaviirus-sars-cov-2-lisatakse-tookeskkonna-bioloogiliste-ohutegurite-nimekirja>
- <https://www.ipu.org/country-compilation-parliamentary-responses-pandemic#N>
- <https://globalcompliancenews.com/netherlands-temporary-covid-19-act-allows-virtual-meetings-for-legal-entities-05102020/>
- <https://www.natlawreview.com/article/amendments-to-temporary-act-covid-19-tijdelijke-wet-covid-19-suspension-bankruptcy>
- <https://www.ipu.org/country-compilation-parliamentary-responses-pandemic#N>
- <https://www.parliament.nz/en/>
- <https://covid19.govt.nz/updates-and-resources/legislation-and-key-documents/>
- <https://www.riigiteataja.ee/en/eli/504062020005/consolide>



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ЦАР ТАХЛЫН НИЙГЭМ, ЭДИЙН  
ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, ИРГЭДИЙН АМЬЖИРГААГ ДЭМЖИХ  
ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ**

(2020 оны 11-р сарын 30-ны байдлаар)

*Б.Төмөр-Очир*

**АГУУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ЦАР ТАХЛЫН ҮЕД НИЙГЭМ, ЭДИЙН  
ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, ИРГЭДИЙН АМЬЖИРГААГ ДЭМЖИХ  
ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ:

**УИХ-ын шийдвэрүүд:**

Нэг. Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх,  
нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль

Хоёр. УИХ-ын 2020 оны 04-р сарын 09-ний өдрийн 21-р тогтоол

Гурав. УИХ-ын 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 32-р тогтоол

**Засгийн газрын шийдвэрүүд:**

Нэг. Монгол Улсын Засгийн Газраас цар тахалын үед авч хэрэгжүүлж  
буй эхний арга хэмжээ буюу 114-р тогтоол

Хоёр. Монгол Улсын Засгийн Газраас цар тахалын үед авч хэрэгжүүлж  
буй хоёр дах арга хэмжээ буюу 167-р тогтоол

Гурав. Монгол Улсын Засгийн Газраас цар тахалын үед авч хэрэгжүүлж  
буй гурав дах арга хэмжээ буюу 183-р тогтоол

**Цар тахлын үеийн нөхцөл байдлын талаар хийсэн судалгааны тойм:**

1. КОВИД-19-ийн нөлөөллийг даван туулах өрхүүдийн арга хэмжээний судалгаа
2. КОВИД-19 цар тахал ба Монголын эдийн засаг судалгаа
3. “Коронавирус ба эдийн засаг” ҮСХ-ны 10-р сарын судалгаа
4. МҮХАҮТ-Хөл хорионы үеийн бизнесийн нөхцөл байдлын судалгааны үр дүн

## **МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ЦАР ТАХЛЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, ИРГЭДИЙН АМЬЖИРГААГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ**

Монгол Улсад коронавирусийн анхны тохиолдол 2020 оны 03-р сарны 10-ны өдөр бүртгэгдсэнийг Улсын комиссоос зарлаж байсан бол 2020 оны 11-р сарын 11-ний өдөр дотооддоо халдвар бүртгэгдсэнийг зарлан 2020 оны 11-р сарын 12-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хөл хорио тогтоогоод байна.

Анх шинэ коронавирусийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн Газрын 2020 оны 01-р сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30-р тогтоол баталсанаас хойш Монгол Улсын хэмжээнд нийтдээ коронавирусийн цар тахалтай холбоотой 1 хууль, УИХ-ын 4 тогтоол, Засгийн газрын 36 тогтоол батлагдсан байна.

Дэлхийн эдийн засагт КОВИД-19 цар тахлаас үүдсэн хямрал үүсээд байна. Энэхүү цар тахалаас үүдэлтэй хямралаас сэргийлэхийн тулд улс орнуудын бодлого тодорхойлогчид шуурхай ажиллаж байна. Цар тахлын нөлөө нь манай улсын нийгэм, эдийн засгийн байдалд шууд болон шууд бусаар сөрөг нөлөө үзүүлж байгаа бөгөөд эдгээр хууль, тогтоолоор КОВИД-19-ийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг бууруулах, тархалтыг зогсоох, хариу арга хэмжээг Монгол Улсын төрөөс шуурхай, шат дараатай арга хэмжээнүүд авсаар байна.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас цар тахлын нийгэм эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах хариу арга хэмжээний хүрээнд гаргасан шийдвэрүүд, авсан арга хэмжээний тойм:

### **УЛСЫН ИХ ХУРЛЫН ШИЙДВЭРҮҮД**

**Нэг. Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль**<sup>167</sup>

2020 оны 4 сарын 29-нд баталсан уг хуулийн зорилт нь коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах юм.

1. Хуулийн үйлчлэх хүрээ болон коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд баримтлах зарчим, нэр томъёог тодорхойлсон.
2. КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын Онцгой комисс, Төв банк, арилжааны банк болон бусад төрийн байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон.
3. Иргэн, аж ахуйн нэгжийн эрх, үүрэг, үйл ажиллагаанд хориглох зүйлийг тусгасан.
4. Бусад зохицуулалтын хүрээнд хандив, эд хөрөнгийн дайчилгаа, хуулийн үйлчлэх хугацаа зэргийг тусгасан.

<sup>167</sup> <https://www.legalinfo.mn/law/details/15312?lawid=15312>

**Хоёр. УИХ-ын 2020 оны 04-р сарын 09-ний өдрийн 21-р тогтоол<sup>168</sup>**

КОВИД-19-ийн цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай тогтоолыг баталснаар дараах цогц асуудлыг зохицуулсан эрх зүйн орчныг бий болгов.

2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд:

1. Төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд ажилладаг иргэдээс бусад иргэдийн олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх;
2. Сайн дураар даатгуулсан иргэний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлж, даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцох;
3. Үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалсан, мөн хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн төрийн байгууллагаас бусад хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчийн төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцох;
4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага байсан төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад албан татвар төлөгчийн олсон орлогод ногдуулан тайлагнасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг чөлөөлөх;
5. КОВИД-19 цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон, мөн 2020 оны 2, 3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан аж ахуйн нэгжүүд ажлын байрыг хадгалж байгаа бол уг аж ахуйн нэгжийн даатгуулагч иргэнд 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгох;
6. 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд ногдуулж тайлагнасан боловч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагыг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан торгох шийтгэлээс чөлөөлөх;
7. 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд татвар төлөгчийн хуулийн дагуу ногдуулан тайлагнасан төлбөл зохих татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас тухайн татвар төлөгчийг нэг удаа чөлөөлөх;

<sup>168</sup> <https://www.legalinfo.mn/law/details/15236?lawid=15236>

8. 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлсэн албан татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан тохиолдолд бууруулсан хэмжээгээр түрээсийн орлогод ногдуулах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэх;
9. 2020.03.01-2020.06.30-ны хооронд стратегийн зарим хүнсний барааг импортлоход гаалийн болон импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх;
10. Дотоодын аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хийхдээ нэн тэргүүнд үндэсний үйлдвэрлэгчийг шалгаруулах зарчим баримтлах зэрэг зохицуулалт болно.

### **Гурав. УИХ-ын 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 32-р тогтоол<sup>169</sup>**

КОВИД-19-ийн цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай:

Монгол Улсын урт хугацааны тогтвортой өсөлтөд дэмжлэг үзүүлж, үүсэх эрсдэлээс хамгаалж, санхүүгийн чадвартай байх, эрүүл, тогтвортой, зохистой засаглал бүхий банкны салбарыг бий болгох шинэчлэлийн хөтөлбөрийг гаргаж, хэрэгжүүлэх, зээл, санхүүжилтийн хүү болон эх үүсвэрийн зардлыг бууруулах, цар тахлын үед төрөөс нийгмийн шаардлагатай хэсэгт хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх, хүн амын эрүүл мэнд улсын аюулгүй байдлын төлөө эрсдэл гарган тасралтгүй ажиллаж байгаа төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагчдад ипотекийн зээлийн тусгай бүтээгдэхүүн гаргах, жижиг дунд үйлдвэрийн зээлд төрөөс гаргах батлан даалт болон улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, банкны бус санхүүгийн салбарыг зохицуулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор ноолуурын түүхий эдийн нөөц бүрдүүлэх, ноолуурын үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох, ноолуурын экспортыг дэмжих чиглэлээр ноолуурыг хилийн бүх боомтуудаар саадгүй нэвтрүүлэх, холбогдох хураамжуудын хэмжээг “0” болгох, малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20 000 төгрөгийн урамшууллыг малчин өрх бүрд олгох зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх эрх зүйн орчиныг бүрдүүлсэн.

### **ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРҮҮД**

#### **Нэг. Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 03-р сарын 27-ны өдрийн 114-р тогтоол:**

Эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай<sup>170</sup>

1. 2020 оны 04 сарын 01-нээс 10-р сарын 01-ний өдөр хүртэл зургаан сарын хугацаанд аж ахуйн нэгж, компаниудыг НДШ-ээс чөлөөлөв
2. 2020 оны 04 сарын 01-нээс 10-р сарын 01-ний өдөр хүртэл зургаан сарын хугацаанд ажилтан, албан хаагчдын цалин, хөлст ХХОАТ ногдуулахгүй байх,

<sup>169</sup> <https://www.legalinfo.mn/law/details/15310>

<sup>170</sup> <https://www.legalinfo.mn/law/details/15279?lawid=15279>

3. 2020 оны 04 сарын 01-нээс 10-р сарын 01-ний өдөр хүртэл зургаан сарын хугацаанд албан татвар ногдох орлогын дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага албан татвар төлөгчдийг ААН-ийн ОАТ-аас чөлөөлөв.
4. КОВИД-19 халдвараас шалтгаалан үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байраа хадгалсан хувийн хэвшлийн ажилтан бүрт гурван сарын хугацаанд сар бүр 200,000 төгрөгийн бэлэн мөнгөний дэмжлэг олгох,
5. Ноолуур бэлтгэлийн цаг болсонтой холбогдуулан, малчдын амьжиргааг дэмжих зорилгоор ноолуур худалдан авагч, бэлтгэгчдэд 3% хүүтэй нэн хөнгөлөлттэй зээл олгох
6. Хүүхдийн мөнгийг гурван сарын хугацаанд 10,000 төгрөгөөр нэмэгдүүлж олгох,
7. 2020 оны 04-р сарын 15-ны өдрөөс бензин, шатахууныг литр тутамд 300, түүнээс дээш төгрөгөөр бууруулах зэрэг дэмжлэгүүд

**Хоёр. Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 05-р сарын 06-ны өдрийн 167-р тогтоол**

КОВИД-19 цар тахлын үед төсвийн Зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай<sup>171</sup>

1. 0-18 насны хүүхэд бүрт 04 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 70,000 төгрөгөөр нэмэгдүүлж 100,000 болгон олгох
2. Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгож байгаа хүнсний талоныг 05 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хоёр дахин нэмэгдүүлнэ. Ингэснээр 122 мянган насанд хүрэгч 32,000 төгрөг, 118 мянган хүүхэд тус бүр 16,000 төгрөгийн хүнсний талоны дэмжлэг үзүүлэх
3. Нийгмийн халамжийн сангаас сар бүр дараах иргэдэд олгодог 188 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 05 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд тус бүр 100,000 төгрөгөөр нэмэгдүүлж олгох
4. Малчдын орлогыг нэмэгдүүлж, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талаар УИХ-аас өгсөн чиглэлийн дагуу малчдад тушаасан ноолуурын нэг килограмм тутамд 20,000 төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэлээ. Урамшууллыг 2019 оны жилийн эцсийн мал тооллогын А данс дахь ямааны тоог үндэслэн олгох зэрэг дэмжлэгт 793.6 тэрбум төгрөг зарцуулахаар тооцож байсан байна.

**Гурав. Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 11-р сарын 18-ны өдрийн 183-р тогтоол**

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай<sup>172</sup>

1. Хүүхдийн 100 мянган төгрөг 2021 оны долдугаар сарын 1-н хүртэл олгох;

<sup>171</sup> <https://www.legalinfo.mn/law/details/15358?lawid=15358>

<sup>172</sup> <https://www.legalinfo.mn/law/details/15730?lawid=15730>

2. 2020.11.01-2021.07.01 хүртэл НДШ төлөөгүй ААН, байгууллагыг алданги, торгуулиас чөлөөлөх хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэх;
3. ААН, байгууллагын төлбөл зохих татварт алданги тооцохгүй. 2021 оны долдугаар сарын 1-ний өдрийг хүртэл хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэх;
4. Түрээсийн төлбөрөө бууруулсан нь холбогдох баримтаар тогтоогдож байгаа зах, худалдааны төвийн болон үйлдвэрлэл, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлэгчийн түрээсийн орлогод түрээсийн төлбөр бууруулсан хэмжээгээр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлтийг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд эдлүүлэх хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэх;
5. Хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор импортлох бүх төрлийн хүнсний будаа, ургамлын тос, өвс, хүнсний улаан буудай зэрэг импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас, Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсруулж дотооддоо борлуулсан хүнсний будаа, ургамлын тос, өвс, мал, амьтны бүх төрлийн тэжээлийг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд тус тус чөлөөлөх хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэх;
6. Төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацааны үндсэн болон хүүгийн төлбөрийг зээлдэгчийн хүсэлтэд үндэслэн хойшлуулах, ингэхдээ үлдэгдэл төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр зээлийн гэрээний хугацааг сунгах зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Сангийн сайдад даалгаж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус зөвлөх;
7. Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооноос иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацааг зээлдэгчийн хүсэлтийг харгалзан нэмэгдүүлсэн хүү, торгууль, алданги тооцохгүйгээр зээлдэгчид ямар нэгэн дарамт үүсгэхгүй байхаар төлбөрийн чадварт нь нийцүүлэн гэрээнд өөрчлөлт оруулах зохицуулалтын арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд авч хэрэгжүүлэхийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус зөвлөх;
8. Монгол, Хятадын хилийн боомтод хэрэгжүүлж буй “Ногоон гарц”-ын үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигт малтмал, газрын тосны экспортыг хэвийн, тасралтгүй явуулах саналыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд дипломат шугамаар тавьж харилцан тохиролцохыг холбогдох байгууллагуудад даалгах
9. Татвар төлөгчийн хүсэлтээр татварын өрийг тухай бүрд суутгах;
10. Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн, бизнесийг сэргээхэд чиглүүлэх. Тус сангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх;
11. Төсвийн, төрийн өмчийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлсэн иргэд, байгууллагад төлбөрийг шуурхай олгох;



12. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих;

13. ААН-ийн үйл ажиллагааг хэвийн явуулахад анхаарах.

Дээрх хууль, тогтоомжийн хүрээнд хийгдсэн шат дараатай арга хэмжээнүүдээс гадна дараах нийгэм эдийн засгийн чиглэлээр үр нөлөөг тооцох судалгаануудыг хийсэн байна.

## ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТОЙМ

### 1. КОВИД-19-ийн нөлөөллийг даван туулах өрхүүдийн арга хэмжээний судалгаа<sup>173</sup>

Коронавирусын өрхөд үзүүлж буй нөлөөг “цаг тухайд нь” хянах зорилгоор Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк хамтран 2020 оны 05-р сарын 22-29 өдрүүдэд 1334 өрх хамрагдсан уг судалгааны үр дүнг тоймловол:

- Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 73 хувь нь 1 сарын сүүлээс хойш орлого багассан, 16 хувь нь ямар орлогогүй болсон гэж хариулсан байна. Энэ нь КОВИД-19-ийн улмаас худалдан авагч цөөрсөн, ажлын байр хаагдсан, ложистик тасалдсантай холбоотой.
- Цалинтай хөдөлмөр эрхлэгчдийн байдал КОВИД-19-ийн нөлөөлөлд харьцангуй бага өртсөн хэдий ч гурван өрх тутмын нэг нь цалингийн орлого буурсан гэж мэдээлсэн байна.
- Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 12 хувь ажлын байргүй болсон гэж үзсэн бол 7 хувь нь ХАА-н бус бизнесээ хаахад хүрсэн байна.
- Өрхүүдийн 64 хувь нь хүнсний гол бүтээгдэхүүнүүдийн үнэ нэмэгдсэнийг дурдсан байна.
- Ядуу өрхүүдийн тэн хагас шахам хувь нь мөнгөгүй, эсвэл үнийн өсөлтийн улмаас сүүлийн 30 хоногт хүнс хоолтой золгох эсэхдээ эргэлзэнгүй байсан байна.

### 2. КОВИД-19 цар тахал ба Монголын эдийн засаг судалгаа

Фридрих-Эбертийн сангийн захиалгаар МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн Профессор С.Даваасүрэнгийн 2020 оны 08-р сарын 25-нд хийсэн судалгааны тойм

- КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан экспортын орлогын бууралтаас шалтгаалан дотоодын аж ахуй нэгжүүдийн орлого буурах нь хөдөлмөрийн зах зээлээр дамжин өрхийн орлогод сөргөөр нөлөөлж байна. Өрхийн орлогын түвшнээс шууд хамаарах өрхийн хэрэглээ, хуримтлал бууран бизнесийн байгууллагуудын орлого, үйл ажиллагаа хумигдах замаар манай улсын эдийн засаг хүндэрч байна.
- Эдийн засгийн уналт, иргэд, аж ахуй нэгжээ дэмжих зорилгоор засгийн газар зардлаа нэмэгдүүлснээр төсвийн алдагдал өсөх, дотоод болон гадаад өр нэмэгдэх томоохон эрсдэл байна.
- 2019 оны 7 сартай харьцуулахад экспортын 17.1 хувийн бууралтад зэсийн баяжмал болон нүүрсний экспорт хамгийн их нөлөөг үзүүлсэн байна.

<sup>173</sup><https://www.worldbank.org/mn/country/mongolia/brief/world-bank-groups-response-to-covid-19-coronavirus-in-mongolia>

- Цар тахал КОВИД-19-тай холбоотой манай улсын эрсдлийн үнэлгээ эрс муудсаны гол шалтгаан нь Өмнөд хөрш БНХАУ-ын эрэлт багассанаас болон хилийн хязгаарлалтаас шалтгаалан манай улсын нүүрсний үнэ, экспортын хэмжээ буурах нь эдийн засагт бүтцийн эрсдлийг нэмэгдүүлэхээр байгаа талаар EIU (Economic Intelligence Unit) мэдээлсэн.
- Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ийнхүү 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай гараад байна. Харин улсын гадаад өр 2020 оны 6-р сарын байдлаар 30.5 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий 220 хувьтай тэнцэж байна. Гадаад өрийн бүтцийг харвал нийт өрийн 37 хувь нь засгийн газрын өр, 10 хувь нь төв банкны өр, үлдсэн 53 хувь нь хувийн хэвшлийн өр байна. Иймээс засгийн газар өөрийн өрийг амжилттай санхүүжүүлэхээс гадна хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүд гадаадын өрөө амжилттай төлөх, хямд өртөг бүхий дахин санхүүжилтийг олоход дэмжлэг үзүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай. Учир нь Монголын компаниуд дефолт зарлаж, гадаад валютын албан нөөц шавхагдаж, төгрөгийн ханш огцом унаж, ажил эрхлэлт буурч, иргэдийн амьжиргаа муудаж улмаар ядуурал нэмэгдэнэ.
- Аж ахуйн нэгжүүдийн хувьд үйл ажиллагаагаа түр хугацаагаар зогсоосон ч түрээсийн төлбөр, цахилгаан, ус, халаалт гэх мэт ашиглалтын зардал, ажилчдын цалин хөлс зэрэг тогтмол зардал гарсаар байна. Тэгэхээр дэмжлэг үзүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлээ хамгаалах улмаар иргэдийнхээ амьжиргааг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай.
- Аж ахуй нэгж, өрхийн орлого буурснаар санхүүгийн зах зээл дээрх санхүүжилтийн эх үүсвэр хумигдах, зээлийн эргэн төлөлт муудах зэргээр санхүүгийн хямралд ч хөтөлж байна.
- Бүхэлдээ эдийн засгийн бүхий л секторыг хамарч буй энэ хямралыг давахын тулд макро эдийн засгийн системтэй бодлого чухал. Өөрөөр хэлбэл мөнгөний зохистой бодлогоос гадна төсвийн оновчтой бодлого хэрэгжүүлэх нь эдийн засгийн хямралын нөлөөг бууруулахад ихээхэн ач тустай.
- Ажлын байрыг хадгалах, ажилгүйдлийг нэмэгдүүлэхгүй байх бодлогын арга хэмжээг цаг алдалгүй, тууштай авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Учир нь хөдөлмөрийн зах зээл нэгэнт “гэмтвэл” өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн зах зээл уналтад орвол буцаж сэргэхдээ удаан байдаг.
- Дунд хугацаанд засаглалыг сайжруулах, макро эдийн засгийн эрүүл бодлого хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг тууштай даллан дуудах, том төслүүдийг зоригтой хөдөлгөх, гадаад худалдааг, тэр дундаа экспортыг урамшуулах, хөнгөвчлөх, доноруудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэх, бүтцийн бодлого, реформыг салбар бүрт зөв эрэмбэ, дэс дараалалтай хийх зэрэг өргөн хүрээний ажил засгийн газрын үйл ажиллагаанаас шууд хамаарахаар байна.
- Улсын хөрөнгө оруулалтыг хийхдээ эдийн засгийн болон нийгмийн үр ашгийг гол шалгуур болгон ажиллах. Улсын томоохон хөрөнгө оруулалтын төсөвт авчрах дарамт, энэ чиглэлийн эрсдлийг бууруулахад онцгой анхаарч ажиллах.
- Бүс нутгийн нийлүүлэлтийн, өртгийн сүлжээнд нэгдэх, хамтын ажиллагааны болон чөлөөт худалдааны гэрээ байгуулах. Үүний зэрэгцээ гадаад худалдаанд тулгарч буй хилийн наана болон цаана байгаа саад бэрхшээлийг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах.

- Эдийн засгийн төрөлжилтийн стратегийг аж үйлдвэрийн бодлоготой уялдуулан хөгжлийн банкны санхүүжилтэд тулгуурлан хэрэгжүүлэх. Ингэхдээ хөдөө аж ахуйн салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх, боловсруулах салбарын худалдаа, хөрөнгө оруулалтыг нээлттэй байлгах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

### 3. “Коронавирус ба эдийн засаг” ҮСХ-ны 10-р сарын судалгаа<sup>174</sup>

Цар тахлын дэгдэлт нь Монгол Улсын эдийн засагт ихээхэн нөлөөлж эхэлсэнийг Үндэсний статистикийн хорооноос гаргасан 10-р сарын “Коронавирус ба эдийн засаг” судалгаанаас харж болно. Тухайлбал:

- Дотоодын нийт бүтээндэхүүн өмнөх оны мөн үеэс (7.3%) их наяд төгрөгөөр буурсан байна. 2020 оны эхний 9 сард уул уурхай, олборлолтын салбарын үйл ажиллагаа 20.7 хувиар буурснаар нийт эдийн засаг агшсан байна.
- Оны эхний 10 сарын байдлаар төсвийн тэнцлийн алдагдал 3.3 их наяд төгрөгт хүрсэн нь татварын орлого буурсантай холбоотой.
- Монгол Улсын нийт ажиллагчдын 53.6 хувь худалдаа, үйлчилгээний салбарт ногдож, Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ын 40 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа (дотоод худалдаа)-ны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг учраас энэ салбарт анхаарлаа хандуулах нь чухал болоод байна.
- Дотоод худалдааны нийт борлуулалт 2020 оны эхний 9 сард 15.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.7 (9.8%) их наяд төгрөгөөр буурсан байгаа нь иргэдийн худалдан авах чадвар буурч байгааг харуулж байна.
- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 10 дугаар сарын эцэст 1.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 79.5 (6.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 274.1 (28.8%) тэрбум төгрөг буюу 1.9 пунктээр өссөн байна.
- КОВИД-19 цар тахлын сөрөг үр дагаврын нөлөөллөөр гадаад худалдааны нөхцөл муудаж экспорт 2020 оны эхний 10 сард 6.0 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 542.5 (8.3%) сая америк доллароор буурсан байгаа нь мэдээж Монгол Улсын экспортын голлох бүтээгдэхүүн зэс 153 сая ам.доллар, нүүрс 976 сая ам.доллараар тус тус буурсан нь голлох нөлөө үзүүлжээ.

*Экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, (сая ам.доллараар.)*



<sup>174</sup> [https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=covid-19\\_2020\\_oct.pdf&ln=Mn](https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=covid-19_2020_oct.pdf&ln=Mn)

#### 4. МҮХАҮТ-Хөл хорионы үеийн бизнесийн нөхцөл байдлын судалгааны үр дүн<sup>175</sup>

МҮХАҮТ-аас хатуу хөл хорионы үед бизнесийн нөхцөл байдлыг үнэлэх зорилгоор 2020 оны 11-р сарын 23-25 өдрүүдэд 3530 ААН, бизнес эрхлэгчдийг хамруулан хийсэн судалгааны тойм

- Хатуу хөл хорио тогтоосон энэ хугацаанд судалгаанд оролцогсдын 66 хувь нь бүрэн зогссон, 22 хувь нь хязгаарлагдмал хүрээнд, 10 хувь нь зайнаас ажиллаж байгаа гэсэн бол дөнгөж 2 хувь нь хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна гэсэн бөгөөд 53 хувь нь 1 сараас бага хугацаанд, 31 хувь 1-3 сарын хугацаанд ажлын байрны тоог өөрчлөхгүй хадгалж үлдэх боломжтой гэсэн хариулт өгсөн байна.
- Хатуу хөл хорионы дэглэмийн хугацааг 3 шатлалтайгаар авч, ажлын байр дах нөлөөллийг тодруулахад 11 сарын 12-ны өдрөөс хөл хорионы дэглэм тогтоосноос хойш харин судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн 67 хувь нь ажлын байрны тоонд ямар нэг өөрчлөлт оруулаагүй, 25 хувь нь ажлын байрны тоог бууруулсан ба нийт 7,645 ажлын байр цөөлжээ
- Хатуу хөл хорионы дэглэм тогтоосонтой холбоотойгоор аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд үүсээд буй хүндрэл, бэрхшээлийн хувьд 24 хувь нь ажлын байраа хадгалах, ажиллагсдын цалин тавих, 21 хувь нь бизнесийн зээлийн эргэн төлөлт хийх, 17 хувь нь хөл хориотой холбоотой төр, засгаас гаргаж буй шийдвэрийн ойлгомжгүй, уялдаа холбоогүй байдал гэсэн бол 16 хувь нь түрээсийн төлбөрөө төлөх нь хамгийн хүндрэлтэй байна гэж хариулжээ.
- Хөл хорионы дэглэм дууссаны дараа бизнесийн үйл ажиллагаагаа сэргээхэд Засгийн газраас ямар дэмжлэг, шийдэл шаардлагатай байгааг тодруулахад судалгаанд оролцсон аж ахуй нэгж, бизнес эрхлэгчдийн 56 хувь нь татвар (НӨАТ)-ын хөнгөлөлт, чөлөөлөлт, 54 хувь нь зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах, 50 хувь нь НДШ-ийн төлбөрийг хөнгөлөх, төлөх хугацааг хойшлуулах, 47 хувь нь санхүүгийн дэмжлэг, 44 хувь нь хөнгөлөлттэй зээл олгож бизнес, эдийн засгаа дэмжих нь зүйтэй байна гэжээ. Түүнчлэн түрээс, аж ахуйн нэгжийн ашиглалтын зардлуудад дэмжлэг үзүүлэх, ажиллагсдын цалин 4 олгоход дэмжлэг үзүүлэх, төрөөс батлан дааж бизнес эрхлэгчдэд бага хүүтэй, урт хугацааны зээл олгох зэргийг нэрлэсэн байна.
- Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарын ажилчид хамгийн хүндээр өртөж байна.

<sup>175</sup> <https://www.mongolchamber.mn/a/493>

**КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСАГТ  
ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ БА ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН**

(2020 оны 11-р сарын 30-ны байдлаар)

*Д.Халиун, Р.Оргилмаа*

**АГУУЛГА**

СУДАЛГААНЫ ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН УНАЛТЫН ЦАР ХҮРЭЭ

БҮС НУТГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТОЙМ (ТӨВ АЗИ)

ТӨВ АЗИ БҮС НУТАГ ДАХЬ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

IMF:ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САНГААС КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## Удиртгал

Дэлхийн улс орнууд КОВИД-19 цар тахлын эсрэг тэмцэж байгаа энэ үед улс орнуудын Засгийн газрууд эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн нөлөөллийг арилгах арга хэмжээ авч байна. Энэхүү тэмцэлд Олон улсын валютын сан, цар тахлыг арилгахын тулд идэвхтэй арга хэмжээ авч ажиллаж байна. Олон Улсын Валютын Сангаас КОВИД-19-н үед эдийн засгийн хямралд өртсөн орнуудад үзүүлж буй хөтөлбөр арга хэмжээ, эдийн засгийн уналтын цар хүрээг хэрхэн тодорхойлсныг судласан. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас нэгтгэн гаргасан КОВИД-19 цар тахлын үед Улс орнуудын татварын бодлого арга хэмжээг хэрхэн авсан талаар энэхүү судалгаанд түүвэрлэн хүргэв.

## Эдийн засгийн уналтын цар хүрээ


Доорх зурагт ДНБ-ий хамгийн сүүлийн үеийн мэдээлэл авах боломжтой 38 улс орны эдийн засгийн уналтын цар хүрээг 2020 оны 2-р улиралд (4-6-р сар) ДНБ-ний бууралтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж харуулав.

### Economic decline in the second quarter of 2020

The percentage decline of GDP relative to the same quarter in 2019. It is adjusted for inflation.

Our World  
in Data

+ Add country



Source: Eurostat, OECD and Individual national statistics agencies

Note: Data for China is not shown given the earlier timing of its economic downturn. The country saw positive growth of 3.2% in Q2 preceded by a fall of 6.8% in Q1

CC BY

## Зураг 1. 2020 оны 2-р улирлын эдийн засгийн үзүүлэлт, ДНБ-ний өмнөх оны мөн үетэй харьцуулсан бууралтын хэмжээ<sup>176</sup>


Зарим улс орнуудад эдийн засгийн уналт нэлээд өндөр байгааг харж болох юм. Тухайлбал, Испани, Их Британи, Тунис хоёрдугаар улирлын эдийн засгийн гарцын хэмжээ өнгөрсөн оны мөн үеийнхээс 20 гаруй хувиар бага байна. Энэ нь эдгээр улсуудын өмнө бүртгэгдсэн улирлын уналтаас 4-5 дахин их байгаа юм. Перугийн хувьд жилийн уналт үүнээс ч илүү буюу 30%-иар буурчээ.

Харин бусад орнуудад эдийн засгийн үр нөлөө нь хамаагүй бага байгаа юм. Тухайлбал, Тайваньд ДНБ 2020 оны 2-р улиралд 2019 оны мөн үетэй харьцуулахад 1%-иас бага байна. Мөн Финланд, Литва, БНСУ зэрэг улс ДНБ-ийхээ 5%-иас бага хувиар буурсан байна.

Доорх зургийн хэвтээ тэнхлэгт ДНБ-ний өгөгдөл, босоо тэнхлэгийн дагуу нэг сая хүн амд ногдох КОВИД-19 нас баралтын тоог тус тус харуулав.

<sup>176</sup> Мөн тэнд





**Зураг 2. 2020 оны 2-р улирлын эдийн засаг, ДНБ-ний өмнөх оны мөн үетэй харьцуулсан бууралтын хэмжээ /хэвтээ тэнхлэг/, КОВИД-19 нас баралтын хэмжээ 2020.08.30-ны байдлаар /босоо тэнхлэг/**<sup>177</sup>

Дээрхээс үзэхэд Перу, Испани, Их Британи зэрэг эдийн засгийн хамгийн хүнд уналтад орж буй улсуудад КОВИД-19 нас баралтын түвшин хамгийн өндөр байна. Эдийн засгийн сөрөг үр нөлөө бага Тайвань, Өмнөд Солонгос, Литва зэрэг улсуудад нас баралтын хувь мөн адил бага байгаа юм.

Дээрх зургаас харахад ДНБ-ийн хэмжээ ижил хэмжээнд буурсан орнуудад нас баралтын түвшин харилцан адилгүй байна. Тухайлбал, АНУ, Швед Улсуудыг Дани болон Польш Улстай харьцуулж үзвэл, дээрх улсын эдийн засгийн агшилт 8-9 хувь орчим байгаа бол нас баралт АНУ, Швед Улсад нэг сая хүн амд 5-10 дахин их бүртгэгдсэн байна.

КОВИД-19 нас баралтын түвшин болон эдийн засгийн цочролд олон хүчин зүйл нөлөөлж байгаа нь тодорхой бөгөөд цар тахлын тархалтыг хянах талаар улс орны Засгийн газруудаас авч хэрэгжүүлсэн бодлого, шийдвэрийн үр дүнг нэгтгэн дүгнэхэд хараахан эрт байгаа юм.

Дээрх үзүүлэлт, мэдээллийг дүгнэвэл таамаглаж байсанчлан хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах, эдийн засгаа хамгаалах хоёрын аль нэгийг сонгож буй явдал ажиглагдахгүй байна гэж үзэж болох юм. Эсрэгээр цар тахлын дэгдэлтийг үр дүнтэй хянаж, тогтоож буй улс орнууд хүн амын эрүүл мэндийг хамгаалахын зэрэгцээ эдийн засгийн сөрөг үр нөлөөллийг бууруулах сайн, үр дүнтэй стратеги хэрэгжүүлж байна гэж үзэж болох юм.

**Монгол Улсын хувьд**<sup>178</sup> Оксфордын Их сургуулиас Монгол Улсын КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр улс орнуудын Засгийн

<sup>177</sup> Мөн тэнд

<sup>178</sup> 2020 оны 9-р сарын байдлаар: ДНБ (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2020 оны эхний 9 сард урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 26.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 953.5 (3.5%) тэрбум төгрөгөөр, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 12.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.0 (7.3%) их наяд төгрөгөөр тус тус буурсан байна.

ДНБ-ий 7.3 хувийн бууралтад уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 595.5 (20.7%) тэрбум төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 401.4 (7.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

ДНБ (эцсийн ашиглалтын аргаар тооцсон) оны үнээр 2020 оны эхний 9 сард 26.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 372.7 (1.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна.


ДНБ-д 2020 оны эхний 9 сард эцсийн хэрэглээ 73.5 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 26.0 хувь, цэвэр экспорт 0.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс эцсийн хэрэглээ 6.8 пунктээр, бараа, үйлчилгээний цэвэр экспорт 3.6 пунктээр нэмэгдэж, хөрөнгийн нийт хуримтлал 10.4 пунктээр буурсан байна.

газруудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээг үнэлэн, хязгаарлалтын арга хэмжээний индекс боловсруулснаас Монгол Улс 2020.11.30-ны байдлаар 100 онооноос 85.19 оноотойгоор хатуу арга хэмжээ авч буй орнуудын тоонд орж байгаа юм.

### COVID-19: Government Response Stringency Index, Dec 1, 2020

Our World in Data

This is a composite measure based on nine response indicators including school closures, workplace closures, and travel bans, rescaled to a value from 0 to 100 (100 = strictest). If policies vary at the subnational level, the index is shown as the response level of the strictest sub-region.



Source: Hale, Webster, Petherick, Phillips, and Kira (2020). Oxford COVID-19 Government Response Tracker – Last updated 2 December, 00:01 (London time)  
Note: This index simply records the number and strictness of government policies, and should not be interpreted as ‘scoring’ the appropriateness or effectiveness of a country’s response.  
OurWorldInData.org/coronavirus • CC BY

### Зураг 3. КОВИД-19 цар тахлын эсрэг улс Засгийн газруудаас авсан хязгаарлалтын арга хэмжээний индекс<sup>179</sup>

**Монгол Улсын хувьд** Олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудаас төсвийн дэмжлэг, төслийн санхүүжилтэд нийт 418.9 сая ам.долларын гэрээ хэлцэл байгуулсан. Үүнээс төсвийн дэмжлэг хэлбэрээр 199.5 сая ам.доллар, төслийн санхүүжилт хэлбэрээр 32.8 ам.долларыг тус тус авсан байна. Эдгээр зээл, тусламжийн хөрөнгийг КОВИД-19 цар тахалтай тэмцэх эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлын хангах, оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр эрүүл мэндийн байгууллагуудыг хангах, иргэдийн орлогыг хамгаалах, эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулж байна.<sup>180</sup>

Бүс нутгийн нөхцөл байдлын тойм (Төв Ази)<sup>181</sup>

Төв Азийн бүс нутгийн улс орнуудыг<sup>182</sup>, дэлхийн зарим улс оруудтай харьцуулж үзэхэд (ЭЗХАХБ-аас 2020.11.16-нд гаргасан мэдээ) хатуу чанга хөл хорионы дэглэм, арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь КОВИД-19 нас баралтын үзүүлэлтээр бусад бүс нутгаас харьцангуй бага байгаад нөлөөлсөн бөгөөд 9-10 сарын байдлаар зөвхөн Киргиз Улсад өвчлөлийн тоо эрс нэмэгдсэн байна. Нас баралтын тоогоор Киргиз Улс /42-рт/ нас баралт хамгийн өндөр 50 улсын тоонд багтаж байна. Харин Казахстан 61-рт, Афганистан 86-рт, Узбекистан 109-р байранд тус тус эрэмбэлэгдэж байна.


<sup>179</sup><https://ourworldindata.org/grapher/covid-stringency-index?stackMode=absolute&time=2020-12-01&region=World>

<sup>180</sup> Монгол Улсын Засгийн газраас КОВИД-19 цар тахалтай холбоотой авч буй гадаадын зээл, тусламжийн дүн, зарцуулалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоор орж үзнэ үү. /2020.11.18/ [https://mof.gov.mn/article/entry/News\\_2020\\_11\\_19](https://mof.gov.mn/article/entry/News_2020_11_19)

<sup>181</sup> Мөн тэнд

<sup>182</sup> <http://www.oecd.org/coronavirus/policy-responses/covid-19-crisis-response-in-central-asia-5305f172/>

Figure 1. Total COVID-19 cases and deaths in Central Asia and selected OECD countries (log scale)



**Зураг 4. Төв Ази болон ЭЗХАХБ-ын зарим гишүүн орнуудын КОВИД-19 бүртгэгдсэн тохиолдол болон нас баралтын тоо (1 сая хүн амд ногдох халдварын тоо, 1 сая хүн амд ногдох нас баралтын тоо)**


Төв Азийн ихэнх улс орнууд цар тахлын тархалтыг харьцангуй амжилттай хязгаарлаж, хөл хорионы хатуу дэглэм тогтоосон хэдий ч цар тахлын бүс нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөө КОВИД-19-ийн анхны тохиолдол бүртгэгдэхээс өмнө ч илэрч байсан. Бүс нутаг нь цагаачдын мөнгөн гуйвуулга, олборлох салбарын экспорт зэргээс ихээхэн хамааралтай байдаг тул хил хаагдсан, олон улсын эрэлт буурсан зэргээс шалтгаалж 2-р сарын эхээр өсөлтийн хэтийн төлөвт нөлөөлж эхэлсэн. Үүний зэрэгцээ, үйлдвэрлэл, экспортын харьцангуй бага төрөлжсөн бүтэц, хувийн хэвшлийн хязгаарлагдмал хэмжээ, албан бус эдийн засгийн хэмжээ өндөр, мөн төсөвт ирж буй ачаалал өндөр зэрэг нь зарим улс орнуудад хямралын эсрэг хариу арга хэмжээ авахад хүндэл үзүүлж байгаа юм.

**Эдийн засгийн нөхцөл байдал** Хамгийн сүүлийн урьдчилсан тооцоогоор бүс нутгийн эдийн засаг энэ жил дунджаар 1.7%-иар агшина гэж тооцоолж байгаа бөгөөд энэ үзүүлэлт нь Төв Азийн улс орнуудын хувьд харилцан адилгүй юм. Тухайлбал, албан ёсны мэдээллээр (Дэлхийн банк, 2020) (ОУВС, 2020) Киргиз Улсын хувьд 12.6%-ийн агшилттай байх бол Туркменистан Улсын хувьд 1.8%-ийн өсөлттэй байх тооцоол гарсан байна. Улс орнууд 7-р сараас хатуу хөл хориог зөөлрүүлж эхэлснээс хойш дамжин өнгөрөх болон ажлын байрны хөдөлгөөн аажмаар нэмэгдэж, дотоодын эдийн засгийн идэвхжилийг сэргээж байгаа хэдий ч эдийн засгийн өсөлт удаашралтай байх юм. Эдийн засгийн урьдчилсан таамаглалаар 2021 онд огцом сэргэх төлөвтэй байгаа боловч халдварын шинэ давлагаа гарах, болон хатуу хөл хорио тогтоох нөхцөлд өсөлт мэдэгдэхүйц удааширч магадгүй гэж ЭЗХАХБ-аас дүгнэсэн байна.

Төв Азийн эдийн засгийн худалдааны хамаарлыг харгалзан үзвэл тэдний ойрын хэтийн төлөв дэлхийн чиг хандлагаас ихээхэн хамаарахаар байна. Өдгөө ЭЗХАХБ нь дэлхийн ДНБ-ийг 2020 онд 4.5%-иар буурна гэж таамагласан байна. Энэ онд Хятадаас бусад бүх G20-ийн эдийн засаг агших төлөвтэй байгаа бөгөөд цар тахалд хамгийн ихээр нэрвэгдэж буй улс орнуудын ДНБ 10% буурах үзүүлэлттэй байна. Дэлхий даяар энэ жил л гэхэд 90 орчим сая хүнийг туйлын ядуу зэрэгт оруулж болзошгүй байгаа нь нэг жилийн дотор 14%-иар өссөн үзүүлэлт юм. Энэ нь 2021 онд энэ тоо нэмэгдэх магадлалтай юм.

Цар тахлын тархалтын үр нөлөөний хувьд хот, хөдөө, бүс нутгуудад ялгаатай нөлөөллийг үзүүлж болзошгүй юм. Худалдааны болон дэлхийн эрэлтийн цаашдын удаашрал нь хөдөө аж ахуй, уул уурхай, аялал жуулчлал зэрэг арилжаалагдах боломжтой үйл ажиллагаанаас илүү хамааралтай хөдөө орон нутгийн эдийн засагт хүндээр тусах юм. Энэ нь бүс нутгийн бодлого болон хот, хөдөөгийн ялгаатай байдлыг илтгэнэ. Хэдийгээр хөдөө орон нутагт халдвар тархах эрсдэл бага ч эрүүл мэнд, нийгмийн дэд бүтэц харьцангуй муу байх бөгөөд Төв Азийн бүс нутгийн орон нутгийн оршин суугчид бүхэлдээ алсаас буюу зайнаас ажиллах боломж тааруу байгаа юм. Үүнээс гадна, (ялангуяа дижитал) дэд бүтцийн чанар, онлайн буюу цахим сургалтын хүртээмж, дижитал ур чадвар сул байгаа юм. Төв Азийн ихэнх хэсэгт интернэт, үүрэн холбооны өргөн зурвасын холболтын зардал нь иргэдийн орлоготой харьцуулахад нэлээд өндөр байна юм. Өөр нэгэн чухал зүйл бол алсын зайнаас ажиллах чадвар нь ур чадварын түвшингээс хамаарч өөр өөр байдаг, өөрөөр хэлбэл тэгш бус байдлын нэг хэлбэр нөгөөгөө бэхжүүлдэг. Ур чадварын болон дижитал ялгаатай байдал (чадвар, хүртээмжийн хувьд хоёулаа) Төв Азийн хувьд шинэ сорилт биш боловч энэ цаг үед урьд урьдынхаас илүү хурцаар тавигдаж байгаа юм. Ийнхүү ихэнх улс орнууд онлайнаар суралцах боломжийг хангах чанарт илүү их хөрөнгө оруулах шаардлагатай юм.


Figure 6. Debt levels (%GDP) and total debt service across Central Asia



Note: Turkmenistan data non available; Non-official includes bondholders, commercial banks and other private entities.

Source: (World Bank, 2020[3]).

Figure 7. General government fiscal balances in Central Asia



Note: Turkmenistan data not available.

Source: (World Bank, 2020[37]).

## Төв Азийн бүс нутаг дахь хариу арга хэмжээ

ЭЗХАХБ-аас гаргасан судалгаанаас үзэхэд<sup>183</sup> КОВИД-19 хариу арга хэмжээ нь бүс нутгийн хэмжээнд харилцан адилгүй байгаа бөгөөд i) Засгийн газруудын эрүүл мэндийн нөхцөл байдлыг үнэлэх үнэлгээ, ii) төсвийн чадавхыг илтгэж байна. (Хүснэгт 1).

Эхний бүлэг улсууд (Казахстан, Монгол, Узбекистан) түргэн шуурхай хариу арга хэмжээ авч, хөл хорионы хатуу дэглэм тогтоож, хилээ хааж, эдийн засгийн томоохон дэмжлэгүүдийг үзүүлсэн. Хямрал улам даамжрах үед дээрх улс орнууд тэд халдвараас хамгаалах болон санхүүгийн арга хэмжээг авч эхэлсэн бөгөөд зуны улиралд аажмаар арга хэмжээг сулруулж эхэлсэн. Хоёр дахь бүлэг улсууд (Афганистан, Киргиз) нөхцөл байдлыг эрт хүлээн зөвшөөрсөн боловч зарим талаараа олон нийтийн чадавх, бодлогын явц төвөгтэй зэрэгтэй холбоотойгоор хожуу арга хэмжээ авч эхэлсэн. Хариу арга хэмжээ нь төсвийн хязгаарлагдмал байдал, олон улсын яаралтай зээл тусламжийн хэрэгцээ нэмэгдсэн зэргээ хязгаарлагдсан байна. Гурав дахь бүлгийн улсууд (Тажикстан, Туркменистан) КОВИД-19-ийн тохиолдол цөөн, эсхүл огт бүртгэгдээгүй бөгөөд хязгаарлагдмал, төвлөрсөн бодлогын арга хэмжээнүүдийг аажмаар нэмж боловсруулсан.

Олон улсын хөдөлгөөний хязгаарлалтын тухайд зөвхөн Афганистан Улс иргэний хөдөлгөөнийг нэвтрүүлэхээр хилээ нээсэн. Туркменистан, Монгол Улсад аялах нь бараг бүхэлдээ хаалттай хэвээр байгаа бол Казахстан, Киргизстан, Тажикистан Улсад зөвхөн тодорхой улс орнуудаас, хорио цээрийн хатуу шаардлага хангасны үндсэн дээр аялах, нэвтрэхийг зөвшөөрч байна (IATA, 2020).

### Хүснэгт 1.Төв Азийн бүс нутгийн улс орнуудын хариу арга хэмжээ

Арга хэмжээ	Ерөнхий үнэлгээ	Цар тахлыг барьж тогтоох арга хэмжээ			Макро эдийн засаг	Төсвийн бодлого, бусад /ААН-д чиглэсэн/		
Улсын нэр	Бодлогын хариу арга хэмжээ	Барьж тогтоох арга хэмжээ	Эрүүл мэндийн дэмжлэг	Орлогын дэмжлэг	Зохицой бодлого	Санхүү	Татвар	Цахимжуулалт
Казахстан	Өндөр	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм
Монгол	Өндөр	тийм	тийм	тийм	тийм	тийм	Хяз.	тийм
Узбекистан	Өндөр	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм
Афганистан	Хяз.	тийм	тийм	Хяз.	тийм	Хяз.	Хяз.	Үгүй
Киргиз	Хяз.	тийм	тийм	Хяз.	тийм	тийм	Хяз.	тийм
Тажикстан	Бага	Хяз.	Хяз.	Хяз.	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Туркменистан	Бага	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй

Тийм - үндэсний хэмжээний төлөвлөгөө, арга хэмжээ

Хяз. /Хязгаарлагдмал - хязгаарлагдмал хүрээ, эсхүл хэмжээтэй зохицуулалт/хязгаарлалт

Үгүй - ямарваа нэгэн арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй

<sup>183</sup> Мөн тэнд



**Хөл хорионы хоёр дахь давлагаа илүү орон нутгийн шинжтэй/хязгаарлагдмал хүрээтэй**

Цар тахлын хоёр дахь давлагаатай холбоотойгоор Төв Азийн улс орнууд бусад улс орнуудын адил халдварын хоёр дахь давлагаанаас урьдчилан сэргийлэх үүднээс хязгаарлалт, хөл хорионы хатуу арга хэмжээ авч магадгүй юм. Төв Азийн Засгийн газруудын цар тахлын хоёр дахь давлагааны үр нөлөөг багасгах бодлогын хариу арга хэмжээ нь хэд хэдэн орны хэрэгжүүлж буй орон нутгийн шинжтэй/хязгаарлагдмал хүрээтэй, зорилтот бүлэгт чиг хандлагыг дагаж, эдийн засгийн зарим салбарыг нээлттэй байлгах, нийгмийн эмзэг бүлгийн хамгаалалтыг хамгийн дээд хэмжээнд байлгах, арга хэмжээнүүд нь орон нутгийн эрсдэл, хэрэгцээтэй нийцэж байгаа эсэхэд анхаарлаа хандуулах болно.

Тухайлбал, Казахстан Улсын Засгийн газар, орон нутгийн засаг, захиргаанаас орон нутгийн дэгдэлтэд тохирсон бүс нутгийн хатуу дэглэмийг чангаруулж, хүн амын зарим бүлэгт чиглэсэн хязгаарлалт тогтоож, хэд хэдэн хотод 65-аас дээш насны хүмүүсийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан. Үүнтэй адил Киргиз Улсад 9-р сарын сүүлчээр Баткен бүс нутагт зорчих дотоод хязгаарлалтуудыг тогтоож, Узбекистан, Тажикстан Улсаас тухайн бүс нутгаар дамжин зорчих аялагч, жуулчид PCR шинжилгээ өгөх бол Засгийн газраас сургуулиудыг хаах тухай шийдвэрийг орон нутгийн засаг захиргаанд хүргүүлсэн байна.

Сүүлийн хэдэн сарын туршлага, нөхцөл байдлаас үзэхэд Засгийн газруудаас авч хэрэгжүүлж хариу арга хэмжээ нь орон нутгийн нөхцөл байдалд илүү нийцсэн байж болох ч дотоод болон олон улсын хэмжээнд үүсэж буй зохицуулалтын шинэ сорилтууд нь төв ба орон нутгийн эрх барих байгууллагаас гаргаж буй хязгаарлалтын шийдвэрийг уялдуулж зохицуулах, хурдан өөрчлөгдөж болзошгүй нөхцөл байдалд хариу үзүүлэх чадавх, нөөц бололцоотой байхыг шаардаж байгаа юм.

**IMF: Олон Улсын Валютын Сангаас КОВИД-19 цар тахлын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ**

Олон Улсын Валютын Сан (ОУВС) нь дэлхий нийтийг хамраад буй коронавирус цар тахлын үеэр эдийн засгийн хямралд өртөөд байгаа, нэн ялангуяа эдийн засаг нь хүнд цохилтонд орсон улс орнуудад санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлж, эдийн засгаа сэргээхэд нь тэдгээр улсуудад хөшүүрэг нь болоход чиглэн ажиллаж байна. ОУВС болон Дэлхийн Банкны жил бүрийн хамтарсан хуралдааны өмнө ОУВС-ийн Гүйцэтгэх захирал Кристалина Георгиева хэлэхдээ “Дэлхийн эдийн засаг коронавирус цар тахлын хямралын гүнээс гарахаар мацаж эхэлж буй боловч энэхүү гамшгаас бүрэн салах хол байна” гэсэн байна. Урьд өмнө тохиолдож байгаагүй дэлхий дахиныг хамарсан энэ хямралын үед ОУВС нь дэлхийн улс орнуудад бодлогын зөвлөгөө, санхүүгийн тусламж дэмжлэг, эдийн засгаа сэргээх боломж бололцоог нь нэмэгдүүлэхэд чиглэсэн тусламж үйлчилгээ үзүүлэх, ядуу буурай улс орнуудын өрийг тэглэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

ОУВС нь цар тахалд эдийн засаг нь хүндээр нэрвэгдсэн гишүүн орнууддаа санхүүгийн зээл тусламж болон өрнөөс чөлөөлөх үйлчилгээ үзүүлж байгаа болно. 2020 оны Гуравдугаар сарын сүүлээс олон төрлийн зээл тусламжийн үйлчилгээгээрээ дамжуулан дэлхийн улс орнуудад эдийн засгаа сэргээх, тогтворжуулах үйл ажиллагаанд зориулан зээл тусламж олгож, Гамшгаас чөлөөлөх тусламжийн сангийн санхүүжилтээр зарим гишүүн орнуудын өрийг



тэглэх үйлчилгээ үзүүлсэн байна. ОУВС нь өөрийн зээлийн боломжит 1 их наяд долларын ¼ буюу 250 тэрбум долларыг гишүүн орнууддаа зээл олгох болон зарим улс орнуудын өрийг тэглэхээр төсөвлөсөн байна. Гишүүн орнууд энэхүү зээл тусламжийн зарцуулалтад хариуцлагатай, нээлттэй хандах шаардлагатай байна.

Дэлхийн 5 бүсийн 83 улсад 102,150.73 ам долларын санхүүгийн зээл тусламжийг олгоод байна.<sup>184</sup> Гамшгаас чөлөөлөх тусламжийн сангийн санхүүжилтээр дэлхийн 29 улсын 488.7 сая ам долларын өрийг тэглээд байна. ОУВС нь дараах 7 төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.<sup>185</sup>

### **1. Санхүүгийн яаралтай тусламж дэмжлэг**

КОВИД-19 цар тахал дэгдсэн үеэс ОУВС нь дэлхийн 100 гаруй улсаас ирүүлсэн санхүүгийн яаралтай тусламжийн хүсэлтэд хариу үзүүлэн ажиллаж байна. Энэ хямралын үеэр гишүүн орнуудаас ирүүлж буй санхүүгийн тусламжийн эрэлт хэрэгцээ эрс ихэссэнтэй холбогдуулан яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх боломжийг хоёр дахин нэмэгдүүлэн ажиллаж байна.

ОУВС-ийн Удирдах зөвлөлийн зөвшөөрснөөр одоогоор санхүүгийн яаралтай тусламжийг 76 улс орон хүлээн аваад байна. 2020 оны 6-р сараас хойш, зээл тусламж үзүүлэх бусад журмын дагуу дэлхийн нийт 81 улс оронд санхүүгийн тусламж үзүүлээд байна.

### **2. Зээлээс чөлөөлөх санхүүгийн тусламж**

ОУВС нь журмын дагуу, Гамшгаас чөлөөлөх тусламжийн сангаараа дамжуулан зээлээс чөлөөлөх үйлчилгээний цар хүрээгээ өргөжүүлж, 2020 оны Дөрөвдүгээр сараас 2021 оны Дөрөвдүгээр сар хүртэлх хугацаанд өөрийн гишүүн 29 ядуу буурай орнуудыг сонгон санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Энэхүү зээлээс чөлөөлөх санхүүгийн дэмжлэгийн үр дүнд эдгээр улс орнууд нь өөрсдийн санхүүгийн нөөц боломжоо КОВИД-19 цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд голлон хандуулж, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ болон бусад нэн шаардлагатай арга хэмжээнд зориулах боломжтой болж байгаа юм.

ОУВС нь донор орнуудаас Гамшгаас чөлөөлөх тусламжийн санд үзүүлэх хандиваа нэмэгдүүлэхийг уриалснаар ядуу буурай орнуудыг зээлээс чөлөөлөх энэхүү үйл ажиллагаа 2022 оны Дөрөвдүгээр сар хүртэл үргэлжлэх боломжтой болох юм.

### **3. Хоёр талын хэлцэл дээр үндэслэн зээл олгох**

ОУВС нь Дэлхийн Банктай хамтран цар тахлын нөлөөнд нэрвэгдээд буй бага орлоготой ядуу буурай улс орнуудын эдийн засгийн байдлыг харгалзан үзэж 2020-03-25-нд эдгээр орнуудын Зээл төлөлтийг хойшлуулахыг уриалсан байна. Үүний хариуд 2020-04-15-нд Их 20 нь ядуу буурай орнуудын зээл төлөлтийн хугацааг 2020 оны сүүл хүртэл сунгасан бөгөөд 2020 оны Аравдугаар сард зээл төлөлтийн хугацааг дахин 2021 оны Зургадугаар сарын сүүл болгон сунгасан байна.

Энэхүү санаачлагын үр дүнд Их 20 нь дээр дурдсан хугацаанд 73 ядуу буурай орны зээл төлөлтийг хойшлуулсан байна. Үүний үр дүнд эдгээр улс орнуудын санхүүгийн хүндрэлийг хэсэг хугацаанд хөнгөвчилж, эдгээр орнууд нь КОВИД-19-

<sup>184</sup> <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/COVID-Lending-Tracker#AFR>

<sup>185</sup> <https://www.imf.org/en/About/FAQ/imf-response-to-covid-19>

ийн нөлөөнөөс үүдсэн эдийн засгийн хүндрэлээ даван туулахад өөрсдийн нөөц бололцоог чиглүүлэх боломжтой болсон байна.

Олон Улсын Санхүүгийн Байгууллага (International Institute for Finance) нь дээрх жишгээр хувийн хэвшлийн зээлдэгч нарт мөн зээл төлөлтийн хугацааг хойшлуулах санал гаргасан бөгөөд 2020 оны Тавдугаар сард энэхүү санаачлагын хүрээнд Хувийн хэвшлийн оролцооны журмыг боловсруулан гаргасан ба энэ нь зөвхөн сайн дурын үндсэн дээр хэрэгжинэ. ОУВС ба Дэлхийн банк нь зээл төлөлтийг 2021 оны сүүл хүртэл хойшлуулахыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Үүний хариуд “Их 20” 2021 оны Дөрөвдүгээр сард болох ОУВС ба Дэлхийн банкны хамтарсан Хаврын хуралдааны үеэр зээл төлөлтийн хугацааг хойшлуулах асуудлыг судлан, хариу өгөхөө мэдэгдсэн байна.

#### **4. Хөрвөх чадварыг сайжруулах**

ОУВС нь дэлхий дахины санхүүгийн аюулгүй байдлыг баталгаажуулахын тулд Богино хугацааны хөрвөх үйлчилгээг бий болгосон байна. Тухайн үйлчилгээ нь богино хугацааны боломжит санхүүгийн дэмжлэгийг үзүүлэхэд зориулагдсан юм.

#### **5. Одоо явагдаж буй зээл олголтыг зохицуулах**

ОУВС нь одоогоор явагдаж буй зээл олголтын хөтөлбөрийн цар хүрээг нэмэгдүүлж, улс орнуудад өөрсдийн санхүүгийн нөөц бололцоог коронавирус цар тахлын тархалтыг хязгаарлаж, нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн худалдан авалтанд зарцуулах боломжийг нээж өгч байгаа болно.

#### **6. Бодлогын зөвлөмж**

ОУВС нь эдийн засгийн хөгжлийн төвшин болон цар тахлын нөлөөг дэлхий дахин, бүс нутаг, улс орны хэмжээнд хянаж, хямралыг даван гарах, эдийн засгийг дахин сэргээх боломжийг бүрдүүлэх, эмзэг бүлгийг хамгаалах гэх мэт бодлогыг боловсруулан, санал болгож байна.

#### **7. Нөөц бололцоог нэмэгдүүлэх**

Энэхүү цар тахлын эсрэг ОУВС нь дэлхийн 160 гаруй улс орнуудад нөхцөл байдалд нь тохирсон шаардлагатай бодлогын зөвлөмжийг цаг тухайд нь өгч ажиллаж байгаа ба ингэснээр тухайн улс орнууд мөнгөний зохицуулалт, санхүүгийн хяналт, цахим орчны аюулгүй байдал гэх мэт яаралтай асуудлуудаа шийдвэрлэх боломжтой болж байна. Ялангуяа, ОУВС нь хариуцлага, хамгаалалтыг бууруулалгүйгээр улс орнуудын бизнес эрхлэгчид болон хувь хүмүүсийн үйл ажиллагааг алдагдуулахгүй зорилгоор тухайн улс орнуудын татвар болон төсвийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Түүнчлэн ОУВС-ийн мэргэжилтнүүд нь зээлийн зохицуулалтын бодлогыг өөрчлөх, шинэчлэх асуудал дээр улс орнуудтай хамтран ажиллаж байна. Мөн түүнчлэн улс орнуудын засгийн газрын албан хаагчид болон нийт иргэдэд зориулан цахим сургалтыг зохион байгуулж байгаа бөгөөд Youtube Сургалтын цахим хуудсанд ( Learning Channel on YouTube) иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, богино хэмжээний сургалтын бичлэгүүдийг байрлуулж байна.

## КОВИД-19-ИЙН ВАКЦИНЫ ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

(2020 оны 12-р сарын 01-ний байдлаар)

Д.Амаржаргал (Ph.D)

### 1. Туршилтад байгаа вакцинууд

ДЭМБ-ын мэдээллээр нийт 202 вакцины судалгаа хөгжүүлэлтийг идэвхтэй хийж байгаагийн 47 нь эмнэлзүйн туршилтад, 155 вакцин эмнэл зүйн өмнөх буюу амьтан дээр турших шатандаа байна.

Үүнээс 10 нь эмнэлзүйн туршилтын төгсгөлийн шат буюу 3-р шатанд явж байна.

	Вакцин үйлдвэрлэгч	Улс	Вакцины төрөл
1.	Sinovac <sup>186</sup>	Индонез	Идэвхгүйжүүлсэн
2.	Wuhan Institute of Biological Products/Sinopharm <sup>187</sup>	Хятад	Идэвхгүйжүүлсэн
3.	Beijing Institute of Biological Products/Sinopharm <sup>188</sup>	Хятад	Идэвхгүйжүүлсэн
4.	University of Oxford/AstraZeneca <sup>189</sup>	Англи	Сулруулсан вирусийн вектор
5.	CanSino Biological Inc./Beijing Institute of Biotechnology <sup>190</sup>	Хятад	Сулруулсан вирусийн вектор
6.	Gamaleya Research Institute <sup>191</sup>	ОХУ	Сулруулсан вирусийн вектор
7.	Janssen Pharmaceutical Companies <sup>192</sup>	Голланд	Сулруулсан вирусийн вектор
8.	Novavax <sup>193</sup>	АНУ	Цэвэршүүлсэн уураг
9.	Moderna/NIAID <sup>194</sup>	АНУ	РНХ
10.	BioNTech/Fosun Pharma/Pfizer <sup>195</sup>	Герман	РНХ

КОВИД-19-ийн вакциныг түгээхэд дараах үе шатыг даван туулах шаардлагатай гэж ДЭМБ зөвлөж байна.<sup>196</sup>

- Бүх үе шатны эмнэлзүйн туршилтаар вакцин нь аюулгүй, үр дүнтэй болох нь батлагдсан байх
- ДЭМБ-аас вакциныг урьдчилсан шалгаруулалтад (prequalification<sup>197</sup>) хамруулахаас өмнө вакцин үйлдвэрлэсэн орны зохицуулалтын хяналт,

<sup>186</sup> [https://www.ina-registry.org/index.php?act=registry\\_trial\\_detail&code\\_trial=16202009080721WXFM0YX](https://www.ina-registry.org/index.php?act=registry_trial_detail&code_trial=16202009080721WXFM0YX)

<sup>187</sup> <http://www.chictr.org.cn/showprojen.aspx?proj=62581>

<sup>188</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04560881?term=vaccine&cond=covid-19&draw=2>

<sup>189</sup> <http://www.isrctn.com/ISRCTN89951424>

<sup>190</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04526990?term=vaccine&cond=covid-19&draw=6>

<sup>191</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04564716?term=vaccine&cond=covid-19&draw=3>

<sup>192</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04505722?term=NCT04505722&draw=2&rank=1>

<sup>193</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04611802>

<sup>194</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04470427?term=vaccine&cond=covid-19&draw=5>

<sup>195</sup> <https://clinicaltrials.gov/ct2/show/NCT04368728?term=vaccine&cond=covid-19&draw=3>

<sup>196</sup> [https://www.who.int/news-room/q-a-detail/coronavirus-disease-\(covid-19\)-vaccines?gclid=CjwKCAiAtK79BRAIEiwA4OskBrUhYei3xeq8y7pBxsEeMyU8fyy3RINnB499dGTWjJvTw0Ty-wsMpsRoCJ20QAvD\\_BwE](https://www.who.int/news-room/q-a-detail/coronavirus-disease-(covid-19)-vaccines?gclid=CjwKCAiAtK79BRAIEiwA4OskBrUhYei3xeq8y7pBxsEeMyU8fyy3RINnB499dGTWjJvTw0Ty-wsMpsRoCJ20QAvD_BwE)

<sup>197</sup> <https://www.who.int/medicines/regulation/prequalification/prequal-vaccines/en/>

аюулгүй байдлын нотолгоо шаардлагатай. Энэ үйл явцад вакцины аюулгүй байдлын дэлхийн зөвлөх хороо (Global Advisory Committee on Vaccine Safety) мөн оролцдог.

- ДЭМБ-аас зохион байгуулах SAGE хэмээх олон улсын шинжээчдийн баг эмнэлзүйн туршилтын үр дүн ба бусад нотолгоонд дүн шинжилгээ хийж, вакциныг улс орнуудад зөвлөх эсэх, хэрэглэх аргачлалын талаар зөвлөмж гаргадаг. Харин улс орнууд ДЭМБ-ын энэ зөвлөмжийг үндэслэн өөрийн оронд уг вакциныг хэрхэн ашиглах талаар бодлого боловсруулна.
- Вакциныг их хэмжээгээр үйлдвэрлэсэн байх ёстой бөгөөд энэ нь урьд өмнө гарч байгаагүй томоохон сорилт байх болно. Үүний зэрэгцээ ашиглагдаж байгаа бусад зайлшгүй хийх вакцины үйлдвэрлэлийг зогсоож үл болно.
- Эцсийн шатанд вакциныг хадгалах менежмент, температурыг чанд мөрдөн ложистикийн нарийн төвөгтэй үе шатаар дамжуулан тараах шаардлагатай.

## 2. Astrazeneca вакцины үр дүнгийн асуудал

Оксфордын их сургууль, эм үйлдвэрлэгч AstraZeneca компанийн бүтээж буй вакцины дархлаа тогтоох чадвар нь 70% ба 90% гэсэн хоёр өөр тоо дурьдагдаж байна.<sup>198</sup> Үүнд:

- Хэрэв вакциныг тал тунгаар эхний удаад тарьж, сарын дараа бүтэн тунгаар дахин таривал дархлаа тогтоох чадвар 90%
- Хэрэв бүтэн тунгаар нэг сарын зайтай 2 удаа тарьсан нөхцөлд дархлаа тогтоох чадвар нь 62% гэсэн үзүүлэлт гарчээ. Эдгээр 2 аргачлалын дунджаар уг вакцин 70%-ийн үр дүнтэй гэж гарч байгаа юм.

Гэвч 90%-н үр дүнтэй гарсан хагас тун, бүтэн тунгийн туршилт нь 55-с дээш насны зөвхөн залуу хүмүүст хийсэн нь асуудал үүсгэж байгаа юм.<sup>199</sup> Харин Moderna ба Pfizer вакцинууд ийм төвөгтэй туршилтын аргачлалыг сонгоогүй ба хоёул 95%-н үр дүнтэй гэж гарсаныг ДЭМБ мэдээлсэн.

AstraZeneca вакцины энэхүү 2 өөр тунгийн туршилт нь туршилтын алдаанаас үүдэж гарсан гэж мэдэгдсэн ба энэхүү алдаа нь эсрэгээрээ шинэ тунгийн үр дүнг харах боломжийг олгосон гэж Astrazeneca-аас мэдэгдсэн юм. Гэвч Astrazeneca вакцины аюулгүй байдал, гаж нөлөөний мэдээлэл одоог хүртэл тодорхойгүй байгаа юм.<sup>200</sup>

2020.11.18-д The Lancet-д хэвлүүлсэн уг вакцины 2-р шатны үр дүнгийн туршилт судалгааны өгүүлэлд нийт 560 хүнийг хамруулсан гэсэн байна.<sup>201</sup> Гэвч энэ 560 хүний судалгааг хийсэн туршилтын үр дүнг харахад шаардагдах хүний тооны тооцооллыг (power calculation) хийгээгүйгээс гадна:

- 18-55 насны 100 хүн,
- 56-59 насны 120 хүн,

<sup>198</sup> <https://www.inverse.com/mind-body/oxford-vaccine-trial-results-tease-a-huge-benefit>

<sup>199</sup> <https://www.businessinsider.com/astrazeneca-oxford-coronavirus-vaccine-news-problems-questions-data-2020-11>

<sup>200</sup> <https://www.businessinsider.com/astrazeneca-oxford-coronavirus-vaccine-news-problems-questions-data-2020-11>

<sup>201</sup> [https://doi.org/10.1016/S0140-6736\(20\)32466-1](https://doi.org/10.1016/S0140-6736(20)32466-1)

- 70-с дээш насны 200 хүнийг хамруулсан нь үндсэндээ ахимаг насны 320 хүнд л туршсаныг илтгэж байна.
- Мөн энэтхэгт уг вакцины туршилтанд оролцсон хүн хурц энцефалопатийн гаж нөлөө үзүүлсэн хэмээн шүүхэд өгч байгаа<sup>202</sup> ба Astrazeneca үүнийг эрс няцаасан ч энэ вакцины гаж нөлөө, аюулгүй байдлын талаарх мэдээлэл олон нийтэд ил бус хэвээр байна.<sup>203</sup>

### 3. Astrazeneca вакцины ложистикийн асуудал

Урьдчилсан мэдээллээс харахад Astrazeneca вакцин үнийн хувьд; Pfizer \$20, Moderna-ийн тун нь \$15-25-тай харьцуулбал нэг тун нь ойролцоогоор \$ 2.50 байна.

Pfizer ба Moderna вакцин нь РНХ-д суурилсан тул хадгалалтын чанд горим шаардана. Үүнд Pfizer вакциныг хасах 94 хэмийн хүйтэнд хадгалах хэрэгтэй ба Moderna-г 6 сар хүртэл хасах 4 хэмийн хүйтэнд хадгалах шаардлагатай.

Харин Astrazeneca вакцин нь хөлдөөгч биш, жирийн хөргөгчинд хадгалах боломжтойгоороо давуу, 6 сар хадгалах боломжтой гэсэн байна.<sup>204</sup>

### 5. Эмийн зохицуулалтын зөвшөөрөл

АНУ-ын Хүнс, Эмийн Хяналтын Албаны 12-р сарын 10-ны өдөр болох хуралдааны дараа АНУ, Их Британи, Герман улс эхний ээлжийн вакцинжуулалтыг эхлэхээр бэлтгэж байгаа гэнэ. Pfizer, BioNTech компанийн вакцинаа бүртгүүлэх хүсэлтийг Их Британы Хүнс, Эмийн хяналтын албанд хэлэлцжээ. Испани улс ирэх оны 1-р сард мөн вакцинжуулалтаа эхлэхээр төлөвлөж байна.<sup>205</sup>

Английн эмийн зохицуулах байгууллага Pfizer вакцинд зөвшөөрөл өгөх нь тодорхой болсон байгаа ба 12 сарын 7-с Англичууд энэ вакцины эхний тунг тариулж эхлэх магадлалтай байна. Харин AstraZeneca вакцины зөвшөөрлийн хувьд тодорхойгүй байна.<sup>206</sup>

Мөн Япон Улсын Засгийн газар Moderna вакциныг авахаар гэрээ хийснийг өнөөдөр зарласан байна. Moderna вакциныг 30 мянга гаруй хүн дээр туршсан бөгөөд 196 хүнд л коронавирусийн халдвар илэрснээс 185 нь уг вакциныг хийлгээгүй хяналтын буюу плацебо бүлэгт гарсан байна. Тиймээс үр дүнгийн маш өндөр үзүүлэлт үзүүлсэн байгаа юм.<sup>207</sup>

<sup>202</sup> <https://www.hindustantimes.com/india-news/sii-to-sue-man-over-claims-of-covishield-side-effects/story-tvjnCYL1PsKIgqSn31Rp2l.html>

<sup>203</sup> <https://www.forbes.com/sites/roberthart/2020/11/30/indian-manufacturer-rejects-claim-as-trazeneca-oxford-covid-19-vaccine-causes-severe-neurological-issues-threatens-legal-action/?sh=21fcd2d644e7>

<sup>204</sup> <https://www.cnbc.com/2020/11/26/astrazeneca-oxford-defend-vaccine-trials-after-questions-raised-in-us.html>

<sup>205</sup> [https://www.theguardian.com/world/2020/nov/23/us-germany-and-uk-could-start-covid-vaccinations-as-early-as-december?CMP=share\\_btn\\_fb&fbclid=IwAR13sRLi3tOGDuYUF-ziiT0-lzwpsbCVPDxibCgZmccpb-8qseTZsd2v\\_H9M](https://www.theguardian.com/world/2020/nov/23/us-germany-and-uk-could-start-covid-vaccinations-as-early-as-december?CMP=share_btn_fb&fbclid=IwAR13sRLi3tOGDuYUF-ziiT0-lzwpsbCVPDxibCgZmccpb-8qseTZsd2v_H9M)

<sup>206</sup> <https://www.businessinsider.com/astrazeneca-oxford-coronavirus-vaccine-news-problems-questions-data-2020-11>

<sup>207</sup> <https://www3.nhk.or.jp/news/html/20201201/k10012739451000.html>

**ОЛОН УЛСАД МӨРДӨЖ БУЙ КОВИД-19-ИЙН ВАКЦИНЫГ АШИГЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ**

(2021 оны 02 сарын 24-ний байдлаар)

*Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа*

КОВИД-19 өвчний шинэ вакцинуудыг үйлдвэрлэж, тээвэрлэж эхэлсэнтэй холбоотойгоор улс орнуудын эрүүл мэндийн систем нь үүнийг ашиглаж эхлэхэд бэлэн байна уу гэдэг асуудал чухлаар тавигдах болсон.

Дэлхийн улс орнуудыг КОВИД-19 цар тахлын эсрэг вакцин ашиглах бэлтгэл ажлыг хангахад дэлхийн болон бүс нутгийн хэмжээний олон байгууллагууд дэмжин ажиллаж байна. Тухайлбал, Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага (ДЭМБ) болон НҮБ-ын Хүүхдийн сан нь (Gavi, Дэлхийн банк, Билл болон Мелинда Гэйтсийн санг оролцуулан) Цар тахлын эсрэг вакцинжуулалтад улс орны бэлэн байдлыг хангах үйл ажиллагаа (Country Readiness and Delivery workstream)-г тэргүүлж байна.

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд **Вакцины танилцуулга, бэлэн байдлыг үнэлэх хэмжигдэхүүн** (Vaccine Introduction Readiness Assessment Tool-**VIRAT**)-ийг улс орнуудын Эрүүл Мэндийн Яамдад зориулан, вакцинжуулалтын бэлэн байдлыг хангах, хангалтгүй газруудыг илрүүлэн дэмжлэг үзүүлэх зорилготой боловсруулсан байна. **VIRAT** дээр үндэслэн Дэлхийн Банкнаас, улс орнуудад вакцинжуулалт хийхэд шаардагдах зардал, санхүүгийн эх үүсвэрийг тооцох, төлөвлөх, дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэхэд туслах зорилгоор **Вакцины бэлэн байдлын үнэлгээний бүтэц** (Vaccine Readiness Assessment Framework-**VRAF**)-ийг мөн боловсруулсан.

Улс орнуудын ачааллыг багасгах, мэдээллийн давхардлаас сэргийлэх үүднээс дээрх хэмжигдэхүүнүүдийг нэгтгэн **VIRAT/ VRAF 2.0** цогц хэмжигдэхүүнийг боловсруулсан бөгөөд энэхүү цогц хэмжигдэхүүн нь үндсэндээ дараах 3 асуудалд чиглэгдсэн байна. Үүнд:

- КОВИД-19-ийн вакцин нэвтрүүлэх хөтөлбөрийн бэлэн байдлыг үнэлэх;
- Хангалтгүй байдлыг тогтоож, бэлтгэл ажлыг сайжруулах үйл ажиллагааг шат дараатайгаар хэрэгжүүлэх;
- Дэлхийн Банкны Эрүүл мэнд, Хоол тэжээл, Хүн амын багц хөтөлбөрөөр дамжуулан улс орнуудад вакцины хүргэлт, хэрэглээг сайжруулах зорилгоор санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжийг тодорхойлох гэх мэт.

Дээрх цогц хэмжигдэхүүний хүрээнд улс орнуудын вакцинжуулалтад бэлэн байдлыг 10 үндсэн чиглэлээр тодорхойлно. Үүнд:

1. Төлөвлөлт болон зохион байгуулалт;
2. Төсөвлөх;
3. Хянан зохицуулах;
4. Тэргүүлэх чиглэл, зорилтот түвшин, КОВИД-19 тандалт;
5. Үйлчилгээг хүргэх;
6. Сургалт болон зааварчилгаа;
7. Хяналт болон Үнэлгээ;
8. Вакцин, хүйтэн гинж тээвэрлэлт, ложистик болон дэд бүтэц;



9. Аюулгүй байдлын тандалт;

10.Эрэлт хэрэгцээ болон харилцаа холбоо зэрэг орно.

Энэхүү 10 үндсэн чиглэлийн хүрээнд тоон болон чанарын 50 үзүүлэлтээр бэлэн байдлыг тодорхойлно.<sup>208</sup>

Улс орнууд нь өөрийн улсын вакцинжуулалтын удирдлага, түгээлт, тээвэрлэлтийн асуудлыг дараах үнэлгээний хуудсын дагуу үнэлж дүгнэхийг зөвлөсөн байдаг.

**Улс орны вакцинжуулалтын бэлэн байдлын үнэлгээний хуудас<sup>209</sup>**

	Үйл ажиллагаа	Тийм/үгүй
1.	Нийлүүлэлтийн удирдлага ба зохицуулалтын механизмын тодорхойлох. Үүнд Үндэсний ложистикийн баг хамрагдана.	
2.	Вакцин болон бусад дагалдах хэрэгслүүдийг худалдан авах болон хандивын механизмын дүгнэх. Үүнд: Хувийн хамгаалалтын төхөөрөмж (Personal protective equipment) Халдвараас урьдчилан сэргийлэх хэрэглэгдэхүүнүүд (Infection prevention and control)	
3.	Вакцин нэвтрүүлэх хилийн боомтууд, хадгалах болон агуулах цэгүүд, тээврийн хэрэгслийн багтаамж болон хадгалах хэмийн горим зэргийг багтаасан хүснэгтийг гаргах (хадгалах хэм 2 °C - 8 °C; -20 °C; -70 °C +/-10 °C)	
4.	Түгээх цэгээс хамааран шаардлагатай хэмжээний вакциныг хүргэх үйл ажиллагааны зааврыг бэлтгэх. Үүнд: вакцины тун болон бусад дагалдах хэрэгслүүд, вакцинжуулалт эхлэх өдрөөс өмнө тулгарах эрсдлүүд болон шийдвэрлэлт зэрэг орно.	
5.	Тухайн вакцины онцлогоос шалтгаалан тус вакцины талаарх мэдээллийн хангамж болон вакциныг нөөцлөх менежментийн үйл ажиллагааны зааврыг бэлтгэх.	
6.	Хүйтэн гинж тээвэрлэлт болон хуурай хадгалалтад тавигдах шаардлагууд, гарах эрсдэл болон шийдлүүдийн зааврыг бэлтгэх.	
7.	Зорилтот бүлгийн вакцины түгээлт болон вакцинжуулалтыг хийхэд шат шатны удирдлагуудад зааварчилгаа өгч, бэлтгэлийг хангах.	
8.	Вакцины онцлогоос шалтгаалан хүйтэн гинж тээвэрлэлтийн стратегийг боловсруулах. (Нөөц бололцоонд тулгуурлан 2 °C - 8 °C дулаан болон хэт хүйтэн хэмийг бүрдүүлэх)	
9.	Хэт хүйтэн хэмийн тээвэрлэлт болон холын замд тоног мөхөөрөмж хүргэх стратеги боловсруулах. Үүнд: шаардлагатай тохиолдолд хамтын хөрөнгө оруулалт болон гаднаас тусламж авах зэрэг орно.	
10.	Нийт хүн амын 3%-д хүрэх хэт хүйтэн хэмийн тээвэрлэлтийн төвийг байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг зохицуулах болон хүйтэн хэмийн тээвэрлэлтийн төвд хуурай мөс үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх.	
11.	Вакцин болон дагалдах хэрэгслийн тээвэрлэлтийн асуудалтай холбогдон гарах эрсдэл, шаардлагыг тодорхойлох.	
12.	Вакцинжуулалтад бэлтгэх гэрээний журамд дараах зүйлсийг багтаана. Үүнд, вакцин тээвэрлэлт, хадгалалт, хаягдлын менежмент, шаардагдах хэмийг бүрдүүлэх зэрэг орно.	

<sup>208</sup> <https://www.who.int/publications/i/item/WHO-2019-nCoV-Vaccine-introduction-RA-Tool-2020.1> COVID-19 vaccine introduction readiness assessment tool

<sup>209</sup> [https://www.technet-21.org/media/com\\_resources/trl/6717/multi\\_upload/17h30\\_8Feb\\_21027\\_COVID-19vaccinationsupplyandlogisticsguidance.pdf](https://www.technet-21.org/media/com_resources/trl/6717/multi_upload/17h30_8Feb_21027_COVID-19vaccinationsupplyandlogisticsguidance.pdf)

13. Вакцины тээвэрлэлт болон хадгалалтын явцад тухайн КОВИД-19-ийн вакцины баталгааг хангах, аюулгүй байдлыг бүрдүүлэх.	
14. Шаардлагатай үйл ажиллагааны стандартыг мөрдүүлж вакцинтай хэрхэн зөв харьцах талаар сургалт зохион байгуулах ба хэт хүйтэн хэмийн хадгалалтын төхөөрөмжөөр хангах.	
15. Вакцины төрөл зүйл болон тухайн орон нутгийн онцлог (хүн амын тоо гэх мэт) шалтгаалан вакцины хаягдлын хэмжээг тооцон гаргах.	
16. Вакцинжуулалтаас гарсан хаягдлыг үе шаттайгаар устгалд оруулах. Үүнээс гарах эрсдэл, шийдлүүдийг тодорхойлох.	
17. Гарсан хаягдлыг цуглуулах цагийн хуваарь гаргах, цуглуулах болон хаях аргачлалд шаардлагатай тээвэрлэлтийн зарчмыг гаргах. Шаардлагатай тохиолдолд хувийн хог хаягдал тээвэрлэлтийн үйлчилгээг ашиглаж болно.	
18. Вакцины шилийг устгалд оруулах төлөвлөгөө боловсруулах зэрэг болно.	

Мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон тэргүүлэх оролцоо бүхий байгууллагуудаас улс орнуудад КОВИД-19-ийн вакцины Үндэсний тархалт, вакцинжуулалтын төлөвлөгөө боловсруулах удирдамжийн дагуу **Үндэсний тархалт ба вакцинжуулалтын төлөвлөгөө** (National Deployment and Vaccination Plan (NDVP)) боловсруулан ажиллахыг зөвлөдөг. Энэхүү төлөвлөгөө нь КОВИД-19-ийн вакциныг нэвтрүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааны төлөвлөгөө юм. Уг төлөвлөгөөг боловсруулах нь улс орнуудад КОВИД-19-ийн вакцинд бэлтгэх, нөөцийн хэрэгцээг тодорхойлох, КОВИД-19-ийн вакцин нэвтрүүлэх үйл явцыг оновчтой болгоход тусалдаг байна.

Үндэсний тархалт ба вакцинжуулалтын төлөвлөгөө (NDVP) ба VIRAT /VRAF 2.0 нь улс орнуудад КОВИД-19-ийн вакцины бэлэн байдлын талаар харилцан уялдаатай аргыг санал болгох үүднээс хоорондоо уялдаатай байх ёстой. VIRAT / VRAF 2.0 нь улс орнуудад КОВИД-19-ийн вакцин нэвтрүүлэх төлөвлөгөө гаргах замын зураглал, бэлэн байдлын явцыг өөрсдөө хянах бүтэц зохион байгуулалтыг бий болгодог.

### ***Улс орнуудын вакцинжуулалтад бэлэн эсэхийг үнэлэх 4 гол шалгуур<sup>210</sup>***

Дэлхийн улс орнуудыг (ялангуяа бага, дунд орлоготой улс орнууд) вакцинжуулалтад бэлэн эсэхийг “ухамсарласан байх”, “хүлээн зөвшөөрөх”, “хүртээмжтэй байх”, “бэлэн байдлыг хангасан байх” зэрэг 4 хэмжүүрээр ерөнхийд нь хэмждэг талаар Дэлхийн эдийн засгийн форум сайтад дурджээ. Энэхүү ерөнхий шалгуурууд нь дээр дурдсан 10 чиглэлүүдийг хамарсан үзүүлэлтүүдээр илэрхийлэгдсэн байна.

#### **1. Ухамсарласан байх**

Баталгаатай эрх бүхий байгууллагын тодорхой, уялдаа холбоотой, баримтад тулгуурласан мэдээлэл бол шуурхай байдлын зөв мэдрэмж төрүүлэх ба шаардлагатай арга хэмжээ авахын нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг. Гэтэл олон улс оронд цар тахлыг дагалдан “инфодемик-эрүүл мэндийн байгууллагадаа үл итгэх байдал” үүсдэг нь бодит үнэн зүйл болоод байна.

<sup>210</sup> <https://www.weforum.org/agenda/2020/12/how-to-assess-countries-vaccine-readiness-in-4-steps/> A 4-point checklist for assessing countries' vaccine readiness

Засгийн газар нь харилцаа холбооны газруудыг хэрхэн цогцоор нь мэдээллийн хэрэгсэл болгон ашиглах нь эрүүл мэндийн системийн хариу арга хэмжээний, ялангуяа дархлаажуулалтын аяны үед их чухал зүйл байдаг. Тухайлбал, засгийн газраас зохион байгуулж буй нийтийн эрүүл мэндийн харилцаа холбоо ба нэр алдартай хүмүүсийг ашиглах зэрэг нь үр дүнг сайжруулахад маш сайн үр нөлөө үзүүлдэг.

Аян зохион байгуулахын зэрэгцээ нийтийн эрүүл мэндийн байгууллагууд нь эрүүл мэндийн мэдээллийн системүүдийг ашиглах, хамтрах арга хэлбэрээр өвчний дэгдэлт, хариу арга хэмжээ, чухал ажлын явц зэргийн талаарх мэдлэгийг түгээн хуваалцаж, мөн эрүүл мэндийн үйл ажиллагааг доголдуулах буруу мэдээлэлтэй тэмцэх баримтуудыг шинжлэн үнэлэх ёстой байдаг.

## **2. Хүлээн зөвшөөрөх**

Урьд өмнөх жилүүдийн өвчний дэгдэлт тархалтын хариу арга хэмжээний практикаас эрүүл мэндийн систем нь орон нутгийн хүн амтай идэвхтэй харилцан санаа бодлыг тандан судалж, асуудлуудыг нь тодруулан, олон нийтийн вакцины талаарх ойлголт, мэдлэгийг олгох, буруу ташаа мэдээллийг залруулах нь ихээхэн чухал юм.

КОВИД-19 өвчний нөхцөл байдал хүнд байгаа хатуу хорио цээрийн дэглэмтэй орнуудад шинэ вакцин хүлээн авах нь илүү хэцүү байж болох юм. Гэвч мэдээллийн тэгш бус байдлаас болж эмзэг бүлгийн хүмүүс буруу мэдээлэлд автамтгай байдаг бөгөөд цахим мэдээлэлтэй хүн амын бүлгүүд ч гэсэн вакцины эргэлзээг нэмэгдүүлэх гэсэн дэлхийн олон нийтийн мэдээллийн кампанит ажлаас бүрэн дархлаагүй байдаг байна. Тиймээс үнэн зөв мэдээллийг албан эх сурвалжаас тэгш хүртээмжтэй олгох, түгээх нь вакцины үр дүнг хүлээн зөвшөөрөхөд чухал нөлөөтэй байдаг.

## **3. Хүртээмжтэй байх**

КОВИД-19 дархлаажуулалт нь цартахлын тархалтыг зогсоохын тулд урьд өмнө төдийлөн тулгарч байгаагүй вакцины их хэмжээний нөөцийг бий болгох шаардлагатай болж байна. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд зорилтот бүлгүүдийг хязгаарлагдмал нөөцөөр цартахлын явцыг хамгийн богино хугацаанд зогсооход хамгийн их нөлөө үзүүлэх ач холбогдолтой байх ёстой. Үүний тулд хүн амыг эрэмбэлэн вакцинд хамруулах дарааллыг тогтоох нь чухал байдаг. Зорилтот бүлгийг тодорхойлох нь вакцинжуулалтыг хүртээмжтэй болгох гол түлхүүр юм.

Олон нийтийн дунд эрүүл мэндийн технологийг нэвтрүүлэх, дархлаажуулалтын цахим бүртгэлийг бий болгох, дэд бүтцийг өргөжүүлэх нь хүртээмжийг сайжруулах арга хэрэгсэл юм. Мөн Вакцинжуулалтын дижитал гэрчилгээг нэвтрүүлэх нь вакцинжуулалтын давхардал, хоцрогдол зэргээс урьдчилан сэргийлэх давуу талтай байдаг.

## **4. Бэлэн байдлыг хангах**

Вакцинжуулалтын бэлэн байдлын нэг гол үзүүлэлт нь вакциныг хадгалах, хангамжийг нөөцлөх, түүнийг төлөвлөх асуудал юм. Хадгалах хугацаа,

шаардагдах тун, хадгалах үзүүлэлт зэрэг вакцины шинж чанарууд нь вакцины хангамжийн гинжин хэлхээний үр дүнтэй үйл явцыг төлөвлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг.

КОВИД-19-ийн вакцины хүртээмжид тулгарч буй хамгийн том бэрхшээлүүдийн нэг нь хүйтэн хангамжийн сүлжээ юм. Тиймээс хүйтэн гинжин хэлхээний бүрэн бүтэн байдал, ялангуяа бага дунд орлоготой орнуудын хувьд эрүүл мэндийн тогтолцооны сул байдал нь үнэ цэнэтэй вакциныг ихээхэн үр ашиггүй сүйрэлд хүргэж болзошгүй тул төлөвлөлтийг сайн хийх, бэлтгэл байдлыг хангах нь чухал ажээ.

Ийнхүү КОВИД-19-ийн эсрэг Эрүүл мэндийн систем өөрөө хэрхэн амжилттайгаар дархлаажуулалт тогтоох хүчин чармайлтын чадвартай хамтрагч болох нь вакцинжуулалтын бэлэн байдлыг хэрхэн хангаж байгаагаар тодорхойлогдох юм. Хувийн сектор, хандивлагчид, техникийн хамтрагчид ба бусад салбарынхантай нягт хамтран ажиллах нь вакцинжуулалтыг үр ашигтай, оновчтой ашиглах амжилтын нэг үндэс болдог байна.

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <https://www.who.int/publications/i/item/WHO-2019-nCoV-Vaccine-introduction-RA-Tool-2020.1> COVID-19 vaccine introduction readiness assessment tool
- [https://www.technet-21.org/media/com\\_resources/trl/6717/multi\\_upload/17h30\\_8Feb\\_21027\\_COVID-19vaccinationsupplyandlogisticsguidance.pdf](https://www.technet-21.org/media/com_resources/trl/6717/multi_upload/17h30_8Feb_21027_COVID-19vaccinationsupplyandlogisticsguidance.pdf)
- <https://www.weforum.org/agenda/2020/12/how-to-assess-countries-vaccine-readiness-in-4-steps/> A 4-point checklist for assessing countries' vaccine readiness
- <https://www.who.int/initiatives/act-accelerator/covax/covid-19-vaccine-country-readiness-and-delivery>
- <https://www.technet-21.org/en/forums/discussions/covid-19-vaccine-introduction-new-telegram-channels>

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**КОВИД-19-ИЙН ЭСРЭГ ВАКЦИН ҮЙЛДВЭРЛЭЛ БА ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААРХ  
ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ**

(2021 оны 02 сарын 24-ний байдлаар)

*Д.Амаржаргал (Ph.D), О.Билгүүтэй  
С.Золжаргал*

**АГУУЛГА**

НЭГ. ВАКЦИН ҮЙЛДВЭРЛЭЛ БА ХЭРЭГЛЭЭНД НЭВТРҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ

КОВИД-19-ийн вакцинуудын гаж нөлөө

ХОЁР. ЕВРОПЫН УЛСУУДЫН КОВИД-19 ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТЫН  
СТРАТЕГИ

ГУРАВ. АЗИЙН ОРНУУДЫН ВАКЦИНЖУУЛАЛТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ВАКЦИНЖУУЛАЛТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ





## НЭГ. ВАКЦИН ҮЙЛДВЭРЛЭЛ БА ХЭРЭГЛЭЭНД НЭВТРҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ

ДЭМБ-ын яаралтай үед хэрэглэх КОВИД-19-ийн вакциныг урьдчилан шалгаруулах үнэлгээний явцад нийт 15 коронавирсийн эсрэг вакцин бүртгэгдсэнээс гуравт нь одоогийн байдлаар албан ёсны зөвшөөрөл олгоод байна. Үүнд Pfizer Biontech, SK BIO Astrazeneca The University of Oxford, Serum Institute of India covishield вакцинууд орж байна.<sup>211</sup> (Хүснэгт 1) Үүн дээр нэмэгдээд Gamaleya, Moderna, Бээжин институтын Синофарм нь ДЭМБ-ын эрх бүхий байгууллагын шалгуурын дагуу олон улсын зохицуулалтын байгууллагуудаас зөвшөөрөл авсан байна.<sup>212</sup>

Нотлогдсон үр дүн гаргасан вакцинууд:

- Астразенека 62%
- Пфайзер 95%
- Гамалея 92%
- Модерна 94%
- Новавакс 89%
- Синофарм 79%
- Синовакс 50-91% (Бразил 50%, Индонез 65%, Турк 91%, АНЭУ 86%)<sup>213</sup>-н үр дүнтэй байна.

Эдгээрээс олон улсад нийтлэг хэрэглэгдэж эхэлж буй болон Монгол Улсад орж ирж буй вакцины талаарх мэдээллийг дор дурдвал:

### 1. Спутник вакцин

ОХУ-ын Эрүүлийг хамгаалах яамны харьяанд байх Н.Ф.Гамалейн нэрэмжит Тархвар судлал, микробиологийн хүрээлэнгийн хөгжүүлж гаргасан Gam-COVID-Vac буюу оноосон нэршлээр “Спутник V” вакциныг ОХУ-ын Эрүүлийг хамгаалах яам өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдөр бүртгэсэн. Тухайн үед эмнэл зүйн 1 болон 2 дугаар шатны судалгаа нэгтгэн хийгдэж дууссан байсан.

Түүний дараа 2020 оны 9 дүгээр сараас эмнэлзүйн 3 дугаар шатны судалгаа хийгдэж эхэлсэн бөгөөд ОХУ-ын зүгээс вакцинаа үнэлүүлэх хүсэлтээ ДЭМБ-д 2020 оны 12 дугаар сард гаргасан. Үнэлгээний форматаа тохирсон ч үнэлгээ хараахан хийгдэж эхлээгүй байгаа тул “Яаралтай нөхцөлд хэрэглэх зөвшөөрөл” олгогдох тов одоогоор тодорхой бус<sup>214</sup> байна. /Энэ мэдээлэл нь ДЭМБ-аас 2 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар гаргасан албан мэдээлэлд тулгуурласан болно/

### 2. БНХАУ-ын Синофарм/Бээжин - Вероселл вакцин

БНХАУ-ын төрийн өмчит Синофарм компанийн Бээжингийн биотехнологийн хүрээлэнтэй хамтран гаргасан VERO CELL вакцин нь идэвхгүйжүүлсэн вакцин бөгөөд ДЭМБ-аар уг вакцины аюулгүй байдал, үр нөлөөг үнэлэх үнэлгээ хийгдэж

<sup>211</sup> [https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status\\_COVID\\_VAX\\_16Feb2021.pdf](https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status_COVID_VAX_16Feb2021.pdf)

<sup>212</sup> Wouters, O. J., Shadlen, K. C., Salcher-Konrad, M., Pollard, A. J., Larson, H. J., Teerawattananon, Y., & Jit, M. (2021). Challenges in ensuring global access to COVID-19 vaccines: production, affordability, allocation, and deployment. The Lancet.

<sup>213</sup> [https://doi.org/10.1016/S0140-6736\(21\)00306-8](https://doi.org/10.1016/S0140-6736(21)00306-8)

<sup>214</sup> [https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status\\_COVID\\_VAX\\_20Jan2021\\_v2.pdf](https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status_COVID_VAX_20Jan2021_v2.pdf)

байна. Хамгийн хурдандаа 3 дугаар сарын эхээр “Яаралтай нөхцөлд хэрэглэх зөвшөөрөл” олгогдох тов<sup>215</sup> байна. /Дээр дурьдсан ДЭМБ-аас 2 дугаар сарын 20-ны өдрийн албан мэдээлэлд тулгуурласан болно/

### **3.Оксфордын Их Сургуультай хамтарсан Астразенека вакцин**

Уг вакциныг КОВАКС хөтөлбөрийн хүрээнд болон Европын Холбоонд зориулан үйлдвэрлэж байгаа бөгөөд Европын эмийн агентлаг ба БНСУ-ын Хүнс ба Эмийн Яамнаас зохицуулга хийж байна. Вирусийн рекомбинант вектороос гаргаж авсан уг вакциныг 2021 оны 2 сарын 15-д ДЭМБ-аас эцэслэн зөвшөөрөл олгосон. Харин Европын эмийн агентлагийн зохицуулж буй зөвшөөрлийг 2021 оны 3-4-р сард олгохоор болсон байна.

### **4. ХБНГУ-ын Biontech Pfizer**

Уг вакциныг мэдээллийн РНХ-д суурилан гаргаж авсан бөгөөд Европын эмийн агентлаг зохицуулж байна. Бүх шатны эмнэл зүйн туршилтаа амжилттай явуулж, ДЭМБ-аас хамгийн анх буюу 2020 оны 12 сарын 31-нд зөвшөөрөл олгожээ.



<sup>215</sup> [https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status\\_COVID\\_VAX\\_20Jan2021\\_v2.pdf](https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status_COVID_VAX_20Jan2021_v2.pdf)

Хүснэгт 1. ДЭМБ-ын яаралтай үед хэрэглэх КОВИД-19-ийн вакциныг урьдчилан шалгаруулах үнэлгээний явц (2021 оны 2 сарын 6-ны байдлаар хамгийн сүүлд шинэчлэгдсэн)

N	Үйлдвэрлэгч	Вакцины нэр	Үндэсний зохицуулагч агентлаг	Те-рөл	Хүсэлт хүлээн авсан эсэх	Ярилцлага хийсэн эсэх	Материал хүлээн авсан эсэх	Үнэлгээний үр дүн	шийдвэр гаргах өдөр
1	Pfizer Biontech	BNT162b2/COMIRNATY Tozinameran	Европын эмийн агентлаг	МРНХ	✓	✓	✓	зөвшөөрсөн	2020.12.31
2	Astrazeneca The University of Oxford	AZD1222	Европын эмийн агентлаг	Рекомбинант вектор	✓	✓	COVAX өгөгдлийг 3 сард авна	хүлээгдсэн	2021 оны 3-4 сар
3	SK BIO Astrazeneca The University of Oxford	AZD1222	БНСУ-ын Хүнс ба Эмийн Яам	Рекомбинант вектор	✓	✓	✓	зөвшөөрсөн	2021.02.15
4	Serum Institute of India	Covishield	Энэтхэгийн эмийн хяналтын газар	Рекомбинант вектор	✓	✓	✓	зөвшөөрсөн	2021.02.15
5	Sinopharm/ BIBP	SARS-CoV-2	Үндэсний эмийн бүтээгдэхүүний удирдлагын газар	идэвхгүйжүүлсэн	✓	✓	нэмэлт дата 2 сарын сүүлээр	-	3 сарын эхээр
6	Sinovac	SARS-CoV-2	Үндэсний эмийн бүтээгдэхүүний удирдлагын газар	идэвхгүйжүүлсэн	✓	✓	нэмэлт дата 2 сарын сүүлээр	-	3 сарын эхээр
7	Moderna	mRNA-1273	Европын эмийн агентлаг	Рекомбинант вектор	✓	✓	нэмэлт дата 2 сарын сүүлээр	-	2 сарын сүүлээр
8	Janssen, Infectious Diseases & Vaccines	Ad26.COV2.S	Европын эмийн агентлаг	Рекомбинант вектор	✓	✓	нэмэлт дата 2 сарын сүүлээр	эхлээгүй	2021 оны 3-4 сар
9	The Gamaleya National Center	Sputnik V	ОХУ-н үндэсний зохицуулагч агентлаг	аденовирус вектор	нэмэлт мэдээлэл ирсэн	хэд хэдэн удаа	нэмэлт дата 2 сарын сүүлээр	-	-
10	CanSinoBio	Ad5-nCoV	Үндэсний эмийн бүтээгдэхүүний удирдлагын газар	Рекомбинант вектор	✓	✓	2021 оны 4 сард эхэлсэн	-	-

11	Vector State Research Centre of Virology and Biotechnology	EpiVacCorona	ОХУ үндэсний зохицуулагч агентлаг	пептид эсрэгтөрөгч	Хүлээн авахаас татгалзсан	-	-	-	-	-
12	Zhifei Longcom, China	Recombinant Novel Coronavirus Vaccine	Үндэсний эмийн бүтээгдэхүүний удирдлагын газар	рекомбинант уураг	нэмэлт мэдээлэл хэрэгтэй	-	-	-	-	-
13	IMBCAMS, China	SARS-CoV-2	Үндэсний эмийн бүтээгдэхүүний удирдлагын газар	идэвхгүйжүүлсэн	Хүлээн авахаас татгалзсан	-	-	-	-	-
14	Sinopharm/WIBP	SARS-CoV-2	Үндэсний эмийн бүтээгдэхүүний удирдлагын газар	одоогоор мэдээлэлгүй	-	-	-	-	-	-
15	NOVAVAX		Европын эмийн агентлаг	одоогоор мэдээлэлгүй	хүлээгдсэн	-	-	-	-	-

## КОВИД-19-ийн вакцинуудын гаж нөлөө

Австралид хийсэн хүн амд суурилсан судалгаагаар КОВИД вакцины гарч болох гаж нөлөөнөөс үүдэлтэйгээр хүн амын 10 хувь нь вакцин хийлгэмээргүй байна гэжээ.<sup>216</sup> Гэвч зөвхөн коронавирусийн вакцинаас гадна бүх төрлийн вакцинд бага хэмжээний гаж нөлөө гарах эрсдэлтэй байдаг. 40 мянган эрүүл мэндийн ажилтанд хийсэн судалгаанд<sup>217</sup>

Пфайзер вакцинйг хийлгэсэн гурван хүний нэгд нь бага зэргийн гаж нөлөө илэрсэн байна. Үүнд: тариулсан газар хавдах 37%, хөнгөн халууралт, чичрэх, толгой өвдөх, ядрах, булчин өвдөх гэх мэт бүх биеийг хамарсан шинж тэмдгүүд 14%-тай илэрсэн байна. Харин 55-с доош насны хүмүүст илүү бүх биеийг хамарсан бага зэргийн гаж нөлөө илрэх нь 55%-тай бол ахимаг насныханд 14%-тай байсан байна. Эдгээр шинж тэмдгүүд 1-3 хоногт богино хугацаагаар илэрнэ. Энэ нь биеийн дархлааны хариу урвал сайн ажиллаж байгааг илтгэх нэг шинж юм.

2020 оны 12-р сард **Pfizer** вакциныг тариулсан хүмүүст хүчтэй харшлын хариу урвал буюу анафилаксийн шок үүсэн тохиолдол бүртгэгдсэн байна. Уг мРНХ вакцин нь полиэтилен гликол (PEG) нэгдэл агуулдаг ба энэ бодис урьд өмнө зөвшөөрөгдсөн вакцинуудад ашиглагдаж байгаагүй юм. Гэсэн ч энэ найрлага нь олон эмийн бүтээгдэхүүнд агуулагддаг бөгөөд зарим тохиолдолд анафилаксийн шок үүсгэн хүний амьнасанд аюулчруулж болзошгүйнэгдэл юм. Эрдэмтдийн үзэж байгаагаар урьд нь PEG нэгдэлд харшилсан цөөн тооны хүмүүст эсрэг биетүүд үүссэн байдаг тул уг вакцинд анафилаксийн урвал үзүүлэх эрсдэлтэй байдаг байна.<sup>218</sup>

Анафилаксын урвал өгсөн өвчтөнийг эпинефринээр эмчлэх шаардлагатай тул уг эмийн нөөцийг бэлдэх, амьсгалын замыг чөлөөлөх үүднээс эмнэлэгт хэвтүүлэх шаардлагатай. АНУ-н Өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн газраас (CDC) уг вакциныг тариулсаны дараа 15 минут, хүнд хэлбэрийн харшлын түүхтэй бол 30 минутын турш хяналтанд байлгах хэрэгтэй гэж зөвлөсөн байна.

Энэ гаж нөлөөний тархалтыг тодорхойлоход цаг хугацаа шаардагдах ч CDC-ийн хамгийн сүүлийн үеийн мэдээллээс харахад анафилаксийн шок нь Pfizer-ийн 1 сая тун тутамд 6.2 тохиолдол бүртгэгдсэн байна. Тэдгээр тохиолдлын олонхи нь харшлын хүнд хэлбэртэй байсан ба зарим нь анафилаксийн урвал өгч байсан өвчний түүхтэй байна.<sup>219</sup>

Энэтхэгийн Серум Институтийн гаргасан Covishield вакциныг Малдив, Бутан, Непал, Бангладеш, Мянмар гэх мэт хөгжиж буй 22 оронд хандивлаад байгаа ба хийлгэсэн 10 хүний нэгд нь мөн дээрхтэй адил шинж тэмдгүүд илэрсэн байна.

Хятад улсад үйлдвэрлэсэн **Синовак** вакцины эмнэл зүйн туршилт судалгаагаар нийт судалгаанд оролцогчдын 70%-д нь сульдах, 68%- толгой өвдөх, 60% булчин өвдөх, 18% халуурах шинж тэмдэг илэрсэн байна.<sup>220</sup>

<sup>216</sup> [https://www.thelancet.com/journals/laninf/article/PIIS1473-3099\(20\)30926-9/fulltext](https://www.thelancet.com/journals/laninf/article/PIIS1473-3099(20)30926-9/fulltext)

<sup>217</sup> <https://covid.joinzoe.com/post/covid-vaccine-pfizer-effects>

<sup>218</sup> de Vrieze, J. (2021). Pfizer's vaccine raises allergy concerns.

<sup>219</sup> <https://www.statnews.com/2021/02/02/comparing-the-covid-19-vaccines-developed-by-pfizer-moderna-and-johnson-johnson/>

<sup>220</sup> <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0033350621000329>

ОХУ-н үйлдвэрлэсэн **Спутник** вакцины талаар тус улсын Эрүүл Мэндийн Яам мэдээлэхдээ толгой өвдөх, халууралтын шинж тэмдгүүд Аргентинд хийлгэсэн 33013 хүний 317-д нь илэрсэн гэжээ.

Эмнэл зүйн туршилтаар тодорхой болсоны дагуу **Астразенека** вакцин хийлгэсний дараах томуу төст шинж илрэх гаж нөлөө нь уг вакцины тарилгын ложистикийн асуудалд муугаар нөлөөлж байна. ХБНГУ-д хийлгэсэн нэгэн бүлгийн 40%-д нь уг гаж нөлөө илэрсэн ч 3 хоногийн дотор биеийн байдал нь хэвэндээ орж ажилдаа буцаж орцгоосон байна. Мөн бусад улс орнуудад үүнтэй ижил асуудлууд гарсан байна. Шведэд AstraZeneca вакциныг тарьсан ажилчдын дөрөвний нэгд нь томуу төст шинж тэмдэг илэрч маргааш нь ажлаасаа чөлөө авцгаасан тул эрүүл мэндийн байгууллагууд уг вакцинжуулалтыг түр зогсоосон байна. Гэвч дараа долоо хоногоос уг вакцины тарилга хийх хөтөлбөр үргэлжлэнэ гэж мэдэгджээ.

## ХОЁР. ЕВРОПЫН УЛСУУДЫН КОВИД-19-ИЙН ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТЫН СТРАТЕГИ

Европын Комиссоос (European Commission) 2020 оны 6-р сарын 17-нд КОВИД-19-ийн эсрэг вакцин боловсруулах, үйлдвэрлэх, байршуулах ажлыг түргэсгэх Европын вакцины стратегийг (EU Vaccination strategy) танилцуулсан.<sup>221</sup> Аюулгүй, үр дүнтэй вакцин бол цар тахлыг арилгах хамгийн сайн арга юм. Бүрэн найдвартай Вакцин бүтээх нь нарийн төвөгтэй ажил бөгөөд ихэвчлэн 10 орчим жил орчим үргэлжилдэг урт хугацааны үйл явц юм. Вакцины стратегийн дагуу Комисс нь аюулгүй бөгөөд үр дүнтэй вакциныг бий болгох, хүртээмжийг түргэсгэх хугацааг хамгийн ихдээ 12-оос 18 сарын хооронд тооцон төлөвлөсөн байна. КОВИД-19 цар тахлын эсрэг сая сая, бүр хэдэн тэрбум тун амжилттай вакцин үйлдвэрлэх чадвартай байхын тулд үйлдвэрлэлийн хүчин чадалд хөрөнгө оруулахтай зэрэгцэн эмнэлзүйн туршилтыг явуулах шаардлагатай. Европ тивд бүх европчуудад хүрэлцэхүйц вакциныг хурдан боловсруулах, үйлдвэрлэх, байршуулах боломжийг нэмэгдүүлэхийн тулд янз бүрийн технологид суурилсан олон төрлийн вакцины багцууд шаардлагатай гэж үзсэн байна.

КОВИД-19 цар тахлын эсрэг Вакцины стратегийн дагуу Комисс нь Европын орнуудыг төлөөлж вакцин үйлдвэрлэгч байгууллагуудтай гэрээ байгуулсан. Боломжтой, аюулгүй, үр дүнтэй болох нь батлагдаж, Европын холбоо зөвшөөрсөн тохиолдолд бүх гишүүн орнууд КОВИД-19-ийн вакциныг нэгэн зэрэг авах боломжтой бөгөөд хүн бүрт ногдох зарчмаар, шударга хүртээмжийг хангахаар төлөвлөсөн байна.

Комисс нь вакцины стратегийн үр нөлөөг хянах платформыг бий болгосон ба үндэсний вакцинжуулалтын төлөвлөгөөний анхны тойм дүгнэлтийг 2020 оны 12-р сарын хоёрдугаар хагаст танилцуулсан. Вакцин нийлүүлэх гэрээг Яаралтай тусламжийн сангаас (Emergency Support Instrument) санхүүжүүлсэн байна.

Европын Комиссоос Ковидын эсрэг вакциныг сонгохдоо шинжлэх ухааны үнэлгээ ашигласан, технологид суурилсан, Европын холбоог бүхэлд нь хангах хүчин чадалтай байх зэрэг үндэслэлүүдийг харгалзан шийдвэрийг гаргасан байна.

Одоогоор Европын Эмийн Агентлагийн (European Medicines Agency) гаргасан шинжлэх ухааны зөвлөмжийн дагуу Европт ашиглах зөвшөөрөл авсан 3 төрлийн вакцин ашиглагдаж байна.

<sup>221</sup> [https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip\\_20\\_1103](https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_20_1103)



## 1. BioNTech-Pfizer

2020 оны 12-р сарын 21-нд Европын Комиссоос BioNTech Pfizer-ийн вакциныг нийлүүлэх зөвшөөрлийг олгосон ба энэ Европт зөвшөөрөгдсөн анхны КОВИД-19-ийн вакцин болжээ. 2020 оны 11-р сарын 11-нд Европын Комисс нь эмийн үйлдвэрлэгч BioNTech-Pfizer компанитай гэрээг байгуулж, Европын бүх гишүүн орнуудын өмнөөс эхний ээлжинд 200 сая тунг худалдан авах, нэмээд 100 сая тунг хүртэл худалдан авах сонголтыг хийхээр тохиролцсон байна. Вакцин нь КОВИД-19-ийн эсрэг аюулгүй бөгөөд үр дүнтэй болох нь батлагдсаны дараа нийлүүлэхээр гэрээнд заасан байна.<sup>222</sup>

## 2. Moderna

2021 оны 1-р сарын 6-нд Европын Комиссоос Модернагийн боловсруулсан КОВИД-19-ийн эсрэг вакцин бүх болзлыг ханган Европт ашиглах зөвшөөрлийг авсан хоёр дахь вакцин болжээ.<sup>223</sup> Энэхүү зөвшөөрлийг Европын Эмийн Агентлагийн (European Medicines Agency) вакцины аюулгүй байдал, үр нөлөө, чанарыг нарийвчлан үнэлэн, шинжлэх ухааны зөвлөмж гарган түүнийг нь гишүүн орнууд батлан зөвшөөрөл олгосон байна.<sup>224</sup> 2020 оны 11-р сарын 25-ны өдөр Европын Комисс Moderna-тай КОВИД-19-ийн эсрэг вакцин худалдан авах гэрээг баталсан байна.

Энэхүү гэрээнд Европын бүх гишүүн орнуудыг төлөөлөн эхний ээлжинд 80 сая тунг худалдан авах, мөн вакцин нь КОВИД-19-ийн эсрэг үр дүнтэй болох нь батлагдсаны дараа нэмж 80 сая тунгаар авах хүсэлт гаргах хувилбарыг сонгосон байна. 2020 оны 12-р сарын 15-ны өдөр Комиссоос 80 сая тунг нэмж худалдан авахаар шийдвэрлэсэн. 2-р сарын 17-нд Комиссоос Европын Холбооны бүх гишүүн орнуудыг төлөөлөн 300 сая тун (2021 онд 150 сая, 2022 онд 150 сая) нэмэлт худалдан авалт хийх тухай Moderna-тай хоёр дахь гэрээг батласан.<sup>225</sup>

## 3. AstraZeneca

2021 оны 1-р сарын 29-нд Европын Комиссоос AstraZeneca-ийн бүтээсэн КОВИД-19-ийн эсрэг вакциныг ашиглах зөвшөөрөл олгосноор Европт ашиглах эрх бүхий гурав дахь вакцин болжээ. Энэхүү мөн л Европын Эмийн Агентлагийн (European Medicines Agency) зөвлөмж шаардлагын дагуу баталсан байна.<sup>226</sup> Европын гишүүн орнуудыг төлөөлөн 8-р сарын 27-нд Комисс AstraZeneca-тай анхны гэрээ байгуулж гарын үсэг зурсан байна.

Ингээд дээр дурдсанчлан аюулгүй, үр дүнтэй болох нь тогтоогдсон Европт ашиглах зөвшөөрөл авсан 3 төрлийн вакцин байна.

## 4. Бусад

Дээрх 3 төрлийн вакцин нь ДЭМБ-аас зөвшөөрөгдсөн КОВИД-19-ийн эсрэг үр дүнтэй болох нь батлагдсан вакцин бөгөөд үүнээс гадна Европын Комисс туршилтын шатандаа яваа болон бусад вакцин үйлдвэрлэгч компаниудтай мөн урьдчилсан гэрээг хийсээр байна.

<sup>222</sup> [https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip\\_20\\_2081](https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_20_2081)

<sup>223</sup> [https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip\\_21\\_3](https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_21_3)

<sup>224</sup> <https://www.ema.europa.eu/en/news/ema-recommends-covid-19-vaccine-moderna-authorisation-eu>

<sup>225</sup> [https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip\\_21\\_655](https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_21_655)

<sup>226</sup> <https://www.ema.europa.eu/en/news/ema-recommends-covid-19-vaccine-astrazeneca-authorisation-eu>

Үүнд **Sanofi-GSK** (9-р сарын 18-нд Sanofi-GSK ба Европын Комиссын хооронд байгуулсан хоёр дахь гэрээ хүчин төгөлдөр болсон) 300 сая тун, **Johnson & Johnson** (10 сарын 7-нд Европын Комисс эмийн үйлдвэр эрхэлдэг Johnson and Johnson компанийн Janssen Pharmaceutical Companies-ийн нэг Janssen Pharmaceutica NV эмийн үйлдвэртэй байгуулсан гурав дахь гэрээг батлав), **CureVac**, (10 сарын 19-нд Европын Комисс эмийн үйлдвэрлэгч CureVac компанитай тав дахь гэрээг батлав 225 сая тун), мөн **Novavax**, **Valneva** вакцин үйлдвэрлэгч компаниудтай хэлэлцээр хийсээр байна.<sup>227</sup>


**Европ дахь бүртгэгдсэн КОВИД-19-ийн вакцины тун (2021.02.20 ны байдлаар)**

(Тус графикийг тооцохдоо (counted as a single dose) Вакцины тунгийн хэрэглээнээс хамаарч нийт вакцин хийлгэсэн хүмүүсийн тоотой тэнцэхгүй байж болно).<sup>228</sup>

### Cumulative COVID-19 vaccination doses administered

This is counted as a single dose, and may not equal the total number of people vaccinated, depending on the specific dose regime (e.g. people receive multiple doses).

Our World in Data



Source: Official data collated by Our World in Data – Last updated 23 February, 10:30 (London time)

CC BY

<sup>227</sup> [https://ec.europa.eu/info/live-work-travel-eu/coronavirus-response/public-health/coronavirus-vaccines-strategy\\_en#eu-vaccines-strategy](https://ec.europa.eu/info/live-work-travel-eu/coronavirus-response/public-health/coronavirus-vaccines-strategy_en#eu-vaccines-strategy)

<sup>228</sup> <https://ourworldindata.org/coronavirus-data-explorer?zoomToSelection=true&time=2020-12-13..latest&country=~Europe&region=World&vaccinationsMetric=true&interval=total&perCapita=true&smoothing=0&pickerMetric=population&pickerSort=desc>

## Хүснэгт 2. Европын улс орнуудын хэрэглэж буй вакцины жагсаалт<sup>229</sup>

Улс	ISO код	Вакцин	Хамгийн сүүлд мэдээлэл бүртгэгдсэн байдал	Эх сурвалж
Austria	AUT	Moderna, Oxford/AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-22	Эрүүл мэндийн яам
Belgium	BEL	Moderna, Oxford/AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-21	Sciensano
Bulgaria	BGR	Moderna, Oxford/AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-22	Эрүүл мэндийн яам
Croatia	HRV	Pfizer/BioNTech	2021-02-22	Эрүүл мэндийн яам
Cyprus	CYP	Pfizer/BioNTech	2021-02-20	Засгийн газар
Denmark	DNK	Moderna, Pfizer/BioNTech	2021-02-21	Statens Serum Institut
Czech	-	-	-	-
Estonia	EST	Moderna, Oxford/AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-22	Эрүүл мэндийн үндэсний зөвлөл
Finland	FIN	Moderna, Oxford/AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-21	Финландын эрүүл мэнд, халамжийн хүрээлэн
France	FRA	Moderna, Oxford/AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-21	Нийгмийн эрүүл мэнд
Germany	DEU	Moderna, Oxford/AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-22	Роберт Кох институт
Greece	GRC	Moderna, Oxford/AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-22	Эрүүл мэндийн яам
Hungary	HUN	Pfizer/BioNTech	2021-02-22	Засгийн газар
Ireland	IRL	Moderna, Oxford/AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-19	Эрүүл мэндийн үйлчилгээний
Italy	ITA	Moderna, Oxford/AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-22	КОВИД-19 онцгой байдлын онцгой комиссар
Latvia	LVA	Moderna, Oxford/AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-22	Үндэсний эрүүл мэндийн үйлчилгээ
Lithuania	LTU	Moderna, Oxford/AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-22	Эрүүл мэндийн яам

<sup>229</sup> <https://github.com/owid/covid-19-data/blob/master/public/data/vaccinations/locations.csv>

Luxembourg	LUX	Moderna, Oxford/ AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-21	Засгийн газар
Malta	MLT	Pfizer/BioNTech	2021-02-21	КОВИД-19 Мальта Нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ авах баг
Netherlands	NLD	Moderna, Oxford/ AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-21	Нийгмийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчны үндэсний хүрээлэн
Poland	POL	Moderna, Oxford/ AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-22	Эрүүл мэндийн яам
Portugal	PRT	Moderna, Pfizer/ BioNTech	2021-02-22	Эрүүл мэндийн ерөнхий газар
Romania	ROU	Moderna, Oxford/ AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-22	Засгийн газар
Slovakia	SVK	Pfizer/BioNTech	2021-02-22	Эрүүл мэндийн яам
Slovenia	SVN	Oxford/ AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-21	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэн,
Spain	-	-	-	-
Sweden	SWE	Oxford/ AstraZeneca, Pfizer/BioNTech	2021-02-19	Швед улсын Нийгмийн эрүүл мэндийн газар

### Европ болон Их Британи улсын хооронд үүсээд буй вакцины асуудал


Европын бүх орнуудад вакцинжуулалтын ажил явагдаж байна Франц гэхэд 1 саяаас илүү хүн вакцин хийлгээд байна. Нэгдүгээр сарын дунд үеэс эхлэн AstraZeneca вакцин Европт зөвшөөрөгдсөн ба вакцин үйлдвэрлэгч компаний мэдээлсэнээр Европт захиалга хийсэн дозоор түргэн нийлүүлэх боломжгүй хэмээн мэдэгдсэн ч Их Британид саадгүй нийлүүлэхээр яригдсан нь Европын холбоонд маргаан дэгдээх шалтгаан болсон байна. Мөн Бельгийн вакцины үйлдвэр материалын хомсдолд орсон ба Их Британи AstraZeneca вакцинд ашиглахаар нөөц материалаасаа нийлүүлэхгүй байгаа юм байна. Бусад Европын орнуудтай харьцуулбал Малта нь хүн амын талаас дээш хувийг вакцинд хамруулаад байна. Тиймээс Европын улсуудын дунд вакцины хүртээмжтэй, шударга тэгш хуваарилалтын асуудал дэгдсээр байна. Францын SANOFI компани Pfizer вакциныг үйлдвэрлэх зөвшөөрөл авсан нь вакцины нийлүүлэлтийн дарамтыг багасгах төлөвтэй сайн мэдээ гэж үзэж байна<sup>230</sup>.

<sup>230</sup> <https://news.sky.com/>

## Зураг 1.100 хүн тутамд ногдох Вакцины доз

**Vaccination doses by population**

Reported vaccine doses administered per 100 people



Note: Total vaccinations refers to the number of doses given, not necessarily the number of people vaccinated

Source: Our World In Data, 0900 GMT on 30 Jan with latest available data **BBG****ГУРАВ. АЗИЙН ОРНУУДЫН ВАКЦИНЖУУЛАЛТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ<sup>231</sup>**

Зүүн өмнөд Азийн орнууд сүүлийн үед коронавирусийн тохиолдол газар авч байгаа энэ үед вакцинжуулах хөтөлбөрөө хэрэгжүүлэх гэж байна. Сингапур нь 12-р сараас КОВИД-19-ийн эсрэг вакцинжуулах кампанит ажлыг эхлүүлсэн ба бүс нутгийн анхны улс болсон. Индонези улс 1-р сарын сүүлчээр эхлүүлсэн байна.

Үүний зэрэгцээ, ASEAN (Зүүн Өмнөд Азийн улсуудын холбоо)-ны бусад улс орнуудад халдвар, нас баралтын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан вакцин худалдаж авахаар ажиллагаагаа эхлүүлсэн байна.

**Индонези**

Индонез улс нь Зүүн Өмнөд Азийн хамгийн том улс бөгөөд бүс нутагтаа коронавирусийн халдвар хамгийн ихээр тархсан тул 3 сая тун Хятадын Синовак /Sinovac/ вакциныг авчирсан байна. Эрүүл мэндийн сайд Буди Гунади Садикин /Budi Gunadi Sadikin/ Лхагва гарагт тус улсад 1-р сарын сүүлчээр коронавирусийн эсрэг олон нийтийн вакцинжуулалт эхэлсэн гэж мэдэгдсэн байна.

**Тайланд**

Тайландын Ерөнхий сайд Прают Чан-о-ча/Prayut Chan-o-cha /1-р сарын эхээр Синовак/Sinovak/ вакцины эхний 2 сая тунг Хятадаас авах бөгөөд эхний хүргэлт 2-р сарын сүүлчээр ирнэ гэж мэдэгдсэн байна.

**Сингапур**

Сингапур улсын Эрүүл мэндийн ажилтнууд хамгийн түрүүнд BioNTech, Pfizer компанийн хамтран бүтээсэн вакцинд хамрагдаж, вакцинжуулалтыг 12-р сарын 30-наас эхлүүлжээ. Эрүүл мэндийн яам мэдэгдэлдээ кампанит ажил Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 30 гаруй эрүүл мэндийн ажилтныг эхний ээлжинд вакцинжуулсанаар эхэлснийг мэдэгдсэн байна. Мөн ARCT-021 вакцин худалдаж авах эрхийн нийлүүлэлтийн гэрээнд гарын үсэг зурснаар эхний ачааг 2021 оны 1-р улиралд татан авахаар хүлээгдэж байна.

<sup>231</sup> <https://www.aa.com.tr/en/asia-pacific/southeast-asian-nations-race-to-acquire-covid-19-vaccine/2102821>

## Малайз

Малайз улс эмийн үйлдвэрлэгч AstraZeneca компанитай 12-р сарын сүүлчээр КОВИД-19-ийн вакцины 6.4 сая тунг худалдан авах гэрээ байгуулжээ. Тус улс Pfizer, Covax компаниудтай хамтран нийт хүн амын 30% -д КОВИД-19-ийн вакцин хийлгэх гэрээ байгуулжээ. Малайз улсын Засгийн газар мөн Синовак/Sinovac/, КанСино/CanSino/, Гамалея/ Gamaleya/ нартай хамтран вакцины нийлүүлэлтийг улсынхаа нийт хүн амын 80 гаруй хувь буюу 26.5 сая хүн амд хийлгүүлэх хэлэлцээр эцсийн шатандаа явж байна гэж мэдэгдсэн байна.

## Филиппин

Зүүн өмнөд Азид халдварын түвшингээр хоёрдугаарт ордог Филиппин улс ч вакцинжуулалтыг эхлүүлэхээр ажиллаж байна. Одоогийн байдлаар Филиппин улс AstraZeneca компанийн бүтээсэн 2.6 сая тунг КОВИД-19-ийн вакциныг худалдан авахаар болжээ.

## БНХАУ

БНХАУ-ын Үндэсний Эмийн хяналтын газрын мэдээлсэнээр, тус улсад таван төрлийн арга, техникээр бүтээсэн 16 вакцинд яаралтай байдлаар клиникийн туршилт хийх зөвшөөрөл олгоод байна.

Эдгээрээс 6 вакцины клиникийн 3 дугаар шатны туршилтыг эхлүүлээд байгаа юм. Түүнээс гадна Хятад улсад хоёр төрлийн вакциныг яаралтайгаар зах зээлд нэвтрүүлэх зөвшөөрөл олгоод байгаа ба эдгээр нь Sinopharma /2020.12.30-нд зөвшөөрөл авсан/, Sinovac /2021.02.05-нд зөвшөөрөл авсан/ гэх вакцинууд юм.

## ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ВАКЦИНЖУУЛАЛТЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын зүгээс нийт хүн амын 60 хувь буюу насанд хүрсэн хүн амаа дархлаажуулах төлөвлөгөө гаргасан. Үлдсэн 40 хувь нь хүүхэд буюу насанд хүрээгүй хүн амын бүлэг байна. Өнөөдөр дэлхий дээр бүтээгдэж, яаралтай нөхцөлд хэрэглэх зөвшөөрөл олгогдсон бүх төрлийн вакцинууд эмнэл зүйн туршилтдаа хүүхдийг хамруулаагүй тул зөвхөн насанд хүрэгчдэд зориулагдсан байна.

ДЭМБ, Олон улсын вакцины холбоо-Гави, НҮБ-ын Хүүхдийн сан, Эпидемийн бэлэн байдлын төлөөх холбоо хамтран бий болгосон КОВАКС механизмын хүрээнд холбогдох нөхцөл, шаардлагуудыг хангасны үндсэн дээр нийт хүн амын 20% буюу 659.372 хүнийг дархлаажуулах тарилга буюу 1,318,744 тун вакциныг буцалтгүй тусламжийн нөхцлөөр хүлээн авна. /Хэд хэдэн үе шаттайгаар 2021 ондоо багтан хүлээж авна/

Үлдсэн 40% буюу 1,978,122 хүнийг дархлаажуулахад шаардлагатай санхүүжилтийг Засгийн газар, Сангийн яам шийдвэрлэсэн. Хорогдлын коэффициентыг тооцоолох учиртай тул нийт 2 сая хүнээр тооцоолж тэдгээрийг дархлаажуулах 4 сая тун вакцин худалдан авах шаардлагатай гэж тооцоолсон. Үүнээс 2021 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар БНХАУ-ын буцалтгүй тусламжийн 300,000 тун, БНЭУ-ын буцалтгүй тусламжийн 150,000 тун буюу нийт 225,000 хүнийг дархлаажуулах тунг тусламжаар бүрдүүлсэн байна.232

Монгол Улсын хувьд КОВИД-19-ийн эсрэг вакцин бүртгэх журмыг боловсруулж, “Pfizer/BioNTech”, “AstraZeneca”, “Moderna”-гийн вакциныг Монгол Улсын эмийн

<sup>232</sup> Эрүүл Мэндийн Яам 2021.02.23



бүртгэлд бүртгэсэн байна.<sup>233</sup> Монгол Улсад хамрагдах нийт хүний тоо ойролцоогоор 2 сая ба эрүүл мэндийн салбарын ажилчид, хариу арга хэмжээний багийн ажилчид, ахимаг насныхан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, архаг суурь өвчтэй иргэдээс эхлэн тарих эрэмбэ тогтоосон. Бүлэг тус бүрд хамрагдах тоог Хүснэгт 3-т харуулав. Энэ нь ДЭМБ-с гаргасан КОВИД-19-ийн вакцины хязгаарлагдмал нөөцийн хүрээнд хүн амын хамруулалтын эрэмбэ гаргах зөвлөмжид (WHO SAGE Roadmap For Prioritizing Uses Of КОВИД-19 Vaccines In The Context Of Limited Supply) дурьдсан эрүүл мэндийн ажилчид, нийгэм ба өвчний эрсдэл өндөртэй бүлгийн хүмүүс, хариу арга хэмжээний тусламж үйлчилгээ үзүүлэх төрийн албан хаагчид буюу хүн хоорондын зай барьж ажиллах боломжгүй иргэд гэсэн дараалалтай дүйцэж байна.

Хүснэгт 3. Монгол Улсын иргэдийг вакцинжуулах дараалал<sup>234</sup>

	Зорилтот хүн ам	Хамрагдах хүн амын тоо	Нийт хүн амд эзлэх хувь
1	Эрүүл мэндийн салбарын ажилчид	56047	1.7%
2	Хариу арга хэмжээний багт ажиллаж буй бусад салбарынхан	52570	1.6%
3	50-с дээш насны хүн ам	583545	17.7%
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	230781	7%
5	Суурь өвчтэй хүмүүс	276937	8.4%
6	Дайчлах боломжтой ажиллагсад	65937	2%
7	Стратегийн ач холбогдолтой салбарын ажилчид	329687	10%
8	Бүх шатны боловсролын байгууллагын ажилчид	69234	2.1%
9	Вакцинжуулалтанд хамрагдах шаардлагатай бусад хүн ам	313202	9.5%
		1978120	60%

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>233</sup> <https://news.mn/r/2398213/>

<sup>234</sup> <https://ikon.mn/n/24ps>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status\\_COVID\\_VAX\\_16Feb2021.pdf](https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status_COVID_VAX_16Feb2021.pdf)
- Wouters, O. J., Shadlen, K. C., Salcher-Konrad, M., Pollard, A. J., Larson, H. J., Teerawattananon, Y., & Jit, M. (2021). Challenges in ensuring global access to COVID-19 vaccines: production, affordability, allocation, and deployment. *The Lancet*.
- [https://doi.org/10.1016/S0140-6736\(21\)00306-8](https://doi.org/10.1016/S0140-6736(21)00306-8)
- [https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status\\_COVID\\_VAX\\_20Jan2021\\_v2.pdf](https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status_COVID_VAX_20Jan2021_v2.pdf)
- [https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status\\_COVID\\_VAX\\_20Jan2021\\_v2.pdf](https://extranet.who.int/pqweb/sites/default/files/documents/Status_COVID_VAX_20Jan2021_v2.pdf)
- [https://www.thelancet.com/journals/laninf/article/PIIS1473-3099\(20\)30926-9/fulltext](https://www.thelancet.com/journals/laninf/article/PIIS1473-3099(20)30926-9/fulltext)
- <https://covid.joinzoe.com/post/covid-vaccine-pfizer-effects>
- de Vrieze, J. (2021). Pfizer’s vaccine raises allergy concerns.
- <https://www.statnews.com/2021/02/02/comparing-the-covid-19-vaccines-developed-by-pfizer-moderna-and-johnson-johnson/>
- <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0033350621000329>
- [https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip\\_20\\_1103](https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_20_1103)
- [https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip\\_20\\_2081](https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_20_2081)
- [https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip\\_21\\_3](https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_21_3)
- <https://www.ema.europa.eu/en/news/ema-recommends-covid-19-vaccine-moderna-authorisation-eu>
- [https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip\\_21\\_655](https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/ip_21_655)
- <https://www.ema.europa.eu/en/news/ema-recommends-covid-19-vaccine-astrazeneca-authorisation-eu>
- [https://ec.europa.eu/info/live-work-travel-eu/coronavirus-response/public-health/coronavirus-vaccines-strategy\\_en#eu-vaccines-strategy](https://ec.europa.eu/info/live-work-travel-eu/coronavirus-response/public-health/coronavirus-vaccines-strategy_en#eu-vaccines-strategy)
- <https://ourworldindata.org/coronavirus-data-explorer?zoomToSelection=true&time=2020-12-latest&country=~Europe&region=World&vaccinationsMetric=true&interval=total&perCapita=true&smoothing=0&pickerMetric=population&pickerSort=desc>
- <https://github.com/owid/covid-19-data/blob/master/public/data/vaccinations/locations.csv>
- <https://news.sky.com/>
- <https://www.aa.com.tr/en/asia-pacific/southeast-asian-nations-race-to-acquire-covid-19-vaccine/2102821>
- Эрүүл Мэндийн Яам 2021.02.23
- <https://news.mn/r/2398213/>
- <https://ikon.mn/n/24ps>

**“КОВИД-19” ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ВАКЦИНЫ ТАЛААРХ НИЙГМИЙН  
СҮЛЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН КОНТЕНТ АНАЛИЗ  
(Мэдээллийн сайт, фэйсбүүк, твиттерийн хүрээнд)**

(2021 оны 02 сарын 24-ны байдлаар)

*Д.Аюуш, Б.Батцэцэг, Б.Ариунаа*

Сүүлийн үед цахим орчин түүний дотор “нийгмийн сүлжээ”-нд гарч буй мэдээлэл, нөлөөллийн үйл ажиллагаагаар дамжуулан олон нийтийн санаа бодлыг чиглүүлэх, массын бөөгнөрлийг удирдах хандлага<sup>235</sup> бий болсон. Учир нь **олон нийтийн санаа бодлыг заримдаа зохиомлоор үүсгэж болох бөгөөд үүнийг хэвлэл мэдээлэл, нийтлэг бүлгүүд<sup>236</sup>-ийг хамарсан удирдагч нараар дамжуулан хийх** бололцоотой байдаг байна.

Иймээс хэвлэл мэдээлэл болон нийгмийн сүлжээний орчинд вакцин болон вакцинжуулалтын үйл ажиллагаанд нийгмийн сүлжээнд олон дагагчтай хүмүүсийн хандаж буй байр суурь, аль талыг дэмжиж уриалж байгаа талаар Контент анализыг тогтсон хугацааны интервалаар (02.17-02.23) түүвэрлэн тоймлов. Судалгаанд дараах нийгмийн сүлжээний хэрэгслүүдийг хамруулав. Үүнд:

- Фэйсбүүк
- Твиттер /Жиргээ/
- Мэдээллийн сайт

### **ФЭЙСБҮҮК**

Фэйсбүүк орчинд “КОВИД-19” цар тахлын вакцинжуулалтын талаарх үйл ажиллагааг иргэд, олон нийт хэрхэн хүлээж авч буйг тандан судлав. Ингэхдээ нийгэм, улс төрийн идэвхтэй байр суурь илэрхийлдэг, олон дагагчтай пэйж хуудасны мэдээллийг түүвэрлэж, вакцинтай холбоотой “гишүүнчлэлтэй групп” үүсгэсэн эсэх, түүнд ямар төрлийн мэдээлэл зонхилж байгааг тодруулав.

Судалгаанд дор дурьдсан пэйж хуудаснуудын мэдээллийг хамруулав.

Хүснэгт. Нийгэм, улс төрийн талаар идэвхтэй байр суурь илэрхийлдэг пэйж хуудас

Д/д	Пэйж хуудасны нэр	Дагагчийн тоо	эерэг	сөрөг
1	Оном сан	78к		
2	Uyanga Gantumur	102к		
3	Б.Жаргалсайхан	144к		Вакцины үйл ажиллагааг
4	Сэтгүүлч Л.Мөнхбаясгалан	216к	Зөвхөн спутник	
5	Tsetsgee Byambaa	146к		


<sup>235</sup> XIX зууны сүүлээр Сцилион Сегелийн “La folla criminale” нэртэй ном гарсан байдаг. Оросоор орчуулж, “Преступная толпа” нэртэй гаргасан уг номын нэрийг манай Б.Даш-Ёндон гуай “Хөөрсөн түмэн ба гэмт хэрэг” гэж монгол хэлэнд хөрвүүлэн уншигчдын хүртээл болгосон.

<sup>236</sup> Фэйсбүүк групп болон Пэйж хуудас

6	Мөнхтөрийн Нарантуяа-Нара	272к		
7	Эмүжин	143к		
8	Сэтгүүлч Н.Өнөрцэцэг	11к		
9	Төр Овогт Аюурзаны Отгонбаатар	8,3к		
10	Осоржамаа	125к	байр суурь илэрхийлээгүй	
11	Ганбаатар Сайнхүү	143к	байр суурь илэрхийлээгүй	
12	Жагар Бямбасүрэн	43к	байр суурь илэрхийлээгүй	

Нийгэм, улс төрийн талаар идэвхтэй байр суурь илэрхийлдэг, хандалт өндөртэй 12 пэйж хуудсыг шүүж үзвэл 9 пэйж хуудас нь вакцины талаар байр суурь илэрхийлсэн байна. Үүнээс Г.Уянга болон Б.Жаргалсайхан гэсэн пэйжүүд сөрөг хандлагатай байгаа бол Оном сан, Л.Мөнхбаясгалан (зөвхөн спутникийг дэмжиж буй), Цэцэг Бямба, Нара, Эмүжин, Өнөрцэцэг, Отгонбаатар нар нь дэмжсэн байр суурь илэрхийлсэн. Харин Осоржамаа, С.Ганбаатар, Б.Жагар нарын пэйжүүд ямар нэгэн байр суурь илэрхийлээгүй байна.

График. Вакцины талаар мэдээлэл түгээсэн пэйж хуудсын давтамж



“КОВИД-19” цар тахлын эсрэг вакцины талаар байр суурь илэрхийлсэн 9 пэйжээс Оном сан, Цэцэг Бямба нар идэвхтэй эерэг байр суурь илэрхийлсэн бол Г.Уянга пэйжээс идэвхтэй сөрөг байр суурь илэрхийлсэн байна. /Постын дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү./

**Дээрх пэйжийн мэдээллүүдийн сэтгэгдэл, лайк, шэйрийн төлөв зэргийг шүүж үзвэл нийт 24 мэдээллийн 9853 эерэг (92.8%), 839 сөрөг төлөв (reaction) үзүүлсэн байна. Иргэд, олон нийт вакциныг дэмжин хүлээж авч байна.**

Харин мэдээлэл болон коммент хэсгийг шүүж үзвэл дараах байдал ажиглагдаж байна. Үүнд:

- Ерөнхийлөгчийн зөвлөх Г.Уянга вакциныг тариулахгүй байх тухай уриалга гаргаж эрс татгалзаж байсан бол сүүлийн өдрүүдэд зөөлрүүлж бусаддаа боломж олгох үүднээс вакцин хийлгэхгүй байх тухай байр суурь илэрхийлсэн гэж тайлбарласан.

- Б.Жаргалсайхан вакцинжуулж буй үйл ажиллагааг шүүмжилж, төрийн хүнд суртал, вакцинаар бизнес хийж буй талаар шүүмжилж байна.
- Сэтгүүлч Мөнхбаясгалан зөвхөн Sputnik вакциныг дэмжиж байгаа байдал ажиглагдаж байна.
- Улс төрийн хүчнүүд тодорхой байр суурь илэрхийлээгүй боловч вакцины талаарх үйл ажиллагааг эсэргүүцээгүй. МАХН-ын дарга Н.Энхбаяр МН25 сувгийн “Ам нээвэл” ярилцлагад орохдоо иргэдийг вакцинд идэвхтэй хамрагдахыг биечлэн уриалсан.
- Ерөнхий сайдыг вакциныг өөрийн биеэр эхлэн тариулж уриалсан явдлыг иргэд дэмжиж, сайшаан хүлээж авч байна. Улс төрийн манлайлал гэж харж байна.
- Мөн вакцины талаарх мэдээлэл (сөрөг) түгээх зорилготой гишүүнчлэлтэй групп хараахан үүсээгүй байна. Харин “**Улсаа аврах ард түмний үндэсний хөдөлгөөн**” (93.8к гишүүнтэй) зэрэг группүүдэд вакцины талаарх дараах мэдээллийг “тролл” хаягнаас явуулж байна.
  - “Хятадаас тусламжаар ирсэн 100 мянган тун вакциныг Монгол Улсын зэвсэгт хүчнийг вакцинжуулах болсон” гэх мэдээлийг түгээж “Хятад вакцин-Монгол цэрэг” гэсэн хардлагыг дэвэргэх /олон давтамжтай/
  - Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрөлгүй вакциныг ард түмэнд тарих гэж буй тухай, ерөнхий сайд руу чиглэсэн мэдээлэл түгээх
  - Коронавирус 2019 онд Монголд орж ирсэн, вакцин тариулах шаардлагагүй тухай
  - Ерөнхий сайдыг Энэтхэгээс ирсэн вакцин тариулсаны дараа энэтхэг бүжиг хийж буй дүрслэлээр видео хийж элэглэх маягаар ерөнхий сайд руу чиглэсэн мэдээлэл түгээх

Ерөнхийд авч үзвэл, “КОВИД-19” цар тахлын эсрэг вакцины үйл ажиллагаа өөрөө хүмүүст хэрэгтэй, сайн зүйл учир ямар нэг байдлаар тэмцэх, буруушаах нь улс төрийн хувьд сөрөг оноо авчрахаар байна. Иймээс ерөнхийлөгчийн институтын зүгээс вакцины үйл ажиллагаанаас /нэр хүнд/ ирэх дэмжлэгээс /оноо/ хуваалцах байдалтай байна. Үүнд:

- Вакцин хийлгэхээр бол Орос улсын “Спутник” вакцин хийлгэх
- Хятадаас ирсэн 300 мянган тун вакцин нь Ерөнхийлөгчийн санаачилсан 30 мянган хонины хариу байсан г.м.

## ТВИТТЕР




Твиттер фэйсбүүкийг бодвол худал мэдээлэлд автаж “туйлшрах” нь бага боловч, алдаа дутагдалыг зүгээр өнгөрүүлдэггүй. Мөн тухайн цаг мөчдөө үйлчилж, товчхон буюу 140 тэмдэгтээр илэрхийлэгддэг. Иймээс твиттерийн контент анализыг цаг хугацааны дарааллаар мэдээллийг хайх гэхээсээ “вакцин” гэдэг үгээр хайлт хийж үр дүнг тооцов.

**Твиттерын орчинд вакцины үйл ажиллагааны талаар маш идэвхтэй бичиж байгаа бөгөөд хүмүүс нэлэнхүйдээ дэмжиж байна.** Тэдний хандлагыг тоймловол дараах байдалтай байна. Үүнд: */Жиргээний дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү. Вакцины талаарх хамгийн их лайк, ретвийт авсан жиргээнүүдийг оруулав./*

- Вакциныг үйл ажиллагааг бүхэлд нь дэмжиж байна.
- Вакцины талаар шүүмжлэлт хандлагатай байсан хүмүүсийг нэр цохож шүүмжилж байна. /Ерөнхийлөгчийн зөвлөх Г.Уянгын вакцин хийлгэхгүй байх тухай бичсэн постын зургийг оруулж түүнийг буруу шаасан тайлбарыг хүмүүс дэмжиж, түгээж байна./
- Вакциныг ерөнхийд нь шүүмжилж байсан хүмүүс Оросын “Спутник” вакциныг дэмжих хандлага ажиглагдаж байна. /Судлаач Ганаа, Баатархуяг, тролл аккаунтууд (Мулан г.м.)/
- Хятадаас ирсэн 300.000 тун вакциныг дэмжсэн талыг Ерөнхийлөгчийн 30 мянган хонины хариу байлаа гэж тодотгох, холбох хандлага ажиглагдаж байна.
- Мөн Хятадаас ирсэн 100.000 тун вакциныг Монгол Улсын Батлан хамгаалах яаманд өгсөн явдлыг цэргүүдэд хийх гэлээ “Хятад вакцин-Монгол цэрэг” гэсэн байдлаар шүүмжлэлт хандлага үүсч байна.
- Ерөнхий сайдыг вакциныг өөрөө эхлэн тариулж уриалсан явдалд иргэд дэмжиж, сайшааж хүлээж авч байна. Улс төрийн манлайлал гэж харж байна.
- Вакцины үйл ажиллагааг улс төрийн хүчний төлөөлөлүүд бүгд дэмжиж байна. /ХҮН-Наранбаяр, АН, МАХН-Энхбаяр зэрэг/

## МЭДЭЭЛЛИЙН САЙТ

График. Вакцины талаар мэдээлэл түгээсэн пэйж хуудасны давтамж



Мэдээллийн сайтад “КОВИД-19” цар тахлын вакцины талаарх ямар мэдээллүүд гарав иргэд, олон нийт хэрхэн хүлээж авч буйг тандан судлав. Ингэхдээ Нийгэм, улс төрийн талаарх идэвхтэй идэвхтэй мэдээлэл оруулдаг news.mn, eagle.mn,



urug.mn, ikon.mn, eguug.mn зэрэг 5 сайтын мэдээллийг сүүлийн 7 хоногоор шүүж үзэв. Тус хугацаанд вакцинтай холбоотой мэдээлэл нийт 13 байсан бөгөөд 02.18-02.20-ны өдрүүдийн мэдээлэлд хүмүүс вакциныг шүүмжилсэн, эргэлзсэн, бизнес, мөнгө угаах арга зэргээр тодорхойлж сэтгэгдэлээ илэрхийлж байсан бол 02.21-ээс хойш мэдээллүүдэд дэмжсэн, эерэг байр суурьнаас хандаж байна.

Энэ нь иргэд, олон нийт эхлээд вакциныг Монголд ирэх эсэхэд эргэлзэж байсантай холбоотой байна. 02.21-ээс хойш вакцин “бодит” болж ирсэн. Монголд вакцин ээлж дараагаараа буусан, Ерөнхий сайд иргэдийг уриалж, улс төрийн манлайлал гаргаж анхны тунг тариулсан зэргээс шалтгаалж иргэд вакцинд улам илүү итгэж байна.

**Харин ямар вакцин тариулах эсэх дээр иргэд болон мэргэжлийн байгууллагуудад нэгдсэн ойлголт, мэдээлэл алга байна. Иймээс иргэд ямар вакциныг тариулах талаар сонголт хийж чадахгүй байна.**

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Хавсралт 1. Вакцины талаар мэдээлэл оруулсан байдал

Пэйжийн нэр	Огноо	Мэдээний нэр	Мэдээний товч утга	Шэйр тоо	Коммент	Коментын агуулга	Реакшн	
							Эерэг	Сөрөг
Сэтгүүлч Л.Мөнхбаясгалан 216к	10-Feb	Монгол Улс Спутник-V вакцинд хэрэглэх эрх олголоо	Онцгой байдлын үед ашиглах зөвшөөрлийг Монгол Улсын эм үйлдвэрлэлийн салбарт тэргүүлэгч компани болох Монгол Эмимпекс Концерн ХХК-ийн тусламжтайгаар авсан байна. Ингэснээр Монгол Улс спутник-в вакцинд зөвшөөрөл олгосон 23-дахь улс болж байгаа юм.	66	44	Спутник-V вакциныг ихэнх нь дэмжсэн байна.	559	0
Tsetsgaе Byambaa 146к	16-Feb	Вакцин	Вакцин хийлгэж хэвийн амьдралдаа хурдан орьё	30	338	Вакцин хийлгэсний дараах хүндрэл сөрөг нөлөөнд эргэлсэн хандлага их байна.	718	46
Tsetsgaе Byambaa 146к	16-Feb	Вакцин	Би нэг л юмыг бат мэдэж байна наанаа вакцин хийлгэхгүй гэж сүржигнээд нууцаар очоод хатгуулна гэдгийг чинь л маш сайн мэдэж байна.	1	115	Хийлгэх хийлгэхгүй хүний эрх гэсэн хандлага их байна.	255	132
Ууyanga Gantumur 102к	17-Feb	Вакцин	Пээш, вакцин ярьсан хүн тариулахаасаа өмнө сошлд чадарч байгаа нэж надад хэлэхгүй яав аа	32	922	Ард иргэдийг буруу зүйлд турхирч байна гэсэн хандлагатай байна.	1126	35
Б.Жаргалсайхан 144к	17-Feb	Нийгмийн дайсан...	Коронавирусын вакцин тариулна, тариулахгүй гэсэн талцал яваад эхэллээ. Яг ийм хандлага барууны улсад ч ажиглагдсан зүйл. Ерөнхийдөө эрх баригчдад итгэхгүй байгаагийн илрэл юм. Тийм учраас олон нийтийн итгэл хүлээсэн улс төрчид, олон нийтийн зүтгэлтнүүд уриалан вакцин хийлгэдэг юм билээ.	150	214	Иргэн вакцинд хамрагдах эсэх нь иргэний эрх нийгмийн дайсан болж улс төржүүлж байгааг эсэргүүцсэн хандлагатай байна.	936	17
Мөнхтөрийн Нарантуяа-Нара 272к	17-Feb	Вакцины талаар	Корона вакцин магад улаан бурхны товлолт вакцин шиг ч юм уу эсвэл бусад төрлийн вакцин шиг жил бүр хамрагдах шаардлагатай вакцин ч болж мэдэх.	13	599	Маш хурдан хугацаанд бүтээгдсэн учраас сайн судлагдаагүй суурь өвчтэй хүнд сөрөг нөлөөтэй гэсэн эргэлзээ их байна.	3к	0

Эмужин 143к	17-Feb	Бумаа тэгээд хэн нь юм бэ ээ?	Орос, Хятадын вакциныг сайн муугаар нь ялгаад, Америк, Англи, Энэтхэг гэж эрэмбэлээд монгол хүний ген вакцинуудыг даваад гарна гэж мухар сүсэлгэх	63	144	Туршилтын хугацаа дуусаагүй гэдгээр вакцины чанарт эргэлзсэн хандлага их байна.	376	210
Оном сан 78к	18-Feb	Вакцин	Хэрэв би байсан бол вакциныг түр харзнаад, харин түүний оронд хүн амынхаа өөрийн нь дархлааг дэмжих иж бүрэн хөтөлбөр орон даяар зохион байгуулах байлаа. Хэт сүржигнэлгүй ажил амьдралаа хэвийн үргэлжлүүлж, вакцин бүрэн туршигдаж дууссан хойно сонголт хийх өргөн боломж гарна гэж үзэх байлаа.	2.2к	690	вакцин хийлгэх хийлгэхгүй нь хувь хүний өөрийн сонголт гэсэн хандлагатай байна	2.4к	17
Оном сан 78к	18-Feb	КОВИД-19 өвчний эсрэг вакцины талаар шинжлэх ухааны мэдээлэл	АНУ-ын Үндэсний эрүүл мэндийн хүрээлэнгэй Модерна компани хамтран бүтээсэн КОВИД-19 өвчний эсрэг Модерна mРНК-1273 вакцины судалгаа, танилцуулга, вакцины үр, нөлөө	265	210	Вакцины талаар шинжлэх ухааны үндэстэй тайлбар өгч байгаад иргэд талархалтай байна.	623	8
Ууянга Gantumur 102к	19-Feb	Вакцин	Ард иргэд өөр өөрсдийн чадал, боломжоор аль болох олон эх үүсвэрээс мэдээлэл авч түүнийгээ бусадтай хуваалцаж байна. Харин энэ мэт талцал үүсгэж байгаа асуултуудад төр эх сурвалжтай, баримттай нэгдсэн хариулт өгөх зайлшгүй шаардлага байна гэж үзэж байна.	199	340	Вакцин хийлгэсний дараа гарах үр дагаварт төр ямар хариуцлага хүлээх сөрөг нөлөөллийн талаар судалгаа авах арга хэмжээний талаар мэдээлэл дутмаг байна гэж шүүмжлэлтэй хандаж байна.	1,2к	15
Төр Овогт Аюузааны Отгонбаатар 65к	19-Feb	Бид вакцин хийлгэх ёстой	Чанартай сайн вакцин хийлгэх ёстой. Гэтэл дэлхийн банк-аас мөнгө зээлж вакцин авч байгаа нэрийн дор мөнгө зээлсэн хүмүүсийн эрхшээлд орж муу вакцин авч болохгүй.	103	38	Спутник-V вакциныг эсэргүүцсэн хандлага их байна.	165	6
Ууянга Gantumur 102к	20-Feb	Вакцин	Настай хүмүүст халтай байна л гээд байна шүү!	189	331	Вакциныг улс төржүүлээд байна гэсэн хандлага их байна	380	147
Ууянга Gantumur 102к	20-Feb	Вакцин	Солонгосчууд 65-аас дээш насныхандаа хийхгүй гэж шийдсэн байна.	83	251	Сөрөг коментоор өдөр бүр хүмүүсийн тархийн угааж байна гэсэн хандлага их байна	502	40

Tsetsgee Byambaa 146к	20-Feb	Вакцин	Вакцинаа харуулдаад л байжийнэ	0	56	Вакцин хийлгэнэ гэсэн хандлага нэмэгдэж байна.	1,3к	36
Оном сан 78к	21-Feb	КОВИД-19 өвчний эсрэг вакцины тухай	Монгол Улсад хэрэглэгдэхээр төлөвлөгдөж байгаа АстраЗенека компаний вектор вакцины тухай	1.1к	947	АстраЗенека вакцин хийлгэсний дараа хүний генийн санд ямар нэг сөрөг нөлөөтэй нь судлагдсан талаар их асуусан байна.	1142	23
Оном сан 78к	22-Feb	АстраЗенекагийн вакцины 2 дахь тунг эхний тунгаас 3 сарын дараа хийвэл вакцины үр дүн нь өндөр буюу 81.3% гарсан.	АстраЗенекагийн 150 мянган тунг вакциныг 150 мянган хүнд нэг дэх тунгаар хийгээд 3-н сарын дараа 2 дахь тунг АстраЗенека вакцины дараагийн татан авалтаас хийх нь шинжлэх ухааны сайн үндэслэлтэй байна.	134	35	Вакцины 2 дахь тунгийн хугацаан дээр нилээд шүүмжлэлтэй байна.	384	1
Ууянга Gantumur 102к	22-Feb	Вакцин	Бид 100 % иргэдээ вакцинжуулж чадахгүй, тиймээс зарим нь үлдэж таарна, би үлдээ гэлээ	67	306	Вакцины эсрэг улс төр хийж байна гэсэн хандлага их байна	889	13
Сэтгүүлч. Мөнхбаясгалан 216к	22-Feb	Спутник-Vвакцин	Би л лав Спутник-V вакцин хийлгэнэ	72	855	Олон төрлийн вакцины сонголт орж ирж өайгаад ард иргэд эргэлзээтэй байна.	2,4к	83
Сэтгүүлч Н.Өнөрцэцэг 11к	22-Feb	Вакцины эхний тунг Ерөнхий сайд П.Оюун-Эрдэнэ хийлгэж иргэдээ уриална	150 мянган хүн тун AstraZeneca вакциныг манай улсад буцалтгүй тусламжаар өгч вакцины эхний тунг Ерөнхий сайд П.Оюун-Эрдэнэ хийлгэж, иргэдээ уриална гэдгээ мэдэгдсэн.	9	35	Өөр өөр улсаас биш нэг улсын вакцин оруулж ирэх нь зөв гэсэн хандлагатай байна.	115	35
Оном сан 78к	23-Feb	АстраЗенека вакцины 2 дахь тунг хэзээ хийх нь зөв бэ?	АстраЗенека вакцины 2 дахь тунг эхний тунгаас 4 долоо хоногийн дараа хийх нь үр дүнг бууруулах талаар Оном сангийн Эрдэмтдийн багаас энэ асуултын шинжлэх ухааны үндэстэй хариуг өгнө	342	236	Вакциныг суурь өвчтэй хүмүүс хийлгэж болох талаар иргэдийн дунд эргэлзээ их байна	396	1
Tsetsgee Byambaa 146к	23-Feb	Уншаад аваарай	BBC: Хятадын “CoronaVac” вакцин сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл хамгийн бага	49	43	Хүмүүс хятад вакцин итгэх итгэл муу байна.	100	13
Tsetsgee Byambaa 146к	23-Feb	Вакцины анхны тунг хийлээ	КОВИД-ын эсрэг дархлаажуулалтын вакцины анхны тунг Ерөнхий сайд хийлгэж байна	14	5	Иргэдийг сайн зүйлд уриалсан зэрэг хандлагатай	113	1

Мөнхтөрийн Нарантуяа-Нара 272к	23-Feb	Вакцин амжилттай байх болтугай	КОВИД-ын эсрэг дархлаажуулалтын вакцины анхны тунг Ерөнхий сайд хийлгэж байна	4	0	49	0
Сэтгүүлч Н.Өнөрцэцэг 11к	23-Feb	Вакцин	Дархлаажуулалтын вакцины анхны тунг Ерөнхий сайд хийлгэж байна	4	0	20	0

Хавсралт 2. Вакцины талаар жиргэсэн жүргээнүүд /хамгийн өндөр ретвийт, лайктай байдлаар/

/д	Твиттер нэр	Твиттерийн утга	Ретвийт	Лайк	Хариулсан хандлага
1	Khurelbaatar Shimed / УИХГишүүн/	Өнөөдөр вакцинжуулалт Монголд эхэллээ. Вакцинжуулалтыг Япон, Австрали-тай бараг зэрэг, Өмнөд Солонгосоос ч өмнө эхлүүлж чадлаа. Энэхүү ажлыг эхлүүлэхэд хүчин зүтгэсэн бүх хүмүүст талархал илэрхийлье. Монголыг байнга дэмждэг хөгжлийн түншүүддээ баярлалаа.	204	726	Дэмжсэн, сайшаасан
2	Өөжтэй Өлзий-Орших	Манайхан өвдөхөөрөө хямд сайн гээд Хятад руу л голдуу явж эмчлүүлдэг биздээ. Орос руу ер нь эмчилгээнд бараг явдаггүй биздээ. Тэгсэн мөртлөө Орос вакцин сайн, Гитад муу чигтэй эдр	193	579	Дэмжсэн, сайшаасан
3	Бундан Болдсайхан	... орж ирж буй 250.000 вакциныг 125.000 хүнд биш 250.000 хүнд хийх н зөв 1. эхнийхээр 70%-с дээш %-д дархлаа тогтоно 2. давтах 3 сарын хугацаанд 2 дахи тун олж л таараа 3. дараа н өөр вакцинаар 2-дахи тун хийж ч болно, бүр илүү ...	288	508	Дэмжсэн, сайшаасан
4	Сэтгүүлч Доржоо	Хөөрхий 30 мянган хонь маань 300 мянган тун вакцин болоод л ирлээ. Малын буян их шүү	82	362	Дэмжсэн, сайшаасан
5	Battamir.U	Вакцин хийлгэхгүй гэж олон нийтийг турхирч байгаа болон тэдэнд итгэж байгаа хүмүүс дараах 10 фактыг уншаарай. 1.ДЭМБ зөвшөөрсөн бөгөөд үр дүн нь дэлхийн том сэтгүүлүүдэд хэвлэгдсэн бол үйлдвэрлэгчдэд ямар ч нэмэлт туршилт хийх шаардлага байхгүй.	193	352	Дэмжсэн, сайшаасан
6	Баабар / нийтлэлч/	ЭМЯ вакциныг зөв тайлбарлах ажил зохио. 90%-тай гэхээр үлдсэн 10% нь тариулаад үхчихдэг юмшиг ойлголт их бна.100%-тай вакцин гж үгүй. Тухайн хүний биеийн онцлогоос зарим хүнд вакцины дараа дархлаа үүсдэггүй. Вакцин 50%-тай ч байсан сайн, яахавдээ үлдсэнд нь дархлаа үүсээгүй л биз	147	337	Дэмжсэн, сайшаасан
7	Их эмч Б.Гэрэлээ	Эхний уушиг эрүүл хүнийх. Хоёр дахь цайрсан зураг нь КОВИД19 оор өвчилсөн хүний уушиг. Эрхтэнийг чинь ийм хүндээр өвчлүүлэхгүйн тулд вакцин хийлгэх нь зөв гэж зөвлөөд байгаам. /Уушигны харьцуулсан зурагтай/	234	314	Дэмжсэн, сайшаасан

8	Khurelbaatar Shimed / УИХГишүүн/	Вакцин бол шинжлэх ухааны бүтээл. Би шинжлэх ухаанд итгэдэг. Шинжлэх ухааны олон олон нээлтүүд хүмүүсийн насыг уртасгаж, амьдралыг хөнгөвчилж байгаа... гээд вакцинний талаар өөрийнхөө байр суурийг фэйсбүүк гэж дээрээ илэрхийллээ. Энд бичихээр багтахгүй учир зургаар орууллаа.	121	298	Дэмжсэн, сайшаасан
9	Dr.ND Dashdorj /Оном сан/	Сайн мэдээ! Их Британид вакцинуудын үр дүн маш сайн гарчээ! АстрадаЗенекагийн вакцин их хэмжээгээр хэрэглэгдсэн, үр дүн нь Пайзерын вакцинтай ижил гарсан байна. Монголчуудаа, вакцинаа хийлгээрэй! /ВСС мэдээ ишилж оруулсан/	151	286	Дэмжсэн
10	Гунгаагийн Базарваань	Сүлжээний юу нь ч мэдэгдэхгүй эм уугаад байдаг байж вакцин дээр нэг л их гайхсан хүмүүс.	68	223	Дэмжсэн, сайшаасан
11	Гонгоржав ГАНБАТ	БНХАУ-ын Засгийн газрын тусламж, тус улсын Синофарм компанид үйлдвэрлэсэн 300 мянган тун вакцин Улаанбаатарт буулаа. Баярлалаа, БНХАУ.	73	217	Дэмжсэн, 30к хонины талаар дурьдсан
12	Naranbayar Наранбаяр	Би дархлаа, тархвар судлалыг мэдэхгүй. Гэхдээ вакцин хийлгэнэ. Вакцин хүн төрөлхтөнийг олон аюулт өвчнөөс аварсан, энэ удаад ч тэгнэ. Улс орнууд вакцин хийлгээд энгийн, хэвийн амьдралдаа орсоор л байна шүү дээ.	59	193	Дэмжсэн, сайшаасан
13	Самданнамын Мөнхчулуун	Вакцин хийлгэх, хийлгэхгүй нь хувь хүний эрхийн асуудал. Мөн вакцин хийлгээгүй хүнд үйлчилгээ үзүүлэхгүй байх нь үйлчилгээний байгууллагуудын эрхийн асуудал юм. Олон улсын авиа компаниуд, онгоцны буудлууд вакцин хийлгээгүй хүнд үйлчлэхгүй гэж байгаа юм билээ. Цаашлаад дотоодод ч /Г.Уянгын фэйсбүүк дээрээ вакцин хийлгэхгүй тухай бичсэн постын зургийг оруулсан/	56	169	Дэмжсэн, сайшаасан
14	SiTluS	Ерөнхий сайд маань Энэтхэг вакцин хийлгэсний дараа #гэнээ /энэтхэг бүжигчинд Ерөнхий сайдын нүүрийг оруулсан бичлэг/	64	164	Хөнгөн маазарсан байдалтай хүлээж авсан
15	Ё.Отгонбаяр	No jab no job буюу вакцин тариулаагүй бол ажилгүй гэсэн тренд гарчээ. Ер нь цаашдаа ингэх л байхдаа	98	160	Дэмжсэн
16	Түмүрбаатар.JS /япон судлаач/	Вакцинжуулалт амжилттай явагдаж байгаа Израйль улс 2 дахь вакцинаа хийлгэсэн иргэдийг вакцин огт хийлгээгүй иргэдтэйгээ харьцуулан судалгаа хийж үзэхэд вакцин хийлгэсэн хүн коронавирусыг амь насаа алдахаас 98.9% хүнд өвчлөхөөс 99.2% хамгаалагдаж буй нь батлагджээ!!!!	95	155	Дэмжсэн, сайшаасан
17	Ganzorig Vanchig	Вакцин тариулахгүй гэж байгаа хүмүүсийг сонсохоор дундад зуунд Бруног шатааж алсан Ромын лам санваартан нарын түүх санагдах юм. Саяхныг хүртэл зураг авахуулбал нас богино болно, усанд орвол буян арилна гэж “ярьдаг” байсан бид аргагүй байх өө	54	151	Дэмжсэн, сайшаасан
18	Asashoryu	Японд вакцин хийлгэсэн эмч нарын тоо 10,000 даваад бн. Сайдны жиргээ	29	143	
19	Аанхаа / нийтлэлч/	Вакцин ерөөсөө сайн дураараа тариулах нь тариулаад айл нь болиод явья, сургууль ч бас сайн дураараа явах нь яваад үлдэх нь үлдий. Би лав орос, хятад, астразэнэка аль ч вакцинд орж туршилтын туулай болоход бэлэн шүү!	35	123	Дэмжсэн



20	Эрдэнэбилгүүн	Anti vaxxer буюу вакцин хийлгэхээс татгалзах үйлдэлийг дэлхийн хэмжээнд эрүүл мэндэд аюул заналхийлж буй арван том асуудлын нэг гэж ДЭМБ тодорхойлжээ. Вакцин хийлгэхгүй бх нь зөвхөн өөрийн эсвэл өөрийн хүүхдэд хамаарах асуудал биш эргэн тойронд бгаа бүх хүмүүст хамаарах асуудал	65	120	Дэмжсэн, сайшаасан
21	Munkhsaikhan O.	Манай ЭМЯ, ДЭМБ-р шүүдэг олон улсад шалгарсан, үр нөлөөтэй вакцин нь өндөр настан зэрэг эрсдэлт иргэдийг хамгаалах, нийгэм, эдийн засгийн амьдралыг сэргээхэд нэн чухал. Нөлөө бүхий этгээдүүд өөрсдөө вакцин хийлгэхгүй бж болох ч үүнийгээ бусдад уриалж буй нь бусдыг хорлож буй хэрэг	51	114	Дэмжсэн, сайшаасан
22	Хашчулуун (PhD)	БНСУ-д Астра Зенека коронагийн вакциныг 26-ны өдрөөс эхэлнэ. Олон улсын дүрэм заавар дээр тулгуурлан” КОВИД19-ийн вакцин тариулаад ямар нэг шинж тэмдэг илэрвэл, тэр шинж тэмдэг арилсны дараанаас хойш 7 хоногийн дараа цусаа өгөх, хандивлах боломжтой ажээ.	32	99	
23	Хүрлээ, Д	300К вакцин ирлээ. Хичнээн хүний амь нас, улсын хөрөнгө, мөнгө аврагдаж, хэмнэгдэхийг таашгүй ээ.	17	96	Дэмжсэн
24	Чөлөөт хүн	Зөвлөх Уянга Женког Орос явж вакцин авчирх сургаар манай Баатархуяг спутник 5 хийлгэнэ гэнээ чихшиг... Саяхан л гэр бүлээрээ хийлгэхгүй чихшиг юм яриад бсан даа	35	88	Дэмжсэн
25	Дашзэвэг Ганхуяг / судлаач Ганаа/	“Оросын “Спутник” вакцин бол үр дүн, найдвартай байдлаараа Калашниковын автомат л гэсэн үг” гэж Вены Анагаахын ИС-ийн тэргүүлэх халдвар судлаач Флориан Тальхаммер дүгнэжээ.	43	83	
26	О.Амартүвшин /МУХАУТДарга/	Шинэ өдрийн мэнд. 3 дугаар хөл хориогоо нилээд үр дүнтэй амжилттай давигаалаа. Аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж эхэллээ. Вакцин ч эхэллээ. Эдийн засгийг эрчимжүүлэх хөтөлбөрүүд шийдэгдэж эхэллээ. Түүхий эдийн супер цикл ч эхэллээ. Сорилт бүгдийн эхлэл байдаг.	19	82	
27	Purevkhuu	Ерөнхий сайд Астра зенекаг тариулаад иргэдэд уриаллаа. Одоо ирж байгаа вакцинаас Ерөнхийлөгч Хятад вакциныг нь өөрөө тариулж иргэдэд уриалах хэрэгтэй гээд бичихсэн чинь Ардчилсан намын ажлын албаныхан уурлаад байх юм. Хятад вакцин Ерөнхийлөгч 2 яачихаад байгаан бол?	34	79	Ерөнхийлөгчийг Орос вакцин хийлгэх талаар, хятадын эсрэг бодлогтой талаар хариулсан
28	Оддын охин	БНХАУ-аас Монгол цэргийн алба хаагчдад 100 мянган тун вакцин хандивлалаа /gogo.mn мэдээг ишилж оруулсан, зурагтай/	17	78	Хятад вакциныг Монгол цэргүүдэд тарих гэлээ гэж хардсан
29	Цогтсайхан	Монголчууд вакцин бүтээж байсан. 1990-ээд оны эхээр гепатитийн (элэгнийх биш шүү) В вирусийн эсрэг вакциний технологи бэлэн болчихсон байсан.	39	78	Дэмжсэн

30	Tsogtbaatar Damdin / УИХГишүүн/ Монгол улсын иргэн Зориг	Вакцин замдаа гарлаа. /Миатын онгоцны зураг/	22	74	Дэмжсэн
31		БНХАУ-аас өнөөдөр 300000 тун “Vero cell” вакцин ирэх юм байна. Вакцин тээвэрлэсэн тусгай үүргийн онгоц 23:00 цагт бууна.	31	73	
32	БАТ инженер	Мояа: Бид вакцин хийлгэхгүй Мояа: Бид СПУТИНИКВи хийлгэнэ Дүгнэлт: СПУТИНИКВи бол вакцин биш Би та нарт нэг нууц юм хэлэх үү?	21	68	Дэмжсэн
33	Гонгоржав ГАНБАТ	Хятадын Синовак вакцин байна шдээ, чишш... тэр чинь одоогоор дэлхийд байгаа вакцинуудаас хамгийн өндөр үнэтэй нь шдээ. Нэг тун нь 30\$. Өглөө Оюун-Эрдэнийн хийлгэдэг АстраЗенека 3\$. Хүнд битгий хэлээрэй	23	63	
34	Regina Phalange	Вакцин хийгээд эхлэхээр манай улс цусны донорын хомсдолд орж магадгүй Thinking face Та хэд вакцинаа хийлгэхээсээ өмнө чадвал цусаа хандивлаж олон хүнд тус болоорой	40	56	Дэмжсэн
35	Samandar Tsogtbayar / Цогтбаяр шог зураач/	Аюулт цар тахлын аймшигт хор хөнөөлийг даран сөнөөж Аварч тэтгэх ерөндөг нь ВАКЦИН л байна даа энэ цаг үед. /Үнэн алдартны шашны гэгээн Жорж жадны оронд гартаа вакцин барьж Лууг алж буй шог зураг	10	51	Дэмжсэн
36	Samandar Tsogtbayar / Цогтбаяр шог зураач/	Өөрөө вакцин хийлгэхгүй хэмээсэн ч Өрөөлийг бас давхар шаардаж ятгах нь Амь наснаасаа уйдаж цөхрөөд Арван давхраас үсрэхээр шийдсэн нэгэн Араасаа бусдыг хамт үсрэхийг уриалах лугаа Агаар нэг адил гэмт үйлдэл шүү! /Коронаг дүрсэлсэн чонын зураг/	21	43	Дэмжсэн
37	erde_criminalist /Эрдэнэбат/	Гитадын вакцин ямар нэгэн side effect гүй боловч МОЯ чуудад зодуулах outside effect тэй Швейцарийн Холбооны Улсын Ерөнхийлөгч: “Хэн аялахыг хүсч байна, тэр вакцин хийлгэх шаардлагатай”. Guy Parmalen, Le Président de la Confédération: “A l’avenir, qui souhайте voyager devra ktre vaccini”	17	37	
38	D.Bayarsaikhan	Мангусыг вакцин сайн муу, Pfizer Astrazeneca аль нь дээр эдр гээд мэдэхгүй маргаад сууж байхад цаадуул чинь хоёр төрлийн вакциныг хослуулж хэрэглэвэл үр дүнтэй байж магадгүй гэж нотлоод эмнэлэгийн туршигт эхэлчихсэн байдаг. mRNA + vector vaccine Вакцин хийлгэнэ.	18	37	
39	Tuvshin MD	Вакциныг энэ пандемийн эсрэг Г. Уянга бид 2-оос илүү ШУ гадарладаг хүмүүс уншиж судлаж гаргаж ирж ОУ-ын ЭМ байгууллагууд нь батлалчихсан бгаа.	13	24	
40	Sangaamaa	Вакцин бол аймшигт тахлуудаас хүн төрөлхтнийг аварсан бидний түүхэн том ололт. /Г.Уянгын фэйсбүүк дээрээ вакцин хийлгэхгүй тухай бичсэн постын зургийг оруулсан/	12	22	Дэмжсэн
41	Мулан	Аяганы хариу өдөртөө Агтны хариу жилдээ гэж... 30 мянган хонь, 300 мянган вакцин болж ирвүү дээ	8	13	Дэмжсэн

Хавсралт 3. Вакцины талаар мэдээлэл оруулсан сайтууд

д/д	Сайтын нэр	Огноо	Мэдээний нэр	Мэдээний товч агуулга	Сэтгэгдэл тоо	Сэтгэгдлийн хандлага
1	news.mn	2021.02.18	“Шинэ мутациас хамгаалахын тулд 3 тун вакцин хийлгэх хэрэгтэй”	“Microsoft” корпорацийг үүсгэн байгуулагч Билл Гейтс COVID-19 өвчнөөс бүрэн хамгаалагдахын тулд вакцинжуулалтыг гурван үе шаттайгаар явуулах шаардлагатай болно хэмээн ярьжээ. Одоогоор дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн вакцинууд нь бүгд хоёр тун хийх шаардлагатай байгаа ба энэ хоёр тун нь хүний биед энэ өвчний эсрэг дархлаа үүсгэх бол гурав дахь тун нь шинэ мутациудаас хамгаална гэж тэрээр ярьсан байна.	29 сэтгэгдэл	Сэтгэгдлийн дийлэнх олонхи нь вакциныг туршилт, бизнес болгох гэсэн эргэлзээ, эсэргүүцэл илэрхийлсэн
2	news.mn	2021.02.19	Танилц: Монголчууд эхэлж хийлгэх “Covishield” вакцин	Монгол Улс ДЭМБ-ын “COVAX” хөтөлбөрийн хүрээнд 2021 оны нэгдүгээр улиралд “AstraZeneca”-гийн 163,200 тун, “Pfizer”-ийн 25,740 тун вакциныг тус тус хүлээн авахаар болсон. Эдгээр вакцинуудын талаар дэлгэрэнгүй мэдээллийг хүргэсэн байна.	126 хандалт, 49 сэтгэгдэл	сэтгэгдлийн 10% нь Спутник вакциныг дэмжсэн, бусад нь эдгээр вакцинуудын талаар ойлголт сул байгаагаа илэрхийлсэн байна
3	eduur.mn	2021.02.20	Иргэд: “ОХУ-ын вакцин тариулна, харж байж л болно, олонхоо дагана”	Тус сайтын сэтгүүлч иргэдтэй уулзан вакцины талаар (16 иргэнээс) сэтгэгдэл авсан байна. Тэдний дийлэнх нь вакцин хийлгэх хандлагатай байгаа ч гэж нөлөө, хуурамч вакцин байх вий гэсэн хардлага, төлбөртэй эсэх талаар эргэлзээ байгаагаа илэрхийлсэн байна. Зарим залуучуудын хувьд тодорхой мэдээлэлгүй байхад ахмадууд мэдээлэл сайтай байна.	8 сэтгэгдэл	Олонхи нь вакцинй талаар ШУны ойлголт сул
4	ikon.mn	2021.02.22	Сергей Диордица: Коронавирусын эсрэг ОХУ болон БНХАУ-ын вакциныг ДЭМБ ойрын хугацаанд баталгаажуулна	“ДЭМБ вакцинуудыг үр дүн болон чанарын хувьд магадлан няталсны үр дүнд үнэлгээ өгч баталгаажуулдаг. Гэхдээ вакцинуудад чанарын баталгаа өгөхөд цаг хугацаа шаарддаг.  AstraZeneca болон Pfizer-ийн коронавирусын эсрэг вакциныг ДЭМБ яаралтай горимын жагсаалтад бүртгэж, үр дүн болон чанарын хувьд хангалттай гэж үзсэн тул баталгаажуулсан. Харин ОХУ-ын Спутник V болон БНХАУ-ын Сенофарм компанийн вакциныг ДЭМБ эмнэл зүйн туршилт судалгааны үр дүнг нь үнэлж, яаралтай горимоор баталгаажуулах үйл ажиллагаа явагдаж байна. Ойрын хугацаанд баталгаажуулалтыг өгнө.	зэрэг хандалт 41, 21 сэтгэгдэл	Сэтгэгдэлийн дийлэнх нь сөрөг сэтгэгдэл бичсэн нь вакцины талаар иргэдийн ШУны үндэслэлтэй ойлголт сул байна.

5	eagle.mn	2021.02.22	Нэг хүнд нэг тун вакцинаар дархлаа тогтоох боломжтой юу	Дэлхий нийтээр вакцины эрэлт ихтэй байгаа үед нэг хүнд нэг тун вакцин тарьж хүн амаа яаралтай дархлаажуулах талаар яригдаж эхэлжээ. Их Британи насанд хүрсэн иргэдээ нэг тунгаар вакцинжуулах нь илүү үр дүнтэй гэсэн эрдэмтдийн зөвлөгөөг дагаж хэрэгжүүлж, AstraZeneca вакцины тун хооронд дархлаа тогтож эхний тунгаас 22 дахь хоног дээрээ 76 хувийн хамгаалах чадвартай болж буй нь тогтоогдсон. Гавьяат эмч Б.Болдсайхан энэ жишгээр насанд хүрсэн хүн амаа нэг тунгаар дархлаажуулах боломжтойг өөрийн цахим хуудсаар хуваалцсан талаар өгүүлсэн байна.	1 сэтгэгдэл	зэрэг 1 сэтгэгдэл
6	gogo.mn	2021.02.22	Вакцин гаж нөлөө үзүүлбэл нөхөн төлбөр олгох төлөвлөгөөг ДЭМБ боловсруулжээ	Коронавирусын эсрэг вакциныг хэрэглэсний дараа хүчтэй гаж нөлөө илэрсэн тохиолдолд нөхөн төлбөр олгох төлөвлөгөөг ДЭМБ-аас боловсруулжээ. Энэхүү төлөвлөгөө нь олон улсын Ковакс хөтөлбөрийн хүрээнд вакцин хүлээн авах бага болон дундаж орлоготой 92 улсад хамаатай бөгөөд 2022.06.30 өдөр хүртэл хүчин төгөлдөр хэрэгжих юм байна.	27 сэтгэгдэл	бүгд зэрэг сэтгэгдэл
7	gogo.mn	2021.02.22	Вакцинтай холбоотой бүх мэдээллийг нэг дороос	Коронавирусын вакцины талаар мэдээллүүдийг багцлан хүргэсэн байна.	108 хандалт, 31 сэтгэгдэл	дийлэнх олонхи нь вакцины талаар мэдээлэл дутмаг байна хэмээн шүүмжлэлтэй хандсан байна
8	gogo.mn	2021.02.22	ОХУ-аас авах вакцины эхний ээлжийг ирэх 7 хоногт оруулж ирэхээр тохиролцсон	ОХУ-ын үйлдвэрлэж буй Спутник В вакцины эхний ээлжийг ирэх долоо хоногт оруулж ирэхээр тохиролцсон талаарх ЭМ-ийн сайдын мэдээлэл.	141 хандалт, 15 сэтгэгдэл	Дийлэнх олонхи нь Спутник вакцинд зэрэг хандлага илэрхийлсэн байна
9	ikon.mn	2021.02.23	Коронавирусын эсрэг вакцины талаар ЗААВАЛ мэдэх ёстой зүйлс	Каназава Үндэсний их сургуулийн Анагаахын сургуулийн дэд профессор, АШУҮИС-ийн дэд профессор, доктор Д.Нямбаярын онлайн уулзалтын үеэр өгсөн мэдээлэл: “ДЭМБ-аас 50 хувиас дээш үр дүн өгч байгаа вакциныг “Үр дүнтэй” гэж тооцдог. Pfizer, Moderna вакцинуудын зургаадугаар шатны туршилтуудын дүнгээс харвал 95 хувийн үр дүнтэй гэсэн судалгааны бүтэц гарсан. Сүүлийн шинэ мэдээлэл нь Pfizer вакциныг -20 градуст хоёр долоо хоног хадгалж болно гэдгийг тогтоосноо ДЭМБ-д мэдээлсэн байна. Манай хоёр хөршийн хувьд нэг болон хоёрдугаар шатны туршилтаа хийсний дараа хүн амаа вакцинд хамруулаад эхэлсэн. Хятадын Синофарм вакцины	зэрэг хандалт 4.1 к, 27 сэтгэгдэл	Дийлэнх олонхи нь ШУНЫ үндэслэлтэй мэдээлэлд талархсан байна

10	eagle.mn	2021.02.23	Та вакцинжуулалтад хамрагдах уу? Онлайн санал асуулга	гүравдугаар шатны туршилтыг Бразил улсад хийж эхэлсэн ч дундаас зогсчихсон. Спутник вакцины хувьд AstraZeneca-тай төстэй ч үр дүнгийн талаар мэдээлэл алга байна. Дэлхий даяар Спутник вакцины үр дүнд итгэхгүй байгаа. Коронавирусийг харьцангуй тогтвортой вирус гэж хэлж болно, азаар коронавирус харьцангуй тогтвортой байгаа. Хурдан хувьсдаг вирусийн эсрэг вакцин хийхэд маш хэцүү”	74 хариулт	дийлэнх олонхи нь вакцинд хамрагдах хүсэлтэй
11	gogo.mn	2021.02.23	Цай Вэньгүй: Дотооддоо вакцинаар бүрэн хангаагүй ч Монголд эргэлзэлгүй буцалтгүй тусламж үзүүлэхээр шийдсэн	БНХАУ-ын Засгийн газар болон Ардын чөлөөлөх армиас тусламжаар илгээсэн 300 мянган тун коронавирусын вакциныг Монгол Улсын холбогдох албаны хүмүүс хүлээн авсан.	360 хандалт, 26 сэтгэгдэл	сөрөг сэтгэгдэл 3
12	zarig.mn	2021.02.23	ДЭМБ: Бүгд хамрагдсан тохиолдолд л вакцинжуулалт үр дүнтэй	ДЭМБ-ын захирал Коронавирусийн эсрэг вакцинжуулалт бодит үр дүнтэй байх нөхцөлийг нэрлэжээ. Тэрээр “Вакцинжуулалт дэлхийн бүх оронд зэрэг явагдах нь дэлхий дахины ашиг сонирхолд нийцнэ. Хэрвээ аль нэг оронд вакцинжуулалт явагдахгүй хойшилбол тухайн газар вирусийн шинэ хувилбар үүсэж үржих талбар болж хувирна” хэмээжээ.	11 сэтгэгдэл	сөрөг сэтгэгдэл 9
13	ulug.mn	2021.02.23	Вакцин хийнэ гэдэг хүний дархлалын системийг сөнөөнө - Худал	Сэтгүүлч Б.Отгон өөрийн цахим хуудсаараа олон улсын тоймч Ш.Гантулгын ярилцлагын хэсгээс “Вакцин хийнэ гэдэг чинь хүний дархлалын системийг сөнөөнө гэсэн үг” гээд байр суурийг нь хуваалцжээ. Мэдээлэлд Ш.Гантулгын яриаг баримтаар няцаасан байна.	1000 сэтгэгдэл	дийлэнх олонх нь сэтгүүлчийн няцаалтыг дэмжсэн байна



Улсын Их Хурлын Тамгын газар  
“ПАРЛАМЕНТ” судалгааны эмхэтгэл - XXXIII БОТЬ

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх, олшруулах цех  
Хэвлэлтэнд шилжүүлсэн: 2021.03.17  
Хэвлэсэн тоо: 350  
Цаасны хэмжээ: B5

УБ., 2021